

ISSN 2957-4285

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2024 №04 (91)
22 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭМЕРИТ ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Энхсайхан ДАШГААДАН

ДОКТОР (Ph.D)

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Энхсайхан ДАШГААДАН

ДОКТОР (Ph.D)

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Шаравдорж АРИУНБИЛЭГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

Лувсан БАТ-ОЧИР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Сэнгээ ГАНТУЛГА

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА

ДОКТОР (Ph.D)

Жаргалсайхан МӨНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бат-Ерөөл МӨНХДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Нямдорж ОДОНТУУЛ

ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батсайхан ЭРДЭНЭБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Дорж ЭНХТӨР

ДОКТОР (Ph.D)

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>Х.Баатарбилэг</i>	5
Амиа хорлох нөхцөл байдалд хүргэж байгаа шалтгаан, нөхцөл	<i>Б.Нямгэрэл</i>	11
Хиймэл оюун ухаан (AI) ашиглан зам тээврийн осол, зөрчлийг бууруулж байгаа гадаад улсын туршлага	<i>О.Болорцэцэг</i>	21
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй байдал: Герман болон Япон Улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзэх нь	<i>Г.Батжаргал</i>	30
Төрлөөр устгах гэмт хэрэгт хүлээлгэх олон улсын эрүүгийн хариуцлага: Responsibility to protect – R2P (хамгаалах үүрэг) зарчим	<i>Б.Алтангэрэл</i>	37
Халдашгүй байх эрхийг хүний генетикийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замаар хамгаалах нь	<i>Ц.Амарсанаа</i>	51
Хүчиндэх гэмт хэргийг төсөөтэй зарим гэмт хэргээс ялган зүйлчлэх нь	<i>Т.Одбаатар</i>	73
ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Эрүүгийн процессын эрх зүйн харьцуулсан судлал	<i>Н.Сайнбаяр</i>	80
Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт	<i>Б.Ганболд</i>	88
ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам, боломж, чиг хандлага	<i>Х.Одонтуяа</i>	95
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хохирлыг иргэний журмаар нөхөн төлүүлэх ажиллагаа	<i>Б.Оюун-Эрдэнэ</i>	110
ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн талаар авч үзэх нь	<i>Ё.Болормаа</i>	120

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

КИБЕР ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE CURRENT STATE OF WORK ON PREVENTING CRIMES AGAINST CHILDREN IN THE CYBER ENVIRONMENT

Х.Баатарбилэг

Дотоод хэргийн их сургуулийн докторант

Товч агуулга. Кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үгс. Кибер орчин, хүүхэд, гэмт явдал, урьдчилан сэргийлэх ажил, нөлөөллийн аян.

Abstract. The current state of work on preventing crimes against children in the cyber environment was analyzed and recommendations were developed to improve prevention work.

Keywords. Cyber environment, children, crime, prevention work, advocacy.

Кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын чухал хэсэг бол энэхүү гэмт явдалтай тэмцэх стратегийг боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинээр болон шинэчлэн баталсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн агуулга, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах явдал байдаг.

Монгол Улсын Засгийн газар харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр зарлаж, “Цахим үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Засгийн газрын бүтцэд Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулсан билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 493 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг баталсан. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Кибер аюулгүй байдлын зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулсан.

УИХ-аас 2021 онд Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталж, улмаар Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шинжид нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Иргэдэд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, кибер аюулгүй байдлыг хангах чиглэлийн мэдээллийг хүргэх чиглэлд анхаарал хандуулж, цөөнгүй арга хэмжээг авч хэрэгжүүлж, эхнээсээ үр дүнд хүрч байна. Дээр дурдсан ажил, арга

хэмжээний үр дүнд сүүлийн жилүүдэд Монгол Улсын цахим засаглалын кибер аюулгүй байдлын индекс хэд хэдэн байраар урагшилсан эерэг үр дүн гарчээ.

Төрийн болон төрийн бус байгууллагаас кибер орчин дахь хүүхдийн эсрэг урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөн, нөлөөллийн аяныг зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Тухайлбал,

Монгол Улсын Засгийн газар, ХЗДХЯ, МУГХУСА33, ЦЕГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, НҮБ-ын Хүүхдийн сан, Faro төрийн бус байгууллага хамтран кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2018, 2019 онд **“UNFRIEND, “Цахим орчинг зөв болгоё”, “Зөвийг түгээе”** аяныг зохион байгуулжээ.

Аяны хүрээнд хүүхэд залуусыг кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, кибер сүлжээг зөв зохистой хэрэглэх, аюулгүй байдлаа хангах талаар сургалт, соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээх хэлбэрээр зохион байгуулсан.

Кибер орчин дэлхий ертөнцийг холбох гүүр болсон төдийгүй улам бүр хурдацтай хөгжиж байгаа шинэ эриний хүчтэй хэрэгсэл болоод байна. Монгол Улсад интернэт хэрэглэгчдийн тоо сүүлийн 4 жилд 40%-иар өсч, 2.9 сая хэрэглэгчтэй болсон төдийгүй фэйсбүүкийн идэвхтэй хэрэглээгээрээ Азидаа 1-т, Дэлхийд 10-т багтаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон кибер орчинд үйлдэгдэж буй бусад төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Дээрх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах, хүүхдийг кибер орчныг ашиглаж үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил бусад эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, кибер орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хяналт тавих, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2019 онд ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ЦЕГ хамтран **“UNFRIEND хөдөлгөөн”**-ийг зохион байгуулжээ.¹

Тус хөдөлгөөний хүрээнд 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Төрийн ордны их танхимд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, оюутан, сурагч зэрэг 800 хүн оролцуулсан “Таны хүүхдийг танихгүй хүмүүс хүмүүжүүлж байна” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжийг Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарт гардуулан өгсөн.

Facebook дэх садар самууныг сурталчилсан болон зохисгүй агуулга бүхий контент агуулсан групп, пэйж хуудсуудыг REPORT хийж, фэйсбүүк компанид мэдээлснээр уг контентыг хэсэгчлэн болон группыг бүхэлд нь устгуулах зорилготой “Хар жагсаалт/Black list” группыг үүсгэсэн. Группэд 19,300 гишүүн идэвхтэй репорт хийн тус группын үйл ажиллагааг дэмжиж байна.

Unfriend хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэд, олны танил 150 хүнээр фэйсбүүк дэх ковер, фрэйм зураг солиулж, цахим гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд уриалсан пост нийтлүүлэх зэргээр цахим давлагаа өрнүүлсэн.

¹ Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт судалгааны тайлан. НҮБ-ын Хүүхдийн сан, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль. УБ., 2021. 32 дахь тал

Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, анхааруулга, сэрэмжлүүлэг агуулга бүхий 15 видео контент бүтээж олон нийтийн цахим сүлжээгээр түгээснийг давхардсан тоогоор 3,465,293 хүн үзэж, 47,791 хүн бусадтай хуваалцаж, 36,829 хүнд таалагдаж, 2,552 сэтгэгдэл үлдээсэн байна. Дээрх контентуудыг 31 телевизээр түгээснийг 318,720 хүн үзжээ. Анхааруулга, сэрэмжлүүлэг, мэдээлэл бүхий 51 зурагт мэдээг олон нийтийн цахим сүлжээнд нийтэлснийг 813,165 хүн үзэж, 7,142 хүнд таалагдаж, 5,794 хүн бусадтай хуваалцан, 398 сэтгэгдэл үлдээжээ.²

Кибер гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхдүүд ихээхэн холбогдож, өртдөг тул тэдний сонирхдог дуучдаар “Unfriend” дуу бүтээлгэн Youtube, Facebook page хуудсуудад байршуулсныг давхардсан тоогоор 813,760 хүн үзэж, 11,510 хүнд таалагдаж, 24,455 хүн бусадтай хуваалцаж, 392 сэтгэгдэл үлдээжээ. Дуу, клипийг олон нийтэд хүргэх зорилгоор 32 радио, 31 телевизэд тараан, цацуулах ажлыг зохион байгуулсан.

Оюутан, сурагчдад зориулж **“Цахим орчны талаар таны мэдэхгүй үнэн”** сэдэвт хичээл бэлтгэж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын ямаар дамжуулан сургалт зохион байгуулсан бөгөөд уг сургалтад ерөнхий боловсролын 65 сургуулийн 72.751 сурагч, 15 их, дээд сургууль, коллежийн 2385 оюутан хамрагдсан. Оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор их, дээд сургуулиудын дунд чалленж зохион байгуулахад 16 сургууль бүтээл ирүүлснийг олон нийтийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулж, урамшуулсан.

Иргэд, олон нийтэд мэдлэг олгох, хөдөлгөөнийг сурталчлах, өрнүүлэх ажлын хүрээнд 192,603 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тарааж, олон нийтийн газар байршсан 220 LED дэлгэц, томоохон кино театруудаар видео контент түгээж, 88 хулдаасан самбар байршуулсан. Үүрэн телефоны 4 оператороор дамжуулан 2 удаагийн зорилтот мессежийг хүргэн, Univision, Skymedia, DDISH телевизэд хөдөлгөөнийг сурталчилсан баннер байршуулах ажлыг зохион байгуулсан. Мөн 2018 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр “Гэрэлт гудамж”-нд урлагийн оддыг оролцуулан тоглолт зохион байгуулж, залуусыг нэгдүүлсэн.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах хүрээнд 41 телевиз, 9 радиогоор 374 удаагийн нэвтрүүлэг, зочны цаг, хэлэлцүүлэгт алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын албан хаагч нар оролцож, мэдээ, мэдээлэл өгснийг 318,720 хүн үзжээ. Мөн 8 сонинд 24, 76 сайтад 45 мэдээ, мэдээлэл, сурвалжлага нийтлүүлсэн байна.³

Монгол Улсын Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар хамтран кибер орчинд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор **“Цахим орчинг зөв болгоё”** ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгааны аяныг 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 27-ны өдрийн хооронд олон нийтийн сүлжээний facebook, twitter, Instagram орчинд зохион байгууллаа.

Байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд сошиал, медиагийн 20 видео контент бүтээж телевиз, цахим сүлжээгээр түгээсэн нь давхардсан тоогоор

² Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл. 2019 он

³ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл. 2019 он

4,460,882 хүнд хүрч, 2,367,700 хүн үзэж, 34,748 хүн бусадтай хуваалцаж, 122,062 хүнд таалагдаж, 89642 эерэг сэтгэгдэл бичсэн байна.⁴

Мөн иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг бүхий 50 бүтээлч постер /зурагт хуудас/ цахим сүлжээнд нийтэлсэн нь 1,073,922 хүнд хүрч, 11,359 хүнд таалагдаж, 4516 хүн бусадтай хуваалцан, 1955 эерэг сэтгэгдэл үлдээсэн байна.

Өсвөр насны хүүхэд, залуусыг цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох, цахим харилцааны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулсан.

“Зөвийг Түгээ” хэмээх нэгдсэн аянд Faro Foundation Mongolia төрийн бус байгууллага нь нэгдсэн аяны хэрэгжилт, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа, түүнд ашиглах цахим постер, видео хичээлүүдийг бэлтгэх үүрэг гүйцэтгэсэн.

Нэгдсэн аян 10 дугаар сарын 1-ний өдрөөс 25-ны өдрийг хүртэл амжилттай хэрэгжсэн ба уг хугацаанд 40 цахим постер /Хавсралт 1/, 15 видео хичээлийг нийгмийн сүлжээнд Faro Foundation Mongolia болон Digital Literacy Mongolia цахим хуудсаар олон нийтэд түгээн нийтэлсэн.

Цахим постеруудаар интернэт, нийгмийн сүлжээг зөв зохистой хэрэглэх, цахим орчны давуу болон сул талыг таниулан ойлгуулах, өөрийн хувийн мэдээллийг нууцлах, цахим аюулгүй байдлыг сахих, мэдээллийн үнэн зөвийг таних, зөв шүүмжлэлт сэтгэлгээг дэмжих, цахим ертөнц болон нийгмийн сүлжээн дэх эерэг харилцаа хандлагыг хөгжүүлэхэд уриалсан болно.

Цахим боловсролын хөтөлбөрийн сэдвийн хүрээнд олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх зорилгоор нийт 18 видео хичээлийг дүрсжүүлэн нийгмийн сүлжээнд нийтэлсэн. Хүний анхаарал төвлөрөх хугацааг харгалзан үзэж дүрс бичлэг тус бүрийн үргэлжлэх хугацааг 1 минутаас хэтрүүлэхгүй байхаар тооцоолон хийсэн ба олон нийтэд хүргэхийн тулд сонирхолтой зураглалаар дүрсжүүлж, 2D болон график зургийг хослуулсан ба үүндээ олны танил мөн нийгмийн нөлөөлөл бүхий хүмүүсийг оролцуулан тоглуулсан болно.

Аяны хүрээнд Faro Foundation Mongolia нь Цахим боловсролын хөтөлбөрийг олон нийтэд танилцуулснаар **“Зөвийг Түгээ”** аяны үйл ажиллагааг эхлүүлсэн. ICT EXPO 2019 гурван хоног үргэлжилсэн ба давхардсан тоогоор 500 гаруй хүнд Цахим боловсролын хөтөлбөрийн талаар мэдээлэл хүргэсэн байна.

“Зөвийг Түгээ” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд нийгмийн сүлжээний зохистой хэрэглээг бий болгох, цахим орчин дахь эерэг харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, цахим аюулгүй байдлыг хангах, аливаад хандах зөв шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх зэрэг олон талт асуудлаар ухуулга, нөлөөллийн ажил хийсэн.

Нөлөөллийн аяны үр дүн, үзэгчдийн хандалт, тэдгээрийн үзүүлж буй хариу үйлдлээс дүгнэн үзэхэд, мэдээлэл дутуугаас болж хувийн нууцлалаа алдах, эх сурвалж нь тодорхойгүй худал мэдээллийг цааш нь түгээх, хэт туйлшрах зэрэг

⁴ Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл. 2019 он

сөрөг асуудлууд нийгмийн сүлжээнд бий болж эргээд өөрсдөө хохирох хандлага их байна.

Олон нийтэд түгээсэн мэдээлэл бүхий контентуудаар цахим боловсролыг таниулан, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох, цахим харилцааны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд том түлхэц болж, амжилттай хэрэгжиж өндөрлөсөн. Аяны үйл ажиллагаатай уялдаа бүхий дагалдах хөтөлбөр, төлөвлөгөөт сургалтууд нь олон нийт хэрхэн хүлээн авч, ач холбогдолтойг ойлгосны үр дүн юм.⁵

Дүгнэлт

- Нөлөөллийн арга хэмжээнүүд нь кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлыг тодорхой хугацааны дотор тогтоон барих, бууруулах, иргэдийг сэдэлжүүлэхэд илүү үр дүнтэй бөгөөд уг арга хэмжээг зогсоосноор энэхүү гэмт явдал өсөх, эсрэгээрээ энэ гэмт явдлын талаар мэдээлэх байдал буурах хандлагатай байна.
- Хүүхдийн цахим хэрэглээнд хяналт тавих, зөв зохистой хэрэглээ, соёлтой хэрэглээг төлөвшүүлэхэд дээрх нөлөөллийн арга хэмжээний зөвлөмжийг тогтмол мөрдлөг болгох хандлагатай байна.
- Нөлөөллийн арга хэмжээнүүд нь олон нийтэд кибер орчин дахь гэмт явдал, ялангуяа, хүүхдийн эсрэг гэмт явдал, түүний хор уршгийн талаар тодорхой ойлголт өгч, цаашид хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг илчлэх, түүнтэй үл эвлэрэх соёл, хандлага төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулсан гэж үзэж болохоор байна.
- Гадаадын улсын сайн туршлагыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх, нийгмийн бүлэг, хэсэгт чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх ажилд хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглах шаардлагатай байна.

Санал

- Кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлыг бууруулах чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Кибер орчныг ашиглаж хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улс, бүс нутгийн байгууллага, сүлжээнд нэгдэх, хамтран ажиллах;
- Энэ гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлд иргэдийг оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн шийдлийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.
- Кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдалтай үр дүнтэй тэмцэж байгаа гадаадын улсын туршлагыг судалж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.
- Энэ гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, кибер орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын хор уршгийн талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

⁵ Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт судалгааны тайлан. НҮБ-ын Хүүхдийн сан, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль. УБ., 2021. 34 дэх тал

Ашигласан материал

Нэг.Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). 2015
- Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016
- Хүүхэд хамгааллын тухай хууль. 2024
- Кибер аюулгүй байдлын тухай хууль. 2021
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. 2021

Хоёр.Судалгааны тайлан, ном бүтээл

- Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан. ГБХЗХГ. 2018
- Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар “Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, мэдээлэл технологийн зохистой хэрэглээг дэмжих ажлын тайлан”. УБ, 2018
- О.Мягмар. Сэтгэл судлал, хүүхэд бүрийн хөгжил. УБ., 2016

Гурав. Байгууллагын мэдээлэл, судалгаа

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан
- Улсын Ерөнхий прокурорын газрын тайлан
- Цагдаагийн ерөнхий газрын тайлан
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тайлан
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлан

АМИА ХОРЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭЖ БАЙГАА ШАЛТГААН, НӨХЦӨЛ

CAUSES AND CONDITIONS THAT LEAD TO SUICIDE

Б.Нямгэрэл

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахмад

Товч агуулга: "Suicide or suicidal behavior" буюу амиа хорлох гэдэг нь аливаа хүн санаатайгаар өөрийн амийг таслах үйл юм. Амиа хорлох үйлдэл хийхэд биологи, нийгэм, сэтгэлзүйн хүчин зүйлс нөлөөлдөг. Амиа хорлосон хүмүүсийн удамд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн хүн байх, бие махбодын тавилан муутай өвчнөөр өвчлөх, улирлын байдал, ажилгүйдэл, хүн хоорондын таагүй харилцаа, сэтгэлзүйн гэмтэл, стресс бухимдлаа буруугаар тайлах, амьдралын зарим тааламжгүй нөхцөл байдлыг даван туулах чадваргүй байх зэрэг хүчин зүйлс нь амиа хорлох нөхцөл байдалд хүргэдэг.

Бусдыг амиа хорлоход хүргэх үйлдлийг Монгол Улсын Эрүүгийн хуульд "эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн" гэж томъёолж, гэмт хэрэгт тооцсон байна. Судлаач миний бие энэхүү өгүүлэлдээ Монгол Улсад бүртгэгдэж буй "бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг"-ийн нөхцөл байдлыг бусад орнуудтай харьцуулсан байдлаар судалж, шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулахыг зорьсон.

Abstract: "Suicide or suicidal behavior" is an intentional act of taking someone's own life. Biological, social, and psychological factors contribute to suicidal behavior. Factors such as being a person who has committed suicide or attempted suicide in the family of suicidal people, suffering from an illness with a poor prognosis, seasonality, unemployment, bad interpersonal relationships, psychological trauma, misrepresenting stress and frustration, and the inability to cope with some unpleasant life situations things lead to suicidal situations.

In the Criminal Code of Mongolia, the act of causing others to commit suicide is defined as "the act of committing suicide due to constant abuse, insult, beating, torture, or intimidation of a person under one's control due to property, position, family relationships, or other circumstances." is considered a crime. In this article, I, the researcher, studied the situation of "crimes that cause others to commit suicide" recorded in Mongolia in a comparative manner with other countries, and aimed to develop scientific conclusions and suggestions.

Түлхүүр үгс: Амиа хорлолт, шалтгаан нөхцөл, хууль зүй, Монгол Улс, олон улсын түвшин, нийгмийн хүчин зүйл, биологийн хүчин зүйл, сэтгэл зүй.

Keywords: Suicide, causes, law, Mongolia, international level, social factors, biological factors, psychology.

Олон улсын эмнэлгийн нэр томъёогоор зориуд амиа хөнөөх үйлдлийг суицид /suicide/, зориуд амиа хорлох оролдлого хийх үйлдлийг парасуицид /parasuicide/ гэж нэрлэдэг. Парасуицидыг өөрөөр зориуд өөртөө хор хүргэх, зориуд

өөрийгөө гэмтээх, өөртөө зориуд шарх үүсгэх, зориуд өөрийгөө хордуулах гэх зэргээр тайлбарладаг.

Амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх олон улсын байгууллагаас (IASD) гаргасан мэдээллээр энэ зуунд дэлхий дээр ойролцоогоор 5 сая хүн амиа егүүтгэж нас барсан байх бөгөөд энэ нь нийгмийн эрүүл мэндэд тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Амиа хорлолтын тархалтыг олон улсын түвшинд авч үзвэл 100.000 хүн амд ногдох амиа егүүтгэгчдийн тоо 25-аас дээш байхыг хамгийн өндөр, 10-аас доош байхыг доод түвшинд тооцдог. Амиа егүүтгэгчдийн энэ интенсив үзүүлэлтийг нарийвчлан үзвэл, амиа хорлогчдын тоо Скандинавийн хойг, Швейцар, ХБНГУ, Австри болон зүүн Европын орнуудад, үүний зэрэгцээ Япон Улсад хамгийн өндөр түвшинд, Испани, Ирланд, Египет, Нидерланд Улсад хамгийн бага түвшинд, харин АНУ-д дундаж түвшинд байна.

Сүүлийн үеийн мэдээллээс үзэхэд амиа хорлолтын хамгийн их тоо Унгар Улсад байх бөгөөд жилдээ 100.000 хүнд 40 тохиолдол, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 36, Испани Улсад хамгийн бага буюу 4 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна (Б.Туяа, 2023).

АНУ-ын Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн (National institute of Mental Health)-ийн 2021 оны тайлангаас үзэхэд, АНУ-д нийт амиа хорлолтын түвшин 2000 онд 100.000 хүн тутамд 10.4 байсан бол 2018 онд 100.000 хүн тутамд 14.2 болж 35.2%-иар өсөж, 2019 онд 100.000 хүн тутамд 13.9 болж буурч, 2020 онд 13.5 болж буурсан. Харин 2021 онд АНУ-д амиа хорлолтын нийт түвшин 100.000 хүн тутамд 14.0 болж өссөн байна (Health, 2022).

Амиа хорлох болон амиа хорлох оролдлого хийсэн хүмүүсийг хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 3 дахин илүү амиа егүүтгэдэг бол, эмэгтэйчүүд харин амиа егүүтгэх оролдлогыг эрчүүдээс 3 дахин илүү хийдэг нь тогтоогджээ. Судалгаанаас үзэхэд нийт амиа егүүтгэгчдийн 80.9% нь эрэгтэйчүүд байсан бол амиа егүүтгэх оролдлого хийгчдийн 56%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2024 оны мэдээнээс үзэхэд, Монгол Улс 2023 онд амиа хорлох тохиолдлын тоо 100.000 хүн амд 19.05 гэж мэдээлсэн байна (Organization, 2023).

Дээрх мэдээллээс үзэхэд Европ тивд Унгар Улс, харин Ази тивд Хятад, Монгол, Япон Улс амиа хорлосон хүмүүсийн тоогоороо хамгийн өндөрт орж байна. Мөн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол илүү их амиа егүүтгэдэг байхад, эмэгтэйчүүд харин амиа хорлох оролдлогыг эрчүүдээс илүү хийдэг байна.

Биологи, нийгэм, сэтгэл зүйн олон сөрөг хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээс болж хүмүүс амиа егүүтгэдэг буюу амиа егүүтгэх оролдлого хийдэг. Эдгээр сөрөг хүчин зүйлсийг байгаль, биологийн хүчин зүйлс, нийгмийн хүчин зүйлс, сэтгэл зүйн хүчин зүйлс гэж 3 бүлэгт хуваан авч үздэг. Үүнд:

- Байгаль биологийн хүчин зүйлс - удамшлын, насны, хүйсийн, биохимийн, улирлын болон бусад биологийн хүчин зүйлс;
- Нийгмийн хүчин зүйлс - нийгэм-эдийн засгийн, соёлын, шашны, ажилгүйдлийн болон бусад нийгмийн хүчин зүйлс;

- Сэтгэл зүйн хүчин зүйлсэд сэтгэлийн дарамтад орох, сэтгэл зүйн хямралд орох, сэтгэцийн зарим өвчнөөр өвчлөх болон бусад сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэг болно.

Амиа егүүтгэгчдийн амиа хорлох нэг үндсэн шалтгаан бол сэтгэцийн өвчин байдаг. Сэтгэцийн өвчин бол хамгийн ихээр амиа хорлох төрх үйлийг нөхцөлдүүлэгч хүчин зүйл юм. Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн амиа хорлолтын байдлыг үзэхэд эрүүл хүний амиа хорлолтоос 10 дахин их эрсдэлтэй байдаг.

Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн дотроос сэтгэл гутрах эмгэг, архи, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх эмгэг, шизофрени, хоёр туйлт эмгэгийн үед амиа хорлох төрх үйл харьцангуй элбэг тохиолддог. Эдгээрээс хамгийн их тохиолддог нь сэтгэл гутралын эмгэг байдаг. Гэхдээ бүх сэтгэцийн өвчтэй хүмүүс амиа хорлож нас бардаггүй бөгөөд, харин шизофренитэй гэж оношлогдсон хүмүүсийн 10-15% нь солиорлын үедээ илүү их амиа хорлож нас бардаг байна.

Е.Н.Hoyer, R.W.Licht нарын сэтгэл хөдлөлийн эмгэгтэй хүмүүсийн дунд хийсэн 1995 оны судалгаагаар удамдаа амиа хорлох оролдлого хийж байсан гэсэн анамнезтай хүмүүст амиа хорлох эрсдэл нь өндөр байдаг гэдэг нь статистикаар тогтоогджээ. Барууны орнуудад амиа егүүтгэж нас барсан хүмүүсийн ойролцоогоор 90% нь сэтгэцийн өвчтэй байсан ба харин Азийн орнуудад, тухайлбал: Бүгд Найрамдах Хятад Ард Улсад амиа хорлох төрх үйлдэл нь сэтгэцийн өвчинтэй хамаарал бага байсан.

Амиа егүүтгэх болон амиа хорлох оролдлогын шалтгааныг нь судалж үзвэл, залуучууд, өсвөр үеийнхэнд илүү тохиолдож байна гэсэн тооцоо гарчээ. Цаашилбал, амиа хорлох оролдлого хийх нь амиа бүр мөсөн хөнөөхөөс 10-20 дахин илүү тохиолддог. Хувь хүний түвшинд амиа хорлолтын шалтгааныг судалж үзэхэд, гэмтэл осол, сэтгэлийн маш хүнд цохилтод орсны улмаас, мөн сэтгэцийн өвчин буюу аз жаргалгүй байдлаас болоод амиа егүүтгэдэг байна гэсэн дүн гарсан. Суицид болон парасуицид нь гэр бүл болон найз нөхдийн хүрээнд сөрөг сэтгэл зүйн үр дагаврыг авчирдаг. Парасуицид тохиолдсон хийсэн гэр бүлд ихэвчлэн сэтгэл түгшилт их байх ба улмаар парасуицидад өртөх төрх үйл их байдаг.

Hatcher-Kay, King нарын судалгаагаар амиа хорлох оролдлого хийсэн залуучуудын 80%, амиа егүүтгэгчдийн 90% нь сэтгэцийн эмгэгтэй байсан болох нь тогтоогджээ.

Уг амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон хүмүүсийн сэтгэцийн эмгэгийн төрлийг авч үзэхэд сэтгэл гутралын эмгэг, архи, мансууруулах бодис хэрэглэх эмгэг, төрх үйлийн эмгэг, сэтгэл түгших эмгэг элбэг тохиолдож байсан ба амиа егүүтгэх болон амиа хорлох оролдлогын эрсдэлт хүчин зүйл ижил байдаг гэж тогтоожээ.

Япон Улсын судлаач Taisuke Kitamura болон Keiichi Tanaka нарын амиа хорлох оролдлого хийсний улмаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлж буй хүмүүсийн дунд хийсэн судалгаагаар эмийн бодисоор өөрийгөө хордуулсан нь нийтлэг тохиолдсон ба үүнээс 52% нь эмэгтэйчүүд, 39% нь эрэгтэйчүүд байсан байна. Эндээс үзэхэд, амиа хорлох болон амиа хорлох оролдлого хийгчдийн гол үндсэн шалтгаан нь сэтгэцийн өвчин болох нь тодорхой болж байна. Тэр дундаа сэтгэл гутрах эмгэгийн үед амиа хорлох явдал элбэг тохиолддог байна. Taisuke Kitamura, Keiichi Tanaka нарын Япон Улсад хийсэн судалгаагаар амиа хорлох нь эрчүүдэд эмэгтэйчүүдээс илүү байх бөгөөд эрчүүд нь ялангуяа дүүжлэх аргыг сонгосон байхад, эмэгтэйчүүд

харин эмийн бодисоор өөрсдийгөө хордуулах нь элбэг байсан байна. Насны үечлэлээр нь үзвэл, бүх насныханд эмийн бодисоор амиа хорлох оролдлого хийх нь элбэг байсан. Үүнээс, 10-40 насныханд өндрөөс үсрэх, 50-иас дээш насныхан дүүжлэх аргыг сонгосон гэсэн тооцоо гарсан байна.

Америкийн Нэгдсэн Улсын статистикийн 2022 оны мэдээгээр өөрийгөө буудаж амиа егүүтгэх нь 52.1%, өөрийгөө дүүжилж, боомилох аргаар амиа егүүтгэх нь 22.2%, эмийн бодисоор өөрийгөө хордуулсан нь 17.6%, бусад аргаар 8.1% байна. Хүйсээр нь авч үзвэл, өөрийгөө буудах нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдэд их (57.6%), харин эмэгтэйчүүдэд эмийн бодисоор өөрийгөө хордуулах нь их (39.1%) буюу 3 дахин их тохиолддог юм байна. Мөн залуучууд, хүүхдүүдийн дунд (5-24 нас) амиа егүүтгэл нь эрс ихэссэн байхад насанд хүрэгчдэд (45-85 нас) амиа егүүтгэл нь эрс буурсан байна гэсэн дүн гарчээ.

Англи улсад амиа хорлох оролдлогын 85% нь эмийн бодисоор өөрийгөө хордуулсан байсан ба эрэгтэйчүүдийн 75% нь, эмэгтэйчүүдийн 25% нь архи хэтрүүлэн хэрэглэж, өөрийгөө хордуулж амиа хорлох оролдлого хийсэн байна. Өөрийгөө гэмтээж амиа хорлох оролдлого хийсэн нь 5-15% байсан бөгөөд залуучуудын дунд шуугаа зүсэж амиа хорлох оролдлого хийх нь элбэг байсан байна.

Харин манай оронд 1997-2012 онд судалгаагаар өөрийгөө боомилох аргаар эрэгтэйчүүд (51.1%) амиа егүүтгэдэг бол эм болон бусад бодисоор өөрийгөө хордуулах аргаар эмэгтэйчүүд (45.7%) амиа хорлох оролдлого хийдэг гэсэн тоо баримт гарсан.

2010 онд эхэлсэн Грекийн санхүүгийн хямралын эхний дөрвөн жилд амиа хорлолт 45 хувиар өсжээ. Жилд дунджаар 328 хүн амиа хорлодог байсан бол 2011 онд энэ тоо 477 болон өссөн гэж Афинд байрладаг “Климака” байгууллага албан ёсоор мэдэгдсэн юм. 2012, 2013 онд энэ үзүүлэлт өссөөр байсан гэж тухайн байгууллагаас гүйцэтгэсэн судалгаанд дурджээ. Гэсэн хэдий ч, Грек Улсад амиа хорлолт өссөн боловч Грек Улс нь Европын улсуудын дунд амиа хорлолт бага гарч буй улсын нэгт орсон хэвээр байна. Ядуурал, ажилгүйчүүдийн тоо эрс өссөн энэ улсад амиа хорлох хэрэг өсөж буй нь эдийн засгийн хатуу бодлоготой холбоотой ажээ.

Эдгээрээс дүгнэж үзэхэд, дэлхий дахинд амиа хорлох явдал нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байгаа ба манай улсад ч мөн адил амиа хорлох явдал нь сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн тулгамдсан асуудлын нэг болсон байна. Иймд амиа егүүтгэх болон амиа хорлох оролдлогоос урьдчилан сэргийлж, иргэдийн сэтгэцийн өвчнийг эрт оношилж эмчлэх нь амиа хорлолтын түвшинг бууруулахад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Амиа хорлолтыг зарим улс оронд гэмт хэрэгт тооцдог бол зарим улс оронд гэмт хэрэг гэж үздэггүй. Тухайлбал,

- Канад Улсын Эрүүгийн хуулийн 241"Б" хэсэгт "Хэн нэгэн этгээд бусдыг амиа хорлоход өдөөн түлхсэн буюу амиа хорлоход тусалсан нь тогтоогдсон бол 14 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан.

- Бельги Улсад 2006 онд эвтанази буюу эдгэшгүй хүнд өвчтэй өвчтөний хүсэлтээр эмчилгээг зогсоож, түүний өөрийн хүсэлтээр амийг нь хороох үйлдлийг хууль ёсны болгож, хүлээн зөвшөөрсөн байна.

- Бүгд Найрамдах Хятад Ард Улсад амиа хорлоход хүргэсэн болон завдсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Жилд дунджаар 100.000 хүнд 22, 23 хүн амиа хорлодог бөгөөд эмэгтэйчүүд нийт амиа хорлосон тохиолдлын 14.8 хувийг эзэлдэг байна.

- Япон Улс нь дэлхийд амиа хорлолтын түвшнээрээ дээгүүр байр эзэлдэг. Нийт амиа хорлосон тохиолдлын 71 хувийг эрэгтэйчүүд, 29 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Японд өнгөрсөн онд сүүлийн 15 жилийн хугацаанд анх удаагаа амиа егүүтгэгчдийн тоо 30 мянгаас илүү гарсангүй гэж NHK телевизийн мэдээлжээ. Япончуудын амиа егүүтгэхэд хүргэдэг хамгийн гол шалтгаан нь эрүүл мэндийн шалтгаан байдаг. Үүний дараа санхүүгийн болон гэр бүлийн шийдвэрлэгдээгүй асуудлууд ордог байна. Мэргэжилтнүүдийн тооцоолсноор сүүлийн жилүүдэд 15 минут тутамд Японы нэг иргэн амиа хорлож байгаа гэх бөгөөд 2009 он хүртэл Япон Улс Азийн орнуудын дунд амиа хорлогсдынхоо тоогоор тэргүүлж байв. Харин одоо энэхүү үзүүлэлтийг Өмнөд Солонгос Улс тэргүүлж, Япон удаалж байна.

- Франц, Люксембург, Нидерланд, Колумб улсад эвтаназийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд Колумб Улсад хамгийн анх 1997 оны 5 дугаар сард эвтаназийг хүлээн зөвшөөрсөн байна.

- Дани Улсад амиа хорлоход хүргэсэн бол 3 хүртэл жилийн хорих ял оногдуулдаг.

- Герман Улсад эвтаназийг гэмт хэрэг гэж бөгөөд үүнийг "Mercy killing" гэж нэрлэдэг.

- Шинэ Зеланд Улсын Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлд "Хэн нэгэн этгээд бусдыг амиа хорлоход өдөөн түлхсэн буюу амиа хорлоход тусалсан бол 6 хүртэл жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан байдаг.

- АНУ-ын Oregon, Washington DC болон Montana гэсэн 3 мужид эвтаназийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Oregon мужид 2010 оноос хойш 58 хүн хүсэлтээ гаргасны 15 хүнийг хүлээн зөвшөөрсөн байна. Судалгаагаар эмнэлгийн практикт эдгэрэх боломжгүй өвчтөнүүдийн 60 хувь /Physician-Aided dying/ эвтаназийг хүсдэг байна.

- ОХУ-д амиа хорлолтын дийлэнх хувь нь архидалтаас болж гарсан байдаг. 1990 онд 100.000 хүнд 40 хүн амиа хорлодог байсан бол 2013 онд 27.1 болж буурсан.

Монгол Улсад хувьд амиа хорлогчдын 80 хувь нь эрчүүд байна. Өнөөдөр манай оронд амиа хорлохоос урьдчилан сэргийлэх асуудал нь бусад орнуудтай харьцуулбал эрүүл мэндийг хамгаалах салбарын хүрээнд хамрагддаггүйгээр барахгүй, уг асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлоогүй, эрх зүйн орчин боловсронгуй болоогүй, амиа хорлохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлдэггүй нь уг үзэгдлийн тархалтад нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Монгол Улсын 2002 онд батлагдсан хэрэгжсэн Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлд бусдыг амиа хорлоход хүргэсэн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцсон.

2002 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан "Амиа хорлох болон учрал, золгүй байдлын улмаас хүний амь нас хохирсныг шалгах журам тогтоох" тухай 373/220 дугаар тушаалаар амиа хорлох болон учрал, золгүй байдлын улмаас хүний амь

нас хохирсон тохиолдолд 2002 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйл (бусдыг амиа хорлоход хүргэх)-ээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байхаар тогтсон. Энэ тушаалаар хүний амь нас хохирсон хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгахдаа шинжээчийн дүгнэлт нэн даруй гаргуулж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагааг шуурхай хийж гүйцэтгэн хэргийн бодит байдлыг тогтоосны эцэст хэргийг шийдвэрлэхийг цагдаагийн байгууллагад даалгасан юм.

2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйлд дээрх үйлдлийг “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэж нэршлийг өөрчлөн хуульчилсан.

Хүснэгт 1. Амиа хорлоход хүргэх үйлдлийг
Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчилсан байдал (хууль, 2015)

Эрүүгийн хууль (2002 он)	Эрүүгийн хууль (2015 он)
95 дугаар зүйл. Бусдыг амиа хорлоход хүргэх 95.1 Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 1.Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Амиа хорлож нас барсан хүмүүсийн 33 буюу 8.1 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байх бөгөөд тэдэнд нийтлэг ажиглагдаж буй шинж нь гар утас, компьютер болон дэлгэцийн донтолтод хэт автах, мөн гэр бүлийн маргаан, таагүй харилцаа, суурь хүмүүжил, ёс суртахууны доголдол, хайр сэтгэлийн асуудалтай холбоотой байна.


Нийслэл болон орон нутагт бүртгэгдсэн амиа хорлосон тохиолдлуудыг насны бүлгээр ангилан, хэдэн насанд ямар шалтгааны улмаас зонхилон үйлдэгдсэн байгааг дараах хүснэгтээс харуулъя.

2019-2023 онд улсын хэмжээнд нийт 1878 хүн амиа хорлож нас барсан нь жилд дунджаар 375, сард 31 хүн нас барсан .



Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд амиа хорлогсдын 82.8 хувь нь эрэгтэй, 17.2 хувь нь эмэгтэй хүн байгаа бол нас барсан хүмүүсийг насны байдлаар нь


авч үзвэл 1268 буюу 67.5 хувийг 18-44 насны иргэд эзэлж байна. Амиа хорлож нас барсан хэрэг учралыг нутаг дэвсгэрийн байдлаар нь үзвэл:



/2019-2023 он/

Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Өвөрхангай аймагт амиа хорлож нас барах хэрэг учрал хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Нийслэлийн хэмжээнд амиа хорлож нас барагсдын тоон үзүүлэлт дараах байдалтай байна.




Хүн амын нийслэл рүү шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд маш их идэвхэжсэн. Энэ нь орон нутгаас нийслэлд ирсэн иргэдэд ажил олдохгүйгээс амьжиргааны эх үүсвэргүй болох, бичиг баримтын зөрчилтэйн улмаас нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байдалд орох, хөдөлмөр эрхэлж чадахгүй байх, амьдралын өртөг өндрөөс ядууралд орох, гэр бүлийн хүмүүсээ тэжээх чадваргүй болох байдалд орж байгаа нь архи уух, гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдох, амиа хорлох хүртэл сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Нийслэл хотод шилжин ирэгсдийн дийлэнх нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт суурьшсан бөгөөд эдгээр дүүрэгт гэмт хэрэг, зөрчил, золгүй байдлаар болон амиа хорлон нас барсан хүмүүсийн тоо өндөр байгаа нь дээрх шалтгаантай холбож үзэх магадлалтай юм.

Амиа хорлох нь өөрийгөө боомилох, өндрөөс унах байдлаар ихэвчлэн гэр, орон сууцанд үйлдэгдэж байна.

Үйлдэгдсэн байдал



Хүснэгт 2. Монгол Улсад амиа хорлосон хүмүүсийг насны ангилал болон амиа хорлосон шалтгаанаар ангилан нь харуулбал

Нийслэлд	Нас	Орон нутагт
Гэр бүлийн таагүй харилцаа, гэмт хэрэгт холбогдсон, сэтгэл гутрал	10-15	Гэр бүлийн таагүй харилцаа
Хайр сэтгэлийн асуудалтай, хувь хүний ёс суртахуун, суурь хүмүүжил	16-20	Архидалт, гэр бүлийн таагүй харилцаа
Сэтгэл гутрал, мөрийтэй тоглоомд донтсон, хувь хүний ёс суртахуун, суурь хүмүүжил	21-25	
Гэр бүлийн таагүй харилцаа, архидалт, сэтгэл гутрал	26-30	Архидалт, гэр бүлийн таагүй харилцаа
Гэр бүлийн таагүй харилцаа, архидалт, сэтгэл гутрал, өр зээл	31-35	Архидалт, гэр бүлийн таагүй харилцаа, гэмт хэрэгт холбогдсон
Архидалт, сэтгэл гутрал, сэтгэцийнөөрчлөлт	36-40	Архидалт, сэтгэл гутрал, хувь хүнийёс суртахуун, суурь хүмүүжил
Архидалт, сэтгэцийн эмгэг, гэр бүлийн таагүй харилцаа	41-45	Архидалт, сэтгэцийн эмгэг
Сэтгэл гутрал, архидалт, гэр бүлийн таагүй харилцаа	46-50	Архидалт, сэтгэл гутрал
Архидалт, сэтгэл гутралд орсон	51-55	Архидалт, ажилгүйдэл, сэтгэл гутрал
Насны доройтол, сэтгэл гутрал, архидалт	56-аас дээш	Архидалт, сэтгэл гутрал, хүнд өвчинтүссан

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар амиа хорлолт нь 15-34 насны хүмүүсийн нас баралтын тэргүүлэх шалтгаан бөгөөд нийт нас баралтын шалтгаануудаас 12 дугаарт эрэмбэлэгдэж байгаа бол манай улсын хувьд 6 дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн амиа хорлолтын 79 хувь нь бага болон дунд орлоготой

улс оронд үйлдэгддэг бөгөөд амиа хорлолт нь 15-29 насны хүмүүсийн үхлийн шалтгааны 2 дахь том хүчин зүйл болж байгааг онцолсон.

Дэлхийн 4 хүн тутмын 1 нь амьдралынхаа хугацаанд сэтгэцийн ямар нэг эмгэгт нэрвэгдэж байна. Дэлхийн хүн ам зүйн судалгааны байгууллагаас 2018 онд гаргасан судалгаагаар улс орнуудад бүртгэгдэж буй амиа хорлолтын нийтлэг шалтгаан нь хүн амын сэтгэл гутрал, ядуурал, шашин соёл, хувь хүмүүсийн суурь хүмүүжил зэрэг олон төрлийн хүчин зүйлээс хамааралтай үйлдэгдэж байгааг дурдсан байдаг.

Монгол Улсын сүүлийн 10 жилийн статистик мэдээгээр хүн амын төрөлт, нас баралтын үзүүлэлтийг харьцуулан үзвэл хүн амын төрөлт жилд 45326-82839 байсан бол үүний 19.9-36.7 хувийг нь нас баралт эзэлж байна.

Манай улсад 2020 онд бүртгэгдсэн амиа хорлох тохиолдлыг ДЭМБ-ын 100 мянган хүнд ногдох аргачлалаар тооцоход 12.2 болж, энэ үзүүлэлтээрээ 184 орноос Чех Улстай нэг төвшинд буюу 140 дүгээрт эрэмбэлэгджээ. Энэхүү жагсаалтыг Үндэстнүүдийн хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүнд багтах Антигуа, Барбуда Улс 0.39 үзүүлэлтээр тэргүүлдэг бол Лесото Улс 72.4 гэсэн үзүүлэлтээр хамгийн сүүлд эрэмбэлэгдэж, хөрш Оросын Холбооны Улс 25.1 буюу 175 дугаарт, Бүгд Найрамдах Хятад Ард Улс 8.07 буюу 102 дугаарт бичигджээ.

Дүгнэлт

Амиа хорлолт нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар байна. Амиа хорлох зан үйл нь хүйс, насны бүлэг, газарзүйн бүс нутаг, нийгэм-улс төрийн орчинд ялгаатай бөгөөд янз бүрийн эрсдэлт хүчин зүйлүүдтэй харилцан холбоотой байдаг нь этиологийн нэг төрлийн бус байдлыг харуулж байна.

Эмнэл зүйн практикт амиа хорлохыг урьдчилан таамаглах үр дүнтэй алгоритм байхгүй ч эмнэл зүй, сэтгэл зүй, социологи, биологийн хүчин зүйлсийг таних, ойлгох чадварыг сайжруулах нь өндөр эрсдэлтэй хүмүүсийг илрүүлэх, эмчилгээг сонгоход тусална.

Сэтгэцийн эмгэгийн сэтгэлзүйн эмчилгээ, фармакологийн эсвэл нейромодуляцийн эмчилгээний тусламжтайгаар амиа хорлох зан үйлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Нэмж дурдахад, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээгээр амиа хорлохыг завдсан хүмүүсийг тогтмол хянах нь ирээдүйд амиа хорлох зан үйлээс урьдчилан сэргийлэх гол түлхүүр юм.

Амиа хорлох зан үйлийн тархвар судлалын талаарх мэдээлэл нь бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

Амиа бүр мөсөн хорлох нь Монгол Улсад болон дэлхийн хэмжээнд эрэгтэйчүүдийн дунд илүү түгээмэл байдаг бол үхэлд хүргэхгүй амиа хорлох зан үйл нь залуу, гэрлээгүй эсвэл сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйчүүдийн дунд илүү их тохиолддог.

Сүүлийн 10 жилийн хугацаанд амиа хорлохыг завдсан хүмүүст хийх эмчилгээ нэмэгдсэн хэдий ч амиа хорлох зан үйлийн өвчлөл нийгмийн хэмжээнд буураагүй байна.

Цаашид олон улсын судалгаанд тулгуурлан амиа хорлолтыг бууруулах арга замыг тодорхойлж, энэ чиглэлээр урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. 2002
- Монгол Улсын Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. 2016

- “Монгол хэлний тайлбар толь”, Я.Цэвэл, Улаанбаатар хот, 1962 он.
- “Сэтгэл судлалын сонгодгууд”, Ш.Батболд, Улаанбаатар хот, 2010 он.
- “Донтолт ба сэтгэл зүйн зөвлөгөө” Д.Мөнхцэцэг, Улаанбаатар хот, 2019 он.
- “Монголын нөхцөлд амиа хорлох болон амиа хорлох оролдлогын учир шалтгаан” нийтлэл. Б.Туяа, С.Бямбасүрэн, З.Хишигсүрэн, Б.Жаргал, Улаанбаатар хот.
- Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас гаргасан танилцуулга.
- <https://www.ncbi.nlm.nih.gov>
- <https://nli.gov.mn/>
- <https://www.nimh.nih.gov/>
- <https://www.who.int/>

ХИЙМЭЛ ОЮУН УХААН (AI) АШИГЛАН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛЖ БАЙГАА ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА

FOREIGN EXPERIENCES IN REDUCING TRAFFIC ACCIDENTS AND VIOLATIONS USING ARTIFICIAL INTELLIGENCE /AI/

О.Болорцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
лаборант, цагдаагийн дэд ахлагч, хууль зүйн магистр

Товч агуулга: Өнөө үед зам тээврийн осол, зөрчлүүд дэлхий даяар түгээмэл асуудал болж, олон хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна. Тиймээс улс орнууд зам тээврийн осол, зөрчлөө бууруулахад шинэ технологийг нэвтрүүлэхээр хүчин чармайлт гаргасаар хиймэл оюун ухаан (AI)-ыг ашиглаад багагүй хугацаа өнгөрч, энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад ихээхэн хувь нэмэр оруулж буй хувьслын нэг хэсэг болж байна.

Өгүүллийн зорилго нь зам тээврийн осол, зөрчлүүдийг бууруулахад хиймэл оюун ухааны технологи хувьсгал хийж буй талаар, түүнийг дэлхийн зарим улс орнууд хэрхэн ашиглаж байгаа туршлагыг танилцуулах бөгөөд Монгол Улсад эдгээр технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх боломжийг судлах явдал юм.

Abstract: Nowadays, road accidents and violations have become a common problem all over the world, posing a serious threat to the lives and health of many people. Therefore, as countries make great efforts to introduce new technologies to reduce road accidents and violations, artificial intelligence (AI) is becoming part of the revolution that is making a significant contribution to ensuring road safety.

The purpose of this presentation is to present how artificial intelligence technology has revolutionized the reduction of road accidents and violations, and how it is being used around the world, and to explore the possibility of introducing these technological solutions in Mongolia.

Түлхүүр үг: Хиймэл оюун ухаан (AI), осол, зөрчил, технологийн шийдлүүд, эдийн засгийн үр ашиг

Keywords: Artificial intelligence (AI), accidents, conflicts, technological solutions, economic benefits.

Зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт нь дэлхийн хэмжээнд жил бүр 1.35 сая хүний амь насанд хүрдэг бөгөөд энэ нь 5-29 насны хүмүүсийн нас баралтын тэргүүлэх шалтгаан юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахын тулд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нь хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, замын нөхцөлийг сайжруулах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байна. ДЭМБ-аас 2030 он гэхэд ослын улмаас хохирогчдын тоог хоёр дахин бууруулах зорилт тавьсан байна⁶. Монгол Улсад зам тээврийн ослоос жил бүр дунджаар 500-700 хүн амь насаа алдаж, олон мянган хүн бэртэж гэмтдэг. Тухайлбал, нийслэл болон орон нутагт жолоочийн буруугаа, явган зорчигчийн буруугаа, замын нөхцөл байдлаас шалтгаалан осол гарч, хурд хэтрүүлэлт, согтуугаар тээврийн хэрэгсэл

⁶ <https://www.bing.com/search?pc>

жолоодох, тээврийн хэрэгслийг анхаарал болгоомжгүй жолоодох байдлаас үүдэн гарсан ослоуд зонхилдог.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар бүх төрлийн 3214414 зөрчил бүртгэгдсэнээс 2890852 буюу 88.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчил эзэлж байна.

Монгол Улсын Замын хөдөлгөөний хууль тогтоомж зөрчсөн нийт зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Хүснэгт №1 Замын хөдөлгөөний хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн 2022 болон 2023 оны харьцуулалт

Зөрчил	2022 он	2023 он	Өсөлт, бууралт
Улс	2433344	2890852	18.8%
Орон нутаг	540983	744745	37.7%
Нийслэл	1892361	2146107	13.4%

2023 оны байдлаар нийслэл хотод 2146107 зөрчил бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн 2.846.780 хүнд 83 тэрбум 814 сая 568 мянга 500 төгрөгөөр торгож, 33691 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хас ч, торгож 8303 хүнийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн шийтгэврээр баривчлах арга хэмжээг тус тус авч нийт 2.888.774 зөрчил шийдвэрлэсэн байна. Зөрчлийн шийдвэрлэлт нь өмнөх оны мөн үеийнхээс 18.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.⁷

Хүснэгт №2 Зөрчил шийдвэрлэлтийн харьцуулалт

Он	Шийдвэрлэлт	Торгосон хүн	Эрх хасаж, торгосон	Шүүхээр баривчлуулсан
2022 он	2431984	2377193	46051	8740
2023 он	2888774	2846780	33691	8303

Монгол Улсад зам тээврийн осол нь нийгэм, эдийн засгийн аюул заналхийлэл бөгөөд үүнтэй холбоотой асуудал нь олон талт, комплекс байдлаар хариулт шаарддаг. Өнөөгийн байдлаар зам тээврийн ослын тоо өсөж, түүнтэй холбоотой хохирол, гэмтэл, нас баралт нэмэгдэж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) зам тээврийн ослын улмаас жил бүр 1.19 сая гаруй хүн нас барж, ялангуяа хүүхэд, залуучуудын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгааг онцолж байна.⁸

Зам тээврийн осол гэдэг зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг хэлнэ.⁹ Зам тээврийн ослын тодорхойлолт нь эх сурвалжаас хамааран бага зэрэг ялгаатай боловч олон улсын хэмжээнд нэг буюу хэд хэдэн тээврийн хэрэгсэл, явган зорчигч, дугуйчид оролцож, гэмтэл бэртэл, амь насаа алдахад хүргэсэн

⁷ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2023 он

⁸ <https://www.who.int/health-topics/road-safety-2024>

⁹ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль-2015 он

аливаа ослыг ихэвчлэн ойлгодог. Нэгдсэн Үндэстний Байгууллагын мэдээлснээр зам тээврийн ослыг үр дагаврын зэрэглэлээр нь ангилдаг, тухайлбал үхэлд хүргэсэн осол (үхлийн үр дагавар) болон үхэлд хүргэхгүй гэмтэл, хүнд болон хөнгөн гэмтэл гэж ангилдаг.¹⁰

Манай улсын хэмжээнд 2023 онд 25235 зам тээврийн осол бүртгэгдсэний 21053 буюу 83.4 хувь нь нийслэл хотод, 4182 буюу 16.6 хувь нь орон нутагт бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.¹¹

Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын 23.9 хувь нь Баянзүрх дүүрэг, 21.2 хувь нь Сонгинохайрхан дүүрэг, 18.0 хувь нь Хан-Уул дүүрэг, 15.1 хувь нь Сүхбаатар дүүрэг, 6.1 хувь нь Чингэлтэй дүүрэг, 1.1 хувь нь алслагдсан 3 дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгджээ.

Орон нутагт бүртгэгдсэн 4182 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн бөгөөд Төв аймаг хамгийн их буюу 602 бүртгэгдсэн нь нийт ослын 14.3 хувийг, Говь-алтай аймаг хамгийн бага буюу 47 бүртгэгдсэн нь нийт ослын 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт №3 Зам тээврийн ослын ангилал тоон үзүүлэлт-2023 он

Эд материалын хохиролтой зам тээврийн осол			Хүн гэмтсэн осол		
Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрахыг ойлгоно.			Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрахыг хэлнэ.		
Улс	Орон нутаг	Нийслэл	Улс	Орон нутаг	Нийслэл
21625	2568	19057	3610	1614	1996
Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.5 хувиар өссөн			Өнгөрсөн оны мөн үеийнхээс 19.4 хувиар өссөн		

Эдгээр статистик үзүүлэлтээс харахад эдгээр тоо нь олон хүний амь нас, эд хөрөнгө, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж буйг илтгэх томоохон илрэл бөгөөд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь манай улсын хувьд үндэсний хэмжээний анхаарал хандуулах цаг нь ирсэн асуудал мөн юм.

ХОУ (Хиймэл Оюун Ухаан, AI) нь: Хүнээс гадна компьютер болон техник хэрэгслүүдийг оюун санааны үүргийг гүйцэтгэх чадвартай болгох шинжлэх ухаан, технологийн салбар юм. Хиймэл оюун ухаан нь өгөгдлийг боловсруулах, мэдлэгийг олж авах, таамаглал дэвшүүлэх, суралцах чадвартай системийг бий болгодог.

Хиймэл оюун ухаан нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

1. Машины суралцахуй (Machine Learning): Машины суралцах нь алгоритм ашиглан мэдээллийг шинжлэх, загвар гаргах үйл явц юм. Энэ нь робот, программ хангамжийг амьдралд болон олон төрлийн асуудалд ашиглах боломжийг бүрдүүлдэг.

¹⁰ <https://www.undrr.org/understanding-disaster-risk/terminology-2024>

¹¹ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2022 он

2. Гүнзгий суралцахуй (Deep Learning): Гүнзгий суралцах нь машин суралцах технологийн салбар бөгөөд олон давхар мэдээллийн бүтцийг ашиглан нарийн түвшний шийдвэр гаргахад тусалдаг. Энэ нь зураг таних, хэлний боловсруулалт, авиа таних зэрэг салбаруудад өргөн хэрэглэгддэг.

3. Табигийн хэл боловсруулах (Natural Language Processing, NLP): ХОУ-ийн салбаруудын нэг бөгөөд хүний хэлний ойлголт, хэрэглээг компьютерын хувьд ойлгож боловсруулах чадвартай болгож өгдөг.¹²

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хиймэл оюун ухааныг ашиглах боломжууд¹³

1. Автопилот болон өөрөө удирддаг тээврийн хэрэгсэл: ХОУ-ийн технологи нь өөрөө удирддаг автомашины хөгжүүлэлтэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Энэ төрлийн тээврийн хэрэгслүүд замын хөдөлгөөнд оролцох явцад бусад жолоочид болон орчинтой харилцан уялдаа холбоо тогтоох боломжтой болдог.

2. Замын хөдөлгөөний урсгалын менежмент: ХОУ-ийн технологи ашиглан замын хөдөлгөөний урсгалыг хянах, удирдах, цагаа хэмнэх шийдлүүдийг гаргаж болох юм. Мөн олон нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг оновчтой удирдах, хүндрэлтэй нөхцөлд хурд, цаг хугацааг зөв тооцоолох боломжийг олгоно.

3. Замын аюулгүй байдлыг хянах систем: Хиймэл оюун ухааны тусламжтайгаар замын аюулгүй байдлыг хангахын тулд зорчигчдын үйлдлийг таамаглах, камерын болон бусад мэдрэгч төхөөрөмжүүдийн мэдээллийг ашиглан ослын эрсдэлтэй нөхцөлд урьдчилан сэргийлэх боломжтой болно.

4. Гаралт / оролтын замын системүүд: ХОУ-г ашиглан замын хөдөлгөөнд оролцогчдын хурд, байршил, чиглэл зэргийг бүртгэн хянаж, хурдны хязгаарыг шинэчилж, аюулгүй байдлыг хангах системүүдийг хөгжүүлэх боломжтой.

Энэхүү илтгэлдээ Гадаад туршлагаас Монголд хэрэгжих боломжтой технологийн шийдлийг дэвшүүлэв: ¹⁴

Хүснэгт №4- Гадаад орны туршлагаас Монгол Улсад хэрэгжих боломжтой технологийн шийдэл

Туршлага	Чиглэл	Үр дүн	Эдийн засгийн үр ашиг	Монголд нэвтрүүлэх боломж
АНУ: Замын хөдөлгөөний урсгалыг удирдах системүүд ¹⁵	АНУ-д замын урсгалыг удирдах системүүд нь камер, хиймэл оюун ухаан, мэдрэгч төхөөрөмжүүдийг ашиглан замын	Ослын тоо 20%-иар буурсан Замын түгжрэлийг 30%-иар бууруулж, зорчих хугацааг 25%-	Жилд 10 сая ам.долларын түлшний хэмнэлт, Замын хөдөлгөөний саатлаас үүдэлтэй	Монголд хотын төв хэсэгт энэ системийг турших, гол замд тохируулга хийх боломжтой.

¹² https://en.wikipedia.org/wiki/Artificial_Intelligence:_A_Guide_for_Thinking_Human-2024

¹³ <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0968090X21004241-2024>

¹⁴ <https://www.its.dot.gov/>- USA: Intelligent Transportation Systems (ITS) - US DOT (Department of Transportation),

https://commission.europa.eu/eu-regional-and-urban-development/topics/cities-and-urban-development/city-initiatives/smart-cities_en,

https://www.japanindustrynews.com/2023/05/japan-grants-first-level-4/Japan:_Autonomous_Vehicles_Technology_-_Japan_Ministry_of_Land,_Infrastructure,_Transport_and_Tourism

¹⁵ World Economic Forum. *AI for Smart Cities*. U.S. Department of Transportation *Traffic Management Solutions-2020*

	хөдөлгөөнийг хянаж, урсгалыг зохицуулдаг.	иар багасгасан.	алдагдлыг 15%-иар бууруулсан.	
Европын холбоо: Ухаалаг хотуудын ХОУ-д суурилсан замын хөдөлгөөний шийдлүүд ¹⁶	Европын холбоо ХОУ (Хурдны зохицуулалт, онцлог мэдрэгч)-д суурилсан ухаалаг хотын системүүдийг ашигладаг. Энэ нь жолоочийн зан төлөвийг судалж, замын аюулгүй байдлыг хангадаг.	- Замын осол 25%-иар буурсан (2019-2022 он, Стокгольм). - Хурд хэтрүүлэх тохиолдол 35%-иар багассан.	Агаарын бохирдлыг 18%-иар бууруулсан, Хурдны торгуулиас 15 сая евроны орлого олсон.	Монголд гол замуудад ухаалаг замын төслүүдийг хөгжүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад хэрэгтэй.
Япон: Автономит тээврийн хэрэгсэл ба ослоос сэргийлэх технологи ¹⁷	Япон улс бүрэн автономит тээврийн хэрэгслийг хөгжүүлж, аюулгүй байдлыг хангах автомат системийг туршиж байна.	- Токио хотод туршилтын төслийн хүрээнд ослын түвшин 40%-иар буурсан. - Зорчигчдын сэтгэл ханамжийн үзүүлэлт 90%-д хүрсэн.	Зорчигч тээврийн зардлыг 12%-иар хэмнэсэн, Автономит тээврийн хэрэгслийн хөгжүүлэлтээр 1.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан.	Монголд тээврийн хэрэгсэлтэй харьцах шинэ зохицуулалттай, ирээдүйн ухаалаг тээврийн хэрэгслийн зохицуулалтыг хөгжүүлэх боломжтой.
Өмнөд Солонгос: Камер ба хяналтын системүүд ¹⁸	Өмнөд Солонгос нь замын хөдөлгөөнийг хянах камер, лиценз унших технологи ашигладаг бөгөөд энэ нь орчин үеийн жолоочийн хариуцлагыг сайжруулдаг.	- Зөрчлийг бүртгэх хурд 40%-иар өссөн. - Ослын улмаас нас барах үзүүлэлт 15%-иар буурсан (2021-2023 он, Сөүл).	Жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлж, торгуулийн орлого 20%-иар өссөн, Нийтийн тээврийн ашиглалтын тоо 20%-иар нэмэгдсэн.	Монголд нийтийн тээврийн болон том замуудын хяналтыг камер ашиглан сайжруулах боломжтой.
Сингапур: Замын хөдөлгөөний үр ашгийг нэмэгдүүлэх "ухаалаг зам" төслүүд ¹⁹	Сингапурт "ухаалаг зам" систем нь хөдөлгөөний урсгалыг хянаж, зохицуулалт хийдэг. Үүний зэрэгцээ, систем нь ашиглалтын зардлыг бууруулж, аюулгүй байдлыг хангадаг.	Замын хөдөлгөөний урсгалын үр ашиг 35%-иар нэмэгдсэн. Замын хөдөлгөөний ачаалал 20%-иар буурсан.	Жилд 30 сая ам.долларын түлшний хэмнэлт, Тээврийн хэрэгслийн элэгдэл багассанаар замын засварын зардал 25%-иар буурсан.	Монголд замын ачаалал ихтэй газруудад "ухаалаг зам" төслүүдийг турших, үр ашигтай байдал бий болгох боломжтой.

Гадаад орнуудад хиймэл оюун ухаан болон автономит тээврийн хэрэгсэлтэй холбоотой туршлагууд нь зам тээврийн ослын улмаас нас баралтын тоог эрс бууруулж, эдийн засагт хэмнэлттэй, нийгэмд аюулгүй байдлыг нэмэгдүүлж байгаа нь Монгол Улсад эдгээр технологийн шийдлүүдийг нэвтрүүлснээр зам

¹⁶ European Commission *Smart Mobility in European Cities*. Bloomberg Philanthropies & WHO *Road Safety and Smart Technology-2022*

¹⁷ Toyota Research Institute. *Autonomous Vehicles: Global Trends and Impact*. Japan National Police Agency. *Autonomous Vehicle Trials-2022*

¹⁸ South Korean Ministry of Transportation. *AI for Road Safety: Case Studies*. Korea Transport Institute *Smart Traffic Solutions-2021*

¹⁹ Singapore Land Transport Authority. *Smart Mobility Solutions* Gartner Research *AI in Traffic Management-2023*

тээврийн ослын улмын нас баралт, бэртэж гэмтэх явдлыг бууруулах, хүний амь нас болон эдийн засгийн хохирлыг бууруулах өндөр ач холбогдолтой.

Эдгээр гаднын орны туршлагыг Монгол Улсад нутагшуулахад тулгамдах асуудал болон шийдэл гарцын талаар тайлбарлая.

Хүснэгт №5-Технологийг нэвтрүүлэхэд тулгамдах асуудал, шийдэл гарц

Тулгамдах асуудал	Шийдэл, гарц
1. Дэд бүтцийн дутагдал: Монголд замын хөдөлгөөний ухаалаг системүүдийг нэвтрүүлэх суурь дэд бүтэц хангалтгүй байна.	Ухаалаг системүүдэд тохирсон суурь дэд бүтцийг үе шаттайгаар хөгжүүлэх, Төсөлд орон нутгийн болон олон улсын хөрөнгө оруулалт татах.
2. Санхүүгийн хязгаарлагдмал байдал: Орчин үеийн технологиудын өндөр өртөгтэй холбоотой асуудал.	Хувийн хэвшил, төрийн хамтын ажиллагааны (PPP) загвараар хөрөнгө оруулалт хийх, Олон улсын зээл, буцалтгүй тусламж авах.
3. Техник, технологийн мэдлэг дутмаг: Орон нутагт өндөр технологи ашиглах мэргэжилтнүүдийн дутагдал.	Мэргэжилтэн бэлтгэх, сургалт зохион байгуулах, Гадаадын туршлагатай компаниудтай хамтран ажиллах,
4. Хууль эрх зүйн орчны сул тал: Автономит тээврийн хэрэгсэл, ухаалаг замын системтэй холбоотой зохицуулалт дутагдалтай.	Олон улсын туршлагад үндэслэн хууль, дүрэм, стандарт боловсруулах, Орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн тохируулга хийх.
5. Нийгмийн хүлээлт ба итгэлгүй байдал: Шинэ технологид иргэдийн дасан зохицох байдал удаан, итгэлцэл сул.	Иргэдэд ухаалаг системийн ач холбогдлыг улсын хэмжээнд сурталчлан таниулах. - Туршилтын төслүүдийг хэрэгжүүлж, үр дүнг танилцуулах.
6. Хот төлөвлөлтийн доголдол: Замын хөдөлгөөний эрчим ихтэй хэсгүүдэд систем хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх магадлалтай.	- Хотын хөдөлгөөний ачаалал ихтэй хэсгүүдийн зохион байгуулалтыг сайжруулах. - Ухаалаг хот төлөвлөлтийн загвар хэрэгжүүлэх.

Зам тээврийн аюулгүй байдал болон ослын тоог бууруулахад чиглэсэн технологийн шийдлүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зөвхөн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал биш, мөн иргэдийн идэвхтэй оролцоо шаардлагатай. Төр нь дэд бүтэц, хууль тогтоомж, зохицуулалтын үүрэг хариуцлагыг хүлээх ёстой бол хувийн хэвшил нь техник, технологийн дэвшлийг авчрах, инновациудад хөрөнгө оруулах үүрэгтэй байна. Иргэдийн оролцоо нь замын хөдөлгөөний соёлыг өөрчлөх, зөв зан үйлийг төлөвшүүлэх, мөн аюулгүй байдлыг хангах бүхэл бүтэн системийн амжилтад чухал нөлөө үзүүлнэ. Түүнчлэн, иргэдийн мэдээлэлтэй, соён гэгээрсэн байх нь осол гарах эрсдэлийг бууруулахад туслах юм. Иймээс олон нийтийн боловсрол, тэдний оролцоог дэмжих, технологийн хөгжилтэй уялдуулан хууль, дэд бүтэц, боловсон хүчнийг бэлтгэх зэрэг нь Монгол Улсад ухаалаг замын системийг нутагшуулах үр дүнтэй арга зам болно.

Монгол Улсад ухаалаг замын системийг амжилттай нутагшуулахын тулд технологийн хөгжлийг хууль эрх зүйн орчин, дэд бүтэц, боловсон хүчнийг бэлтгэх зэрэг асуудлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай. ²⁰

Технологийн дэвшлийг дэмжих: Технологийн хөгжлийг дэмжих, шинэлэг шийдлийг хэрэгжүүлэхэд зориулсан судалгаа, хөгжүүлэлтийг тэргүүлэх чиглэлд тавих хэрэгтэй. Замын хөдөлгөөнд зориулсан хиймэл оюун ухаан, автомашины хяналтын системүүд, олон төрлийн мэдрэгч төхөөрөмжүүдийг хөгжүүлж, Монгол Улсад туршиж эхлэх нь хамгийн эхний алхам байх ёстой.

Эрх зүйн орчны шинэчлэл: Зам тээврийн аюулгүй байдлын асуудалд холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, технологийн хөгжилд нийцүүлэн шинэ шаардлага, дүрэм журам, хяналтын аргачлалуудыг боловсронгуй болгох шаардлагатай. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс хиймэл оюун ухааны үр ашигтай хэрэгжилтэд хууль эрх зүйн орчны дэмжлэг чухал.

Дэд бүтцийн хөгжүүлэлт: Замын хөдөлгөөний удирдлагын системийг сайжруулах, замын засвар үйлчилгээ, хяналтын төвүүдийг шинэчлэх, интеллектуал шийдлүүдийг хэрэгжүүлэхэд дэд бүтцийг шинэчилж, тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай. Хиймэл оюун ухааны системүүдийг зам дээр суурилуулахад дэд бүтцийн тогтолцоо, технологийн дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэнэ.

Боловсон хүчний бэлтгэл: Ухаалаг замын системийг амжилттай нэвтрүүлэхэд өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчин шаардлагатай. Зам тээврийн аюулгүй байдлын шинэчлэл болон технологийн дэвшилд нийцсэн сургалт, мэргэжилтнүүдийг бэлтгэх, тэдгээрийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх нь чухал. Мөн, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хиймэл оюун ухааны чиглэлээр мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх хэрэгтэй. ²¹

Ийнхүү технологи, хууль эрх зүй, дэд бүтэц, боловсон хүчний бэлтгэл зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг зэрэгцүүлэн хөгжүүлэх нь Монгол Улсад ухаалаг замын системийг амжилттай нутагшуулахад туслах бөгөөд зам тээврийн осол, зөрчлүүдийг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулахад үр дүнтэй арга зам болно.

Дүгнэлт

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах нь зөвхөн одоо цагийн шаардлага биш, харин ирээдүйн хөгжилд чиглэсэн стратегийн гол чиглэл юм. Хиймэл оюун ухаан дээр суурилсан дэвшилтэт технологи нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад эрс өөрчлөлт авчрах төдийгүй Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна.

Олон улсын туршлагуудаас харахад, хиймэл оюун ухаан нь замын хөдөлгөөний ослыг бууруулах, замын хөдөлгөөнийг оновчтой удирдах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад гайхалтай үр дүнтэй болохыг харуулж байна. Монгол Улс эдгээр технологийг нутагшуулснаар зөвхөн зам тээврийн аюулгүй байдлыг хангахгүй, мөн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, замын

²⁰ Замын хөдөлгөөний удирдлагын ухаалаг системүүд: Монгол Улсад хэрэгжих боломжууд. Эрдэм шинжилгээний тайлан- МУИС Технологийн Сургууль-2020 он

²¹ Өлзийтогтох, Ц- Хиймэл оюун ухаан ба замын аюулгүй байдлын шийдэл. Технологийн судалгаа, Тээвэр, хөдөлгөөн судлал-2019 он

түгжрэлийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах зэрэг олон талын ашигтай байх болно.

Энэ бол зөвхөн замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах алхам бус, мөн Монгол Улсын ирээдүйн технологийн дэвшлийн үндэс суурь болох боломж юм. Одоо бидэнд хэрэгтэй зүйл бол технологийн хөгжлийг дэмжих, ухаалаг шийдлүүдийг турших, олон нийтийг соён гэгээрүүлэх, бодитой хамтын ажиллагааг эхлүүлэх явдал юм.

Санал

Монгол Улсад зам тээврийн осол, зөрчлүүдийн тоо өсөж байгаа тул замын хөдөлгөөний аюулгүй байдлын шинэ технологиудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Жишээлбэл, камер, мэдрэгч төхөөрөмж болон хиймэл оюун ухааны үндсэн дээр хөгжүүлсэн жолоочийн хариуцлагыг сайжруулах системийг нэвтрүүлэх;

Зам тээврийн ослыг бууруулахад зориулсан автономит тээврийн хэрэгслүүдийн судалгаа, хөгжүүлэлт, Монгол Улсад түүнийг турших боломжийг олгох;

Замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, жолоочийн зан төлөвийг судлах, хурд хэтрүүлэлт болон анхааралгүй жолоодох зөрчлүүдийг бууруулах зорилгоор Европын орнууд болон Америкийн Нэгдсэн Улсад ашиглагдаж буй замын хөдөлгөөний удирдлагын ухаалаг системүүдийг өөрийн улсад турших;

Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалд үүссэн хохирлын тоог бууруулахын тулд хиймэл оюун ухааны судалгаа, хөгжүүлэлтийн асуудалд төрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;

Зам тээврийн аюулгүй байдлын талаар олон нийтэд мэдээлэл өгч, ХОУ, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сурталчлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн Улсын хэмжээний үндэсний аян, сургалтууд зохион байгуулж замын хөдөлгөөний соёлыг хэвшүүлэх;

Эдгээр шийдлүүд нь Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлийг бууруулах, мөн иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулах ажил юм.

Ашигласан материал

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль-2015 он
- Өлзийтогтох, Ц. Хиймэл оюун ухаан ба замын аюулгүй байдлын шийдэл. Технологийн судалгаа, Тээвэр, хөдөлгөөн судлал-2019 он
- Замын хөдөлгөөний удирдлагын ухаалаг системүүд: Монгол улсад хэрэгжих боломжууд. Эрдэм шинжилгээний тайлан- МУИС Технологийн Сургууль-2020 он
- World Economic Forum. AI for Smart Cities. U.S. Department of Transportation Traffic Management Solutions-2020
- European Commission Smart Mobility in European Cities. Bloomberg Philanthropies & WHO Road Safety and Smart Technology-2021
- Toyota Research Institute Autonomous Vehicles: Global Trends and Impact. Japan National Police Agency Autonomous Vehicle Trials-2021
- South Korean Ministry of Transportation AI for Road Safety: Case Studies. Korea Transport Institute Smart Traffic Solutions-2020

- Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2022 он
- Singapore Land Transport Authority Smart Mobility Solutions. Gartner Research. AI in Traffic Management.-2021
- Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2023 он
- <https://www.japanindustrynews.com/2023/05/japan-grants-first-level-4/Japan: Autonomous Vehicles Technology> - Japan Ministry of Land, Infrastructure, Transport and Tourism
- <https://www.bing.com/search?pc-2024> он
- <https://www.who.int/health-topics/road-safety-2024>
- <https://www.undrr.org/understanding-disaster-risk/terminology-2024>
- https://en.wikipedia.org/wiki/Artificial_Intelligence:_A_Guide_for_Thinking_Human-2024
- <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0968090X21004241-2024>
- <https://www.its.dot.gov/>- USA: Intelligent Transportation Systems (ITS) - US DOT (Department of Transportation)-2024
- https://commission.europa.eu/eu-regional-and-urban-development/topics/cities-and-urban-development/city-initiatives/smart-cities_en-2024

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА ТОГТООЖ БУЙ БАЙДАЛ: ГЕРМАН БОЛОН ЯПОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАРЬЦУУЛАН ҮЗЭХ НЬ

THE STATE OF MORTGAGE IN MONEY LAUNDERING AND TERRORISM FINANCING: A COMPARISON OF THE LEGAL REGULATIONS OF GERMANY AND JAPAN

Г.Батжаргал

ДХИС-ийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн профессор,
цагдаагийн хошууч

Товч агуулга: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь дэлхий нийтийн эдийн засаг, улс төрийн тогтвортой байдалд ноцтой аюул учруулж байгаа тул хууль, эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага урган гарч байна. Эдгээр гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үйл явц нь нарийн төвөгтэй, ихээхэн хугацаа шаарддаг онцлогтой учир хөөн хэлэлцэх хугацааг оновчтой тогтоох нь нэн чухал хэмээн зарим улсын эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн үзвэл, Монгол Улс дээрх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, мөн илрүүлэх хугацаанд үндэслэн уян хатан зохицуулалт хийх нь зүйтэй байна.

Abstract: Money laundering and terrorist financing crimes pose a serious threat to the global economic and political stability, so there is a need to improve legal regulations. Since the process of detecting and investigating these crimes is complex and requires a lot of time, it is very important to set the statute of limitations. Flexible arrangements are desirable.

Түлхүүр үгс: Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт явдал.

Key words: Limitation period, money laundering, financing of terrorism

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь нэг улсын төдийгүй дэлхий нийтийн эдийн засаг болон улс төрийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж буй томоохон асуудал бөгөөд уг гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага тулгарч байна. Өнөө цаг үед улс орнууд өөрсдийн нийгэм, улс төр, эдийн засгийн онцлогт тохируулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн суурь асуудлын нэг нь уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хууль тогтоомжид оновчтой тогтоох асуудал бөгөөд энэ талаар улс орнууд харилцан адилгүй байдлаар тусгаж өгчээ.

Гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь эрх зүйн уламжлал, бүлийн хамаарлаас шалтгаалан харилцан адилгүй байдаг нь олон улсын хэмжээнд эрх

зүйн интеграцид төөрөгдөл, зөрчил бий болгодог төдийгүй үндэсний хэмжээнд нэхэмжлэлийн хүчин төгөлдөр байдлын талаар тодорхойгүй байдал, найдваргүй байдалд хүргэх асуудал цөөнгүй гарсаар ирсэн талаар судлаачид онцолсоор ирсэн байна.²²

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь далд хэлбэрээр, нарийн зохион байгуулалттайгаар үйлдэгддэг бөгөөд санхүүгийн болон хуулийн арга хэрэгслийг ашиглан ул мөрөө нуун далдалдаг хил дамнан, бүс нутаг болон олон улсыг хамарч үйлдэгддэг учир илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд их хүн хүч, хөрөнгө мөнгө, цаг хугацаа их шаарддаг. Улмаар улс орны эдийн засаг, аюулгүй байдалд ихээхэн хор хөнөөл учруулж, хохирлын цар хүрээ өргөн байдаг тул өндөр хариуцлага, зохион байгуулалттай арга хэмжээ шаарддаг.

Тиймээс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа нь нарийн төвөгтэй, олон улсын хамтын ажиллагаа шаардагддаг, мэдээлэл солилцоо удааширдаг, санхүүгийн сэжүүрийг мөшгөх, баримт бүрдүүлэхэд шаардлагатай цаг хугацаа их шаарддаг, технологийн дэвшилтэт шийдэл, хэрэгслийг өргөнөөр ашигладаг зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үйл явцыг удаашруулах эрсдэл бий болгодог.²³

Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа багаас болж мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, гэмт хэрэг гарах эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай тул тус гэмт хэргийн шинж чанар, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албаны зөвлөмж, улс орнуудыг жишигт уялдуулан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хугацааг нэмэгдүүлэх шаардлагатай талаар цөөнгүй судлаачид хөндөн гаргасан байдаг.²⁴

Иймд эдгээр гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг оновчтой тогтоох нь хууль зүйн хариуцлага хүлээлгэх, гэмт хэргийн эсрэг үр дүнтэй тэмцэх зорилтыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийн нэг юм.

Хөөн хэлэлцэх хугацааны зорилго нь шударга ёсыг хангах, нийгмийн харилцааг тогтворжуулах, эрх зүйн харилцааг тодорхой болгоход чиглэдэг. Гэсэн хэдий ч хуулийн тодорхойгүй байдал, нийгмийн шударга ёсны шаардлага, нотолгоо цуглуулах хүндрэл зэрэг асуудлууд нь энэ механизмыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Эдгээрийг шийдвэрлэхийн тулд хуулийн шинэчлэл, шүүхийн практикийг нэг мөр болгох шаардлагатай.²⁵

Тиймээс ч олон улсын жишигт зарим улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах эсвэл зарим төрлийн гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаагүй болгох, хөөн хэлэлцэх хугацааны эхлэлийг оновчтой тодорхойлох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах арга зүй, хүний нөөцийн чадавхыг сайжруулах, санхүүгийн ил тод байдлыг сайжруулах арга хэмжээний

²² Ц.Цэлмэг, Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны учир холбогдол, 2019

Г.Халиун, Б.Ариунжаргал, Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь, 2020

²³ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага, Санхүүгийн зохицуулах хороо, 2019

²⁴ Н.Жавхлан, Г.Отгонжаргал, Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт ба шийдвэрлэлтэд тулгамдаж буй асуудлууд, 2023, <https://fiu.mongolbank.mn/file>

²⁵ Tyler T. Ochoa, Andrew Wistrich, The Puzzling Purposes of Statutes of Limitation, Santa Clara Law, 1997, <http://digitalcommons.law.scu.edu/facpubs>

тусламжтайгаар санхүүгийн гүйлгээг хянах нь сайжирсан хэдий ч хууль бус хөрөнгийг үр дүнтэй мөрдөхөд бэрхшээлтэй хэвээр байгааг олон судалгаа, практик мэдээ тайланд дурдсаар ирсэн.

Хууль, эрх зүйн шинэчлэл болон олон улсын хамтын ажиллагааг сайжруулах нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой. Иймд энэ удаа дээрх гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоож буй байдлыг харьцуулан судлах замаар дээрх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй байдлыг зарим улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахыг зорилоо.

Зорилтын хүрээнд эрх зүйн бүл, хууль тогтоомжийн системчлэлийн хувьд өөр хоорондоо эрс ялгаатай, мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэл бага хэмээн үнэлэгддэг²⁶ ХБНГУ (3,5 оноо), Япон Улс (4,77 оноо)-ыг сонгон авч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн ноцтой байдлыг үнэлэх хандлага хэрхэн ялгаатай байгааг авч үзье.

Герман Улсын Эрүүгийн хууль дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт. Герман Улсад хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн ноцтой байдлаас хамаарч өөр хоорондоо эрс ялгаатай тогтоодог байна. Германы Эрүүгийн хууль (StGB-Strafgesetzbuch)-ийн 78, 79 дүгээр зүйлд²⁷ хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн хүнд, хөнгөн шинж болон учруулсан хохирлын хэмжээ зэргийг үндэслэн дараах байдлаар тогтоодог:

- Хөнгөн гэмт хэрэг (*leichte Straftat*): 3 жил хүртэл,
- Дунд зэргийн гэмт хэрэг (*mittlere Straftat*): 5-10 жил,
- Хүнд гэмт хэрэг (*schwere Straftat*): 10-20 жил хүртэл,
- Онц хүнд гэмт хэрэг (*besonders schwere Straftat*): Хөөн хэлэлцэх хугацааг хязгааргүй байхаар тогтоож болно.

Германы Эрүүгийн хуулийн §261 дүгээр зүйлд мөнгө угаах гэмт хэргийг зохицуулсан байдаг. Мөнгө угаах гэмт хэрэг нь ангиллын хувьд Германы Эрүүгийн хуулийн дагуу дунд зэргийн гэмт хэрэг (*mittlere Straftat*) хэмээн тооцогддог тул хөөн хэлэлцэх хугацаа нь:

- 5 жил (ердийн тохиолдолд)
- 10 жил (ноцтой тохиолдолд, тухайлбал, их хэмжээний хохирол учруулсан бол) байна.

Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн тооцдог боловч хэрэв гэмт үйлдэл удаан хугацаанд үргэлжилсэн бол сүүлчийн үйлдэл хийгдсэнээс эхлэн тооцогддог.

Мөнгө угаах гэмт хэргийг далд хэлбэрээр үйлддэг тул хэрэв гэмт хэрэг илрэхэд хугацаа шаардагдсан бол мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүднээс хугацааг сунгах нөхцөл боломжийг хуулиар олгодог.

Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг Германы Эрүүгийн хуулийн §89с дугаар зүйлд онц ноцтой гэмт хэрэг гэж үзэж, хөөн хэлэлцэх хугацааг харьцангуй урт хугацаагаар тогтоожээ. Хэлгийн хөөн хэлэлцэх хугацаа нь ихэвчлэн

²⁶ Дэлхийн мөнгө угаах эрсдэлийн үнэлгээний олон улсын Базелийн хорооны 2024 оны мөнгө угаах эрсдэлийн ерөнхий оноо, <https://index.baselgovernance.org/map>

²⁷ https://www.gesetze-im-internet.de/stgb/_78.html, https://www.gesetze-im-internet.de/stgb/_79.html

терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үйлдэлд 10 жил, ноцтой хохирол учруулсан, эсвэл олон улсын шинж чанартай үйл ажиллагаанд 20 жил байхаар хуульчилсан бөгөөд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болох тул хөөн хэлэлцэх хугацааг тасалдуулахгүйгээр мөрдөн шалгах үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжийг хуульчилсан байдаг.

Энэ нь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай цаг хугацааны боломж олгох, мөн гэмт этгээдийг хариуцлагаас мултрахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа хэрэг юм.

2. Япон Улсын Эрүүгийн хууль дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, эрх зүйн зохицуулалт

Япон Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээгээ олон улсын жишигт нийцүүлэн, ялангуяа Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсэг (FATF)-аас тогтоосон стандартад нийцүүлэн идэвхтэй хөгжүүлж байна. Энэхүү хүчин чармайлт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд хууль тогтоомжийн арга хэмжээ, зохицуулалтын тогтолцоо, байнгын үнэлгээг багтаасан болно.²⁸

Япон Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд Эрүүгийн хууль (刑法, *Keihō*) болон холбогдох бусад хуулиудад нарийвчилсан зохицуулалтыг тусгасан байдаг. Хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн шинж чанар, үйлдэгдсэн арга хэлбэр болон хохирлын хэмжээнээс хамааран өөр өөр тогтоогддог.

Японы Эрүүгийн хуулийн дагуу мөнгө угаах гэмт хэргийг санхүүгийн гэмт хэрэг болон зохион байгуулалттай гэмт хэрэг гэж ангилж үздэг. Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн гэмт хэргийн онцлогоос хамаарч 3-10 жил хүртэл байж болно. Бага хэмжээний мөнгө угаах буюу хохирлын цар хүрээ бага тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа 3-5 жил, олон улсын мөнгө угаах болон зохион байгуулалттай үйл ажиллагаатай холбоотой хэргүүдийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа 7-10 жил хүртэл тогтоохоор заасан байна.

Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэгдсэн үеэс тооцох боловч хэрэв мөнгө угаах үйлдэл нь үргэлжилсэн байдалтай хийгдсэн бол хамгийн сүүлчийн үйлдлээс хойш хугацааг тоолдог. Мөрдөн шалгах ажиллагаа удаашрах, эсвэл гэмт хэрэг хожуу илэрсэн тохиолдолд шүүх эрх бүхий байгууллагад хөөн хэлэлцэх хугацааг сунгах эрхийг олгодог. Санхүүгийн байгууллагуудад сэжигтэй гүйлгээний тайлан (STR) гаргах үүрэг хүлээлгэдэг бөгөөд энэ нь мөрдөн байцаалтыг хурдасгахад дэмжлэг үзүүлдэг.

Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь Японы Эрүүгийн хуулиар хамгийн ноцтой гэмт хэрэгт тооцогддог бөгөөд Япон Улс олон улсын гэрээ, байгууллагуудын (FATF гэх мэт) шаардлагад нийцүүлэн тусгай зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

²⁸Anti-Money Laundering Japan, law business Research, 2024, https://www.mhmjapan.com/content/files/00068499/In%20Depth%20Antimoney%20Laundering_%20Japan.pdf

Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа 7-15 жил байдаг. Онц ноцтой хэргүүдийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа хязгаарлалтгүй байх боломжтой.

Ялангуяа олон хүний амь нас, улс орны аюулгүй байдалд нөлөөлсөн үйлдлүүдэд цаг хугацааны хязгаарлалтгүйгээр мөрдөн шалгах эрхийг олгож, хариуцлага тооцох зохицуулалттай. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хэргийг илрүүлэхэд Санхүүгийн гүйлгээний хяналтын алба (JAFIC) идэвхтэй ажилладаг. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, санхүүгийн урсгалыг хянах, мөрдөн шалгах ажиллагааг уялдуулан хэрэгжүүлдэг.

Япон Улс терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомждоо 2001 оны НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөлийн тогтоолууд, мөн FATF-ийн зөвлөмжүүдийг тусгасан байдаг.

Японы эрх зүйн тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тооцдог:

1. Гэмт хэрэг үйлдэгдсэн үеэс хөөн хэлэлцэх хугацаа эхэлнэ.
2. Хэрэв гэмт хэрэг нь үргэлжилсэн шинжтэй бол хамгийн сүүлчийн үйлдлээс эхэлж тооцно.
3. Гэмт хэрэг хожуу илэрсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн хугацаанд тулгуурлан тооцох зохицуулалт байдаг.

Япон Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, ФАТФ (FATF)-ийн зөвлөмж-ийг хэрэгжүүлдэг. Олон улсын хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа болон мэдээлэл солилцооны механизмыг сайжруулсан нь гэмт хэргийг илрүүлэх хугацааг богиносгоход дэмжлэг үзүүлэн ажилладаг байна.

3. Герман болон Японы харьцуулсан дүгнэлт

Шалгуур	Герман	Япон
Хөөн хэлэлцэх хугацаа (мөнгө угаах)	5-10 жил	3-10 жил
Хөөн хэлэлцэх хугацаа (терроризм)	10-20 жил	10-15 жил (ноцтой тохиолдолд хязгааргүй)
Хугацаа тооцох арга	Гэмт хэрэг үйлдэгдсэн үеэс тооцдог	Илэрсэн болон мөрдөн шалгасан үеэс тооцож болно
Үргэлжилсэн үйлдэл	Сүүлчийн үйлдэл хийгдсэнээс тооцно	Үргэлжлэх хугацаанаас хамаарч хянана
Олон улсын хамтын ажиллагаа	Европын Холбооны хуульд нийцсэн	Олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг
Гэмт хэргийн ангилал	Онц ноцтой гэмт хэрэг	Онц ноцтой гэмт хэрэг

Хоёр улсын туршлагаас суралцах нь:

Германы давуу тал: Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ноцтой байдлаас хамааруулан тодорхойлдог. Үргэлжилсэн хэлбэрээр үйлдэгдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн үйлдлээс тооцох нь хууль зүйн үр нөлөөг сайжруулдаг.

Японы давуу тал: Илрүүлэхэд цаг хугацаа шаарддаг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг илүү уян хатан байдлаар тооцдог. Терроризмыг санхүүжүүлэх ноцтой гэмт хэргийг хязгааргүй хугацаанд мөрдөн шалгах боломж олгодог нь илүү оновчтой.

Дүгнэлт

Герман болон Япон Улс нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг өөр өөр зохицуулалтаар тогтоодог. Герман Улс гэмт хэргийн шинж чанар, хохирлын хэмжээнээс хамааран хугацааг ялгаатайгаар тооцдог бол Япон Улс илүү уян хатан зохицуулалт хийж, хэргийг илрүүлэх хугацаанд анхаардаг.

Мөн Германы эрх зүйн тогтолцоо нь хөөн хэлэлцэх хугацааг илүү тогтвортой байдлаар тооцож, тодорхой нөхцөлд зогсоож, үргэлжлүүлэх боломжийг хангадаг. Харин Япон Улс илрүүлэлтийн онолыг илүү өргөн хэрэглэж, гэмт хэрэг нуугдмал байсан тохиолдолд хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлд анхаардаг.

Хөөн хэлэлцэх хугацааны талаарх хоёр орны эрх зүйн зохицуулалт нь хуулийн үндсэн зорилго болох шударга ёсыг хангах, гэмт хэргийг үр дүнтэй илрүүлэх, хариуцлагыг оновчтой хүлээлгэхэд чиглэгдсэн байна.

Монгол Улс эдгээр туршлагаас суралцаж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, илрүүлэх хугацаанаас хамаарч хөөн хэлэлцэх хугацааг тооцох уян хатан зохицуулалт хийх, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ашигласан материал

- Ц.Цэлмэг, Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны учир холбогдол, 2019 он
- Г.Халиун, Б.Ариунжаргал, Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь, 2020 он
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага, Санхүүгийн зохицуулах хороо, 2019 он
- United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances, December 20, 1988
- United Nations Convention against Transnational Organized Crime, November 15, 2000
- Protocol to Prevent, Suppress and Punish Trafficking in Persons Especially Women and Children, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime, 15 November 2000
- Protocol against the illicit manufacturing of and trafficking in firearms, their parts and components, and ammunition, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime, 31 May 2001
- Protocol against the smuggling of migrants by land, sea and air, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime, on 15 November 2000
- Statue of Limitations (A Goddess of Greene St. Mystery) 2020
- Statute of Limitations Steven F. Havill January 1, 2006
- Statute of Limitations A Novel By John Montgomery Buckley
- The law of limitations Graeme Mew, Debra Rolph, Daniel Zacks October 27, 2023

- An overview of the criminal law system in Japan
<https://travel.gc.ca/travelling/advisories/japan/criminal-law-system>
- German Criminal Code 13 November 1998
- Anti-Money Laundering Japan, law business Research, 2024,
[https://www.mhmjapan.com/content/files/00068499/In%20Depth%20Anti-Money%20Laundering %20Japan.pdf](https://www.mhmjapan.com/content/files/00068499/In%20Depth%20Anti-Money%20Laundering%20Japan.pdf)
- Дэлхийн мөнгө угаах эрсдэлийн үнэлгээний олон улсын Базелийн хорооны 2024 оны мөнгө угаах эрсдэлийн ерөнхий оноо,
<https://index.baselgovernance.org/map>
- https://www.gesetze-im-internet.de/stgb/_78.html,
- https://www.gesetze-im-internet.de/stgb/_79.html

**ТӨРЛӨӨР УСТГАХ ГЭМТ ХЭРЭГТ ХҮЛЭЭЛГЭХ ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН
ХАРИУЦЛАГА: RESPONSIBILITY TO PROTECT - R2P (ХАМГААЛАХ ҮҮРЭГ)
ЗАРЧИМ**

THE INTERNATIONAL RESPONSIBILITY OF THE GENOCIDE: THE PRINCIPLE
“RESPONSIBILITY TO PROTECT- R2P”

Б.Алтангэрэл

Монгол Улсын Дээд шүүхийн хэргийн хөдөлгөөн,
мэдээлэл, судалгааны хэлтсийн судлаач, докторант

Товч агуулга: Төрлөөр устгах гэмт хэрэг нь тодорхой бүлгийг системтэй устгах зорилготой хүчирхийллийн үйлдэл бөгөөд энэ нь НҮБ-ын 1948 оны "Геноцидын конвенц"-оор эрүүгийн ноцтой гэмт хэргийн ангилалд хамаарагдаж, хариуцлага ногдуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч улс орнуудын хувьд гарч буй маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, эсхүл хүний эрхийн зөрчлийг таслан зогсооход гар бие оролцох үүргээ үл биелүүлснээр тус гэмт хэргээс үүдэх хохирлыг улам даамжрах эрсдэлийг нэмсэн харамсалтай үйл явдлууд багагүй гарсан билээ.

Хэдийгээр улс орнуудын хувьд Эрүүгийн хуульдаа төрлөөр устгах гэмт хэргийг тодорхойлж, бүх насаар хорих, цаазаар авах хүртэл хатуу ялыг хуульчилж, олон улсын эрүүгийн шүүхүүд, тухайлбал, ICC, ICTY, ICTR нь гэмт хэргийг хожмоо шийдвэрлэж, гэмт этгээдүүдэд хатуу хариуцлага ногдуулж, хүн төрөлхтний нэр төр, эрхийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулсан ч, түүнийг эцсийн үр дүн хүртэл гэмт хэргийг бүрэн үйлдэхээс өмнө олон улсын хамтын ажиллагааны үүднээс таслан зогсоосноор гарах үр дагавар харьцангуй бага байх юм. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэрэгт улс орнуудын дотоод асуудал төдийгүй олон улсын хамтын нийгэмлэгийн хариуцлагын чухал асуудал юм.

Иймд улс орнууд геноцидын гэмт хэрэгт хариуцлага ногдуулах хууль эрх зүйн орчноо сайжруулж, R2P зарчмыг хэрэгжүүлэхийн тулд олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай талаар хөндөн судаллаа.

Abstract: Genocide is an act of violence aimed at systematically exterminating a specific group. It was classified as a serious criminal offense under international law by the United Nations' 1948 "Convention on the Prevention and Punishment of the Crime of Genocide," establishing a legal basis for accountability. However, there have been regrettable instances where countries failed to fulfill their obligations to support conflict resolution or intervene to halt human rights violations, thereby increasing the risk of exacerbating the harm caused by such crimes.

Although nations have incorporated the crime of genocide into their criminal laws, prescribing severe penalties such as life imprisonment or even capital punishment, and international criminal courts like the International Criminal Court (ICC), the International Criminal Tribunal for the former Yugoslavia (ICTY), and the International Criminal Tribunal for Rwanda (ICTR) have subsequently adjudicated these crimes, imposing strict accountability on perpetrators and contributing significantly to the protection of human dignity and rights, it is more effective to prevent the commission of these crimes through international cooperation before they reach their final stages, thereby mitigating the consequences.

In other words, addressing such crimes is not only a domestic issue for individual countries but also a critical responsibility for the international community.

Therefore, it is essential for nations to enhance their legal frameworks for holding perpetrators of genocide accountable and to expand international cooperation to implement the Responsibility to Protect (R2P) principle.

Түлхүүр үг: Хамгаалах үүрэг, төрлөөр устгах гэмт хэрэг, олон улсын гэмт хэрэг, олон улсын эрүүгийн эрх зүй, төрлөөр устгах гэмт санаа

Keywords: Responsibility to protect, genocide, international crime, international law, *dolus specialis*

I. Удиртгал

Олон улсын алан хядах үйлдэл, гэмт бүлэглэлийн өсөлт, насанд хүрээгүй хүмүүсийг улс дамжуулан худалдах, гадаадын иргэдийг нууцаар хил гаргах, экологийн гэмт хэргүүд, компьютер болон теле холбооны хэрэгсэл ашиглахтай холбогдсон гэмт хэргүүд дэлхийн хамтын нийгэмлэгийг түгшээж байсан цаг саяхан.

Тэдгээрийн дотроос Геноцид нь олон улсын гэмт хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн жигшүүрт гэмт хэргийн нэг юм. Энэ нь үндэстэн, угсаатны, арьс өнгө, шашны бүлгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилготойгоор зориудаар, системтэйгээр устгах явдал билээ.

1948 онд НҮБ-аас Геноцид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенцийг (геноцидийн конвенц) баталсан бөгөөд мөнхүү үр дүнд хүргэсэн шалтгаан нь Дэлхийн 2-р дайны харгислал, ялангуяа Холокост (католик шашинтнууд, польш угсаатнууд, цыганууд, Зөвлөлтийн энгийн иргэд, Зөвлөлтийн цэргийн олзлогдогсод, тахир дутуу хүмүүс, ижил хүйстнүүд, жэновагийн гэрч нар, бусад улс төр, шашны өрсөлдөгчдийг сая саяар нь системтэй устгасныг оруулах нь зүйтэй гэж үзсэн үзэл, үйлдэл) байв.

Түүнчлэн, Дэлхийн II дайн дууссанаас хойш төрлөөр устгахтай холбогдсон гэмт хэрэг, цэргийн гэмт хэргүүд гарах болсны улмаас НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр 1991 оноос хойш хуучин Югославын нутаг дэвсгэр дээр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчсөн этгээдүүдийг шүүх Олон Улсын Шүүх түүнчлэн Руандагийн нутаг дэвсгэр дээр гарсан төрлөөр устгах гэмт хэрэг, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бусад ноцтой зөрчлийн төлөө хариуцлага хүлээх Руандагийн иргэдийг шүүх Олон Улсын Шүүхийг тус тус байгуулсан.

Олон улсын хэм хэмжээ, номлолын дагуу геноцид нь *jus cogens*²⁹ хэм хэмжээ гэж тооцогддог бөгөөд бүх нийтээрээ геноцидийг хориглох үүргээс татгалзаж үл болно. Геноцидийн зохицуулалтын хэрэгжилтийг Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR), Хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүх (ICTY), сүүлийн үед Олон улсын эрүүгийн шүүх (ICC) зэрэг олон улсын шүүхээр дамжуулан хэрэгжүүлж байна. Хэдийгээр тодорхой эрх зүйн зохицуулалт хүчин төгөлдөр хэрэгслээр ирсэн хэдий ч улс төр, дипломат болон нотлох баримтын нарийн төвөгтэй байдлаас үүдэн геноцидээс урьдчилан сэргийлэх, хариуцлага ногдуулахад бэрхшээлтэй хэвээр байна.

²⁹ *Jus cogens* буюу албадан хууль гэдэг нь олон улсын заншлын эрх зүйг зохицуулдаг хэм хэмжээний ангилалд хамаарна. Латин нэр томъёог англи хэл дээрх "зайлшгүй норм" гэсэн үгтэй сольж хэрэглэдэг. *Jus cogens* хэм хэмжээ нь бусад хэм хэмжээнээс үндсэн хоёр зүйлээр ялгаатай. Нэгдүгээрт, *jus cogens* хэм хэмжээ нь заавал байх ёстой, хоёрдугаарт заавал дагаж мөрдөх ёстой юм.

Геноцидийг хүлээн зөвшөөрч, эрүүгийн хариуцлага ногдуулах нь олон улсын хамтын нийгэмлэг хүний нэр төрийг сахин хамгаалах, үй олноор харгис хэрцгийгээр устгах үйлдлээс урьдчилан сэргийлэх явдлыг илэрхийлж байгаа ч, сүүлийн жилүүдэд хүн төрөлхтний дунд гарч буй гэмт хэргийн шалтгаанууд, үйл олноор амь үрэгдэж буй явдалд төрлөөр устгах гэмт хэргийн зарим шинж агуулагдаж буй нь энэ төрлийн гэмт хэргийг тодорхойлоход мөн л бэрхшээл дагуулсаар.

Иймд энэхүү судалгаагаараа төрлөөр устгах гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүнийг нарийн тодорхойлсны үндсэн дээр түүнд хариуцлага ногдуулахад олон улсын эрүүгийн эрх зүйн зарчим тэр дундаа олон улсын хамтын ажиллагааны “Хамгаалах үүрэг” зармын ач холбогдлыг судалсан болно.

II. Үндсэн хэсэг

2.1. Төрлөөр устгах гэмт хэргийн бүтээц, онцлог

Төрлөөр устгах гэмт хэрэг (genocide) гэдэг нь тодорхой бүлэг, үндэстний эсрэг систематик устгал, дарамт, хүчирхийллийн үйл ажиллагааг илэрхийлсэн нэр томьёо, гэмт хэргийн төрөл юм. Тус гэмт хэргийн анх Польшийн хуульч Рафаэль Лемкин "Axis Rule in Occupied Europe: Laws of Occupation, Analysis of Government, Proposals for Redress" (1944) бүтээлдээ геноцид" гэдэг нэр томьёог анх ашигласнаар төрлөөр устгах гэмт хэргийг олон улсын гэмт хэргийн нэг хэмээн хүлээн зөвшөөрөх эхлэл тавигдсан гэж үздэг. Гэхдээ Лэмкин анх төрлөөр устгах гэмт хэргийг маш өргөн хүрээтэйгээр тодорхойлсон бөгөөд тэрээр “төрлөөр устгах гэмт хэрэг нь цэрэг, соёл, эдийн засгийн бүх хэлбэрээр явуулж болох үйл ажиллагаа” гэжээ.

Олон улсын эрүүгийн эрх зүйд туссан гэмт хэргүүд нь объектив талаасаа олон улсын энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдал буюу олон улсын дэг журамд онц аюултай байдал буюу олон улсын дэг журамд онц аюултай, асар өргөн хүрээтэй халдсан үйлдэл буюу эс үйлдэл юм. Үүнтэй уялдан олон улсын шинж чанартай гэмт хэрэг нь энх тайвны эсрэг, цэргийн болон олон улсын бусад гэмт хэрэг нь энэ талаараа нийтлэг эрүүгийн хэргээс ялгагдах юм тун бага бол энх тайвны эсрэг, цэргийн болон олон улсын гэмт хэрэг нь нэн олон бодгаль, хуулийн этгээд, улс гүрний олон салбарласан нарийн төвөгтэй үйл ажиллагаа бөгөөд хэд хэдэн орны нутаг дэвсгэр дээр удаан хугацааны туршид явагддаг онцлогтой юм. Ийм тохиолдолд гэмт хэргийн газар нь хор хохирол үүссэн газартай тэр болгон тохирдоггүй. Тухайлбал, АНУ-ын долларыг Италид хуурамчаар үйлдэж, ХБНГУ, Франц, Литва, ОХУ-д тараасан байхад АНУ-д эдийн засгийн хохирол учирсан байх жишээтэй. Түүнчлэн түрэмгий дайн төлөвлөх, өдөөх, явуулахын хувьд ч гэсэн байдал ийм байна.

Үүнээс гадна олон улсын алан хядлага, далайн дээрэм, агаарын тээвэр болон олон улсын онгоцны буудал дахь гэмт хэрэг, хүмүүсийг барьцаанд авах, ард түмний соёлын өвд халдах болон бусад гэмт хэрэг нь энхийн цагт ч гэсэн олон улсын байдлыг хурцатгах, улс гүрнүүдийн хамтын ажиллагааг хүндрүүлэх хэрэгсэл болохоос гадна олон улсын зэвсэгт мөргөлдөөн зөрчлийг өдөөн үүсгэж чадна. Дээрх гэмт хэргүүдийн үйлдсэн газар, цаг хугацаа, нөхцөл байдал нь мөн түүний ангилалд нөлөөлөл үзүүлэх бөгөөд шүүхээс ял шийтгэл ногдуулахдаа гэм бурууг нь хүндрүүлэх буюу хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон ашиглаж болно.

Субъектив талаасаа бол энд авч үзэж буй гэмт хэргүүдийг нарийн тодорхой зорилгоор шууд сэдэлтээр үйлдэнэ. Тухайн субъект хийсэн үйлдлийнхээ нийгмийн

учир утгыг ухамсарлаж байсан эсэх, уг гэмт хэргийн дур зоргын элемент, зорилго, сэдэлтийн тухай асуудлыг зөвхөн үйлдэл буюу эс үйлдлийн шинж чанараар төдийгүй, мөн бичиг баримтаар нотолно.

Харин улс гүрний гэм бурууг тодорхойлох асуудал илүү нарийн төвөгтэй. Аливаа улс гүрний гэм буруу гэдэг нь сэтгэл зүйн бус, харин нийгэм, улс төрийн ба хууль зүйн ойлголт учраас бие хүний гэм бурууг тодорхойлох шалгуур, хэмжүүрийг энд хэрэглэж үл болно.

ОХУ-ын эрдэмтэн хуульч В.А.Василенкогийн³⁰ үзэж байгаагаар эл гэм буруу нь төрийн зохих байгууллагын хууль бус үйл ажиллагаагаар илрэх, эрх зүй зөрчигч гүрний зүй бусаар хэрэгжүүлсэн дур зорго юм.

Төрлөөр устгах гэмт хэргийн объектив тал.

Гэмт хэргийн объектив талын шинж нь төрлөөр устгах гэмт хэргийн физик үйлдэл, эрх зүйн, нийгмийн байдал, үйл явц буюу тухайн гэмт үйлдлийг тайлбарлахад илүүтэй анхаардаг. Үүнийг дэлгэрүүлэн тайлбарлавал:

✓ **Физик үйлдлүүд:** Төрлөөр устгах гэмт хэрэг нь систематик, төлөвлөгдсөн хүчирхийлэл, хүйс, угсаа, үндэстэн, шашны бүлэг, эсвэл бусад тодорхой бүлгийн эсрэг явагддаг. Энэ нь хүний амь нас, эрх чөлөөнд хохирол учруулж, устгах, зодох, хүчээр нүүлгэн шилжүүлэх зэрэг физик буюу идэвхтэй үйлдлүүдийг өөртөө багтаадаг.

✓ **Эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байх:** Төрлөөр устгах гэмт хэрэг нь олон улсын хэм хэмжээ, тухайлбал НҮБ-ын Төрлөөр устгах гэмт хэргийн эсрэг конвенцын хүрээнд тодорхойлогддог. Энэ конвенц нь төрлөөр устгах гэмт хэргийг "угсаатны бүлэг, үндэстэн, шашны бүлгийн эсрэг үе шаттай, төлөвлөгөөтэй устгал" гэж тодорхойлсон. Түүнчлэн Олон улсын эрүүгийн загвар хууль, тухайн улсын Эрүүгийн хуульд гэмт үйлдлийг хуульчилсан байхыг шаарддаг байна.

✓ **Үе шат, төлөвлөгдсөн байдал:** Объектив тал нь гэмт хэргийн үйл явцын систематик, төлөвлөгдсөн байдалд анхаардаг. Энэ нь хүчирхийллийн ажиллагаа, дарангуйлагчийн болон засгийн газрын зүгээс явуулж буй хяналт, зохион байгуулалттай холбоотой. Өөрөөр хэлбэл энэ төрлийн ялангуяа олон хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болохуйц тус төрлийн гэмт хэргийг болгоомжгүй эсхүл бэлтгэлгүйгээр үйлдэх боломжгүй юм.

✓ **Тохиолдол, мэдээлэл:** Төрлөөр устгах гэмт хэрэг нь тодорхой бүлэг, үндэстэн, шашны бүлгийн эсрэг явуулж буй олон тооны хүчирхийллийн үйлдлүүдийг багтаадаг. Тохиолдлууд нь систематик, хяналттай, төлөвлөгдсөн байдлаар явуулж байгаа гэмт хэргийн мэдээлэл, нотолгоо шаарддаг. Өөрөөр хэлбэл олон улсад үйлдэгдэж буй хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс ялгаатай нь тухайн гэмт хэргийг тодорхой бүлгийг устгах зорилгыг нотлохыг шаарддаг.

Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал.

Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал нь гэмт хэрэгтний сэтгэл зүй, нийгмийн хандлага, эрх мэдлийн харилцаа холбоо, зорилго, сэдэлтийг тодорхойлдог. Үүнд:

³⁰ Василенко, В.А. - "Геноцидийн тухай ойлголт ба түүний эрх зүйн зохицуулалт", 1999 он
Василенко, В.А. - "Олон улсын эрүүгийн эрх зүйн асуудал дахь геноцид", 2003 он
Василенко, В.А. - "Гэмт хэргийн төрөл ба ангилал", 2005 он

✓ **Сэтгэл зүйн хүчин зүйл:** Төрлөөр устгах гэмт хэрэг нь тодорхой бүлгийн эсрэг хүчирхийлэл үйлдэхэд хүргэдэг сэтгэл зүйн хүчин зүйлийг агуулдаг. Тус гэмт хэргийн тухайд этноцентризм, үндэсний үзэл, алагчлан үзэх зэрэг нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлдөг буюу өөрийн бүлэг, овог, үндэстнийг бусдаас дээгүүрт үзэх, тэдгээрийн хөгжилд ямар нэгэн байдлаар саад хийж буй гэсэн үндэслэлийг дагуулах нь олонтаа.

✓ **Нийгмийн хандлага:** Тухайн нийгэмд төрлөөр устгах гэмт хэргийг зөвшөөрөх, дэмжих, эсвэл түүнийг өршөөх, уучлах хандлага бий болох нь тус гэмт хэрэг үйлдэгдэх үйл явцад нөлөөлж байдаг. Нийгмийн хүлээлт, соёлын зан заншил нь хүчирхийлэлд хандах хандлагыг тодорхойлж болно.

✓ **Зорилго:** Төрлөөр устгах гэмт хэрэг нь тодорхой бүлэг, үндэстний эсрэг явуулж буй хүчирхийллийн зорилгыг агуулдаг. Энэ зорилго нь бүлгийн устгал, дарангуйлал, эрх мэдлийн тогтолцоог баталгаажуулахад чиглэгдэж болно.

✓ **Эрх мэдлийн харилцаа, холбоо:** Субъектив тал нь төрлөөр устгах гэмт хэргийн үйл явцад оролцож буй эрх мэдлийн бүтэц, түүний төрөл, дарангуйлагчийн сэтгэл зүй, нийгмийн байр суурийг харгалзан үздэг. Энэ нь гэмт хэргийн үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, гэмт хэрэг үйлдэхээр хатгахад нөлөөлдөг.

Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал нь тухайн гэмт хэргийг үйлдэх этгээдийн дотоод сэтгэл санааны байдал, зорилго, ухамсартай үйлдлийг харуулдаг. Энэ нь гэмт хэргийг гүйцэтгэхэд оролцсон этгээдүүдийн бодит зорилго, шууд болон шууд бус санаанд анхаардаг бөгөөд дараах онцлог шинжүүдтэй:

Төрлөөр устгах гэмт хэрэг нь заавал шууд санаатай (Dolus Directus) буюу тодорхой бүлгийг устгах зорилготой байх ёстой. Энэ нь гэмт хэргийг гүйцэтгэгч этгээд тухайн бүлгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн устгахыг зориуд ухамсарлаж, үйлдэл хийсэн гэсэн үг юм. Төрлөөр устгах гэмт хэрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэргээс ялгаатай нь санаа зорилгын өндөр түвшинг шаарддаг. Үүнд ерөнхий санаа буюу хүчин төгөлдөр гүйцгэсэн үйлдэл нь өөрөө гэмт хэрэг болох ёстой. Жишээ нь, хүмүүсийг хөнөөх, гэмтээх гэх мэт. Мөн тусгай санаа (Dolus Specialis) буюу тодорхой бүлгийг устгах зорилготойгоор хийдэг явдал юм. Энэ санаа зорилго нь геноцидийн гэмт хэргийг бусад төрлийн гэмт хэргээс ялгаруулдаг.

Мөн бүлгийг нь устгах бодлого хэрэгжүүлэх; бүлгийн амьдрах орчныг зориуд хордуулах, хүнсний хомсдол үүсгэх гэх мэтээр амьдрах нөхцөлийг үгүй хийх гэх мэтээр устгах үйлдэл хийхдээ гэмт хэрэг үйлдэгч өөрийн хийж буй үйлдлийн үр дагаврыг бүрэн ухамсарласан байхыг шаардана.

Эдгээрээс үзвэл төрлөөр устгах гэмт хэргийн субъектив тал нь зориуд санаатай, үйлдлийнхээ хор уршгийг ухамсарласан эсхүл ухамсарлах бүрэн боломжтой, тухайн халдаж буй бүлгийг зориуд устгах зорилготой байдалд тулгуурладаг бөгөөд энэ нь тухайн гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг бусад гэмт хэргүүдээс ялгадаг байна.

2.2.Төрлөөр устгах гэмт хэрэгт хүлээлгэх олон улсын хариуцлага

Төрлөөр устгах гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ нь олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, болон тухайн улсын үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг. Учир нь дийлэнх тохиолдолд тухайн улсад үйлдэгдсэн төрлөөр устгах гэмт хэргийг улс дотроо гэхээс илүүтэйгээр олон улсын оролцоотойгоор шийдвэрлэдэг байна. Олон улсын болон үндэсний хуулиудад энэ

төрлийн гэмт хэргийг онц ноцтой, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцдог учир шийтгэл нь маш хүнд байдаг.

Олон Улсын Шүүхийн хариуцлага

Олон улсын түвшинд төрлөөр устгах гэмт хэргийг шийдвэрлэхийн тулд НҮБ-ын Олон улсын эрүүгийн шүүх (ICC), Югославын Олон улсын эрүүгийн шүүх (ICTY), Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR) зэрэг шүүхүүд үйл ажиллагаа явуулдаг. 1948 оны НҮБ-ын "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц" нь геноцид үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага тооцох заалтыг тусгасан бөгөөд энэ нь шүүхийн үндсэн баримт бичиг юм. Төрлөөр устгах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага нь хэд хэдэн үндсэн онцлогтой. ***Эдгээрийг дэлгэрүүлбэл:***

✓ ***Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:*** Төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэсэн, зохион байгуулсан, түүнд оролцсон этгээдүүд олон улсын эрүүгийн шүүхээр шүүгдэж, бүх насаар нь хорих ял хүртэл хүнд шийтгэл хүлээдэг.

✓ ***Хамтран оролцсон этгээдүүдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:*** Төрлөөр устгах гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, тусалсан буюу хамтран оролцсон этгээдүүд ч мөн адил гүйцэтгэсэн этгээдийн адил хариуцлага хүлээх зарчмыг баримталдаг байна.

✓ ***Эд хөрөнгө, иргэний эрхийг хасах:*** Зарим тохиолдолд шүүх төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн эд хөрөнгийг хураах, тодорхой иргэний эрхийг хасах шийдвэр гаргаж болно.

Үндэсний Хууль Тогтоомжийн хүрээнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцод нэгдэн орсон олон улс дотоодын хууль тогтоомждоо тусгаж, тус төрлийн гэмт хэргийг дотооддоо шийдвэрлэх үүрэгтэй. 2024 оны байдлаар, нийт 152 улс энэхүү конвенцид нэгдэн орсон байна. Үүнд дэлхийн бүс нутгуудын ихэнх улс орнууд багтдаг бөгөөд тэдгээр нь геноцидийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, түүнд шийтгэл оногдуулах үүрэг хүлээсэн байдаг.

Гэсэн хэдий ч, зарим улс орнууд одоог хүртэл конвенцид нэгдээгүй байна. Тухайлбал, Япон, Индонез, Малайз, Непал, Бутан, Сингапур зэрэг улсууд конвенцид нэгдээгүй хэвээр байна.

Дийлэнх улсууд төрлөөр устгах гэмт хэргийг дотоодод үйлдэгддэг гэмт хэргийн нэгэн адил Эрүүгийн хуульдаа тусгасан байдаг. Монгол улсын хувьд төрлөөр устгах гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг мөн адил Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) 2015- даа тусган зохицуулж байна.

Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шүүхийн хяналт

Геноцидийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэх нь олон улсын хууль, гэрээ хэлэлцээрт тусгагдсан зарчмын асуудал юм. НҮБ-ын Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцоор дан ганц эрүүгийн хариуцлага хүлээлгэх бус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэв гарсан тохиолдолд шүүх хяналтад оруулах

үүргийг хүлээдэг. Олон улсын шүүхүүд төрлөөр устгах гэмт хэрэгт тавьж буй хяналтыг авч үзвэл:

Нюрнбергийн Шүүх Хурал (1945-1946): Дэлхийн II дайны дараа Германы нацист удирдагчид болон геноцид үйлдсэн этгээдүүдийг хариуцлагад татахын тулд Нюрнбергийн шүүх хуралдааныг зохион байгуулсан. Нацист Германы дэглэм Холокост буюу Еврей үндэстний эсрэг төрлөөр устгах гэмт хэрэг үйлдсэн хэргээр олон удирдагчид болон офицеруудыг буруутгаж, хүнд шийтгэл оноосон³¹. Үүний үр дүнд олон нацист удирдагч цаазын ял, бүх насаар нь хорих ял хүлээсэн байдаг. Тухайлбал тус гэмт хэргийг удирдан чиглүүлэх үүрэгтэй оролцож байсан Герман Геринг, Рудольф Хесс зэрэг өндөр албан тушаалтай удирдагчид хүнд ял шийтгэл хүлээсэн³². Тус тохиолдол нь геноцид болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг олон улсын эрүүгийн эрх зүйд анх удаа тусгаж, олон улсын жишиг тогтоосон онцлох үйл явдал байв.

Руандагийн төрлөөр устгах гэмт хэрэг болон Руандагийн Олон Улсын Эрүүгийн шүүх (ICTR) (1994): 1994 онд Руандад тутси угсаатны эсрэг үй олноор нь хоморголон устгах үйл ажиллагаа явагдсан. Энэ явдал 100 хоногийн дотор 800,000 гаруй хүн амь үрэгдсэн аймшигт геноцид болж, олон зуун мянган хүн хохирсон. Руандагийн Олон улсын эрүүгийн шүүх (ICTR) хуралдаж, геноцид үйлдсэн хүмүүсийг шүүхээр шийтгэсэн.³³ Үүний хүрээнд Руандагийн геноцидийг удирдсан Хуту үндэстний зэвсэгт бүлэглэлийн удирдагчид болон дэмжигчид олон улсын эрүүгийн шүүхээс бүх насаар хорих болон урт хугацааны хорих ял шийтгэгдсэн.

Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх (ICTY) ба Сребреницагийн Төрлөөр устгал (1995): Хуучин Югослав улс задарсны дараа Боснийн дайн болж, 1995 онд Сребреница хотод 8,000 орчим Боснийн мусульман эрэгтэйчүүд болон хөвгүүдийг сербийн цэргүүд үй олноор нь хөнөөсөн. Үүнийг олон улсын шүүх геноцид гэж үзэж, Югославын Олон улсын эрүүгийн шүүхээс гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэсэн³⁴. Эл үйл явдлын хүрээнд Боснийн Сербийн удирдагч Радован Караджич болон генералуудыг бүх насаар нь хорих ялаар шийтгэсэн.

Камбожийн "Улаан Кхмерийн" Геноцид ба Камбожийн төрлөөр устгах гэмт хэргийг шийдвэрлэсэн жишээ (1975-1979): Камбожид Улаан Кхмерийн дэглэм 1975-1979 онд Пол Потын удирдлага дор сая гаруй хүнийг хоморголон устгаж, аймшигт геноцид үйлдсэн. Энэхүү гэмт хэргийг үйлдсэн удирдагчид нь олон жил өнгөрсний дараа Камбожийн геноцидийн шүүхээр шүүгдэж, шийтгэл хүлээсэн³⁵. Үүнээс Улаан Кхмерийн гол удирдагч Нуон Чеа, Киу Сампан нарыг геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгаж бүх насаар нь хорих ял оноосон.

Эдгээр жишээнүүд нь геноцид буюу төрлөөр устгах гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдэд олон улсын түвшинд болон дотоодын хууль эрх зүйн хүрээнд

³¹ Tusa, A., & Tusa, J. (1983). *The Nuremberg Trial*. Atheneum.

³² Marrus, M. R. (1997). *The Nuremberg War Crimes Trial 1945–46: A Documentary History*. Bedford/St. Martin's.

³³ Des Forges, A. (1999). *Leave None to Tell the Story: Genocide in Rwanda*. Human Rights Watch.

³⁴ Hagan, J. (2003). *Justice in the Balkans: Prosecuting War Crimes in the Hague Tribunal*. University of Chicago Press.

³⁵ Etcheson, C. (2005). *After the Killing Fields: Lessons from the Cambodian Genocide*. Praeger Security International.

хариуцлага ногдуулж байсныг илтгэдэг сонгодог жишээнүүд юм. Олон улсын эрүүгийн шүүхүүд энэ төрлийн хэргийг мөрдөн шалгаж, шийдвэр гаргах нь улс орнууд болон олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс геноцидийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чухал механизм болж байна.

Сребреницагийн аллага (1995) нь олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд “хамгаалах үүрэг” буюу (Responsibility to Protect - R2P) зарчмыг олон улсын хэмжээнд тогтоож, хэрэв аливаа улс оронд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гарвал олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс тухайн улс оронд оролцох эрх, үүрэгтэй гэсэн ойлголтыг бататгах үндэс суурь болсон юм. Responsibility to Protect (R2P) буюу Хамгаалах үүрэг³⁶ гэдэг нь олон улсын түвшинд хүн төрөлхтний эсрэг ноцтой гэмт хэргүүдийг (тухайлбал, төрлөөр устгах, хүний эрхийн ноцтой зөрчлүүд, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ) зогсоох, урьдчилан сэргийлэх зорилготой³⁷ зарчим юм. Энэ зарчмыг НҮБ-аас 2005 онд баталсан бөгөөд улс орнуудын хамтын үүрэг хариуцлагыг онцлон тэмдэглэснээрээ онцлогтой. Уг зарчмын гол зорилго нь хүний амь нас, эрх, эрх чөлөөг хамгаалах, аливаа хурцадмал үйл явдлаас урьдчилан сэргийлэх, хурцдахаас өмнө зогсоох, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг үйлдсэн аливаа этгээдүүдэд хариуцлага тооцож, хуулийн дагуу шийтгэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг юм.

Тус зарчим нь үндсэн 3 бүрдэл хэсгээс бүрдэх бөгөөд тэдгээр нь:

✓ Улс орон бүр өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүн амыг хоморголон устгах, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдээс хамгаалах анхдагч үүрэг хүлээнэ.

✓ Хэрэв аль нэг улс ард иргэдээ хамгаалах чадваргүй, эсвэл хамгаалахаас татгалзаж байгаа бол олон улсын хамтын нийгэмлэг туслалцаа үзүүлэх замаар тухайн нөхцөл байдалд оролцон асуудлыг тухайн ард иргэдийн эрхийг хамгаалах ёстой.

✓ Улс орон өөрийн үүргээ биелүүлэхээс татгалзах, эсвэл ард иргэддээ хохирол учруулж байгаа тохиолдолд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр олон улсын нийгэмлэг тухайн асуудалд цэргийн болон бусад хүч хэрэглэн оролцох эрхтэй;

Хэдийгээр уг зарчим нь аливаа улсад гарч буй хүний эрхийн ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой хэдий ч хэд хэдэн шүүмжлэлийг дагуулдаг. Тухайлбал улс орнууд R2P-ийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн улс төрийн шахалт, ашиг сонирхлын зөрчилд автах, R2P нэрийн дор томоохон гүрнүүд өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор хүч хэрэглэх, бага, дунд орнуудыг дарамтлах хэрэгсэл³⁸ болж хувирах эрсдэлтэй хэмээн үздэг байна.

2.3.Төрлөөр устгах гэмт хэрэг ба R2P зарчим

1990-ээд оны эхээр хуучин Югослав улс задрахад Босни ба Херцеговина улс тусгаар тогтнолоо зарлаж, энэ нь олон үндэстэн оршин суудаг Босни улсын доторх Серб, Босни, Хорват үндэстнүүдийн хооронд хурцадмал байдал үүсгэсэн.

³⁶ John Janzekovic, Daniel Silander, "Responsibility to Protect and Prevent: Principles, Promises and Practicalities," 2017.

³⁷ S. Grover (Ed.), "The Responsibility to Protect: Perspectives on the Concept's Meaning, Proper Application and Value," 2020.

³⁸ Alex J. Bellamy, Edward C. Luck, "The Responsibility to Protect: From Promise to Practice," 2011.

Улмаар Боснийн Серб үндэстнүүдийн арми Боснийн бусад үндэстний хүмүүсийг тэр дундаа, Мусульман Босни иргэдийг хоморголон устгах зорилготой үйлдэл явуулж эхэлсэн.

Сребреницагийн аллага нь 1995 онд Югославын дайны үед Босни ба Херцеговина улсын Сребреница хотод болсон, орчин үеийн Европын түүхэн дэх хамгийн их хохирол, хор уршиг дагуулсан төрлөөр устгах гэмт хэргийн нэг юм. Энэхүү үйл явдлаар Боснийн Сербийн цэргийн хүчнийхэн 8,000 орчим Босни эрэгтэйчүүд, хөвгүүдийг алсан. Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Сребреницаг "аюулгүй бүс"³⁹ гэж зарлаж, иргэдийг хамгаалахаар болсон ч бодит байдал дээр хамгаалалт хангалтгүй байж, НҮБ-ын хамгаалалт дор байсан Сребреница хотын Босни иргэдийг төд удалгүй устгаж эхэлсэн.

1995 оны 7-р сарын 11-нд Боснийн Серб армийн генерал Ратко Младичийн удирдлага дор Сербийн цэргүүд Сребреницаг эзлэн, НҮБ-ын хамгаалалтад байсан 25,000 орчим Босни иргэнийг хотоос гаргах нэрээр хувааж, эрэгтэйчүүд, хөвгүүдийг олны нүднээс далд газар амь насыг хөнөөж байв. Эрэгтэйчүүдийн хоморголон амь насыг нь хороох үйл явц нь 14–65 насны Босни эрэгтэйчүүдийг хүчээр ялгаж, зэрлэгээр хөнөөсөн бөгөөд тэднийг голдуу ой мод, үйлдвэр, хуучин барилгуудад аваачин, бөөнөөр нь буудан устгаж байв. Хэдхэн хоногийн дотор 8,000 орчим босни эрчүүд, хөвгүүд амиа алдсан⁴⁰. Харин Сребреница хотод байсан эмэгтэйчүүд, хүүхдүүдийг Боснийн бусад нутаг руу цөлж, гэр бүлээс нь салгах байдлаар дарамтлан айлгаж байсан. Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, доромжлох тохиолдол ч элбэг байсныг эх сурвалжуудад тэмдэглэжээ.

Сребреницагийн аллагын үед НҮБ-ын энхийг сахиулагчид хязгаарлагдмал эрх мэдэл, хязгаарлагдмал зэвсгийн нөөцтэй байсан тул энэ аймшигт хэргийг зогсоож чадаагүй. Нидерландын энхийг сахиулагчид Сребреницагийн иргэдийг хамгаалах боломжгүй болсон учир Сербүүдэд хотоо алдах сонголт хийхэд хүрсэн. Олон улсын хамтын нийгэмлэгийн сул ажиллагаа, НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэргүй байдал нь тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг алдсан хэрэг болж, Сребреницагийн аллагын хариуцлагыг НҮБ-ын зүгээс ч хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн.⁴¹

Уг гэмт хэргийг олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд онцгойлон авч үзэн, Хуучин Югославын асуудлаар байгуулагдсан Олон улсын эрүүгийн шүүх (ICTY) Ратко Младич болон бусад Серб удирдагчдыг төрлөөр устгалт, дайны гэмт хэрэгт буруутгаж шүүх ажиллагаа явуулсан⁴². 2017 онд Ратко Младичийг бүх насаар нь хорих ял оноож, энэ нь олон улсын хамтын нийгэмлэгт хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг хүлээн зөвшөөрүүлэх, шударга ёсыг тогтоох чухал алхам болсон юм. Тус гэмт хэргийн хүрээнд аливаа хариуцлага ногдуулсан нь дан ганц олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд хөгжлийг дагуулсан алхам болсноос гадна олон улсын хамтын нийгэмлэгийн үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах томоохон сургамж болсон. Тухайн үед НҮБ болон бусад олон улсын байгууллагуудын зохион байгуулалт, шийдвэр гаргах ажиллагааны удаашрал нь гэмгүй хүмүүсийн амь насыг авч одсон хэрэг болсон тул олон улсын эрх зүйн тогтолцоог дахин шинээр

³⁹ Madeleine Albright, "The UN's Role in the Srebrenica Genocide," (essays published in the late 1990s and early 2000s).

⁴⁰ Sarah Wagner, "To Know Where He Lies: DNA Technology and the Search for Srebrenica's Missing," 2008.

⁴¹ Jan Willem Honig and Norbert Both, "Srebrenica: Record of a War Crime," 1996.

⁴² David Rohde, "Srebrenica: A 'Safe' Area," 1997.

харж, хүчирхийллийн эсрэг шуурхай арга хэмжээ авах талаар олон талын судалгаа, бодлогын өөрчлөлт хийгдсэн.

III. Харьцуулсан судалгаа

Судалгааны энэхүү хэсэгт Англи Саксон буюу Англи Америкийн эрх зүйн тогтолцоо бүхий улсаас АНУ; манай улсын нэгэн адил Ром Германы эрх зүйн тогтолцоо бүхий улсаас ХБНГУ тус тус сонгон авч судалсан болно.

АНУ-ын төрлөөр устгах гэмт хэрэгт баримталж буй эрх зүйн зохицуулалтын онцлог:

АНУ нь 1948 оны “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц”-д 1988 онд нэгдэн орсон бөгөөд үүнийхээ хүрээнд “төрлөөр устгах” буюу *геноцид* гэмт хэрэгт хариуцлага тооцох, түүнийг шийдвэрлэх зохицуулалтыг Холбооны Эрүүгийн хуульдаа тусган зохицуулж байна.

Тухайлбал АНУ-ын Холбооны Эрүүгийн хуулийн 18-р зүйлд “төрлөөр устгах гэмт хэрэг”-ийг “Үндэстэн, гарал үүсэл, арьсны өнгө, шашин зэргийн үндэслэлээр бүлгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн устгах зорилгоор дараах үйлдлийг хийх нь геноцидэд хамаарна. Үүнд:

- ✓ Тухайн бүлгийн гишүүдийг устгах /амь насыг хохироох/;
- ✓ Хүнд гэмтэл учруулах;
- ✓ Бие махбод болон сэтгэл санааны хувьд ноцтой хохирол учруулах;
- ✓ Тухайн бүлгийн нөхөн үржихүйд хор хохирол учруулах арга хэмжээ авах;
- ✓ Тухайн бүлгийн хүүхдүүдийг өөр бүлэгт хүчээр шилжүүлэхийг ойлгоно” хэмээн тодорхойлжээ.

Харин эрүүгийн хариуцлагын тухайд дээрх үйлдлүүдэд АНУ-ын зүгээс төрлөөр устгах гэмт хэрэгт тооцон, түүнийг үйлдсэн, хамтран үйлдсэн этгээдэд бүх насаар нь хорих, цаазаар авах хүртэл ял ногдуулахаар заасан байна.

Түүнчлэн АНУ-н хувьд төрлөөр устгах гэмт хэргийн тухайд өмнө дурдсан Төрлөөр устгах гэмт хэргийн конвенц, Эрүүгийн хуулиас гадна “Төрлөөр устгах гэмт хэрэгт хариуцлага ногдуулах тухай (2007) хуулийг тус төрлийн гэмт хэрэгт хариуцлага тооцоход ашиглаж байна. Тус хууль нь АНУ-д хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хариуцлага тооцох эрх хэмжээг өргөтгөсөн чухал хууль юм. Энэ хууль батлагдахаас өмнө АНУ геноцидийн хэргийг зөвхөн АНУ-ын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн тохиолдолд л мөрдөн шалгах боломжтой байв. Харин 2007 оны хууль нь геноцид үйлдсэн АНУ-ын иргэн эсвэл гадаадын иргэн АНУ-д байгаа тохиолдолд тэдэнд хариуцлага тооцох эрхийг АНУ-д олгосон гэж ойлгож болно. Гол онцлог нь 1. Өргөтгөсөн эрх мэдлийг АНУ-ын шүүхэд олгосон буюу геноцид үйлдсэн этгээд АНУ-д оршин сууж байгаа бол үйлдсэн улс орноосоо үл хамааран АНУ-д шүүх эрх зүйн боломж; 2. Хуулийн дагуу буруутай этгээдэд бүх насаар хорих, зарим нөхцөлд цаазаар авах хүртэл хатуу ял оноох эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна.

Гэсэн хэдий ч Төрлөөр устгах гэмт хэрэгт хариуцлага ногдуулах тухай (2007) хуулийг практикт хэрэгжүүлэхэд дараах хэд хэдэн сорилтууд тулгарч байгаа нь а. Төрлөөр устгах гэмт хэргийн субъектив талыг хэрхэн нотлох талаар өнөөг хүртэл эргэлзээтэй хэвээр байна. Учир нь тодорхой бүлгийг устгах санаа бүхий

үйлдэл гэдгийг батлахад хүндрэлтэй байдгаас гадна бусад төрлийн гэмт хэргүүдтэй харьцуулахад илүү нотлох баримт шаардагддаг; b. Шүүхийн жишиг боловсронгуй болоогүй. Өөрөөр хэлбэл тус хуулийг ашигласан тохиолдолд АНУ-д маш цөөн. Учир нь сэжигтэн этгээдүүдийг АНУ-д олох, нотлох баримт цуглуулах зэрэг нь ихээхэн хүндрэлтэй байдаг явдал юм.

ХБНГУ-н төрлөөр устгах гэмт хэрэгт баримталж буй эрх зүйн зохицуулалтын онцлог, төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) нь төрлөөр устгах гэмт хэргийг дотоодын хууль тогтоомждоо тусгаад зогсохгүй тус гэмт хэргийн эсрэг хэд хэдэн чухал олон улсын гэрээ, конвенцод нэгдсэн бөгөөд эдгээр нь уг гэмт хэргийг хориглох, шийтгэх, түүнчлэн урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагаанд оролцох үүргийг хүлээлгэдэг.

Тус улс нь олон улсын эрх зүйд, ялангуяа төрлөөр устгах гэмт хэргийг тогтоох, шүүх ажиллагаанд оролцох, хариуцлага тооцох чиглэлд идэвхтэй оролцож ирсэн. Германы шүүхүүд олон улсын эрүүгийн шүүхүүдтэй хамтран төрлөөр устгах гэмт хэргийн үйлдлийг мөрдөн шалгах, буруутгагдсан этгээдүүдийг баривчлах ажиллагаанд оролцохоос гадна уг хэргийг олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэх, мөн олон улсын хариуцлагыг бататгах үйл явцад хувь нэмэр оруулдаг бөгөөд төрлөөр устгах гэмт хэргийг зохих ёсоор шийдвэрлэхэд чухал үүрэгтэй оролцож ирсэн.

ХБНГУ нь 1948 оны "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц" 1954 оны 2 дугаар сарын 22-нд нэгдэн орсон бол Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (1998 он)-д 1998 оны 12 дугаар сарын 10-нд гарын үсэг зурж, 2000 оны 12 дугаар сарын 11-нд соёрхон баталсан. Үүнтэй зэрэгцэн 1945 оны Нюрнбергийн шүүхийн дүрэм болон Женевийн конвенцууд ба тэдгээрийн нэмэлт протоколуудад мөн нэгдэн орж, тус гэрээ конвенциудаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, олон улсын хэмжээнд хамтран ажиллах, дотоодын хууль тогтоомждоо тусгах үүргийг өмнө дурдсан улсуудын адил хүлээсэн.

Төрлөөр устгах гэмт хэргийг зохицуулсан эдгээр олон улсын гол баримт бичгүүдээс гадна ХБНГУ нь Европын хүний эрхийн конвенц (1950 он)-д нэгдэн орсон явдал бөгөөд энэ нь хүний амьдрах эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хамгаалах өргөн агуулгыг багтаахын зэрэгцээ төрлөөр устгах гэмт хэрэг зэрэг хүн төрөлхтний эсрэг ноцтой гэмт хэргүүдтэй тэмцэх үндэс суурь болдог. Европын хүний эрхийн конвенц (European Convention on Human Rights, ECHR)⁴³ нь 1950 оны 11-р сарын 4-нд Ром хотод батлагдаж, 1953 оны 9-р сарын 3-нд хүчин төгөлдөр болсон Европын Зөвлөлийн хамгийн чухал баримт бичгүүдийн нэг юм. Уг конвенц нь Европын орнуудын иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг зөрчихөөс сэргийлэх зорилготой. Тус баримт бичгээр төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг шууд нэрлэдэггүй ч улсууд конвенцийн хүрээнд өөрийн нутаг дэвсгэрт хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй хариу арга хэмжээ авах үүрэгтэй" талаар тусгасан байдаг. ХБНГУ нь 1952 оны 1-р сарын 7-нд Европын хүний эрхийн конвенцод гарын үсэг зурж, 1953 оны 9-р сарын 3-нд соёрхон баталжээ. Энэ нь Германы хууль

⁴³ USHMM (United States Holocaust Memorial Museum): Энэ байгууллага нь Холокостийн тухай дэлгэрэнгүй судалгаа хийж, олон эх сурвалжаар дамжуулан Холокостийн үйл явдлыг илтгэн харуулдаг.

тогтоомжийг конвенцын заалтуудад нийцүүлж, хүний эрхийг дотооддоо хамгаалахаас гадна олон улсын түвшинд үүрэг хүлээхэд хүргэсэн.

Эдгээрээс үзвэл Герман улс төрлөөр устгах гэмт хэргийн эсрэг олон улсын конвенц болон Европын хүний эрхийн системийн хэм хэмжээг үндэсний хуульдаа тусгаж, төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг шүүх эрх зүйн тогтолцоогоо бүрдүүлсэн.

ХБНГУ 2002 онд баталсан Олон улсын эрүүгийн хуулийн кодексоор (VStGB) төрлөөр устгах гэмт хэргийг үндэсний хэмжээнд эрүүгийн хуулиар хориглож, олон улсын эрх зүйн дагуу хариуцлага хүлээлгэх эрх зүйн механизмыг бүрдүүлсэн. Германы Эрүүгийн хуулийн 6-р бүлэгт төрлөөр устгах гэмт хэргийг “тодорхой бүлгийн гишүүдийг устгах, хүндээр гэмтээх, нөхөн үржихүйн чадварыг нь сулруулах, эсвэл бүлгийн бүтцийг сүйтгэх зорилготой үйлдэл бөгөөд энэ нь үндэс, угсаа, арьс өнгө, шашны бүлэг хүмүүсийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгт хамаарна” хэмээн тодорхойлсон байдаг. Тус гэмт хэрэгт бүх насаар нь хорих ял эсхүл цаазаар авах ял оногдуулахаар заасан хэдий ч 1951 оноос хойш цаазаар авах ял Германд хязгаарлагдсан тул энэ төрлийн гэмт хэргийг насан туршийн хорих ялаар шийтгэхээр зохицуулж байна.

Дүгнэлт

Төрлөөр устгах гэмт хэргийн хувьд тодорхой бүлэг, үндэстнийг устгах зорилготой систем, төлөвлөгөөт хүчирхийллийн хэлбэр бөгөөд анх 1944 онд хуульч Рафаэль Лемкиний судалгаагаар энэ нэр томъёо үүсчээ. Улмаар НҮБ-ын 1948 оны "Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц"-ээр төрлөөр устгах гэмт хэргийг олон улсын гэмт хэргийн нэг төрөл болгон албан ёсоор эрх зүйн баримт бичигт тусгагдсан байна.

Олон улсад төрлөөр устгах гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлсон онолын олон хандлага төлөвшсөн байх агаад тэдгээр нь төрлөөр устгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг нийгмийн бүтэц, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн зөрчилдөөн, цөөнхийг ялгаварлан гадуурхах үзэл хандлага, нийгмийн сэтгэл зүй хандлагын үүднээс авч үзэн, өнөөг хүртэл хэрэглэгдэн тогтжээ. Эдгээр үзэл хандлага нь дэлхий дахины түүхэнд болж өрнөсөн төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдол бүрээр мөн нотлогдож, энд улс орны онцлог бүрээс шалтгаалсан ялгаатай үйл баримтууд тэмдэглэгдэн үлдсэн байна.

Ийнхүү болж өрнөсөн тохиолдлууд нь дан ганц хүчирхийлэл бус, улс төр, соёл, нийгмийн үзэл санааны гажуудлаас үүдсэн системтэй устгал бөгөөд олон улсын хамтын ажиллагаагаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох томоохон сорилтыг хүн төрөлхтний эрүүгийн эрх зүйн хөгжлийн явцад бий болгожээ.

Гадаад улсуудын хувьд төрлөөр устгах гэмт хэргийн тохиолдлууд гарсан хэдий ч олон улсын шүүхээр түүний заримд нь шийтгэл ногдуулан, заримд нь шийтгэл ногдуулах хангалттай үндэслэлийг нотолж чадаагүй байна. Эдгээр тохиолдлуудыг судлан үзэхэд төрлөөр устгах гэмт хэрэг дан ганц хүн ам, бүлгийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахаас гадна тухайн онцлог хэв шинж бүхий бүлэг, холбоо хамаарал бүхий улсын соёл, уламжлал, эдийн засаг, шашин шүтлэг, амьдралын нөхцөл зэрэгт үнэлж баршгүй хохирол дагуулж буй юм. Эдгээрт хариуцлага ногдуулахад дан ганц улс дотооддоо шийдэхэд учир

дутагдалтай бөгөөд олон улсын хамтын зарчмаар Олон улсын Эрүүгийн шүүх болон бусад холбогдох шүүхүүдээр шийдвэрлэж байна.

Ийнхүү шийдвэрлэхэд олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ болох Responsibility to Protect (R2P) буюу Хамгаалах үүргийг улс орнууд холбогдох хууль тогтоомждоо тусгах, түүнийг биелүүлэхийг эрмэлзэх нь улс орон бүр өөрийн нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүн амыг хоморголон устгах, дайны гэмт хэргүүд, этник цэвэрлэгээ, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүдээс хамгаалах чухал алхам болох юм.

Зөвлөмж

✓ **Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх:** Улс орнууд төрлөөр устгах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох олон улсын механизмуудыг (НҮБ, Олон улсын эрүүгийн шүүх гэх мэт) үр дүнтэй ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, тэдгээртэй хамтран ажиллах шаардлагатай. Хэрэг хянан шийдвэрлэх болон нотлох баримтыг бүрдүүлэх үйл ажиллагааг хурдасгахын тулд мэдээлэл солилцох тогтолцоог сайжруулах нь чухал.

✓ **R2P зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарах:** Улс орнууд R2P зарчмын дагуу иргэдийнхээ эрхийг хамгаалах үндсэн үүргээ хүлээн зөвшөөрч, энэ чиглэлд бодлого, зохицуулалтаа сайжруулах хэрэгтэй. Мөн R2P зарчмыг улс төрийн ашиг сонирхлоос ангид, зөвхөн хүний эрхийг хамгаалах үндсэн зорилгоор хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

✓ **Шүүмжлэл, эрсдэлийг багасгах:** R2P зарчмыг хэрэгжүүлэх явцад их гүрнүүдийн улс төрийн ашиг сонирхлын нөлөөллийг багасгах, ил тод, хариуцлагатай хэрэгжүүлэх механизмыг бий болгох шаардлагатай. Үүнд олон улсын байгууллагуудын хяналт, шалгалтын тогтолцоог бэхжүүлэх нь чухал.

✓ **Дотоодын хууль эрх зүйн орчныг сайжруулах:** Улс орнууд дотоодын хууль тогтоомждоо геноцидийн гэмт хэргийг тодорхойлж, хатуу хариуцлага ногдуулах заалтуудыг нэмж тусгах хэрэгтэй. Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулиа олон улсын стандартад нийцүүлэх, төрлөөр устгах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх талаар илүү нарийвчилсан зохицуулалтыг боловсруулах шаардлагатай.

Ашигласан материал

- Василенко, В.А. - "Геноцидийн тухай ойлголт ба түүний эрх зүйн зохицуулалт", 1999 он
- Василенко, В.А. - "Олон улсын эрүүгийн эрх зүйн асуудал дахь геноцид", 2003 он
- Василенко, В.А. - "Гэмт хэргийн төрөл ба ангилал", 2005 он
- Tusa, A., & Tusa, J. (1983). The Nuremberg Trial. Atheneum.
- Marrus, M. R. (1997). The Nuremberg War Crimes Trial 1945–46: A Documentary History. Bedford/St. Martin's.
- Des Forges, A. (1999). Leave None to Tell the Story: Genocide in Rwanda. Human Rights Watch.
- Hagan, J. (2003). Justice in the Balkans: Prosecuting War Crimes in the Hague Tribunal. University of Chicago Press.
- Etcheson, C. (2005). After the Killing Fields: Lessons from the Cambodian Genocide. Praeger Security International.
- John Janzekovic, Daniel Silander, "Responsibility to Protect and Prevent: Principles, Promises and Practicalities," 2017.

- S. Grover (Ed.), "The Responsibility to Protect: Perspectives on the Concept's Meaning, Proper Application and Value," 2020.
- Alex J. Bellamy, Edward C. Luck, "The Responsibility to Protect: From Promise to Practice," 2011.
- Madeleine Albright, "The UN's Role in the Srebrenica Genocide," (essays published in the late 1990s and early 2000s).
- Sarah Wagner, "To Know Where He Lies: DNA Technology and the Search for Srebrenica's Missing," 2008.
- Jan Willem Honig and Norbert Both, "Srebrenica: Record of a War Crime," 1996.
- David Rohde, "Srebrenica: A 'Safe' Area," 1997.

ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХИЙГ ХҮНИЙ ГЕНЕТИКИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМААР ХАМГААЛАХ НЬ

PROTECTING THE RIGHT TO BE FREE FROM DISASTER BY MEASURING THE
LEGAL REGULATION OF HUMAN GENETIC ANALYSIS

Ц.Амарсанаа

Шихихутуг их сургуулийн докторант

Товч агуулга: Улс орнуудад хүний генетикийн шинжилгээ, оношилгоо хийх, түүн дээр туршилт хийх үйл ажиллагаа явагдаж эхэлсэнтэй зэрэгцэн түүнээс гарах ололт, амжилт болон хор уршгийн талаар санал шүүмж дэлгэрэн гарч ирсэн. Үүний цаана хүний халдашгүй байх эрхийн асуудал хөндөгдөж буй юм.

Хүний генетикийн шинжилгээ, оношилгоо хийхтэй холбоотой харилцааг хууль батлан гаргах замаар зохицуулж эхэлсэн бөгөөд зарим улсын хувьд Үндсэн хуульдаа тусгаж өгсөн байна. Мөн бие даасан хуулийг батлан гаргаж байна.

Монгол Улсын хувьд хүний генетик оношилгоо хийхтэй холбоотой харилцааг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Донорын тухай хууль зэрэгт хэсэгчлэн ерөнхий байдлаар зохицуулж байна.

Энэхүү өгүүлэл нь халдашгүй байх эрхийн хүрээг зөв тодорхойлох, хүний генетик шинжилгээ, оношилгоо хийхтэй холбоотой харилцааг хуульд оновчтой тусгах, бие даасан хууль батлан гаргах ач холбогдлыг тогтоох, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж бусад улсын оновчтой хуулийн зохицуулалтыг тусгах санал гаргахад чиглэсэн болно.

Abstract: As human genetic testing, diagnosis, and experimentation have begun in countries, opinions and criticisms have been widely expressed about the achievements, successes, and harms of these efforts. Behind this, the issue of human rights to inviolability is being raised.

Relations related to human genetic testing and diagnosis have begun to be regulated by law, and some countries have included them in their constitutions. Independent laws are also being enacted.

In Mongolia, relations related to human genetic diagnosis are partially regulated in general terms in the Criminal Code, the Law on Offenses, the Law on Forensic Examination, the Law on the Courts of Mongolia, the Law on the Protection of Personal Information, the Law on Health, the Law on Medical Care and Services, and the Law on Donors.

This article aims to correctly define the scope of the right to privacy, to properly reflect the relationship between human genetic testing and diagnosis in law, to determine the importance of enacting independent legislation, and to analyze the legislation in force in Mongolia and make proposals to reflect the appropriate legal regulations of other countries.

Түлхүүр үгс: Ген, геном, генетик, хүний ген, гений инженерчлэл, ген шилжүүлэн суулгасан, генетикийн шинжилгээ, оношилгоо

Keywords: Gene, genome, genetics, human genes, genetic engineering, transgenic, genetic testing and diagnosis

Эрхийн тухай ойлголтыг С.Нарангэрэлийн Эрх зүйн эх тайлбар бичигт “тодорхой этгээд, төрийн байгууллага, улс түмэн, төр буюу бусад субъектийн боломжтой зан үйлийн төрөл зүйл ба хэмжээ” (С.Нарангэрэл, 2008) хэмээн тайлбарлажээ. Харин хүний эрхийн тухайд Б.Чимид “хүнд өөрт нь байдаг төрөлх шинж, мөн чанар” (Б.Чимид, 2004) гэсэн бөгөөд үүнийг субъектив эрх гэж тодорхойлсон байна.

НТӨ VI-V зууны үед хот улсуудад анх удаа “иргэний тухай”, “тэдний эрх үүргийн тухай” төсөөлөл бий болжээ. МЭӨ V зууны үед эртний Грекийн софистуудын боловсруулсан байгалиас заяасан жам ёсны буюу заяамал эрхийн сургаалаас эхтэй. Энэ нь МЭӨ III зууны үеийн Ромын хуульчдын жам ёсны эрх зүй номлолоор баяжиж (Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, 2007) хөгжжээ. Аристотель “жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрсөн ч, эс зөвшөөрсөн ч хаана ч хэзээ ч үл өөрчлөгдөх, мөнх оршиж, дээд хүчин чадалтай байдаг эрх” (Х.Сэлэнгэ, 2013) гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Америкийн түүхэн эх сурвалж-тунхаглалуудад “эрх”, “салшгүй” эсвэл “заяагдмал эрх” гэсэн нэр томъёонуудыг хэрэглэж ирсэн бол Францын Хүний болон иргэний эрхийн тухай тунхаглалд “хүний эрх” болон “иргэдийн эрх” гэсэн ойлголтуудыг хооронд нь ялган, тусад нь авч үзсэн байдаг. 1867 оны Австрийн Төрийн тулгуур хуульд “төрлөх иргэдийн түгээмэл эрхүүд”-ийг бэхжүүлсэн байдаг. XIX зууны дунд үеэс эхлэн дэлхий нийтийн хууль зүйн утга зохиолд үндсэн хуульд заасан эрхүүдийг иргэн бүрд олгож буй Үндсэн эрхүүд гэсэн утгаар нэг мөр ойлгож эхэлсэн юм. (Й.Изензее, 1994)

Хүний үндсэн эрх хэмээх ойлголтыг олон улсын хэм хэмжээнд хүний эрх, эрх чөлөө гэх байдлаар тусгадаг. Угтаа дээрх агуулга нь адил байх бөгөөд үндэсний хууль тогтоомжид зааснаар хязгаарлагдахгүй өргөн цар хүрээтэй байдлаар тайлбарладаг. Үүнтэй уялдуулан үндсэн эрхийг үндсэн хуультай улсууд хүний эрх, эрх чөлөө гэх нэр томъёогоор тусгаж өгсөн байна. Энэхүү үндсэн (жам ёсны) эрхэд “халдашгүй байх эрх” хамаардаг бөгөөд түүнийг эрдэмтэн, судлаачид болон олон улсын гэрээ, конвенцод дараах байдлаар тусгасан байна.

Хувийн эрх, эрх чөлөө гэж өөрийн гэсэн үзэл бодол, итгэлтэй байж түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, хувийн халдашгүй байх, нэр төр, алдар хүндээ хүндэтгүүлэх, хувийн нууц төрийн хамгаалалтад байх зэрэг аливаа хүний хувийн амьдралын хүрээний бүхий л нөхцөл, бололцоог хэрэгжүүлэх боломжийн нийлбэр мөн. Хувийн эрх, эрх чөлөөнд төрсөн цагаас хүн бүрт заяагдсан жам ёсны халдашгүй эрхүүд багтдаг бөгөөд эдгээр эрх, эрх чөлөөгүйгээр бусад эрх, эрх чөлөө нь утга учраа алдана. (Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн эрх зүй, 2007)

Халдашгүй, чөлөөтэй байх эрх нь онолын хувьд хүний салгаж үл болох үндсэн эрх гэх ойлголтод хамаарах эрх зүйн философийн үндсэн ухагдахуун бөгөөд жам ёсны эрхийн онолд хамаардаг. Халдашгүй эрх нь хууль зүйн нэр томъёоны хувьд “*inviolability*”, “*immunity*”, “*privacy*”, “*inviolability of home*”, “*inviolability of individual life*” гэх ойлголтуудаар илэрхийлэгдсэн байдаг.

Х.Виктор Кондегийн Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлагад “Бүрэн бүтэн байдлын эрх (Integrity rights). Хүний оюун санаа, бие бялдар, ёс суртахууны бүрэн бүтэн байдлыг хамгаалах эрхийг илэрхийлсэн үг.” Бүрэн бүтэн байдал нь сайн сайхан, өв тэгш, эрүүл саруул аюулгүй байдлыг агуулдаг. Жишээлбэл, амьд явах, эрүү шүүлтээс ангид байх эрх чөлөө, шүтэж бишрэх, сүсэглэх эрх чөлөө, хувийн халдашгүй эрх, өөрийн гэр бүлтэй байх эрх” (Кондэ,

1999) хамаарна гэж тайлбарласан байна. В.В.Маклаковын Эрх зүй ба төрийн онол номд халдашгүй байх эрхийн агуулга нь "...сайн дурын зөвшөөрөлгүйгээр шинжлэх ухааны болон эмнэлгийн туршилт хийхийг хориглоно" (В.В.Манова, 1996) гэж тусгасан байна.

Б.Чимид Үндсэн хуулийн мэдлэг номдоо "иммунитет"-ийг "...дотоодын эрх зүйд "дархан эрх" буюу "дархлаа"" (Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008) гэж үзсэн байна.

Г.Совд "Хүн бүр халдашгүй чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх юм" (Г.Совд, 1999) хэмээн тодорхойлсон бол Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар нарын Үндсэн хуулийн эрх зүй номд эрх чөлөөтэй болон халдашгүй дархан эрхийн талаар "Хүн бүр хөндлөнгийн оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй" (Д.Лүндээжанцан, 2000) гэж тайлбарлажээ.

Н.Лүндэндорж Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар номдоо "Халдашгүй байдал" гэсэн ойлголт латин хэлний "чөлөөтэй", "дархлаатай" гэх зэрэг утгыг агуулсан "immuntias" үгээс гаралтай. "Иммуитет" нь уг гарлаараа байгалийн шинжлэх ухааны нэр томъёо бөгөөд гаднын бүхий л төрлийн нөлөөллөөс өөрийгөө хамгаалах организмын дархлааны тогтолцоог энэ ойлголтоор тэмдэглэдэг. Өөрөөр хэлбэл, гаднын вирус, бактери зэргээс өөрийгөө хамгаалах дархлааны тогтолцоо аливаа организмд байдаг. Тийм ч учраас байгалийн шинжлэлд "дархлаа"-г иммуитет гэж нэрлэдэг" (Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль. Шинжлэх ухааны тайлбар, 2022) хэмээн тайлбарласан байна.

Ц.Товуусүрэнгийн Үндсэн хуулиа ойлгохуй (үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар) номд "бие махбод нь халдашгүй байх эрх нь ямар ч тохиолдолд хэн ч эрх чөлөөт хүнээ аливаа үйлдэл хийлгэх, эс хийлгэхийн тулд дарамтлах, хувийн нууцыг нь дэлгэрүүлэх, үг хэлүүлэх, мэдүүлэг өгүүлэх зорилгоор албадах, бие, сэтгэлийг нь шаналгаж, өвтгөн зовоох хэлбэрээс ангид байх шинжээр баталгааждаг" (Ц.Товуусүрэн, 2024) гэжээ.

Хүний халдашгүй эрх гэж өөрийнх нь төрөлх, жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй, мөн чанарын хувьд төрөөс тогтоосон биш зөвшөөрсөн байх бөгөөд эрх зүйн хэм хэмжээгээр бэхжигдэж, хамгаалагдсан, хөндлөнгийн хэн ч дур мэдэн хөндөж, хязгаарлаж үл болох хэд хэдэн туйлын эрхийн цогц юм.

Хүний халдашгүй эрх гэдэг нь "өөрийн жам ёсны шинж чанараас үүдэлтэй бөгөөд хуулиар тогтоосон үндэслэл, журмаас гадуур аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулахгүй байх нь халдашгүй байх эрхийн үндсэн агуулга юм." (Г.Агар-Эрдэнэ, Хүний эрхийн товч тайлбар, 2014), түүнчлэн халдашгүй эрхийн ангилалтыг тусгаж өгсөн байна. Үүнд:

- эрх чөлөөтэй байх;
- бие махбодын халдашгүй байх эрх;
- орон байрны халдашгүй байдал;
- нууцын халдашгүй байдал;
- нэр төрийн халдашгүй байх эрх;
- өмчийн халдашгүй байх эрх;
- захидал харилцааны халдашгүй эрх зэрэг болно. (Г.Агар-Эрдэнэ, Хүний эрхийн товч тайлбар, 2014)

Бие махбодын халдашгүй байх эрхийн хүрээнд хүний биеийг үүсгэн бүрдүүлэгч нэгж болох хүний ген, геном, генетик нь шууд утгаараа хамаарах юм. Энэ утгаараа бие махбодын халдашгүй байх эрхийг нарийвчлан үзвэл хүний генетикийн халдашгүй байх эрх хэмээн тайлбарлаж болох юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр...халдашгүй дархан байх эрхтэй”, 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.” (Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948) гэж заасан байдаг.

Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй...” (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1976), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактын тунхаглал оршилд “...угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх...” (Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, 1966), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлд “Энэхүү Конвенцын зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.” гэж тус тус тусгажээ.

Түүнчлэн дайны үе, хоёр буюу хэд хэдэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хооронд үүсэж болох зарласан дайн буюу аливаа бусад зэвсэгт мөргөлдөөний бүх тохиолдолд зэрэгт хэрэгжих Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн конвенцын 32 дугаар зүйлд “Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд эрх мэдэлдээ байгаа хамгаалагдсан хүмүүсийн бие махбодод хохирол учруулах буюу тэдний амийг хөнөөхөд хүргэх аливаа арга хэмжээ авахыг хориглох талаар тусгайлан хэлэлцэн тохирно. Эдгээр хориглолтод амийг хөнөөх, эрүү шүүлт тулгах, бие махбодыг зовоон тарчлаах, тахир дутуу болгох болон хамгаалагдсан хүмүүст шаардлагагүй эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийх зэрэг хамаарагдахаас гадна бас энгийн иргэд, эсхүл зэвсэгт хүчний зүгээс хийж болох бүх төрлийн хүчирхийлэл хамаарагдана.” (Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай женевийн (iv) конвенц, 1950) гэж заажээ.

Харин тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн олон улсын гэрээ конвенцод дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийн конвенц (Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989)-ийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.”;
- Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын 5 дугаар зүйлийн (b)-д “...хувийн аюулгүй байдлаа хангуулах эрх;” (Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 1969);

- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын оршилд “...хүн бүр эрх чөлөөтэй, нэр төр, эрхийн хувьд тэгш төрдөг бөгөөд тус тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг аливаа ялгаварлалгүйгээр, тухайлбал, хүйсээр ялгаварлалгүйгээр эдлэх ёстой” (Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1979);
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, 1984)-ийн оршилд “...Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд заасныг харгалзан..” зэрэгт тусгасан. Үүнээс үзвэл, хүний халдашгүй, чөлөөтэй байх гэдэг эрх нь хүний үндсэн эрх байх бөгөөд дан ганц бусдын нөлөөллөөс ангид байх, гэдэг агуулгаас гадна бусад эрхийн суурь болдог байна.

Монгол Улсад халдашгүй эрхийн тухайд. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан.

Энэ нь хүний:

- хүний бие;
- нэр төр;
- хувийн болон гэр бүлийн нууц;
- захидал харилцаа;
- орон байрны халдашгүй эрхийг албан тушаалтан болон бусад хүмүүсийн дур зоргоороо аашлан халдах явдлаас хамгаалах асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулсан учраас эдгээр эрх чөлөөнд хэн боловч хуульд заасан үндэслэл, журмаас гадуур халдах эрхгүй байна. (Г.Совд Н. , 2000)

Монгол Улсын хуульч эрдэмтэд “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”- ийг бүрдүүлдэг эрхийг тодорхойлохдоо:

- эрх чөлөөтэй байх (чөлөөтэй байх халдашгүй эрх ч гэдэг);
- бие, махбодын халдашгүй эрх;
- орон байрны халдашгүй байдал;
- нууцын халдашгүй эрх;
- нэр төрийн халдашгүй байдал;
- өмчийн халдашгүй байдал гэсэн 6 хүрээг хамаарна гэж үзсэн байдаг. (Ханнс-Зайделийн сан, 2009)

Үүнээс үзвэл халдашгүй байх эрхийн хувьд хэд хэдэн салбар эрх зүйн зохицуулах зүйлд хамаарах объекттой холбогдож байна. Тухайлбал, Захиргааны эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Иргэний эрх зүй, Зөрчлийн эрх зүй, Гэр бүлийн эрх зүй гэх зэрэг байдлаар холбогдож байна.

Энэхүү судалгаа нь хүний бие махбодын халдашгүй байх агуулгын хүрээнд судалж байгаа болно. Уг эрх нь өргөн цар хүрээтэй ойлголт бөгөөд амьд явах

эрхээс ялгагдах онцлогтой. Тухайн генийн бүрэн бүтэн, гадны нөлөөлөлгүй байх нөхцөлийг хангах, өөрийн генийн бусад хүчин зүйлийн нөлөөллөөс ангид байлгах эрх гэж энгийнээр ойлгож болох юм.

Хүний генетикийн тухайд. Орчин үеийн генетикийн шинжлэх ухаан нь 1800-аад оны дунд үед амьдарч байсан Грегор Менделийн хийсэн ажлаас улбаалдаг. (F, 1991) Генетик бол амьд организмуудын хэлбэр болон удамшлыг судалдаг шинжлэх ухаан юм. (Hartl D, 2005) Өөрөөр хэлбэл, аливаа амьд бие махбодыг эцэг, эхийн шинж тэмдэг үр удамдаа хэрхэн дамжиж удамшдаг зүй тогтлыг судалдаг ухааныг “удам зүй” гэх ба хүний генетикийн шинжлэх ухаан юм. (Ж.Батсуурь, 2010) Уг шинжлэх ухааны нэг судлагдахуун нь ген (эртний грек: γένος - Эх) нь амьд организмын удамшлын мэдээллийг агуулсан бүрхүүл нэгжийг ойлгоно. Харин организмын бүх гений нийлбэрийг геном гэж нэрлэдэг.

Хүний ген гэдэг бол хүнийг бүтээгч нэгж гэж ойлгож болно. Чухамдаа хүний бие махбодыг бүтээгч эсийн дотор хромосом хэмээх биенцэр байдаг. Энэ биенцэрийн дотор ген орших бөгөөд ген үеэс үед үр хүүхдэд дамжин хадгалагдана. (Ж.Раднаабазар, 2008) Уг шинжлэх ухаан генийн инженерчлэл гэдэг нэрээр тун эрчимтэй хөгжиж байна. Генийн инженерчлэл гэдэг нь утгаараа молекул, эсийн түвшинд мэс засал хийнэ гэсэн үг (И.Пүрэвдорж, 2019) юм. Энэхүү хүнийг бусад амьд организмаас ялгагдах, мөн бусад хүмүүсээс өөрийн онцгой өвөрмөц байдлыг илтгэдэг генетикийн хөгжил нь хууль зүйн шинжлэх ухааны судлах, зохицуулах хэрэгцээ бодит бий болсон. Үүнтэй зэрэгцэн олон улсын гэрээ, конвенц, бүс нутгийн конвенц, тунхаглал гарсан бөгөөд улсууд түүнтэй нэгдсэн орж, соёрхон баталж байна. Цаашилбал, дотоодын хууль тогтоомжид хүний генетикийн талаар зохицуулалт оруулах болон бие даасан хууль батлан гаргаж байна.

Олон улсын гэрээ, конвенцод хүний генетикийн талаар тусгасан байдал. Хүний генетикийн мэдээллийн олон улсын тунхаглалын 1 дүгээр зүйлийн (а) “Энэхүү тунхаглалын зорилго нь: хүний удамшлын мэдээлэл, хүний протеомик мэдээлэл, тэдгээрийн авсан биологийн дээжийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалахад хүний нэр төрийг хүндэтгэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалахыг хангахад оршино”, мөн зүйлийн (б) “Хүний удамшлын мэдээлэл, хүний протеомик өгөгдөл, биологийн дээжийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах аливаа үйл ажиллагаа нь хүний эрхийн олон улсын хууль тогтоомжид нийцсэн байна.” (International Declaration on Human Genetic Data, 2003) гэж тусгаж өгсөн бөгөөд хүний генетикийн судалгаа, шинжилгээ, оношилгоотой холбоотой харилцааг зохицуулсан байна.

Био ёс зүй ба хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлийн (с) “олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцүүлэн хүний амь нас, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх замаар хүний нэр төрийг хүндэтгэх, хүнийг эрхийг хамгаалах”, (g) “одоогийн болон ирээдүй хойч үеийнхний ашиг сонирхлыг хамгаалах”, мөн тунхаглалын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, хүний үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн хүндэтгэнэ” (Universal Declaration on Bioethics and Human Rights, 2005) гэж заасан.

Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн төрөлхтний генетикийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх нь хүн төрөлхтний бүх гишүүн улс орнууд заяагдмал нэр төрд халдаж болзошгүй нийгэм, улс төрийн шинж чанартай аливаа тайлбарыг бий болгох ёсгүй” гэж онцолсон (The human genome and the Universal Declaration of Human Rights, 1997) бөгөөд тунхаглалын 2 дугаар зүйлийн (а) “Хүн бүр генетикийн шинж чанараас үл хамааран нэр төр, эрхийг хүндэтгэнэ”

гэж заасан. Био ёс зүйн ба хүний эрхийн тухай тунхаглалын 10 дугаар зүйлд "...хувь хүний ашиг сонирхол, сайн сайхан байдлыг шинжлэх ухаан, нийтийн ашиг сонирхлоос дээгүүрт тавих ёстой" гэж заасан байдаг.

Бүс нутгийн хувьд Овьедогийн конвенц (Convention pour la protection des Droits de l'Homme et de la dignité de l'être humain à l'égard des applications de la biologie et de la médecine: Convention sur les Droits de l'Homme et la biomédecine, 1997), Европын Холбооны Хүний эрхийн дүрэм (Charter of fundamental rights of the european union, 2000), Хүний болон ард түмний тухай Африкийн дүрэм (African Charter on Human and Peoples' Rights, 1986) зэрэгт тусгасан байна.

Хүний нэр төр халдашгүй байх бөгөөд гений инженерчлэл буюу гений хувиргалт нь судалгаа болон эмнэл зүйн оношилгоо, хэрэглээний түвшинд аль алинд нь хүндэтгэлтэй хандах ёстой. Генийн шинж байдал, чанараар нь ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг хориглох, удамшлын өвөрмөц байдал, олон янзын байдлыг хүндэтгэн үзэх, хувь хүний ашиг сонирхлыг бусад эрх ашиг, шинжлэх ухааны ололт амжилтаас илүүд үзэх шаардлагатай байна.

- Бие махбодын бүрэн бүтэн байдлыг хангах (халдашгүй байх) эрх.

Уг эрх нь өргөн цар хүрээтэй ойлголт бөгөөд амьд явах эрхээс ялгагдах онцлогтой. Тухайн гений бүрэн бүтэн, гадны нөлөөлөлгүй байх нөхцөлийг хангах, өөрийн гений бусад хүчин зүйлийн нөлөөллөөс ангид байлгах эрх гэж энгийнээр ойлгож болох юм. Европын Холбооны Хүний эрхийн дүрэмд хүний бие бялдар, оюун санааны бүрэн бүтэн байдалд нөлөөлөх ноцтой болон хүндэвтэр хэлбэрүүд, түүнчлэн зөвшөөрөлгүй аливаа эмнэлгийн эмчилгээ хийхийг хязгаарласан байдаг. Бие махбодын халдашгүй байдлын эрхийг шинжлэх ухааны судалгаа хийх эрх чөлөөг шууд хязгаарлах явдал гэж тодорхойлсон.

Үр хөврөлийг гений инженерчлэл болон бусад хууль бус судалгаанаас хамгаалах, аливаа үр удамд генд өөрчлөлт оруулахыг туйлын хориглосон нь бие махбодын бүрэн бүтэн байдлыг хангах эрх нь үр хөврөл тэр ч байтугай хойч үедээ ч хамааралтай гэдгийг харуулж байна.

Эрх зүйн ерөнхий онолын чиг үүргийн талаар Францын эрдэмтэн Жан-Луи Бержель: "эрх зүйн онолын ерөнхий шинж нь хоёр агуулгаар илэрхийлэгдэнэ. Эрх зүйн онол нь нэгдүгээрт, хууль зүйн хэм хэмжээний үйлчлэх хүрээ, хязгаар, түүний бүтцийн тухай, эрх зүйн сэтгэлгээний арга, хандлага ач холбогдол өгнө. Хоёрдугаарт, эрх зүйн үзэгдлийг тодорхой улс орон, тодорхой сэдвийн хүрээнд авч үзсэн ч зөвхөн эрх зүйн нэг салбар, нэг тогтолцоогоор үл хязгаарлан, тухайн эрх зүйг бүхэл, цогц тогтолцооны хувьд ерөнхийд нь авч үзнэ" (Бержель, 2000) гэжээ. Үүнээс үзвэл, эрх зүйн онолын үүднээс хүний генетикийн талаарх зохицуулалтыг хууль, тогтоомжийн үйлчлэх хүрээг тогтоож өгөх шаардлагатай юм.

Хууль цаазын хавсарга буюу тусгай шинжлэх ухаанд: криминологийн (гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн тухай), виктимологийн (хохилогч судлал), криминалистикийн, шүүх-эмнэлгийн, шүүх-сэтгэгч гэм судлалын гэх зэрэг олон шинжлэх ухаан багтана. Хавсарга шинжлэх ухаан нь хууль цаазын шинжлэх ухаанаас гадна байгалийн техникийн болон бусад шинжлэх ухааны мэдээлэл ололт, арга зүйд тулгуурлан хууль цаазын асуудлуудыг шийдвэрлэхэд туслах шинжтэй үүрэг гүйцэтгэнэ. (Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, 2017)

Энэ утгаараа хүний генетиктэй холбоотой үүсэх нийгмийн харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай бөгөөд түүний хүрээ хэмжээг

тогтоох ёстой юм. Мөн хүний ген нь шууд утгаараа хүний өөрийн бие махбодыг бүрдүүлэгч байх ба түүнтэй холбоотой халдашгүй байх эрхээр хамгаалагдах учиртай. Халдашгүй байх эрхийг хангах үүднээс хүний генетикийн эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид тусгаж өгөх нэн тэргүүний асуудал болж байна.

Гадаад улсуудын үндсэн хуульд халдашгүй байх эрхийг тусгасан байдал.

	Улс	Үндсэн хуулийн зүйл, хэсэг, заалт	Тайлбар
1	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр халдашгүй. Түүнийг хүндэтгэж, хамгаалах нь төрийн бүх эрх баригчдын үүрэг юм”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Германы ард түмэн хүний халдашгүй, салшгүй эрхийг хүн төрөлхтний хамтын нийгэмлэг, дэлхий дээрх энх тайван, шударга ёсны үндэс суурь болгон эрхэмлэнэ.”, Хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр амьд явах эрхтэй бөгөөд хүний бие махбод халдашгүй байна. Хүний хувийн эрх чөлөө халдашгүй байна...”	1949.05.08-ны өдөр Парламентын Зөвлөлөөс Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль (Deutschland, 1949)-ийг баталсан
2	Бүгд Найрамдах Франц Улс	Хүн ба иргэний эрхийн тунхаглалын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Аливаа улс төрийн холбоодын зорилго бол хүний жам ёсны ба салшгүй эрхийг хамгаалах явдал юм.” гэж заасан.	Францын Үндсэн хууль (française, 1958) нь 1958.10.04-ний өдөр батлагдсан бөгөөд 24 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна
3	Испани (хаант) улс	Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр... халдашгүй байх эрх ...төрийн үйл ажиллагааны үндэс мөн”, 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Иргэдийн нэр төр, хувийн болон гэр бүлийн нууцыг баталгаажуулна....” гэж тус тус заасан	Испани Улс 1978.12.06-нд Үндсэн хууль (Espanola., 1978)- баталсан байна.
4	Бүгд Найрамдах Итали Улс	Үндсэн хуулийн 9 дүгээр хэсэгт “...Хувь хүний эрх чөлөө халдашгүй байна”, 32 дугаар хэсэгт “Хуульд зааснаас бусад тохиолдолд хэнийг ч албадан эрүүл мэндийн тодорхой эмчилгээ хийлгэж болохгүй...” гэж заасан.	Итали Улс нь 1947.12.22-ны өдөр Үндсэн хууль (italiana, 1947) баталсан.
5	Бүгд Найрамдах Эстони Улс	Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 17 дахь хэсэгт “Хүний нэр төр, нэр хүндийг гутааж болохгүй”, мөн хуулийн 18 дахь хэсэгт “...хэнийг ч хүсэл зоригийн эсрэг эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт хийж болохгүй”, 26 дугаар хэсэгт “Хүний гэр бүл, хувийн амьдрал халдашгүй байх эрхтэй” гэж тус тус заасан байна.	Эстони 1992.06.29-нд Улсын Үндсэн хууль (põhiseadus, 1992) баталсан.
6	Оросын Холбооны Улс	Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хэнийг ч ... Сайн дурын зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн, шинжлэх ухааны болон бусад туршилтад хамруулж болохгүй”, 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр эрх чөлөө, аюулгүй байдлыг хангуулах эрхтэй”, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр хувийн нууц,	ОХУ-ын Үндсэн хууль нь 9 бүлэг, 141 зүйлээс бүрдэнэ

		хувийн болон гэр бүлийн нууц, нэр төр, алдар хүндээ хамгаалах эрхтэй” гэж тус тус заасан байна.	
7	Бүгд Найрамдах Хятад Улс	Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэдийн хувийн нэр төр халдашгүй дархан байна. Иргэдийг доромжлох, гүтгэх, хилс гүтгэх аливаа арга хэрэглэхийг хориглоно.” хэмээн тусгаж өгсөн.	БНХАУ-ын Үндсэн хууль 4 бүлэг, 138 зүйлтэй. (中华人民共和国宪法, 2018)
8	Япон Улс	Үндсэн хуулийн 11 дүгээр зүйл “Ард түмэн үндсэн эрхээ эдлэхэд саад болж болохгүй”, мөн хуулийн 25 дугаар зүйлийн “Бүх иргэн эрүүл ... амьдрах эрхтэй” гэж заасан байна	Японы Үндсэн хууль (日本国憲法, 1945)-иа 1946.11.03-нд баталсан бөгөөд өдийг хүртэл нэг ч удаа нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.
9	Бүгд Найрамдах Солонгос Улс	Үндсэн хуулийн 8 дугаар зүйлд “Бүх иргэн хүний нэр, төр ... төр иргэний үндсэн эрхийг хангана”, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх хүн бие махбодын эрх чөлөөтэй байна”, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Иргэн бүр эрүүл мэндийг төрөөс хамгаална” гэж тус тус заасан байна.	Өмнөд Солонгосын Үндсэн хуулиа 1948.07.17-ий өдөр баталж, 1987 онд шинэчлэн найруулсан (대한민국헌법, 1988) бөгөөд оршил, 130 зүйл болон бусад нэмэлтээс бүрддэг.
10	Америкийн Нэгдсэн Улс	Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Муж улс бүрийн иргэн бусад Муж улсын иргэдийн нэгэн адил бүх эрх ямба, халдашгүй эрхийг эдэлнэ.” гэж заасан.	АНУ-ын Үндсэн хуулийг 1787 оны 9 дүгээр сарын 17-нд Үндсэн хуулийн Конвент баталж, улмаар тэр үеийн Америкийн арван гурван муж улс бүгд соёрхон баталсан.
11	Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улс	Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэг 34 зүйл “Төр нь хүний халдашгүй дархан байдлыг баталгаажуулна”, 39 зүйл “Иргэний хувийн амьдрал, нэр төрд халдашгүй, хуулиар хамгаална...” гэж заасан.	Алжир 1989 онд үндсэн хуулиа (Constitution of the People's Democratic Republic of Algeria, 1989) баталсан бөгөөд 1996 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
12	Бутаны Хаант улс	Үндсэн хуулийн 7 бүлгийн зүйлд “Бүх хүн амьд явах, эрх чөлөө, хувийн аюулгүй (халдашгүй) байх эрхтэй” гэж заасан	Бутан Үндсэн хуулиа (The Constitution of Kingdom of Bhutan, 2008) 2008.07.18-ий өдөр баталсан.
13	Боливийн Олон Үндэстний Улс	Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 1 зүйлд “Хүн бүр амьд явах, бие махбод, сэтгэл зүй... бүрэн бүтэн байдлыг хангах эрхтэй” гэж заасан.	Болив Улс үндсэн хуулиа (Bolivia (Plurinational State of)'s Constitution of 2009, 2009) 2009.01.25-ны өдөр бүх нийтийн санал явуулж, 2009.02.07-нд батлав

Дээрх улсуудын Үндсэн хуульд халдашгүй байх эрхийн талаар шууд болон агуулгын хүрээнд тусгагдаж өгсөн байна. Халдашгүй байх эрийг үндсэн хуульдаа тусган баталгаажуулж өгсөн нь тухайн улсын хууль тогтоомжоор дамжин хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна. Харин тухайн Үндсэн хуульд заасан халдашгүй байх

эрхийг бүрэн хангах үүднээс хүний генетикийн талаарх хууль тогтоомжийн зохицуулалтыг батлах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Гадаад улсуудын хүний генетикийн шинжилгээ, оношилгооны талаарх хууль тогтоомжид дараах байдлаар зохицуулжээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс. 2009 онд ХБНГУ-ын Холбооны парламент эрүүл мэндийн оношилгоо, удам угсаа тодорхойлох салбар, мөн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн салбарыг багтаасан Хүний генетикийн шинжилгээний тухай хуулийг баталсан. Энэ нь генетикийн шинжилгээ, генетикийн шинжилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох, удамшлын шинж чанараар ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. “Хүний нэр төрийг хамгаалах, хувь хүний өөрийгөө тодорхойлох эрхийг хангалттай мэдээллээр хангах” төрийн үүргийг эхэнд хэсэгт тусгажээ.

ХБНГУ-д оношилгооны генетикийн үзлэгийг индексийн хүний бичгээр болон мэдээлэлтэй зөвшөөрлийн үндсэн дээр ямар ч эмч хийж болно. Гэсэн хэдий ч урьдчилан таамагласан генетикийн үзлэг, генетикийн зөвлөгөөг хүний генетикийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтнүүд эсвэл тусгайлан бэлтгэгдсэн эмч нар хийх ёстой. 3 дугаар зүйлд зааснаар “генетикийн шинжилгээ” гэж генетикийн шинжилгээнд чиглэсэн аливаа үзлэг эсвэл жирэмсний эрсдэлийн үнэлгээний арга хэмжээ гэж тодорхойлсон. (Gesetz über genetische Untersuchungen bei Menschen (Gendiagnostikgesetz -GenDG), 2009)

Биологийн дээжийн генетикийн шинжилгээг зөвхөн хариуцсан эмч эсвэл “хариуцсан эмчийн томилсон хүн, байгууллага” генетикийн шинжилгээний явцад зөвшөөрдөг. (Pascal Borry, Legislation on direct-to-consumer genetic testing in seven European countries, 2012) Генетикийн шинжилгээнд зориулж авсан биологийн дээжийг зөвхөн анхны зорилгоор ашиглаж болох бөгөөд дараа нь шууд устгах ёстой.

Оношилгооны үр дүнг тодорхойлсны дараа шинжилгээнд хамрагдсан хүнд генетикийн зөвлөгөө өгөх шаардлагатай бөгөөд энэ нь хууль ёсны шаардлага юм. Урьдчилан таамаглах болон ургийн (пренатал) генетикийн шинжилгээний хувьд шинжилгээний өмнө болон дараа нь генетикийн зөвлөгөө авах шаардлагатай. Холбогдох шинжилгээний үр дүнг зөвхөн хариуцлагатай эмч эсвэл генетикийн зөвлөх өвчтөнд шууд мэдэгдэнэ. Шинжилгээ хийх эрх бүхий хүн, байгууллага байсан бол үр дүнг зөвхөн түүнийг захиалсан этгээдэд мэдээлж болно. Генетикийн шинжилгээ, шинжилгээний хариуг хариуцагч эмнэлгийн ажилтан 10 жилийн дараа хадгалж, устгах ёстой (Menschen, Gesetz über genetische Untersuchungen bei, 2010).

Швейцарын Холбооны Улс. 2004 оны Хүний генетикийн шинжилгээний тухай Холбооны хууль нь Швейцар дахь генетикийн шинжилгээний эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. ХБНГУ-ын Хүний генетик шинжилгээний тухай хууль нь зорилго, хамрах хүрээний хувьд энэхүү хуулийн агуулгатай маш төстэй байдлаар баталсан. Энэ нь хүний нэр төр, хувийн шинж чанарыг хамгаалах, чанарын баталгааг хангах, удамшлын мэдээллийг зүй бусаар ашиглах, генетикийн шинжилгээ хийхээс зайлсхийхэд чиглэгддэг. Энэхүү хууль ёсны мэдэгдэл нь эрүүл мэндийн оношилгоо, удам угсаа тодорхойлох, түүнчлэн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн асуудалд генетикийн шинжилгээ хийх үндсэн удирдамжийг агуулдаг (Menschen ü. g., 2007).

Генетикийн шинжилгээ, түүнчлэн оношилгооны генетикийн шинжилгээний дарааллыг хууль ёсны зөвшөөрлийн үндсэн дээр ямар ч Швейцарын эмч хийж болно. Гэсэн хэдий ч урьдчилан таамаглах туршилтын тухайд зөвхөн генетикч эсвэл тусгайлан бэлтгэгдсэн эмнэлгийн эмч үүнийг зохион байгуулахыг зөвшөөрдөг. Түүнчлэн Швейцарт генетикийн дээжийг зөвхөн анхны зориулалтаар нь ашиглаж, дараа нь устгадаг.

ХБНГУ-тай харьцуулбал шинжилгээний хариуг генетикийн зөвлөгөө өгөх замаар индексжүүлсэн хүнд мэдээлэх ёстой. Урьдчилан таамаглах болон ургийн (пренатал) генетикийн шинжилгээний хувьд шинжилгээний өмнө болон дараа нь генетикийн зөвлөгөө өгөх шаардлагатай.

Уг хуулийн шинэчилсэн найруулгад боловсруулагдаж байгаа бөгөөд энэ хүрээнд шууд генетикийн шинжилгээ хийхтэй холбоотой зохицуулалтууд хийгдэж байна. Тухайлбал, эмч, эм зүйч нь биеийн тамир, үндэс угсаа зэрэг шинж тэмдгүүдийн генетикийн шинжилгээнд хамрагдана. Цаашид мөн удамшлын бус генетикийг (жишээ нь, хавдрын шинж чанарыг) оруулах ёстой.

Бүгд Найрамдах Франц Улс. Францад иргэний эрх зүйн байдлыг Иргэний хуулиар тодорхойлогддог бөгөөд үүнд “Хүний бие халдашгүй байх эрхтэй”, “Хүний генетикийн шинж чанарыг шалгах, түүний генетикийн хурууны хээгээр хүнийг таних” (Code civil, 1994) тусгай бүлэг байдаг (зүйл 16-10-аас 16-12). Францын Нийгмийн эрүүл мэндийн хуулийн дагуу генетикийн өвчнийг оношлох, хөгжиж буй өвчин үүсгэж болзошгүй нэг буюу хэд хэдэн гений шинж чанарыг тодорхойлох шинжилгээний зорилготой байх ёстой. Харин “мэдээлэл олж авах” зорилгоор генетикийн шинжилгээ хийхийг хориглодог (Pascal Borry, 2012).

2011 оны шинэчилсэн Францын Био-этикийн тухай хуульд Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн нөхцөлөөс гадуур генетикийн шинжилгээ хийхийг хориглож, холбогдох шийтгэл, нэг жил хорих, 15,000 еврогийн торгууль ногдуулахыг Францын эрүүгийн хуульд тусгасан.

Францад ерөнхийдөө генетикийн шинжилгээг зөвхөн эрүүл мэндийн болон шинжлэх ухааны судалгааны зорилгоор ашиглахыг зөвшөөрдөг. Зөвхөн ахлах эмч нар удамшлын шинжилгээг захиалж болох бөгөөд индексжүүлэгчээс бичгээр мэдээлэл өгөх зөвшөөрөл авах үүрэгтэй. Гэсэн хэдий ч шинж тэмдэггүй эсвэл урьдчилан таамаглах шинжилгээг зөвхөн Францын эрүүл мэндийн байгууллагууд зарлаж, хүлээн зөвшөөрсөн олон талт багууд захиалж болно. Эдгээр багуудад генетикч эсвэл өвчний эмч, генетикийн зөвлөх, сэтгэл зүйч багтдаг.

Геномын ДНХ нь генетикийн шинжилгээ хийсний дараа дор хаяж 10 жил хадгалагдах ба хугацааны талаар тодорхой зохицуулалтгүй байна. Шинжилгээ өгсөн тухайн хүн хэдий ч хүссэн үедээ дээжийг устгахыг хүсэх эрхтэй байдаг.

Францад генетикийн зөвлөгөө өгөх нь бүх төрлийн генетикийн шинжилгээнд заавал байх ёстой бөгөөд шинжилгээ өгөхөөс өмнө захиалагч эмч эсвэл эмчтэй хамтран ажилладаг генетикийн зөвлөхөөр хийлгэх ёстой. Захиалга өгсөн эмч эцэст нь үр дүнг хүлээн авч, уулзалтын үеэр өвчтөнд энэ талаар мэдэгдэх үүрэгтэй. Генетикийн мэдээлэл агуулсан бүх бичиг баримтыг ихэвчлэн лаборатори, клиникт өвчтөний файлд хадгалдаг бөгөөд хариуцах биологич, эмч нар хариуцдаг. Эцэст нь генетикийн мэдээллийг дор хаяж арван жил хадгалах бөгөөд зарчмын хувьд генетикийн оношийг албан ёсны хяналтын тайланд харуулахыг зөвшөөрдөг (Franziska Rössler, 2017).

Нидерландын Хаант Улс. Нидерланд дахь мэргэжлийн эмнэлгийн стандарт, өвчтөний эрхийг Нидерланд Иргэний хуульд (Dutch Civil Code, 1992) заасан байдаг. Иргэний хуулийн нэг хэсэг болох Нидерландын эмчилгээний гэрээний тухай зохицуулалт нь өвчтөний эрх зүйн байдлыг тогтоосон ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүх гэрээний харилцаанд хамаардаг.

Нидерланд оношилгоо, урьдчилан таамаглах генетикийн шинжилгээг ямар ч эмчийн захиалгаар хийлгэж болно. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид аливаа эмнэлгийн оношилгоог эхлүүлэхийн өмнө эмнэлгийн эмчилгээний гэрээний тухай хуулийг танилцуулж санал болгож буй эмчилгээ, өөр хувилбар, урьдчилан таамаглал, эрсдэл, болзошгүй гаж нөлөөний талаар бүрэн дүүрэн мэдээллээр хангах ёстой байдаг.

Нидерландын хүн амын үзлэгт хамрагдах тухай хуулийн үндсэн дээр хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, түүнчлэн эмчлэх боломжгүй, урьдчилан сэргийлэх боломжгүй өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх генетикийн шинжилгээг тодорхой этгээдийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэгчдэд шууд санал болгож, хэрэгжүүлдэг. Шинжлэх ухааны үндэслэлгүй, мэргэжлийн эмнэлгийн практикийн стандартад нийцээгүй гэж үзвэл Сайд нь уг шинжилгээний үйл ажиллагааг хүчингүй болгодог. (PJ, 2000)

Нидерландад генетикийн шинжилгээний хүрээнд олж авсан генетикийн дээжийг хугацаагүйгээр хадгалдаг. Харин удамшлын мэдээлэлд уг зохицуулалт нь хамаатай боловч клиник практикт генетикийн өгөгдөл нь тухайн гэр бүлийн 3 үеийн туршид хадгалагддаг байна.

Нидерландын хуулиар оношилгоо, урьдчилан таамаглах тестийн талаар генетикийн зөвлөгөө өгөх талаар зохицуулаагүй байна. Эмнэлгийн гэрээний тухай хуульд өвчтөний нууц мэдээллийн талаар ерөнхий зохицуулалтыг тусгасан ч генетикийн мэдээллийг ашиглах тусгайлсан зохицуулалтыг тусгаагүй бөгөөд өвчтөний зөвшөөрөлгүйгээр генетикийн шинжилгээний хариуг эмч нар ашиглах боломжтой байдаг.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс. Их Британийн үндсэн хууль нь бичмэл баримт бичигт агуулаагүй боловч парламентаас баталсан хууль тогтоомж, шүүхээс гаргасан шийдвэрийн үр дүнд олон зуун жилийн турш оршин тогтнож ирсэн нийтлэг хуулиас олж болно. (The justice system and the constitution, 2024) Гэвч одоо генетикийн шинжилгээтэй шууд холбоотой ямар ч дүрэм олдохгүй байна. Энэ сэдвийг хэсэгчлэн хөндсөн ихэнх хуулиуд нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, эмнэлгийн хэрэгсэл, зар сурталчилгаа эсвэл ерөнхийдөө мэдээллийн хамгаалалтад зориулагдсан байдаг. 2010 онд хүний генетикийн шинэ хөгжлийн талаар засгийн газарт зөвлөгөө өгч байсан Хүний генетикийн комисс нь “Хэрэглэгчид болон тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах” зарчмын нэгдсэн тогтолцоонд зарим удирдамжийг тогтоож, лабораторид туршилт хийх сайн дурын магадлан итгэмжлэлийн схемийг боловсруулсан. Харин Их Британийн Засгийн газар төсвөө танах, шинэчлэх ажлын хүрээнд Хүний генетикийн хороог татан буулгажээ (Commission, UK Budget Cuts Whack Genetics, 2010).

Нэгдсэн Вант улсын эмнэл зүйн практикт зөвхөн зөвлөх эмч нар генетикийн шинжилгээ хийдэг. Оношилгооны болон урьдчилан таамаглах туршилтын хооронд албан ёсны ялгаа байхгүй боловч эмч нар ерөнхийдөө клиник генетикийн үйлчилгээгээр урьдчилан таамаглах шинжилгээг захиалах боломжтой байдаг.

2004 онд биологийн дээжийг ашиглахтай холбоотой Их Британийн Хүний эдийн тухай хууль батлагдсан. Энэхүү хуульд зааснаар донорын хууль ёсны зөвшөөрөлгүйгээр хүний аливаа эд эсэд генетикийн шинжилгээ хийсэн нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцогдоно (Human Tissue Act, 2004). Генетикийн дээжийг эмч, өвчтөн хоёрын харилцан тохиролцсон хугацаанд хадгалдаг бөгөөд генетикийн зөвлөгөө өгөх талаарх тусгайлсан зохицуулалт байдаггүй. Хэрэв зөвлөгөө өгөх тохиолдолд заавал генетикч байхыг шаарддаггүй.

Бүгд Найрамдах Португал Улс. Португал нь хүний эрх, био анагаахын тухай Европын конвенцод ямар ч тайлбаргүйгээр гарын үсэг зурж, соёрхон баталсан бөгөөд Португалийн Үндсэн хуульд заасны дагуу конвенц нь үндэсний хууль тогтоомжоос “дээд хүчтэй” байдаг. Хувийн генетикийн мэдээллийн тухай үндэсний хууль тогтоомжид эрүүл мэндийн мэдээлэл нь генетикийн оношилгоонд тусгайлан зохицуулалт хийсэн. Үүний зэрэгцээ удамшлын өвчтэй эсвэл тодорхой удамшлын өвтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчмаас гадна ажил олгогчид хүний генетикийн мэдээллийг авах зохицуулалтыг тусгасан.

Хуулийн дагуу оношилгооны генетикийн шинжилгээ нь “эрүүл мэндийн бүхий л үйлчилгээнд баримтлах ерөнхий зарчмуудыг” дагаж мөрдөх ёстой. Урьдчилан таамагласан генетикийн шинжилгээг бичгээр болон мэдээлэлтэй зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн эмнэлгийн генетикч захиалж болно. Эмчлэх магадлал бага, бүрэн эмчлэх боломжгүй, хүнд шатанд орсон нөхцөлд сорилтын өмнөх сэтгэл зүйн болон ерөнхий дүгнэлт өгөх ёстой (Patients' Rights in the European Union, 2008).

Генетикийн дээж авахын өмнө цуглуулах зорилго, хадгалах хугацааг багтаасан индексжүүлэгчийн хууль ёсны зөвшөөрлийг баримтжуулсан байх ёстой. Португал нь холбогдох мэргэжилтнүүдийн бүрдсэн эмнэлгийн багийн дэмжлэггүйгээр үндэсний болон гадаадын лабораториудад генетикийн шинжилгээ хийхээс татгалзах талаар генетикийн шинжилгээний санал, гүйцэтгэлийг зохицуулах засгийн газрын үүргийг тодорхой өгсөн байдаг. Үүний үндсэн дээр засгийн газар генетикийн шинжилгээ хийдэг Португалийн бүх лабораториудын магадлан итгэмжлэл, баталгаажуулалт, тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулдаг (Personal genetic information and health information law, 2005).

Дээрх хуульд генетикийн шинжилгээний аливаа үр дүнг зөвхөн индексжүүлсэн хүнд эмчийн зөвлөгөөний хүрээнд өгнө гэж заасан байдаг. Эмнэлгийн бүртгэлийг өвчтөний эмчилгээг хариуцдаг эмчээс авах боломжтой бөгөөд зөвхөн өвчтөний бичгээр өгсөн зөвшөөрлөөр эрүүл мэндийн мэдээллийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрдөг. Эрүүл мэнд, удамшлын мэдээллийг хадгалахдаа төрөлжүүлэн ангилж нууцын баталгааг хангах ёстой байна.

Америкийн Нэгдсэн Улс. АНУ-ын холбооны муж бүрд генетикийн шинжилгээний талаар өөр өөр тусгай журам байдаг. Оношилгооны шинжилгээг эмч бүр захиалж болох ч хууль эрх зүйн орчин харилцан адилгүй байдаг. Хувийн компаниуд янз бүрийн биологийн дээжийг ДНХ-ийн шинжилгээ хийлгэхийг хориглосон холбооны хууль байхгүй тул генетикийн шинжилгээг далд байдлаар явагдаж байгаа. Албан бус генетикийн шинжилгээнээс хориглох, хязгаарлах нөхцөл нь муж улсуудад харилцан адилгүй байдаг ба аль мужид амьдарч байгаагаас хамаарч дээжийг хаана шинжилж, дүгнэлт гаргах зэрэг нь муж улсын хуулийг хэрхэн тайлбарлаж байгаагаас хамаарч байна (Strand, 2016).

АНУ-д ДНХ-ийн дээжийг зөвхөн төлбөр төлсөн тохиолдолд л хадгалдаг. Хэрэв төлбөр төлөөгүй тохиолдолд генетикийн дээжийг боловсруулсны дараа шууд устгадаг. 1996 оны Эрүүл мэндийн даатгалын тухай хууль нь эмнэлгийн мэдээллийг хуваалцахыг хязгаарлаж, “Эрүүл мэндийн хамгаалагдсан мэдээлэл” гэж тодорхойлох замаар өвчтөний хувийн нууцыг хамгаалахад чиглэгддэг. 2013 онд АНУ-ын Конгрессоос 2008 онд баталсан Генетикийн мэдээллийг ялгаварлан гадуурхахгүй байх тухай хуулийн дагуу “Эрүүл мэндийн даатгал гаргагчид болон ажил олгогчдын хувь хүний генетикийн мэдээлэлд нэвтрэх эрхийг хязгаарлах, түүнчлэн генетикийн ялгаварлан гадуурхахыг хориглох” зорилгоор 2013 онд Хувийн нууцын дүрмийг өөрчилсөн (Feldman, 2012).

1966 оны Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь иргэдийн хүсэлтээр Холбооны баримт бичигт хандах боломжийг олгосон АНУ-ын анхны хууль юм. Уг хуульд холбооны мэдээллийн санд бүртгэгдсэн оролцогчдын геномын мэдээллийн талаар тусгайлсан зохицуулалтгүй байна. Хүний геномын судалгааны үндэсний хүрээлэн нь геномын мэдээлэл агуулсан хэд хэдэн мэдээллийн санг хөтөлж, өөрсдийн судалгааны мэдээлэлд зөвхөн судлаачдын хүсэлтээр хандах боломжийг олгодог тусгай мэдээлэл солилцох бодлогыг бий болгосон.

2013 онд АНУ-ын Дээд шүүх хууль сахиулах байгууллага гэмт хэргээр баривчлагдсан бүх сэжигтнээс ДНХ-ийн дээж авч болно гэсэн дүрмийг гаргасан бөгөөд “Алба хаагчид ноцтой гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй үндэслэлээр баривчлагдаж, сэжигтнийг хорих газарт авчрах үед. Цагдан хоригдож, баривчлагдсан хүний ДНХ-ийн хацрын арчдас авч, шинжилгээ хийх нь хурууны хээ авах, гэрэл зураг авахтай адил цагдаад захиалга өгөх хууль ёсны журам юм” (Maryland v. King, 569 U.S. 435 (2013), 2013) гэж шийдвэрлэжээ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс. БНХАУ нь 2017 оны байдлаар үндэсний ДНХ-ийн мэдээллийн санд 68 сая орчим дээжийн мэдээллийг бүртгэн ашиглаж байгаа бөгөөд энэ нь нийт хүн амын (1 млрд 384,350 сая хүн амтай) 4,912 % орчим хувийг эзэлж байна. “Генетик мэдээллийн үндэсний сан” Хятад дахь хүний наймааг таслан зогсооход маш чухал үүрэг гүйцэтгэснийг дурджээ. 2009 оны 4-р сараас хойш 39000 гаруй хүн худалдсан хэргийн тохиолдлыг ДНХ-ийн шинжилгээгээр шийдвэрлэсэн байна.

Үүнээс гадна ДНХ-ийн шинжилгээний үр дүнд сураггүй алга болоод олдсон, орон гэргүй тэнэмэл, асрах хүнгүй 1400 хүүхдийн эцэг, эхээс харьцуулах дээж авч ДНХ-ийн шинжилгээ хийж хүүхдийг эцэг, эхэд нь буцааж олж өгсөн байна. Гений мэдээллийн үндэсний сан бүрдсэнээр Хятадад хүүхэд худалдаалах гэмт хэрэг ихээхэн буурсныг Хятадын нийгмийн аюулгүйн албаны яамны Хүн худалдаалахын эсрэг тэмцэх албаны захирал ЧенШикү мэдэгдсэн байна (И.О, 2010).

Мөн БНХАУ-ын Төрийн зөвлөлийн 2019.03.20-ний өдрийн №717 тушаалаар “БНХАУ-ын хүний генетик нөөцийн менежментийн журам”-ыг баталсан байна. (中华人民共和国人类遗传资源管理条例, 2019) Тус журмын 7 дугаар зүйл “Гадаадын байгууллага, хувь хүн, тэдгээрийн үүсгэн байгуулсан буюу бодитоор хянадаг байгууллага нь манай улсын нутаг дэвсгэрт манай улсын хүний удамшлын нөөцийг цуглуулж, хадгалахыг хориглоно.” гэж өөрийн иргэний халдашгүй байх эрхийг хамгаалах зохицуулалтыг тусгажээ. Журмын 9 дүгээр зүйлд “Манай улсын хүний генетик нөөцийг цуглуулах, хадгалах, ашиглах, гаднаас хангах нь ёс зүйн зарчимд нийцэж, холбогдох үндэсний дүрэм журмын дагуу ёс зүйн хяналтад хамрагдах ёстой. Эх орныхоо хүний удамшлын нөөцийг цуглуулах, хадгалах,

ашиглах, гадаад ертөнцөд хүргэхдээ хүний удамшлын нөөцөөр хангагчдын хувийн нууцын эрхийг дээдэлж, урьдчилан зөвшөөрөл авч, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах ёстой.” гэж хүний генетикийн халдашгүй байх эрхийг баталгаажуулж өгсөн байна.

Оросын Холбооны Улс. ОХУ нь анх 2009 онд “ДНХ-ийн мэдээллийн сан”-ийн хуулиа баталж санд одоогийн байдлаар нийт 300000 орчим дээжийн ДНХ-ийн мэдээлэл бүртгэсэн байгаа нь нийт хүн амын /147 сая хүн амтай/0,2% орчим хувийг хамруулсан байх жишээтэй (Ганболд.С, 2018).

ОХУ-д шүүх ДНХ-ийн адилтгах шинжилгээг анх 1980-аад оны дунд үеэс хийж эхэлсэн ба ДНХ-ийн мэдээллийн сангийн бүртгэлийн системийг боловсруулах ажил 1990-ээд оны дундуур хийгдсэн боловч санхүүгийн бэрхшээлийн улмаас хэрэгжилт нь хойшлогдсоор Төрийн ДУМ нь “Холбооны улсын геномын бүртгэлийн тухай” (О государственной геномной регистрации в Российской Федерации, 2008) хуулийг 2008 оны 12 сарын 9-нд баталсан бөгөөд 2009 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын геномын бүртгэлийг хүн, иргэний нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөөнд нийцүүлэн хууль ёсны, хүмүүнлэг, нууцлал, сайн дурын болон үүргийн хосолсон зарчимд нийцүүлэн явуулна”, мөн зүйлийн 2 дахь “Улсын геномын бүртгэл явуулах нь хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй учруулахгүй, нэр, төр, алдар хүндийг нь гутаан доромжлохгүй байх” гэж хүний генетикийн халдашгүй байх эрхийг хамгаалсан байна.

Дээрх улсуудын хуульд тусган зохицуулалтын хувьд нэгдүгээрт хүний генетикийн халдашгүй байдлыг хангахад тухайн этгээдийн зөвшөөрөл авсан байхыг шаардаж байна. Хоёр дугаарт эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт хийхийг хориглох байдлаар хүний генетикийн халдашгүй байх эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж хамгаалж байна.

Монгол Улсын хууль тогтоомжид халдашгүй байх эрх буюу хүний генетикийн халдашгүй байх эрхийг дараах байдлаар тусгажээ. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй...” (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гэж заасан. Үүнээс үзвэл Монгол Улсын Үндсэн хуульд заасан “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийг агуулгын хувьд эрх чөлөөтэй байх, бие халдашгүй байх эрх, орон сууцны халдашгүй байх эрх, нууцын халдашгүй байх эрх, нэр төрийн халдашгүй байх эрх, өмчийн халдашгүй байх эрх гэсэн 6 хүрээнд авч үзэж байна.

Мөн уг эрхийг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасан бөгөөд энэхүү эрхийг хуулиар хамгаалах талаарх тусгаж өгчээ. Иймд уг эрх нь тунхгийн шинжтэй бус хуулиар хамгаалах шаардлагыг Үндсэн хуульд шууд зааж өгсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж хүний эрхийг хангах баталгааг төр хариуцах үүрэгтэй байна.

Энэ утгаараа хүний генетикийн халдашгүй байх эрхийг хуулиар хамгаалах шаардлагатай бөгөөд төр үндсэн хуульд тусгагдсаны дагуу үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Монгол Улс 2000 онд Донорын тухай хуулийг анх баталсан. Уг хуулиар “эрхтэнг эмчилгээний зориулалтаар хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх, экспортлох, импортлох” зохицуулалтыг тусгасан. Гэхдээ уг зохицуулалт генийн хувилах ажиллагаа биш бөгөөд зөвхөн гений мэдээлэл агуулах эд, эрхтэнг хүнд шилжүүлэн суулгах ажиллагааг зохицуулсан. Харин уг (Донорын тухай хууль, 2018) хуулийн шинэчилсэн найруулга нь 2018 онд батлагдсан бөгөөд үүдэл эс болон эд, эсийн талаар зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйлд Донорын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан бөгөөд хүний эмзэг мэдээллийг хамгаалах талаар цус, цусан бүтээгдэхүүн, эд тусгажээ.

1995 онд Хувь хүний нууцын тухай хууль баталсан боловч хэт ерөнхий зохицуулалттай байсан бөгөөд 2021 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021) батлагдан гарснаар хүний эмзэг мэдээллийг хамгаалах зохицуулалт бий болсон. Уг зохицуулалт нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 заалт “хуульд заасан эрх бүхий байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор генетик болон биометрик мэдээллийг,” гэж заасан. Уг генетик мэдээллийг ашиглахтай холбоотой Цахим хөгжил, харилцаа холбооны Сайдын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/90 дүгээр тушаалын хавсралтаар “Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометр мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам” (Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам, 2023) баталсан.

Уг зохицуулалтаар зөвхөн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор ашиглах харилцааг зохицуулсан. Харин Шүүх шинжилгээний тухай хууль (Шүүх шинжилгээний тухай хууль, 2022)-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт “Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн сан дараах мэдээллээс бүрдэнэ:” гэж заасан бөгөөд мөн хуулийн 22.3.3 дахь хэсэгт “генетик мэдээллийн” гэж заажээ. Уг хуулиар хүний генетикийн халдашгүй эрхэд хуульд заасан үндэслэлээр тухайн этгээдийн зөвшөөрөл шаардахгүйгээр төрийн эрх бүхий байгууллагаас шинжилгээ, оношилгоо хийх харилцааг зохицуулж байна.

Хариуцлагын тооцох зохицуулалтын хувьд Зөрчлийн хууль (Зөрчлийн тухай хууль, 2017)-д 2020, 2021 оны нэмэлтээр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Донорын тухай хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан. Эрүүгийн хууль (Эрүүгийн хууль, 2015)-ийн 15.3 дугаар зүйл.Хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах, мөн хуулийн 15.4 дүгээр зүйл.Хүний цус, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах гэж тусгасан байна. Дээрх зохицуулалт нь гений шинжилгээ, судалгааны талаар шууд хориглосон агуулгатай байна. Мөн Зөвшөөрлийн тухай хууль (Зөвшөөрлийн тухай хууль, 2022)-д зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтад тусгаагүй байна.

Дээрхээс дүгнэн үзвэл Монгол Улсын хувьд хүний генетикийн мэдээлэл хамгаалах зохицуулалтыг тусгаж өгсөн боловч бусад хэлбэрийн халдлагын талаарх зохицуулалт байхгүй байна. Мөн эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжид (гадаад, дотоод) шинжилгээ, оношилгоог хийх ерөнхий зохицуулалтыг тусган боловч хүний генетикийн шинжилгээ, оношилгоо хийх талаарх зохицуулалт байхгүй байна. Тэр ч утгаараа хүний генетикийн халдашгүй байх эрхийг зөрчих

нөхцөл бүрдэж байгаа бөгөөд тусгайлсан хяналт хийх субъект байхгүй байна. Мөн энэ талаарх харилцааг зохицуулах эрх зүйн орчин дутмаг байна.

Дүгнэлт, санал

Олон улсын гэрээ, конвенцод хүний генетикийн халдашгүй байдлыг хангах талаар зохицуулалтуудыг тусгаж өгсөн байна. Тус олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс нэгдсэн орсон бөгөөд хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Мөн хүний генетикийн шинжилгээ, оношилгоо, засварлах зэрэг харилцааг зохицуулсан олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенц батлагдан гарчээ. Үүнтэй зэрэгцэн зарим улс хүний генетикийн талаарх бие даасан хууль, дүрэм, журам батлан гаргах, холбогдох хууль нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг хүний генетикийн халдашгүй байх эрхийг баталгаажуулах арга хэмжээ авсан байна.

Монгол Улсад хүний генетикийн талаарх хууль тогтоомжийн нарийвчилсан зохицуулалтыг бий болгох, хүний генетикийн асуудлыг төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зайлшгүй шаардлагатай байна. Хүн амын эрүүл мэнд, генетик мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, судалгаа, шинжилгээ, оношилгоо хийх талаар анхдагч хуулийг батлан гаргах хэрэгцээ зайлшгүй бий болжээ. Ингэснээр хүний генетикийн мэдээллийг хамгаалах, хүний эрүүл мэнд, сайн сайхны төлөө судалгаа, шинжилгээ, оношилгоо хийх, хадгалах, хамгаалах боломж хууль зүйн хувьд нээгдэх юм.

Дээрх үндэслэлүүдтэй холбогдуулан дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Халдашгүй байх эрхийн хүрээг зөв тодорхойлох. Хүний ген нь хүний махбодын бүрдүүлэгч нэгж болох бөгөөд хүний бие махбодод хамаарна. Иймд хууль зүйн үүднээс хүний ген, геном, генетикт хөндлөнгөөс нөлөөлөх, халдах зэрэг нь халдашгүй байх эрхийг зөрчиж буй хэрэг юм.
2. Хүний генетикийн тухай анхдагч хуулийг батлах. Ингэснээр одоо хэрэгжиж байгаа Шүүх шинжилгээний тухай, Донорын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зэрэг хуулиудад тусгах боломжгүй хүний генетикийн судалгаа, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ үйл ажиллагааг нээлттэй болгох боломжтой. Мөн тухайн хуульд хүний генетикийн талаар нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаж зохицуулагдаагүй харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ.
3. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах. Хүний генетикийн судалгаа, шинжилгээ, оношилгоотой холбоотой үйл ажиллагааг хувийн хуулийн этгээд, судлаачид явуулах боломжийг бүрдүүлнэ. Генетикийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд дан ганц төрийн чиг үүрэгт хамааруулж болохгүй бөгөөд бусад хувийн хуулийн этгээд, судлаачид, эрдэмтдийг оролцуулах шаардлагатай. Бусад улс орнуудын судалгаа, шинжилгээ, оношилгооны үйл ажиллагаа нь их сургуулиудын дэргэдэх лаборатори түшиглэн явуулж байна. Ингэхдээ мэдээлэл, сорьцын хадгалалт нь хуулиар хамгаалагдаж байна.
4. Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль зэрэг холбогдох хууль зохицуулалтыг тусгах6 (Ц.Амарсанаа, 2023). Хэдийгээр эрүүл мэнд, эмчилгээтэй холбоотой зохицуулалт байгаа боловч хүний генетикийн мэдээлэл агуулсан эмчилгээний талаар тусгаж өгөөгүй байна. Цаашид генетикийн түвшний эмчилгээ, оношилгоо явуулж буй тохиолдолд түүнд эмчлүүлэгчээс зөвшөөрөл авах, сорьцыг хадгалах, хамгаалах, устгах зэрэг үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай.

5. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах. Хүний генетиктэй холбогдолтой хууль(Хүний генетикийн тухай хууль)-ийг ноцтой зөрчсөн, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх. Улс орнууд уг үйлдлийг эрүүгийн хариуцлага ногдуулж байна. Монгол улсын хувьд үүнийг нарийвчлан зохицуулсан хууль байхгүй учир хувь хүний нууцад халдах, задруулах гэх байдлаар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна. Гэтэл хувь хүний мэдээлэл дотроо ач холбогдлын хувьд өөр өөр үр дагавар бий болгох учир тусгайлан гэмт хэрэг гэж хуульчлах шаардлагатай.
6. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах. Хүний генетиктэй холбогдолтой харилцааг зохицуулсан хууль (Хүний генетикийн тухай хууль)-ийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгаж өгөх шаардлагатай. Ингэснээр гэмт хэргээс бусад төрлийн зөрчилд хариуцлага тооцох нөхцөл бүрдэнэ.
7. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хүний генетиктэй холбоотой харилцааны талаарх зохицуулалтыг хуульчлан тусгаж өгөх. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хүний генетиктэй холбоотой асуудал хөндөгдөх тохиолдолд түүнийг зохицуулсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж батлах шаардлагатай.

Цаашид хүний генетик түүнтэй холбоотой судалгаа, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, хадгалалт, мэдээлэл шилжүүлэх, устгах зэрэг үйл ажиллагааг тусгайлан бусад үйл ажиллагаанаас ялган зохицуулах хэрэгцээ бий болсон байна. Мөн хүний генетикийн талаар зөвхөн биологи, ангаах ухааны салбарт судлах биш хууль зүйн салбар судлах шаардлагатай гэдгийг бусад улс орны хууль, тогтоомж, олон улсын гэрээ, конвенцоос дүгнэн үзэж болохоор байна.

Ашигласан материал

1. Хенри Ж. Стайнер, Ф. Э. (2000). *Эрх зүй, ёс суртхууны асуудлууд*. Улаанбаатар хот.
2. З.М.Черниловский. (1083). *Всеобщая история государства и права*. Москва.
3. Й.Изензее, П. (1994). *Государственное право Германий*. Мос: Институт государства и права РАН.
4. Кондэ, Х. (1999). *Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага*. Охама: Небраскийн их сургуулийн хэвлэлийн газар.
5. Н.Лүндэндорж. (2011). *JURISPRUDENCE Эрх зүй судлал: Философи, онол*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.
6. С.Нарангэрэл. (2008). *Эрх зүйн эх толь бичиг*. Улаанбаатар хот: ADMON.
7. Б.Чимид. (2004). *Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, хоёр дахь хэвлэл*. Улаанбаатар хот.
8. Ч.Энхбаатар. (2007). *Үндсэн хуулийн эрх зүй*. Улаанбаатар хот: ADMON.
9. Х.Сэлэнгэ. (2013). *Эрх зүйн философи*. Улаанбаатар хот.
10. Ч.Нямсүрэн. (2017). *Эрх зүйн ерөнхий онол*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.
11. Ч.Энхбаатар. (2007). *Үндсэн хуулийн эрх зүй*. Улаанбаатар хот: ADMON.
12. Г.Совд. (1999). *Монгол Улсын үндсэн хууль, хүний эрх (харьцуулсан эрх зүй)*. Улаанбаатар хот.
13. Д.Лүндээжанцан, Ч. (2000). *Үндсэн хуулийн эрх зүй, хоёр дахь хэвлэл*. Улаанбаатар хот: ADMON.
14. В.В.Манова. (1996). *Теория права и государства*. Москва.
15. Х.Эрдэнбат. (2002). *Хүний халдашгүй эрх*. Улаанбаатар хот.

16. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, х. б. (1984, 12 10). *legalinfo.mn*. Retrieved 11 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/1156>
17. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. (1948, 12 10). Retrieved 11 09, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/1271>
18. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. (1976, 03 23). Retrieved 11 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/1257>
19. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. (1966, 12 16). Retrieved 11 02, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/1284>
20. Хүүхдийн эрхийн тухай конвенц. (1989, 11 29). Retrieved 11 02, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/1276>
21. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц . (1969, 01 04). Retrieved 11 02, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1242>
22. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц. (1979, 12 18). Retrieved 11 06, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/1285>
23. Г.Агар-Эрдэнэ, Ч. Т. (2014). Хүний эрхийн товч тайлбар. Улаанбаатар хот: Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс.
24. Г.Агар-Эрдэнэ, Ч. Т. (2014). Хүний эрхийн товч тайлбар. Улаанбаатар хот: Хүний Эрхийн Үндэсний Комисс.
25. Г.Совд, Н. (2000). *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*. Улаанбаатар хот: ADMON.
26. Ханнс-Зайделийн сан. (2009). *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*. Улаанбаатар хот.
27. Хүний эмзэг мэдээлэл, г. б. (2023, 09 11). Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометр мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам. Retrieved 11 11, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452305271>
28. хууль, Ш. ш. (2022, 12 23). Шүүх шинжилгээний тухай хууль. Retrieved 11 11, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532614235741>
29. хууль, З. т. (2017, 05 11). Зөрчлийн тухай хууль. Retrieved 11 11, 2024, from *legalinfo.mn*: <https://legalinfo.mn/mn/detail/12695>
30. Ц.Товуусүрэн. (2024). Үндсэн хуулиа ойлгохуй (үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар). гурав дахь хэвлэл. Улаанбаатар хот.
31. Hartl D, J. E. (2005). *Genetics: Analysis of Genes and Genomes, 6th edition*. . Massachusetts.
32. *Universal Declaration on Bioethics and Human Rights*. (2005, 10 19). Retrieved 11 13, 2024, from *www.unesco.org*: <https://www.unesco.org/en/legal-affairs/universal-declaration-bioethics-and-human-rights>
33. *International Declaration on Human Genetic Data*. (2003, 10 16). Retrieved 11 13, 2024, from *www.unesdoc.unesco.org*: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000136112>
34. *The human genome and the Universal Declaration of Human Rights*. (1997, 11 11). Retrieved 11 13, 2024, from *www.ohchr.org*: <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights>
35. Ж.Батсуурь, Э. (2010). *Монгол Улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар*. Улаанбаатар хот: Стратеги судлалын хүрээлэн.

36. Ж.Раднаабазар. (2008). *Угуйн бичиг-Mongolian Genealogy*. Улаанбаатар хот.
37. F, W. (1991, 06 01). Historical study: Johann Gregor Mendel 1822-1884. *American Journal of Medical Genetics*, 26.
38. И.Пүрэвдорж. (2019). *Удамшил-1*. Улаанбаатар хот: Бэмби сан.
39. Бержель, Ж.-Л. (2000). *Общая теория права*. Москва.
40. *Convention pour la protection des Droits de l'Homme et de la dignité de l'être humain à l'égard des applications de la biologie et de la médecine: Convention sur les Droits de l'Homme et la biomédecine*. (1997, 04 04). Retrieved 11 14, 2024, from www.cfef.org: <http://www.cfef.org/archives/bricabrac/oviedo.pdf>
41. *Charter of fundamental rights of the european union*. (2000, 12 18). Retrieved 11 14, 2024, from www.europarl.europa.eu: https://www.europarl.europa.eu/charter/pdf/text_en.pdf
42. *African Charter on Human and Peoples' Rights*. (1986, 10 21). Retrieved 11 14, 2024, from au.int: <https://au.int/en/treaties/african-charter-human-and-peoples-rights>
43. Ч.Нямсүрэн. (2017). *Эрх зүйн ерөнхий онол*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.
44. *Constitution of the People's Democratic Republic of Algeria*. (1989). Retrieved 11 14, 2024, from adsdatabase.ohchr.org: https://adsdatabase.ohchr.org/IssueLibrary/ALGERIA_Constitution.pdf
45. *The Constitution of Kingdom of Bhutan*. (2008, 07 18). Retrieved 11 14, 2024, from www.dlgdm.gov.bt: <https://www.dlgdm.gov.bt/storage/upload-documents/2021/9/20/Constitution-of-bhutan-2008.pdf>
46. *Bolivia (Plurinational State of)'s Constitution of 2009*. (2009, 02 07). Retrieved 11 14, 2024, from cjad.nottingham.ac.uk: https://cjad.nottingham.ac.uk/documents/implementations/pdf/Bolivia-Constitution_2009_EN.pdf
47. Menschen, ü. g. (2007, 04 12). *fedlex.admin.ch*. Retrieved 11 09, 2024, from fedlex.admin.ch: <https://www.fedlex.admin.ch/eli/cc/2007/131/de>
48. Pascal Borry, R. E.-S. (2012, 01 25). *pmc.ncbi.nlm.nih.gov*. Retrieved 11 09, 2024, from pmc.ncbi.nlm.nih.gov: <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC3376265/>
49. Franziska Rössler, J. R. (2017). *Legislation on Genetic Testing in Different Countries* (Vol. 21).
50. Strand, N. K. (2016, 03 01). *Shedding Privacy Along With our Genetic Material: What Constitutes Adequate Legal Protection against Surreptitious Genetic Testing?* Retrieved 11 11, 2024, from pubmed.ncbi.nlm.nih.gov: <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/27002998/>
51. Feldman, E. A. (2012, 02 08). *The Genetic Information Nondiscrimination Act (GINA): Public Policy and Medical Practice in the Age of Personalized Medicine*. Retrieved 11 11, 2024, from pmc.ncbi.nlm.nih.gov: <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC3358381/>
52. И.О, П. (2010). *Федеральный закон о государственной регистрации в Российской Федерации*. Москва: Спарк.
53. Ганболд, С, П. Т. (2018). Монгол Улс дахь ДНХ-ийн мэдээллийн сангийн өнөөгийн байдал, цаашдын зорилт. *Хууль дээдлэх ёс* №69, р. 178.
54. *Gesetz über genetische Untersuchungen bei Menschen (Gendiagnostikgesetz -GenDG)*. (2009, 07 31). Retrieved 11 11, 2024, from [gesetz-im-internet.de](http://www.gesetze-im-internet.de): <https://www.gesetze-im-internet.de/gendg/GenDG.pdf>

55. Pascal Borry, R. E.-S. (2012, 01 25). *Legislation on direct-to-consumer genetic testing in seven European countries*. Retrieved 11 09, 2024, from pmc.ncbi.nlm.nih.gov: <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC3376265/>
56. *Gesetz über genetische Untersuchungen bei Menschen*. (2010, 02 01). Retrieved 11 15, 2024, from www.gesetze-im-internet.de: <https://www.gesetze-im-internet.de/gendg/index.html>
57. *Menschen, Gesetz über genetische Untersuchungen bei*. (2010, 02 01). Retrieved 11 09, 2024, from gesetz-im-internet.de: https://www.gesetze-im-internet.de/gendg/_13.html
58. *Code civil*. (1994, 07 29). Retrieved 11 11, 2024, from legifrance.gouv.fr: https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006136513/#LEGISCTA000006136513
59. *Dutch Civil Code*. (1992). Retrieved 11 11, 2024, from dutchcivillaw.com: <http://www.dutchcivillaw.com/civilcodebook077.htm>
60. PJ, V. d. (2000, 06 03). *Population screening for breast cancer: an interim assessment*. Retrieved 11 11, 2024, from pubmed.ncbi.nlm.nih.gov: <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/10876703/>
61. *The justice system and the constitution*. (2024). Retrieved 11 11, 2024, from judiciary.uk: <https://www.judiciary.uk/about-the-judiciary/our-justice-system/jud-acc-ind/justice-sys-and-constitution/>
62. *Commission, UK Budget Cuts Whack Genetics*. (2010, 10 15). Retrieved 11 11, 2024, from genomeweb.com: <https://www.genomeweb.com/sequencing/uk-budget-cuts-whacks-genetics-commission>
63. *Human Tissue Act*. (2004, 09 14). Retrieved 11 11, 2024, from legislation.gov.uk: <https://www.legislation.gov.uk/ukpga/2004/30/contents/data.pdf>
64. *Patients' Rights in the European Union*. (2008). Retrieved 11 11, 2024, from Health-rights.org: <http://health-rights.org>index.php>cop>
65. *Personal genetic information and health information law*. (2005, 01 26). Retrieved 11 11, 2024, from eshg.org: https://www.eshg.org/fileadmin/www.eshg.org/documents/Europe/LegalWS/Portugal_Law-UnofficialEnglishTranslation.pdf
66. *Maryland v. King*, 569 U.S. 435 (2013). (2013, 06 03). Retrieved 11 11, 2024, from supreme.justia.com: <https://supreme.justia.com/cases/federal/us/569/435/>
67. *中华人民共和国人类遗传资源管理条例*. (2019, 06 10). *中华人民共和国国务院令*. Retrieved 11 15, 2024, from www.gov.cn: https://www.gov.cn/zhengce/content/2019-06/10/content_5398829.htm
68. *О государственной геномной регистрации в Российской Федерации*. (2008, 12 0). Retrieved 11 15, 2024, from base.garant.ru: <https://base.garant.ru/12163758/>
69. *Монгол Улсын Үндсэн хууль*. (1992, 01 11). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
70. Н.Лүндэндорж. (2022). *Монгол Улсын Үндсэн хууль. Шинжлэх ухааны тайлбар*. Улаанбаатар хот.
71. Б.Чимид. (2008). *Үндсэн хуулийн мэдлэг*. Улаанбаатар хот.
72. *Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай женевийн (iv) конвенц*. (1950, 10 21). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/1180>
73. *Донорын тухай хууль*. (2018, 01 19). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/13160>

74. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. (2021, 12 17). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>
75. Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам. (2023, 09 11). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760452305271>
76. Шүүх шинжилгээний тухай хууль. (2022, 12 23). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532614235741>
77. Зөрчлийн тухай хууль. (2017, 05 11). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/12695>
78. Эрүүгийн хууль. (2015, 12 03). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/11634>
79. Зөвшөөрлийн тухай хууль. (2022, 06 17). Retrieved 11 15, 2024, from legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530780109311>
80. Ц.Амарсанаа. (2023, 04 06). Хүний генетикийн шинжилгээний талаарх зарим улс орны хууль тогтоомжийн зохицуулалт. Retrieved 11 15, 2024, from legaldata.mn: <https://legaldata.mn/buteel/pdf?id=1540>
81. А.А.Ивин. (1997). *Основы теории аргументации*. Москва: Гуманитарный издательский центр владос.
82. Yuji Takahashi, H. M. (2021, 02 16). Initiative on Rare and Undiagnosed Disease in Japan. *JMA journal*, 112-118.
83. Surti, U. (2018, 08 22). *Genome assembly T2T-CHM13v1.1*. (T. G. Medicine, Producer, & The Genome Institute at Washington University School of Medicine) Retrieved 11 2024, from ncbi.nlm.nih.gov: https://www.ncbi.nlm.nih.gov/datasets/genome/GCA_009914755.3/
84. Research, N. H. (2024, 06 13). *Human Genome Project*. (N. H. Research, Producer, & National Human Genom Research) Retrieved 11 2024, from genom.gov: <https://www.genome.gov/about-genomics/educational-resources/fact-sheets/human-genome-project>
85. Research, National Institute for Health. (2021, 11 10). (N. I. Research, Producer, & Research, National Institute for Health) Retrieved 11 2024, from genomicsengland.co.uk: <https://www.genomicsengland.co.uk/initiatives/100000-genomes-project>
86. *Human Genes Research Act*. (2013, 10 31). Retrieved 11 2024, from riigiteataja.ee: <https://www.riigiteataja.ee/en/eli/531102013003/consolidev>
87. Hannah Kim, C. W.-H. (2024, 07 01). *Genetic discrimination: introducing the Asian perspective to the debate*. Retrieved 11 2024, from nature.com: <https://www.nature.com/articles/s41525-021-00218-4>

ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ЗАРИМ ТӨСӨӨТЭЙ ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАН ЗҮЙЛЧЛЭХ АСУУДАЛ

FROM RAPE TO PREMEDITATED CRIME DISTINGUISHING CHARACTERISTICS

Т.Одбаатар

ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад

Товч агуулга: Аливаа хэрэг, явдлыг хууль зүйн үндэслэлтэй, оновчтой зүйлчлэн, хариуцлага хүлээлгэх нь нийгэмд шударга ёс тогтох нэг үндэс болно. Гэмт хэргийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, түүнд тохирох хариуцлагыг хүлээлгэхийн тулд тухайн гэмт хэргийг зөв зүйлчлэх шаардлага заавал ургана гардаг. Энэ асуудал хүчиндэх гэмт хэрэгт ихээр ажиглагддаг. Бэлэгсийн гэмт хэргийн нийтлэг шинж нь бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөнд халдаж буй хүч хэрэглэсэн үйлдэл байдаг ба энэ нь зарим талаараа эргэлзээ бүхий нөхцөл байдалд хүргэдэг. Иймд хүчиндэх гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргүүдээс ялган зүйлчлэх асуудлыг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргаж, санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: Legally justified and reasonable accountability for any incident is one of the foundations of justice in the society. In order to investigate the crime scientifically and impose appropriate responsibility on it, there is a need to classify the crime correctly. This problem is often observed in rape crimes. A common feature of sex crimes is the use of violence against sexual integrity and sexual freedom, which leads to somewhat dubious situations. Therefore, we aim to study the problem of differentiating the crime of rape from similar crimes, make scientific conclusions, and make suggestions.

Түлхүүр үгс: Бэлгийн эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал, төсөөтэй гэмт хэрэг, ялган зүйлчлэх,

Keywords: Sexual freedom, sexually invalidity, a budget crime or felony

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”⁴⁴-т бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргүүд багтсан байна. Эрүүгийн хуулийг хэрэглэх үйл ажиллагааны нэг хэлбэр гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудал юм. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-иар анх удаа эрэгтэй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалж, хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болохоор зохицуулалттай болсон.

Энэ бүлэгт хүний бэлгийн эрх чөлөөнд халдсан, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн явдлын эсрэг гэмт хэргийн төрөл, ял шийтгэл зэргийг тодорхойлсон байдаг.

Тус бүлгийн заалтууд нь хүн бүрийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах зорилготой бөгөөд ийм гэмт хэрэг үйлдсэн хүнтэй холбогдох эрүүгийн хариуцлага, түүний хүндрэлийн хэмжээг тодорхойлдог. Энэхүү бүлэгт дараах гол заалтуудыг багтаасан байдаг:

1. Бэлгийн хүчирхийлэл - Хүний бэлгийн эрх чөлөөнд халдсан гэмт хэрэг.

⁴⁴ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 12 дугаар бүлэг.

2. Бэлгийн дарамт - Бэлгийн зорилгоор хүнийг дарамталсан, хүчээр үйлдсэн үйлдлүүд.
3. Бэлгийн харилцаанд аль ч хүйсийн хүнийг хүчээр оруулах, бэлгийн зорилгоор хүч хэрэглэн амьдрах зэрэг үйлдлүүд.

Эдгээр хэргүүдэд хүлээлгэх ял шийтгэл нь гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байж болно.

Эрүүгийн хуулийн төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх нь эрүүгийн эрх зүйд нийгэмд аюултай тодорхой хэрэг, эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй нийцсэнийг тогтоох үйл ажиллагаа, гэмт үйлд өгсөн эрүүгийн эрх зүйн үнэлэлт юм⁴⁵.

Хүчиндэх гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхдээ Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмыг баримтлан, хэргийн болсон нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжлэн судалж, хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан материаллаг болон материаллаг бус хохирлыг тогтоох, гэмт этгээд, хохирогч нарын хоорондын хэрэг үйлдэгдэхээс өмнөх болон хойшид үүсэх харилцааг нарийвчлан тогтоох нь өндөр ач холбогдолтой.

2015 оны Эрүүгийн хуульд “бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн”⁴⁶ үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцсон. Ингэснээр зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог олон улсын жишигт нийцүүлсэн байна.⁴⁷

Энэ гэмт хэрэг нь хохирогчийн хүсэл зоригоос гадуур хурьцал үйлдэх, энэ зорилгодоо хүрэхийн тулд хүч хэрэглэх, заналхийлэх эсхүл бусдыг согтуурсан, мансуурсны улмаас биеэ хамгаалж, эсэргүүцэл үзүүлж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн харьцаанд орсон эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн байдгаараа Эрүүгийн хуулийн 12.2, 12.3, 12.5 дугаар зүйлд заасан гэмт хэргээс ялгагдана.

Харин хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол тухайн гэмт хэргийн үр дагаврыг нь тодорхойлж хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжтэй гэж үзэж 12.1.4 дахь хэсэгт зааснаар зүйлчлэх бөгөөд тухайн хуулийн 10.1 / хүнийг алах / гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй. Харин хүчиндэх гэмт хэргийг үйлдэх үед хохирогчийн биед хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учирсан бол Шүүх шинжилгээний ерөнхий газар /ШШЕГ/-н шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тус хуулийн 11 дүгээр бүлэгт заасан тохирох зүйлийг давхар хэрэглэж болно.

Хэрэв хохирогч нь сэтгэл мэдрэлийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хурьцал үйлдэхийн учир холбогдол, үр дагаврыг ойлгоогүйн улмаас зөвшөөрсөн эсвэл ийм байдлыг далимдуулж үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл хүчиндэх гэмт хэргээр зүйлчлэх учиртай.

Харин Эрүүгийн хуулийн 12.5 зүйлийн гэмт хэргийг субъект нь 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн харьяалалгүй хүн, аль ч хүйсийн хүн байх ба хохирогчийг 16-аас дээш насны хүн гэж бодитойгоор эндүүрэн итгэж

⁴⁵ Хүүхдээ сонсьё тайлан, үр дүн 2012, ХТҮГ

⁴⁶ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 12 дугаар бүлэг. 12.1 дахь хэсэг.

⁴⁷ ХЗТХЯ-аас эрхлэн гаргасан “Сургагч багш нарт зориулсан гарын авлага” УБ., 2017 он. 114-117 дахь тал

харилцан зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр хурьцал үйлдсэн бол гэмт хэрэг болохгүй. Энэ гэмт хэргийн хохирогч нь 14-16 насны хүн байна. Хохирогч 14-өөс доош настай боловч гэмт этгээд харилцан зөвшөөрөлцөж, хурьцал үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгээр зүйлчилнэ. Учир нь бага насны хүүхэд нь хурьцал үйлдэхийн учир холбогдол, үр дагаврыг ойлгодоггүй материаллаг болон материаллаг бус зүйлд хууртаж зөвшөөрсөн байдаг.

Хохирогч хурьцал үйлдэх үед бэлгийн бойжилт олсон, насны хувьд эргэлзээтэй, насанд хүрсэн эсэхийг мэдэх боломжгүй тохиолдолд 12.5 дугаар зүйлээр хариуцлага хүлээлгэхгүй. Бэлгийн бойжилтыг насанд хүрэх асуудалтай хамааруулж ойлгож болохгүй бөгөөд тухайн хүний биеийн онцлогоос хамаарч хэдийд ч бэлгийн бойжилт олж болно. Ийм тохиолдолд бэлгийн бойжилт олсон эсэх, хэдэн настай гэдгийг ШШЕГ-ын шинжээчийн дүгнэлтээр тогтооно. Хохирогч гэмт этгээдтэй сайн дурын үндсэн дээр бэлгийн харьцаанд орж байгаад сүүлдээ түүний хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орсон бол гэмт этгээдийн үйлдлийг нийлмэл гэмт хэргээр зүйлчилнэ.

Нийлмэл гэмт хэрэг гэдэг нь /compound crime/ Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр ба түүнээс дээш тооны гэмт хэрэг үйлдэж, тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй байхыг хэлнэ. /хэд хэдэн үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангийн хоёр буюу түүнээс дээш зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан нэг удаагийн үйлдэл, эс үйлдэхүй нь нэг үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэг болно.⁴⁸

Тэгэхээр хууль санаачлагчид ЭХТА-ийн 12.5 дахь заалтыг дахин харж, Хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын Иргэний хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд нийцүүлэх, ялын бодлогыг эргэн харах шаардлага үүсэж байна.

Харин 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн объектив үндсэн шинж нь хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан⁴⁹ үйлдэл байх бөгөөд гагцхүү энэ шинжээр хүчиндэх гэмт хэргээс ялгагдаж байгаа боловч 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн үндсэн бүрэлдэхүүнд Хүн худалдаалах гэмт хэргээс ялгах шинжийг “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр” гэж томъёолсон боловч мөн зүйлийн 2, 4 дэх хэсэгт хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан нь төөрөгдөлд оруулах хэм хэмжээ болж, мөрдөгч, прокурор, шүүхээс мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төвөгтэй байдал бий болгож байна.

Мөн тус зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж... бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан”⁵⁰ гэж тус хуулийн 12.1 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн этгээдийн үйлдэлтэй төстэй хэм хэмжээг тогтоосон байгаа нь энэ хуулийн зүйл заалтыг дахин хянаж, хууль ёсны зарчмыг нэг мөр болгох нь зүйтэй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 “Хүчиндэх” гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 12.2 “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэрэгтэй объектив талын шинж болох үйлдэл, үйлдлийн арга, субъектив талын шинж болох гэм буруугийн

⁴⁸ Эрүүгийн эрх зүйн хичээлийн нэр томъёоны тайлбар. УБ., 2016. 18 тал

⁴⁹ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7. 12 дугаар бүлэг.

⁵⁰ Мөн тэнд 12.3.1 дахь хэсэг

хэлбэр, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг үйлдсэн байдгаараа төстэй боловч объектив талын нэмэгдэл шинж болох хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хүчиндэх гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ⁵¹.

Монгол Улсын Эрүүгийн хуульд бага насны хүүхэд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд оногдуулах ялын бодлого чанга, харин насанд хүрсэн хүн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд оногдуулах ялын бодлого сул байна. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч нарт оногдуулах ялын бодлого хэтэрхий ялгаатай байгааг харуулж байна. 14 насанд хүрээгүй бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд оногдуулах ялын бодлого хүнд байх нь нийгмийн ёс суртахууны хэм хэмжээ, хүн ёсны боловсрол учир хууль санаачлагч нартай санал нэг байгаа боловч насанд хүрсэн хүн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд оногдуулах ял хөнгөн байгаа талаар ярьж байгаа хууль санаачлагч нар байхгүй байна.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглалын (1993) 1-р зүйлд “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл”-ийг тодорхойлохдоо “нийгмийн болон хувийн амьдралын хүрээнд эмэгтэйчүүдийг махбодын, бэлгийн болон сэтгэл зүйн зовуурь шаналгаа амсахад хүргэж болзошгүй жендерт суурилсан хүчирхийллийн аливаа үйлдлийг, түүний дотор үйлдэхээр заналхийлэх, эрх чөлөөг нь хасах буюу хасахаар заналхийлэх явдлыг хэлнэ”⁵² гэж заасан. Хууль санаачлагч нар насанд хүрсэн хүн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд оногдуулах ялын бодлогыг дахин харж анхаарах хугацаа болсон гэж харахаар байна.

Жишээ авч үзэхэд: Н.П нь 2016 онд, 2018 оны 8 дугаар сарын 15-аас 9 дүгээр сарын 8-ны өдөр хүртэл хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт өөрийн ахын дагавар охин, 8 настай Б-ийн бие махбодод бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн. Хууль ёсны төлөөлөгч/ээж нь/: “...Нөхөр бид хоёр ажил ихтэй тул гэртээ нэг их хонодоггүй байсан. Охины хувцсыг сольтол дотоож нь норчихсон байсан. Би асууж шалгаахад “..П ах миний уруул дээр үнсдэг. Хоёр эмээг унтсан хойгуур миний боожгойг өвтгөдөг гээд уйлаад эхэлсэн. ... Нэг удаа охин Б надад ээж та надаас мөнгө авах уу гэхээр нь чамд хэн мөнгө өгсөн юм бэ гэхэд П ах надад мөнгө өгсөн гэж хэлж байсан. ...” гэж мэдүүлжээ. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжээчдийн хохирогч Б-д хийсэн шинжилгээний дүгнэлтээр “...Онош, оношийн үндэслэл: 2016 онд хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй, дээрх хугацаанаас хойш сэтгэл түгшилт, айдас, цочрол ихсэлтийн шинжүүд илэрсэн, одоогийн сэтгэцийн байдал: -ухамсарт ухаан саруул, сэтгэл түгшилт, цочрол ихсэлтийн шинж, айдсын шинж, шээс задгайрлын шинж, DS:F43.2 Дасан зохицохын эмгэг. ...” гэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал нь зөрчигдөхөөс гадна сэтгэл түгшилт, цочрол ихсэлтийн шинж, айдсын шинж, шээс задгайрлын шинж гэх мэт эрүүл бус шинжүүд бие махбодод нь илэрч, “DS:F43.2 Дасан зохицохын эмгэг” зэрэг сэтгэцийн өвчтэй болох нь ч байдаг нь тодорхой байна. Эндээс энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нэг бүрд сэтгэл заслын

⁵¹ Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Сурах бичиг. УБ., 2020.

⁵² Жендэрийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ 2013 он

эмчилгээ нэн тэргүүнд хийж байх газар, мэргэжилтэн бий болгох хэрэгцээ байдаг болох нь тодорхой байгаа боловч манай эрүүгийн хуульд энэ заалтыг нарийн тусгаж өгөөгүй байгаа нь учир дутагдалтай харагдахаар байна.

Жишээ авч үзэхэд: 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 18-нд шилжих шөнө Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Marquee” баарны эмэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөнд хохирогч Б.С.г хэл амаар гутаан доромжилж, айлган сүрдүүлж, суултуурын усаар нүүрийг нь угааж, хутга тулган харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж хүчээр бэлгийн харьцаанд орж, бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчид бэлэг эрхтнээ хөхүүлэх, анусанд бэлэг эрхтнээ хийх үйлдэл гаргасан.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 128** тоот: “...Дүгнэлт:

1. Б.С.гийн биед хамар ясны хугарал, хамрын таславчийн мурийлт, дээд уруулд язарсан шарх, зулай, зүүн долоовор, эрхий хурууны завсарт зүсэгдсэн шарх, хошногоны амсарт язарсан шарх, язралт, дух, баруун дээд, доод зовхи, баруун, зүүн өвдгөнд цус хуралт, ахар сүүл, баруун, зүүн өгзгөнд зулгаралт гэмтлүүд тогтоогдлоо.

2. Хошногоны амсарт үүссэн язарсан шарх, язралт нь мохоо зүйлийн үйлчлэлээр үүсэх боломжтой. Бусад хэсгийн зулай, зүүн долоовор, эрхий хурууны завсарт үүссэн шарх нь ир үзүүртэй зүйлийн олон удаагийн үйлчлэлээр, бусад хэсгийн шарх, цус хуралт, зулгаралт, хугарал нь мохоо зүйлийн олон удаагийн үйлчлэлээр үүссэн байна.

3. Б.С.гаас авсан арчдас, наалдцын шинжилгээнд эр бэлгийн эс илрээгүй байна.

4. Б.С.гаас авсан цус, арчдас, наалдцын шинжилгээнд бэлгийн замын халдварт өвчин илрээгүй байна.

6. Дээрх гэмтлүүд нь Гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.4.1-д зааснаар эрүүл мэндийг түр хугацаагаар сарниулах тул гэмтлийн хөнгөн зэрэгт хамаарна. Цаашид ерөнхий хөдөлмөрийн чадвартыг тогтонги алдагдуулахгүй.

Шүүхээс шүүгдэгч Т. овогт Б.ы Х.ыг харгис хэрцгий аргаар, хохирогчийг тохуурхан доромжилж хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, хүчээр бэлгийн харьцаанд орж хүчиндэх гэмт хэргийг үйлдсэн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8, 2.10 дахь заалт, мөн хуулийн 12.2 дахь хэсгийн 1 дахь заалтад зааснаар гэм буруутайд,

Мөн шүүгдэгч Т. овогт Б.ы Х.ыг хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэм буруутайд тус тус тооцсугай... гэж оруулж өгсөн байна. Дээрх гэмт хэрэгт шүүхээс МУ-н ЭХТА-н 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8, 2.10 дахь заалт, мөн хуулийн 12.2 дахь хэсгийн 1 дахь хэсэг, мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт заасан ялыг оногдуулсан байна. Дээрх ялын зүйлчлэлд ял оногдуулсан ЭХТА-н 12.2 дахь хэсгийн 1 дахь заалт нь хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үеэс бусад цаг хугацаанд хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж үйлдсэнээрээ “Хүчиндэх” гэмт хэргээс ялгаатай байдаг тул дээрх гэмт хэрэг нь хохирогчийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр занал хийлж үйлдсэн тул тухайн зүйл заалт нь буруу зүйлчлэл гэж харахаар байна.

Нөгөө талаас энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг нь материаллаг гэхээсээ илүү хохирогчийн сэтгэл зүй, алдар хүнд, оюун санааны хэлбэрээр илэрдэг тул үүнийг мөнгөн илэрхийллээр тооцдог эрх зүйн механизм манай улсад учир дутагдалтай байна. Энэ байдал нь хохирогч гэмт хэргийн золиос болсноо нуух, гэмт этгээдийг илчлэхээс эмээх цаашлаад энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байдлаар өсөн нэмэгдэх эрсдэл байна.

Тэгэхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” -т багтсан тодорхой төрлийн гэмт хэргийг үйлдлийн арга, хэлбэр, гэмт этгээдийн сэдэлт, зорилго, объект, субъект, хэм хэмжээг нарийвчлан судалж гагцгүй нотлох баримтад тулгуурлан зүйлчлэх шаардлага байгааг бодитоор харуулж байна.

Дүгнэлт

Өмнөх хууль (2002 онд батлагдсан)-иас нэг онцлог зохицуулалт нь энэ гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болохоор зохицуулагдсан байна. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх хэсэгт энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинжүүдийг заасан байна. Түүнчлэн бага насны хүүхэд буюу 14-өөс доош насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй болсон.

Хүчиндэх гэмт хэрэг нь хохирогчийн хүсэл зоригоос гадуур хурьцал үйлдэх, энэ зорилгодоо хүрэхийн тулд хүч хэрэглэх, заналхийлэх эсхүл бусдын согтуурсан, мансуурсны улмаас биеэ хамгаалж, эсэргүүцэл үзүүлж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн харьцаанд орсон эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн үйлдэл байдгаараа Эрүүгийн хуулийн 12.2, 12.3, 12.5-р зүйлд заасан гэмт хэргээс яллагдаж байна.

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан үйлдэл байх бөгөөд гагцхүү энэ шинжээр хүчиндэх гэмт хэргээс өөр байна.

Эрүүгийн хуулиар эрэгтэй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах боломжийг бий болгосон.

Санал

1. Хүчиндэх гэмт хэргийг 18-аас доош насны хүн үйлдвэл эрүүгийн хуульд ямар хариуцлага хүлээлгэх талаар нарийвчлан тусгаж өгөөгүй байх тул хууль санаачлагч нар дээрх асуудлыг анхааран авч үзэх.

2. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын сэтгэл санаа, бие эрхтэн, сэргээн засах эмчилгээ бусад нэхэмжлэлийг Иргэний болон ИХШХШ тухай хуульд зааснаар нэхэмжлэх эрхийг нээлттэйгээр үлдээн шийдвэрлэж байгаа нь хохирогчид хүндрэлтэй асуудал болсоор байх тул эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар зүйл “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” дэх бүлэгт нарийн тусгаж хуульчилж өгөх шаардлагатай.

3. Дээрх гэмт хэргийн улмаар хохирогчийн “эрүүл мэндэд хүндэвтэр, хүнд хохирол учирсан” бол гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг Эрүүгийн хуулийн

тусгай ангийн 12.1 дахь хэсэгт нэмэлтээр оруулж өгөх, эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-тэй давхар зүйлчлэхгүй байх.

4. Мөн хуулийн 6 дугаар зүйл “Шударга ёсны зарчим”, 6.2. “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байх тул 12.1.2.7 “Урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;” гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хасах.

5. Дээрх хуулийн 12.4 дах хэсэгт “Бэлгийн дарамт учруулах” гэмт хэргийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон зүйл заалтыг сэргээж, ялын бодлогыг чангатгах учир нь хохирогчид ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны, бусад байдлаар хохирол учруулах үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэж бэлгийн харьцаанд орох сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл бэлгийн харьцаанд орохыг шаардсан мөн Энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн явдлууд ихээр гарч байгаа тул сэргээх шаардлага үүсэж байна.

Ашигласан материал

- Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №7.
- Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги. Сурах бичиг. УБ., 2020 он.
- Эрүүгийн эрх зүйн хичээлийн нэр томъёоны тайлбар УБ., 2016 он
- ХЗТХЯ-аас эрхлэн гаргасан “Сургагч багш нарт зориулсан гарын авлага” УБ., 2017 он.
- Жендэрийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь. УБ 2013 он
- Хүүхдээ сонсьё тайлан, үр дүн 2012, ХТҮГ

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ COMPARATIVE STUDY OF CRIMINAL PROCEDURE

Н.Сайнбаяр

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш,
доктор, цагдаагийн хошууч

Товч агуулга: Улс орны эрх зүйн тогтолцоо нийгмийн хөгжилтэй уялдаж хувьсан өөрчлөгддөг зүй тогтолтой. Хувьсан өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага байгаа ч үндэсний онцлогт тохирсон байх нь чухал.

Аливаа эрх зүйн шинэ үзэгдлийг үндэсний онцлогт нийцүүлэн нутагшуулах болон эрх зүйн салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлохдоо өмнө нь хэрэгжүүлээд тодорхой үр дүнд хүрсэн гадаад улсын туршлагыг судлах нь ихээхэн ач холбогдолтой билээ.

Гадаад орны, тэр дундаа хөрш зэргэлдээх болон эрх зүйн бүлийн онцлогоор судлах нь оновчтой боловч ази тивийн улсуудын хүрээнд судалгаа хийх нь илүү бодитой, үр дүнтэй гэж үзсэн. Энэ хүрээнд эрүүгийн процессын хөгжлийн чиг хандлагыг төв азийн зарим улсуудын эрх зүйн тогтолцоог харьцуулан судлах замаар тодорхойлохыг зорилоо.

Abstract: The legal system of a country is a natural system that evolves and changes in line with the development of society. Although there is a need for change, it is important to be consistent with national characteristics.

When localizing any new legal phenomenon in accordance with national characteristics and determining future trends in the legal field, it is of great importance to study the experience of foreign countries that have previously implemented it and achieved certain results.

Although it is reasonable to study foreign countries, especially neighboring countries and legal families, it is considered more realistic and effective to conduct research within the framework of Asian countries. In this context, the aim is to determine the development trends of criminal procedure by comparing the legal systems of some Central Asian countries.

Түлхүүр үгс: Эрүүгийн процессын эрх зүй, хөгжлийн чиг хандлага, салбар эрх зүй, эрүүгийн процесс, шүүх эрх мэдэл.

Keywords: Criminal procedure law, development trends, branch of law, criminal procedure, judicial authority.

Төв Ази (англиар - Central Asia) гэдэг нь Ази тивийн төв хэсгийг хамардаг бүс юм. Одоогийн хэрэглэгдэж буй албан ёсны ойлголтоор буюу НҮБ-ын тодорхойлсноор энэ бүс нутагт Казахстан, Киргиз, Тажикстан, Туркменистан, Узбекистан гэх 5 улсын ("таван -стан") нутгийг хамруулдаг.

Харин өргөн утгаараа буюу ЮНЕСКО-гийн тодорхойлсноор Монгол Улс, Өвөр Монгол, Өмнөд Сибирь (Буриад, Тува, Алтайн Бүгд Найрамдах Улс, Өвөр Байгалийн хязгаар, Эрхүү муж, Алтайн хязгаар, Омск муж, Хакас, Кемерово муж, Оренбург муж, Курган муж, Тюмень муж, Новосибирск муж), Шинжаан, Хөхнуур,

Ганьсу, Төвөд зэрэг монгол, төвд, уйгурчуудын амьдран суудаг нутаг болон, хойд Афганистан, хойд Иран, хойд Пакистан, Энэтхэгийн баруун хойд талын Кашмир муж зэрэг далайд гарцгүй нутгуудыг хамарна⁵³ гэж тодорхойлжээ.

Судалгааны ажлын хамрах хүрээг үндэсний болон Казахстан, Киргиз, Тажикстан, Туркменистан, Узбекистан зэрэг улсуудын эрүүгийн процессын хууль тогтоомжийн хүрээнд явуулах нь илүү оновчтой, бодитой гэж дүгнэлээ. Учир нь ЗХУ нуран унах үед эдгээр улс нэгэн зэрэг эдийн засгийн болоод эрх зүйн тогтолцооны хувьд бие даах болсон нь салбар эрх зүйн хөгжлийг бодитой тодорхойлох боломжтой юм.

Төв Азийн зарим улсуудад ЗХУ-ын эрх зүйн тогтолцооны хэв маяг одоо ч хадгалагдан үлдсэн байдаг ч өөрийн үндэсний онцлогт тохирсон эрх зүйг бий болгох эрмэлзэл нь бусад тивийн улсуудтай харьцуулахад харьцангуй их байдаг зүй тогтол ажиглагддаг.

Казахстан Улсын Астана хотод энэ оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд "Төв Азийн эрүүгийн шүүх эрх мэдлийн салбарын шинжээчдийн 9 дэх удаагийн форум" болж өнгөрсөн нь ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болов. Энэ удаагийн форум Казахстан Улсын Дээд шүүхийн дэмжлэгтэйгээр, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын Төв Азийн бүс нутгийн алба (OHCHR), НҮБ-ын Төв Ази дах Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC), НҮБ-ын Европ, Төв Азийн бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийн төв (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төв), Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын Хүний эрх ардчилсан институтын алба (OSCE Office for Democratic Institutions and Human Rights (ODIHR)), Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын Астана, Бишкек, Душанбе дахь хөтөлбөрийн газрууд, Эрх зүйн бодлого, судалгааны төв (LPRC) хамтран зохион байгуулж, Казахстан⁵⁴, Монгол⁵⁵, Туркменистан⁵⁶, Узбекистан⁵⁷, Киргизстан⁵⁸, Тажикстан⁵⁹ /цаашид Төв Азийн улсууд гэх/ болон олон улсын, үндэсний хүний эрхийг хангах байгууллагуудын 200 гаруй төлөөлөл оролцсон өргөн хүрээний форум боллоо⁶⁰. Энэ форумын үеэр төв азийн улсуудын эрүүгийн процессын хөгжлийн чиг хандлагын талаар дэлгэрэнгүй авч үзсэн юм.

Олон улсын түвшинд эрүүгийн процессын эрх зүйн хүрээнд аккусац, инквизиц гэсэн хоёр үндсэн загвар байдаг бөгөөд Монгол, Казахстан, Киргиз, Тажикстан, Туркменистан, Узбекистан улсууд нь инквизиц буюу шүүхийн өмнө урьдчилан мөрдөх ажиллагаа явуулдаг загварт хамаарч байгаа нь нийтлэг байв. Эдгээр улсын эрүүгийн процессын харьцуулалтыг системчлах зорилгоор шүүхийн өмнөх болоод шүүхийн дараах гэсэн агуулгаар ангилан авч үзэв. Мөн эдгээр улсууд шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахдаа Киевийн хуралдааны

⁵³ Цахим эх сурвалж: wikipedia.com хандсан: 2024.12.09

⁵⁴ Казахстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль (2014.07.04).

⁵⁵ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017.07.01).

⁵⁶ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль (2009.07.01).

⁵⁷ Узбекистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль (1995.04.01).

⁵⁸ Киргизстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль (2021.10.28).

⁵⁹ Тажикстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль (2009.12.03).

⁶⁰ Цахим эх сурвалж: <https://www.osce.org/odihr/581110> хандсан: 2024.12.09

зөвлөмж⁶¹-ийг хангаж ажиллахын төлөө эрмэлзэж байдаг нь судалгааны ач холбогдолтой байлаа.

Шүүхийн өмнөх үе шат.

Төв Азийн зарим улсуудын хувьд ЗХУ-ын бүрэлдэхүүнд хамаарч байсантай холбоотойгоор эрүүгийн процессын хууль тогтоомжуудад ижил агуулгатай зохицуулалтууд түгээмэл ажиглагдсан. Гэсэн хэдий ч үндэсний эрх зүйн тогтолцооны онцлогт тохирсон өөрчлөлтүүдийг байнга хийсээр байна.

Монгол, Казахстан, Киргиз, Тажикстан, Туркменистан, Узбекистан Улсын эрүүгийн процессын хууль тогтоомжийн хүрээнд бусдын гомдол мэдээллээр мөрдөх ажиллагаа эхлүүлдэг нийтлэг шинжтэй. Гэхдээ мөрдөх ажиллагааг бий болгох гомдол, мэдээлэл гаргагч нь буюу хохирогч гомдолтой эсэхээс хамаарч хэргийг хэрэгсэхгүй журам оруулж өгчээ. Энэ нь нэг талаараа оновчтой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Учир нь зарим нийгмийн аюулын шинж багатай гэмт хэрэгт хохирсон хүн гомдолгүй болсон нь эрүүгийн процессын зорилт хангагдсан гэж үзэх боломжтой. Хохирсон иргэнд учирсан хохирол бүрэн арилсан байхад төр үргэлжлүүлэн шалгаж, шүүхээр эрүүгийн хариуцлага зайлшгүй оногдуулах нь ялын бодлого оновчтой бус байгааг илэрхийлнэ.

Мөрдөх ажиллагааг хувийн, нийтийн, хувийн болон нийтийн хэрэг гэж ангилан авч хэрэгжүүлдэг байна. Хувийн шинжтэй хэргийг хохирогчийн өөрийнх нь гомдолгүйгээр мөрдөх ажиллагааг үргэлжлүүлдэггүй, харин хувийн болон нийтийн шинжтэй хэргийг хэрэгсэхгүй болгох эсэхийг мөрдөх байгууллага дур мэдэн шийддэг⁶² онцлогтой аж.

Гэмт хэргийн шинжтэй байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, түүнчлэн шүүгч тогтоол гаргаж эрүүгийн хэргийг үүсгэх эрх хэмжээтэй байдаг онцлогтой⁶³. Түүнчлэн зарим улсад хүүхдийн асуудлаар мэргэшсэн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хэмээх тусгай субъектууд зөвхөн хүүхдэд хамаарах эрүүгийн процессыг хэрэгжүүлдэг байна⁶⁴.

Казахстан Улс эрүүгийн цахим хэргийг хуульчлан хэрэгжүүлээд багагүй хугацаа өнгөрсөн нь олон талын давуу талын цаг үеийн шаардлагад нийцжээ.

Мөрдөх ажиллагааг бол мөрдөх чиг үүрэг бүхий төрийн албан тушаалтнууд хэрэгжүүлдэг нь нийтлэг байна. Харин Монгол Улсаас бусад төв азийн улсуудад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэсэн 2 төрлийн субъект мөрдөх ажиллагаа хэрэгжүүлдэг байна. Хэрэг бүртгэгч нь хэрэг бүртгэлтийн хэрэг буюу хөнгөн гэмт хэрэгт хамаарах тодорхой төрлийн гэмт хэрэгт мөрдөх ажиллагаа явуулж буй онцлогтой аж.

Мөрдөн шалгах ажиллагааны үед мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч хэрэгжүүлдэг нийтлэг зохицуулалт давамгайлж байна. Мөрдөгч, мөрдөн

⁶¹ Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын Хүний эрх ардчилсан институтын алба (OSCE Office for Democratic Institutions and Human Rights (ODIHR))-аас 2010.06.23-25-ны өдрүүдэд Украин Улсын Киев хотод зохион байгуулсан “Төв болон зүүн азийн улсуудын шүүхийн байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт хуралдаанаас гаргасан зөвлөмж.

⁶² Казахстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 32 дугаар зүйл, Тажикстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 24 дүгээр зүйл, Киргизстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 24 дүгээр зүйл г.м.

⁶³ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 216 дугаар зүйл.

⁶⁴ Киргизстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 5 дугаар зүйлийн 8 дах хэсэг.

байцаагчийн тухайд прокурорын байгууллага⁶⁵, тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх байгууллага⁶⁶, дагнасан мөрдөх байгууллагын харьяаллын алба хаагчид мөрдөх ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн мөрдөх ажиллагааг мөрдөн байцаагч нь бие даан хэрэгжүүлдэг нь нийтлэг байгаа нь манай улсынхаас өөр байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хэм хэмжээ нийтлэг байгаа хэдий ч Туркменистан Улсын хуульд “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд эрүүгийн хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад төрийн хамгаалалтад байдаг”⁶⁷.

Хэрэв гэмт хэргийн шинжтэй бол мөрдөн байцаагч бие даан эрүүгийн хэргийг үүсгэх шийдвэр гаргадаг нь шуурхай байдлыг хангаж буй зохицуулалт гэж үзэхээр байна. Харин манай улсын хувьд хэрэг бүртгэлтийн хэргийг нээх эсэхийг прокурор шийдвэрлэдэг нь мөрдөгчийн бие даасан, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаггүйг илэрхийлнэ.

Мөрдөн байцаалтын хугацаа яллагдагчаар татах тухай тогтоол гарснаас, хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хамаарч байгаа нь нийтлэг зохицуулалт болжээ. Прокурорын зүгээс ерөнхий хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд тэр бүр оролцоод байдаггүй нийтлэг зүй тогтол аж. Прокурорын оролцоог хязгаарласан нь зарим талаараа мөрдөн байцаалтыг хараат бус байдлыг бэхжүүлж, мөрдөх ажиллагааг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлдэг. Прокурорын зарим шийдвэрийг шүүгч хянаж үздэг тогтолцоо ч үйлчилдэг байна. Тухайлбал, прокурорын хэргийг хэрэгсэхгүй болгосон болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг шүүгч хянаж шийдвэрлэх эрхтэй⁶⁸.

Өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мөрдөн байцаагчийн ажлын хэсгээр хэргийг шалгах зохицуулалт төв азийн дээрх улсуудын эрүүгийн процессын хуулиудад тодорхой зааж өгсөн байна. Энэ нь хэргийг бүрэн дүүрэн, бодитой, шуурхай шалгаж шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг онцлогтой.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч нарын эрх зүйн байдлын тухайд ижил зохицуулалттай байна. Сэжигтнийг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд яллагдагчаар татах тогтоол үйлдснээр яллагдагч статустай болдог.

Эвлэрүүлэн зуучлагч⁶⁹ нь эрүүгийн процессын эрх зүйн харилцаанд оролцогчдын хүсэлтээр орж хооронд нь зуучлан эвлэрүүлэх, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг бие даасан хүнийг хэлдэг аж. Эвлэрүүлэн зуучлагч нь хэрэгт хамааралгүй, аль нэг талтай ашиг сонирхлын зөрчилгүй байдаг.

Мөрдөн байцаалтын шүүгч⁷⁰ гэсэн тусгай субъект шүүхийн өмнөх үе шатад мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой зөвшөөрөл олгох, таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүний хэрэгжилт хууль ёсны эсэх, баривчлагдсан сэжигтний эрх

⁶⁵ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 6 дугаар зүйл.

⁶⁶ Тажикстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 39 дүгээр зүйл.

⁶⁷ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 107 дугаар зүйл.

⁶⁸ Узбекистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 29 дүгээр зүйл.

⁶⁹ Казахстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 85 дугаар зүйл.

⁷⁰ Казахстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 7 дугаар зүйл.

зөрчигдсөн эрхийг хянах эрх хэмжээтэй байдаг нь хүний эрхийг хангасан сайн зохицуулалт болжээ.

Монгол Улсын хувьд шүүхийн өмнөх үе шатыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэж ангилан хэрэгжүүлдэг бол бусад улсын хувьд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ангилал байгаа боловч энэ нь үе шат бус тус тусдаа процесс агуулгаар хуульчлагджээ. Тодруулбал, хэрэг бүртгэх хэрэг нь хөнгөн төрлийн гэмт хэрэгт хийгддэг тусдаа ажиллагаа байна. Хэрэг бүртгэлтийн үед яллах дүгнэлтийг прокурор үйлддэг бол мөрдөн байцаалтад мөрдөн байцаагч яллах дүгнэлт үйлддэг зэргээрээ өөр өөр байна.

Талуудын тэгш, мэтгэлцэх зарчмыг хангах зорилгоор өмгөөлөгч нотлох баримт цуглуулж, хавтаст хэрэгт хавсаргаж, үнэлүүлэх эрхийг хуульчилсан⁷¹ нь хүний эрхийг хангасан сайн зохицуулалт болжээ.

Цахим технологийн хөгжилтэй уялдуулан шүүх эрх мэдлийн хүрээний үйл ажиллагааг цахимжуулах явц эрчимжсээр байна. Тухайлбал, мэдүүлэг авах, таньж олуулах, нүүрэлдүүлж мэдүүлэг авах ажиллагааг цахимаар явуулж болох⁷² талаар зохицуулж өгчээ.

Эрүүгийн процессын албадлагын арга хэмжээ.

Манай улсын хувьд зөвхөн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт сэжиглэгдсэн тохиолдолд баривчлах ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд хугацаа нь 48 цагаас ихгүй байх хуулийн зохицуулалттай. Энэ нь хүний эрхийг дээдэлсэн эерэг зохицуулалт гэж дүгнэж байна.

Узбекистан улсын тухайд баривчлах хугацаа 48 цаг бөгөөд шаардлагатай тохиолдолд мөн хугацаар сунгах боломжтой байдаг. Баривчласан хугацааг сэжигтнийг чөлөөтэй зорчих эрх хязгаарлагдсан үеэс эхлэн тоолдог⁷³ аж.

Монгол, Туркменистан улсын хувьд заавал хорих ял оногдуулахаар заасан хэрэгт л баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг нийтлэг зохицуулалттай ба сэжигтнийг баривчлах хугацаа 72 цагаас⁷⁴ ихгүй байх нь түгээмэл байна.

Дан ганц сэжигтэн гэлтгүй яллагдагч, шүүгдэгчийг хуульд заасан үндэслэл тогтоогдвол баривчлах боломжтой байдаг⁷⁵ нь эрүүгийн процессын шуурхай байдлыг хангаж буй оновчтой зохицуулалт гэж үзэхээр байна.

Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл нийтлэг байна. Тодруулбал, хувийн батлан даалт, цэргийн байгууллагын удирдлагад шилжүүлэх, барьцаа авах, хязгаарлалт тогтоох, цагдан хорих гэх мэт.

Гэхдээ зарим онцлог арга хэмжээ тусгасан нь ажиглагдлаа. Тухайлбал, гэрийн баривчилгаа, гадагш явж болохгүй баталгаа авах зэргийг дурдаж байна.

Таслан сэргийлэх арга хэмжээг ихэвчлэн мөрдөн байцаагч, шүүгчийн зүгээс хэрэгжүүлдэг аж. Мөн хувийн баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээнээс гадна байгууллага, хамт олны батлан даалтад авах таслан сэргийлэх арга хэмжээ

⁷¹ Узбекистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 87 дугаар зүйл.

⁷² Мөн хуулийн 91 дүгээр зүйл.

⁷³ Мөн хуулийн 226 дугаар зүйл.

⁷⁴ Казахстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 128 дугаар зүйлийн 5 дах хэсэг. Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 144 дугаар зүйл.

⁷⁵ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 139 дүгээр зүйл.

байгаа⁷⁶ нь нийгмийн зүгээс гэмт хэрэгт тэмцэх үйл ажиллагаанд оролцох, цаашлаад нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж буй үр нөлөөтэй арга хэмжээ болжээ. Тухайлбал, эксгумац хийх зөвшөөрөл, захидал харилцааны нууцад нэвтрэх зэрэг мөрдөн шалгах ажиллагаанд шүүгч зөвшөөрөл олгодог онцлог зарим⁷⁷ улсуудын хууль тогтоомжид тусгагджээ. Шашны онцлогтой холбоотойгоор шарилд үзлэг хийх зөвшөөрлийг шүүгч олгож байж ч болох талтай.

Эрүүгийн процессыг шуурхай хэрэгжүүлэх зорилтыг хангахын тулд паспортын үйлчлэлийг түр зогсоох албадлагын арга хэмжээг зарим тохиолдолд хэрэглэдэг.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 2-оос дээш жилийн хорих ялаар шийтгүүлэх эрүүгийн хэрэгт болон тухайн гэмт этгээд нь тодорхой оршин суух хаяггүй тохиолдолд прокурорын шийдвэрээр цагдан хорьдог зохицуулалт зарим⁷⁸ улсад үйлчилдэг байна. Энэ нь хабиес корпусын үзэл баримтлалтай нийцэхгүй, хүний эрх, эрх чөлөөг хангах тогтолцооноос ухарсан зохицуулалт гэж үзэж болохоор байна.

Эрүүгийн процесст оролцуулахаар оролцогчийг дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх албадан ирүүлэн талаар тогтоол үйлдэж гүйцэтгүүлэх эрх хэмжээтэй⁷⁹ байдаг нь шуурхай байдлыг хангаж буй хэрэг аж. Манай улсын хувьд мөрдөгчийн дуудснаар хүрэлцэн ирээгүй нь албадан ирүүлэх үндэслэл болдоггүй зохицуулалттай.

Шүүхийн үе шат.

Төв Азийн улсууд анхан, давж заалдах, хяналтын гэсэн үндсэн 3 шатны шүүхийн тогтолцоотой байдал нь нийтлэг байна. Гэхдээ үндэснийхээ онцлогийг шингээсэн өвөрмөц зохицуулалтууд цөөнгүй аж.

Нөөцийн шүүгч⁸⁰-ийг ажиллуулдаг зохицуулалт нь онцлог байв. Уг шүүгч нь удаан хугацаанд үргэлжилж буй процессын явцад шүүх танхимд хамт сууж, хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд орлох шүүгчийг бэлэн байлгадаг аж.

Шүүхийн харьяалалын тухайд гэмт хэрэг үйлдэгдсэн газрын шүүх шийдвэрлэдэг зохицуулалт нийтлэг байгаа ч Туркменистан улсын хувьд⁸¹ гэмт хэрэг үйлдсэн газрыг тодорхойлох боломжгүй тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгасан газрын шүүх шийдвэрлэдэг онцлогтой байна. Мөн Улсын дээд шүүх нь хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзаж өөрийн санаачлагаар тухайн хэргийг анхан, давах, хяналтын шатны журмаар шийдвэрлэх эрх хэмжээтэй.

Шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийн эзгүйд нь хэргийг шийдвэрлэх боломжтой байдаг нь эрүүгийн процессын зорилтыг хангахад чухал зохицуулалт гэж үзэж байна⁸². Манай улсын хувьд хэрэв гэмт хэрэгт холбогдон

⁷⁶ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 147 дугаар зүйлийн 3 дах хэсэг.

⁷⁷ Узбекистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 29 дүгээр зүйл.

⁷⁸ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 158 дугаар зүйл.

⁷⁹ Мөн хуулийн 166 дугаар зүйл.

⁸⁰ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 55 дугаар зүйл.

⁸¹ Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хуулийн 64 дүгээр зүйл.

⁸² Мөн хуулийн 339 дүгээр зүйл.

шалгагдаж байгаа этгээд оргон зайлсан тохиолдолд эзгүйд нь шийдвэрлэх боломжгүй байдгаас хохирогчийн эрх ашиг тодорхой хугацаагаар хохирох эрсдэл үүсдэг.

Төв азийн улсуудын эрүүгийн процессын хууль тогтоомжийн хүрээнд хийгдэж буй өөрчлөлтүүд нь ЗХУ-ын бүрэлдэхүүнээс салан, тусгаарлах онцлогтойгоор өмнөх хэв маягаа хадгалсан, шинэ зохицуулалтуудыг бий болгох гэсэн эрмэлзэлтэй болох нь тодорхойлогдож байна. Үүний тод жишээ нь Казахстан Улсын хууль тогтоомжийн шинэчлэлийг дурдаж болох юм. Мөн чухал нөлөөлж буй хүчин зүйлс нь эдгээр улс аливаа эрүүгийн процессын өөрчлөлтийг олон улсын байгууллагуудын зөвлөмжид тулгуурлаж гүйцэтгэж байгаа нь батлагдаж буй хууль тогтоомж хүний эрхийг хангасан, амь бөхтэй оршин тогтнох суурь нь болжээ.

Дүгнэлт

Судалгааны ажлын явцад дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Төв Азийн улсуудын эрүүгийн процессын хууль тогтоомж нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд хамт оршин тогтнож байсан тул нийтлэг зохицуулалтууд түгээмэл аж. Тухайлбал, шүүх тогтолцоо, инквизиц загвар г.м.

2. Эдгээр улсуудад хийгдэж буй эрүүгийн процессын эрх зүйн өөрчлөлтүүд нь олон улсын хүний эрхийн байгууллагуудын мониторинг, судалгаанд үндэслэн хэрэгжүүлж байгаа нь туйлын сайшаалтай алхам болжээ.

3. Манай улсаас бусад төв азийн улсууд шүүх эрх мэдлийн байгуулал хараат бус, бие даасан байх ёстой гэдэгт бүрэн нэгдэж байна. Тухайлбал, мөрдөн байцаагч шүүхийн өмнөх үе шатад мөрдөх ажиллагааг бие даан хэрэгжүүлж, процессын шийдвэрүүдийг хараат бусаар хэрэгжүүлдэг, прокурор, шүүхийн зүгээс тухайн ажиллагаанд хөндлөнгөөс оролцох эрх хэмжээгүй г.м зохицуулалт нийтлэг байна.

4. Төв азийн улсуудын эрүүгийн процессын хууль тогтоомжоос хэрэгжүүлж болохуйц хүний эрхийг хангасан олон зохицуулалт байлаа. Тухайлбал, эвлэрүүлэн зуучлагч, мөрдөн шалгах ажиллагааны шүүгч, хамт олны батлан даалт, хүүхдийн асуудал хариуцсан мэргэшсэн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, доод шатны шүүхэд хамаарах хэргийг дээд шатны шүүх хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй, яллагдагчийг эзгүйд нь хэргийг шийдвэрлэх зохицуулалт зэргийг дурдаж болно.

5. Хүний үндсэн эрхэнд халдаж буй аливаа мөрдөн шалгах ажиллагааны зөвшөөрлийг шүүх олгож байгаа олон улсын туршлагыг зарим улс орнууд үндэсний хэм хэмжээндээ тусгажээ.

6. Хүний эрхийг хангах таатай зохицуулалтууд байхын зэрэгцээ хязгаарласан зохицуулалтууд ч бас цөөнгүй байна. Тухайлбал, Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг прокурор авч хэрэгжүүлдэг, мөрдөн байцаалтын явцад прокурор бүрэн дүүрэн хяналт хэрэгжүүлдэггүй г.м.

Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Энэ чиглэлээр цааш гүнзгийрүүлэн судлах, ингэхдээ дан ганц төв ази гэлтгүй дэлхийн бусад улс орнуудтай харьцуулж авч үзэх.

2. Төв Азийн улсуудын эрүүгийн процессын хэм хэмжээнд тусгасан хэрэглэж болохуйц шинэ зохицуулалтуудыг үндэсний хууль тогтоомжид нэмэлтээр тусгах.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль 1992 он;
- Эрүүгийн хууль 2015 он;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он;
- Казахстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль 2014;
- Туркменистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль 2009;
- Узбекистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль 1995;
- Киргизстан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль 2021);
- Таджикистан Улсын Эрүүгийн процессын төрөлжсөн хууль 2009;
- Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. Уб.,2024;
- Конституция Российской Федерации /принята всенародным голосованием 12.12.1993 с изменениями, одобренными в ходе общероссийского голосования 01.07.2020/;
- "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 02.10.2024);
- Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын Хүний эрх ардчилсан институтийн алба (OSCE Office for Democratic Institutions and Human Rights (ODIHR))-аас 2010.06.23-25-ны өдрүүдэд Украин Улсын Киев хотод зохион байгуулсан “Төв болон зүүн азийн улсуудын шүүхийн байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт хуралдаанаас гаргасан зөвлөмж.
- Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/>;
- Цахим эх сурвалж: <https://www.osce.org/odihr/581110>
- Цахим эх сурвалж: <https://star.worldbank.org/>.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ CRIMINAL LAW CONCLUSION

Б.Ганболд
Хуульч, өмгөөлөгч

Товч агуулга: Одоо дагаж мөрдөж байгаа манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хууль зүйн дүгнэлт” гэж ямар ойлголт болох талаар тусгагдсан зүйл байхгүй байна.

Тус хуулийн 39.5 ба 39.6 дугаар зүйлүүдэд “шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй бол шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэл болно” гэж, 35.24 дүгээр зүйлд “улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт гаргана” гэж тус тус заажээ.

Энэхүү өгүүлээр эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлт гаргах хуульчийн арга ажиллагаа, түүний онол арга зүй, практикийн үндсэн асуудлыг тодорхойлохоор зорилоо.

Abstract: The current Criminal Procedure Code of our country does not contain any definition of what constitutes a “legal conclusion.”

Articles 39.5 and 39.6 of the law state that “if the conclusion specified in the court decision does not correspond to the facts of the case, it shall be grounds for annulling or changing the court decision,” and Article 35.24 states that “the public prosecutor and defense attorney shall issue a conclusion.”

This article aims to identify the legal procedure for issuing a legal conclusion in a criminal case, as well as the main issues of its theory, methodology, and practice.

Түлхүүр үг: Дүгнэлт, эрүүгийн хэрэг, хууль зүйн дүгнэлт

Keywords: Conclusion, criminal case, legal conclusion

Хэл зүйн үүднээс “дүгнэлт – дүгнэх үйлийн үр дүнг заасан нэр, ерөнхийд нь үнэлсэн баталгаат хариу, ерөнхий нийлбэр дүн, тодорхой үнэлгээ” гэсэн⁸³ утгатай бол, хууль зүйн хэлнээ англ. “conclusion”, орос. “заключение” гэж тэмдэглэдэг байна.⁸⁴

Харин хууль зүйн дүгнэлт нь мэргэжлийн хэллэгийн хувьд англ. “legal opinion”, орос. “юридическое заключение” гэх нэршил, томъёоллоор хууль зүйн шинжлэх ухааны эргэлтэд хамаарч судлагдах ухагдахуун болно.

Хууль зүйн дүгнэлт нь аливаа хэргийн хувь заяаг шийдвэрлэх хуульчийн хууль хэрэглээний үндсэн арга ажиллагаа учир энэ нь хуульчийн мэргэжлийн амин сүнс болсон асуудал юм.

Товчхондоо, “хууль зүйн дүгнэлт” гэдэг нь тодорхой асуудал, хэрэг, маргааны /case - кейсийн/ хүрээнд хууль зүйн дүн шинжилгээ хийсний үр дүнд өгсөн үнэлгээ буюу хууль хэрэглээний онол, практик, шийдэл зэрэг асуудлаар гаргасан санал.⁸⁵

Гаргалгаа сайтай, сэтгэлгээ өндөртэй, илэрхийлэмж тодорхой, зөв дүгнэлт өгөх чадвартай, асуудлын нарийн учир зүйд нэвтэрч хууль зүйн талаас бодит

⁸³ Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. II /Д-Л/. УБ., 2008., 765 дахь тал.

⁸⁴ С.Нарангэрэл. Англи - Монгол - Орос хууль зүйн толь. УБ., 1994., 59 дэх тал.

⁸⁵ Б.Ганболд. Хууль зүйн дүгнэлт. УБ., 2022., 14 дэх тал.

бөгөөд судалгаатай ханддаг, төгс шийдлийг олдог, дотоод итгэл үнэмшил бүрэн тогтсон хуульчийн мэргэжлийн арга барилын цогц нийлбэрийн мөн чанар, үндсэн агуулгыг өөртөө багтаасан ойлголт нь хууль зүйн дүгнэлт болно.

Хувь хуульчийн чадвар чансаа, нөөц бололцоо, оюуны бяд, сэтгэлгээний болон мэдлэгийн цар хүрээ, чадамжийг нэг талаар илтгэж, нөгөө талаар түүнийг шалгаж, “хэр зэрэг хуульч вэ” гэдгийг нь тодорхойлдог нэгэн хэмжигдэхүүн нь хууль зүйн дүгнэлт өөрөө болдгоороо нэн онцлогтой.

Энэ онцлог нь эрх зүйн тогтолцоо, хуульчийн үйл ажиллагаа, практик, онолтой салшгүй холбоотой. Тухайлбал: Олон улсын хууль зүйн The Green Bag гэдэг сэтгүүлд Жорж Вашингтоны Их сургуулийн хууль зүйн сургуулийн профессор Orin S. Kerr “How to read a legal opinion” гэсэн гарчигтай /essay/ эссэг “хуулийн сургуульд анх элсэн суралцаж байгаа оюутнуудад зориулан бичсэн” байх жишээнээс тод харагдана.⁸⁶

Ийнхүү сургалт анхнаасаа хууль зүйн дүгнэлтээс эхэлж байгаа явдал нь манай улсынхаар бол “эрх зүйн онол”-ын хичээл ордогтой дүйх боловч хууль зүйн голлох эх сурвалж нь шүүхийн прецедент буюу түүнд тусгалаа олсон үзэл баримтлал нь өдгөөг хүртэл ач холбогдлоо алдахгүй жишиг болон тогтсон байх тул хууль зүйн тодорхой асуудал, хэрэг маргааныг тэрхүү кейс /case/-ийн хүрээнд, түүний хууль зүйн дүгнэлтийн агуулгаар, практикт түшиглэн ойлгож иржээ.

Практик ба жишиг. Америкийн алдарт хөл бөмбөгчин Симпсоны хэрэг гэж дэлхийд зард гарч, хууль шүүхийн системд нөлөөлсөн хэрэг бий. 1990-ээд оны эхээр болсон хэрэг. Эхнэрээ, нууц амрагтай нь буудаад алчихсан. Уг нь бол түүнийг хүн алсныг хангалттай нотлох баримттай хэрэг.

Харамсалтай нь нотлох баримтыг хууль зөрчиж бүрдүүлсэн. Дээд шүүх нь юу гэж үзсэн гэхээр хүний гэм бурууг нотлох хуулийнхны үйл ажиллагаа хэрхэвч хуулиас гадуур хийгдэх ёсгүй, хууль зөрчиж цуглуулсан нотлох баримтыг гэм бурууг тогтооход үнэлэхгүй гэж шийдсэн.

Угтаа бол алуурчныг шүүх нь тавиад явуулчхаж буй хэрэг боловч энэ кейсээр тэд юу хэлсэн гэхээр “хууль сахиулах байгууллага, шүүх хэнбугайг ч шалгаж мөрдөхдөө хууль зөрчиж болохгүй, тэгэх л юм бол тэрийг чинь шүүх үнэлэхгүй, төр өөрөө хууль зөрчдөг, хүнийг эрхийг нь зөрчиж шалгадаг, эрүүдэн шүүдэг, түүгээрээ ялладаг байж таарахгүй” гэдгийг хэлж өгсөн.

Цаад утгаараа нэг алуурчнаар зольж, шүүх эрх мэдлийнхээ шударга ёсны байдлыг хамгаалсан, хууль сахиулагчдаа гарцаагүй хуулийн дагуу ажиллахыг шахаж шаардсан жишиг болж түүхэнд үлдсэн хэрэг аж.⁸⁷

Эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлтийг хийхэд юуны түрүүнд эрүүгийн материаллаг болон процессын эрх зүйн гүн гүнзгий мэдлэгтэй байх нь нэн чухал агаад мэдлэг хэдий чинээ сайтай хуульч байна, түүний хууль зүйн дүгнэлт төдий чинээ сайн гарна гэсэн үг.

Францын соён гэгээрүүлэгч Ш.Л.Монтескье 1748 оны “Хуулийн амин сүнс” гэх алдарт бүтээлдээ “... эрүүгийн хэрэг таслахад удирдлага болговол зохих бат найдвартай горим журмын талаарх мэдэгдэхүүнээс өөр чухаг юм хүн төрөлхтөнд байхгүй дээ, энэ ертөнцөд. Ийм мэдлэгийг зарим оронд нэгэнт хэрэглэж заншжээ.

⁸⁶ Yз. Volume 11., Number 1., Green Bag 2D., p-51-63.

⁸⁷ <https://mojha.gov.mn/newmojha/?p=1300>.

Бусад нь үүнийг дагаж л таарна. Хэргийг шийдэхэд чухамхүү ийм мэдэгдэхүүнд тулгуурлаж гэмээнэ эрх чөлөө тогтож болно” гэж⁸⁸ бичсэн байдаг.

Харин Италийн нэрт сэтгэгч Ч.Беккариагийн хэлсэнчлэн “... хууль нь яв цав тодорхой газар шүүхэд зөвхөн болсон явдлыг тогтоох л үлдэнэ. Нотлох баримтыг цуглуулахад авхаалж самбаа, арга туршлага, дэлгэн тайлбарлахад ойлгомжтой, тодорхой ярих нь чухал байдаг бол энэ бүхэндээ тулгуурлан дүгнэлт гаргахад сургуульд сурсан зохиомол загвар сэлтээр буруутай этгээдийг болон түүний үйлдлийг үнэлж дүгнэх гэхээсээ илүүтэй “эрүүл саруул ухаанаар асуудалд хандах нь” дээр агаад “хууль мэднэ гэдэг шинжлэх ухааны хэрэг болчхоогүй ард түмэн азтай” аж.⁸⁹

Сургамж. Хохирогчийн биеэс 4 дүгээр бүлгийн үрийн шингэн олджээ. Харин тэр хэрэгт сэжиглэж байсан Чикатилогийн цус 2 дугаар бүлэгт хамаарч байсан учраас түүнийг тэр үед суллан явуулжээ.

Гэтэл түүний үрийн шингэн нь 4 дүгээр бүлгийнх, харин цус нь 2 дугаар бүлэгт хамаарч байсныг “цус мөн тийм байх ёстой” гэсэн хууль зүйн алдаатай дүгнэлтийг хийснээр 6 жил цуст аллагаа үргэлжлүүлэн хийх боломжийг олгосон гашуун түүх үлдсэн байдаг.⁹⁰

Чикатило нь Доны Ростов мужид, 1982-1990 оны хооронд 53 хүнийг алсан, бэлгийн гаж донтон байсан бөгөөд тэрээр “хүн алах яг тэр агшиндаа дур тавьдаг, хүний нүцгэн биеийг харвал өөрийн эрхгүй араатан шиг дайрч давшилдаг, энэ нь хурьцах тэмүүлэл бус, байгаль эх намайг бэлгийн хэвийн амьдралаар дутаасанд л хорсож цөхөрсөн үйлдэл байсан, би сексээс ямар ч таашаал авч үзээгүй, харин хүн алах үедээ сэтгэлийн тайвшралыг олсон” гэж мэдүүлж байжээ.

Түүний хэргийг илрүүлэхийн тулд 20.000 хүнийг сэжиглэн шалгаж, нэг хүнийг түүний аллагад буруутган хэлсээр цаазалж байсан байдаг ба 12 жилийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд баривчилж, хэргээ хүлээн мэдүүлж, улмаар 1994 онд цаазаар авсан гэдэг.⁹¹

Хууль зүйн ямар дүгнэлт гарснаас шууд шалтгаалж эрх зүйн олон талт үр дагавар үүснэ. Тухайлбал: шүүх гэм буруугүй гэж үзвэл цагаатгах бол, харин гэм буруутайд тооцвол торгохоос аваад бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

Жишээ, дүгнэлт. 1995.12.31-ний өдөр Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Борбэлчир” гэдэг газарт “П” нь бусдын гарт амь насаа алдсан харамсалтай хэрэг гарчээ. Энэ хэрэгт Эрдэнэ-Очир гэх хүнийг сэжиглэж 6 жил, 8 сар, 23 хоног цагдан хорьж, 4 жил 2 сар, 7 хоногийг нь гянданд өнгөрүүлсэн байна.⁹²

Прокуророос тус хэрэгт 6 удаа ял төлөвлөж, шүүхээс 3 удаа цаазаар авах ял, 2 удаа хорих ял, 1 удаад нь мөрдөн байцаалтад буцааж, улмаар Улсын дээд шүүх түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгажээ.⁹³

Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт гаргах арга ажиллагаа нь оюуны маш их хүч, хөдөлмөр шаардсан ажил гэдгийг тодотгон хэлэх нь зүйтэй. Ёстой л Г.Совд

⁸⁸ Ш.Л.Монтескье. Хуулийн амин сүнс /орч.Т.Төмөрхүлэг/. УБ., 2008., 206 дахь тал.

⁸⁹ Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай /орч.Г.Эрдэнэбат/. УБ., 2009.,53 дахь тал.

⁹⁰ Зууны алуурчин. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ., 2002., №01., 47 дахь тал.

⁹¹ Б.Ганболд. Криминологи. УБ., 2013., 122 дахь тал.

⁹² ХЭҮК. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. УБ., 2005., 101 дэх тал.

⁹³ Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны Магадлал., 2002.09.25., №218.

гуайн хэлсэнчлэн “Үдээтэй цаас мэт харагдах хуулийн хүчин чадал мэргэшсэн хуульчийн оюунаар амилдаг” гэдэг энэ.

Прецедент. АНУ-ын Дээд шүүх 1961 онд Мэппийн хэргийг хэлэлцэхдээ хууль бус аргаар /нэгжлэгээр/ олж авсан нотлох баримтыг шүүн таслах үйл ажиллагаанд ашиглахыг хориглосон шийдвэр гаргаж прецедент тогтоосон байдаг бөгөөд үүнийг эрүүгийн процесст “хориотой модны жимс түүх” гэж нэрлэдэг.⁹⁴

Жишээ нь, 1976 онд Чадвикийн хэрэгт “вокзал дээрээс сэжигтэй чемоданыг 3 хүн автомашинд оруулж байхад нь ордер үзүүлж” тэднийг баривчилжээ. Улмаар 30 минутын дараа уг чемоданыг цагдаагийн хэсэг дээр задалсанд дотроос нь хар тамхи гарав.

АНУ-ын дээд шүүх түүнийг нотлох баримт гэж үзээгүй аж /учир нь өмнөх 1961 оны Мэппийн хэргээр тогтоосон прецедент байгаа/. Учир нь чемодан бол тэдгээр 3 баривчлагдсан 3 хүний биед хамаарах /байх/ зүйл биш, тийм учраас “нэгжлэг хийх зөвшөөрлийг тусад нь авах ёстой, ингэх /тийм/ хангалттай үндэслэл, хүрэлцээтэй цаг байсан” гэсэн хууль зүйн дүгнэлт өгчээ.⁹⁵

Эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлт гаргах арга ажиллагааг хамгийн энгийнээр дараах хэсэгт хуваан үзэж болно. Үүнд:

1. Бэлтгэл ажил /хангагдах нөхцөл/;
2. Судалгааны шат /танин мэдэхүй/;
3. Хувилбар боловсруулах /төсөл зохиох/. Эдгээр арга ажиллагааны нийлэмж нь хууль зүйн дүгнэлт болж илэрнэ.

Эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлт гаргах арга ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд энэхүү эхлэл шатанд дараах нөхцөл зайлшгүй хангагдсан буюу бүрдүүлсэн байна. Үүнд:

а/. хавтаст хэргийн материалтай танилцана /бүрэн хэмжээнд нэг бүрчлэн үзэж, шаардлагатай баримтыг хуулбарлан хувилах, техник хэрэгсэл ашиглан зургийг нь дарах, эсхүл бичиж тэмдэглэж авах буюу хэргийн түүвэр хийнэ, мундаг хуульчид хавтаст хэргийг араас нь уншдаг юм гэлцдэг/,

б/. хууль зүйн дүгнэлт гаргахад ашиглагдах, шаардлагатай эх сурвалжийг олж тогтооно /хууль, онол, практик, харьцуулсан судлалд хамаарах зүйлсийг/,

в/. тэдгээрийг олж /цуглуулан/ авна, биет байдлаар, вертауль хэлбэрээр, зураг, хүснэгт, текстээр гэхчлэн,

г/. орчин бүрдүүлэх /нам гүн, тайван, саад болох зүйлгүй, шаардлагатай зүйлс хангагдсан газарт /ажлын байр, техник хэрэгсэл, интернэт гэх мэт/ тогтвортойгоор төвлөрч сууж хийх нь илүү үр дүнтэй.

Юуны өмнө онол зүйн бэлтгэл хангагдсан байх нь зохистой. Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт бүрт эрүүгийн материаллаг ба процессын эрх зүйн онолын гүн бат мэдлэг зайлшгүй шаардагдана. Тухайлбал, манай улс эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүний ямар онол зонхилдог, гэмт хэрэг зүйлчлэл, нотлох баримтын онолын үзэл баримтлал нь ямар байдаг гэх мэт.

Эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлт гаргах арга ажиллагааны 2 дахь үе шат буюу бие даасан хэсэг нь судалгааны ажил байдаг бөгөөд энэ үе

⁹⁴ В.Н.Махов, М.А.Пешков. Уголовные процесс США. М., 1998., стр. 80-81.

⁹⁵ Г.Б.Батзориг, Ч.Н.Баясгалан. АНУ-ын эрүүгийн процесс. УБ., 2008., 7, 27 дахь тал.

шатанд бэлтгэл ажлын хүрээнд цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх явдал хамаарах ба энэ ажлыг хэрхэн хийснээс цаашдын хууль зүйн дүгнэлтийн хувилбарыг хэрхэн яаж боловсруулах үйл ажиллагааны мөн чанар, шинж агуулга тодорхойлогдоно.

Эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлтийг гаргах арга ажиллагааны судалгааны ажлын хүрээнд энэхүү шатанд дараах багц агуулгын судалгааг хийж гүйцэтгэсэн байвал зохино. Үүнд:

- хууль судлал /тухайлбал: хууль, нэмэлт, өөрчлөлт, эрх зүйн акт, эмхэтгэл, хуулийн тайлбар, олон улсын гэрээ, конвенц гэх мэт/,

- онол судлал /тухайлбал: ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага, илтгэл, өгүүлэл, эрдэм шинжилгээний бусад ажлууд/,

- практик судлал /тухайлбал: шүүхийн шийтгэх ба цагаатгах тогтоол, магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол шийдвэр, захирамж/,

- харьцуулсан судлал /гадаад улс орны шүүхийн жишиг, олон улсын эрх зүйн зохицуулалт, чиг хандлага/ зэрэг болно. Тухайлбал, Хэдхэн сарын дотор 15 залуу эмэгтэйг умай руу нь хутга дүрж тамлан шархдуулжээ. Ингэж л “бэлгийн дур хүслээ хангадаг” хэмээн гэмт хэрэгтэн хүлээн зөвшөөрч мэдүүлсэн байна. Үүнд “гэмт этгээд хурьцаж нөхцөхийн өмнө цус урсгах, шархдуулах, хатгаж жадлах” зэргээр бэлгийн тааламжаа хангах нь “яснаас нь л заяагдсан балмад шинж”, ийм шинж “төрөлхийн гэмт хэрэгтэнд” л байдаг гэж проф. Ч.Ломброзо тайлбар өгч байжээ.

Тэрээр “алуурчин гэмт хэрэгтний тархи бол ердийн хүнийхээс 30 граммаар бага байдаг” гэж тогтоосон нь маш сонин санагддаг ч түүний энэ судалгаа цаазаар авхуулсан 400 хүний толгой /гавлын яс/, мөн ердийн үхлээр үхсэн 200 хүний толгойг харьцуулсан харьцаанаас гаргаж ирсэн дүгнэлт юм. Гэхдээ энэ дүгнэлтийг бүгд утгагүй зүйл гэж үздэг мөртөө ийм төрлийн судалгаа шинжилгээний ажил хэн ч хийгээгүй байна.⁹⁶

1927 онд “оюун ухааны хомсдолтой, ген-удам дамжсан, сэтгэл мэдрэлийн сааталтай хүмүүсийн үйлдэж байгаа гэмт хэргээс тэдгээрийн үр удмыг нь төрүүлэхгүй байх, дамжилтыг таслах замаар урьдчилан сэргийлж чадна, энэ нь хүн төрөлхтөнд хэрэгтэй алхам” гэх мэдэгдэл АНУ-ын шүүгч О.W.Holmos хийснийг Дээд шүүх хэлэлцэж “Үргүй болгох” хуулийг батлуулж байсан түүхтэй билээ.⁹⁷

Кейс. Эрнесто Миранда гэх 23 настай залууг 1963 оны 3 дугаар сарын 13-ны өдөр гэртээ байхад нь хүн хулгайлах, хүчиндэх гэмт хэрэгт сэжиглэн баривчилж, 2 цаг орчим байцааж, тэрээр хэргээ хүлээж, 20 жилийн хорих ялаар шийтгэгдсэн байна.

АНУ-ын Дээд шүүх энэ хэрэг дээр хууль бусаар цуглуулсан нотлох баримт нотлох чадвараа алдах болон сэжигтэн, яллагдагч өмгөөлөгч авах эрхтэй гэсэн дүрмүүдийн дагуу түүнийг гэм буруугүйд тооцсон ба Мирандагийн анхааруулга хэмээх ойлголт хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд тавигдах нэг стандарт болж хэвшсэн юм.⁹⁸

⁹⁶ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол I. УБ., 2009., 935 дахь тал.

⁹⁷ Б.Ганболд. Эрүүгийн номлол /зураглалт толь/. УБ., 2016., 22 дахь тал.

⁹⁸ Л.Галбаатар. Эрх зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан шүүхийн шийдвэр: *Miranda v. Arizona* /1963/. Шүүх эрх мэдэл. №1., 2015., 149-152 дахь тал.

Эрүүгийн хэргийн талаарх хууль зүйн дүгнэлт гаргах арга ажиллагааны 3 дахь үе шат буюу хамгийн сүүлчийн бие даасан хэсэг нь хувилбар боловсруулах буюу төсөл зохиох ажил юм.

Хууль зүйн дүгнэлт гаргах бэлтгэл шатны нөхцөл хангагдсан, судалгааны ажил хийгдэж дууссан тохиолдолд хууль зүйн дүгнэлтийн төсөл зохиож, боломжит бүх хувилбаруудыг дэвшүүлэн гаргана.

Энэ үе шатанд энгийн авч онол ба практикийн онол бэрхшээлтэй асуудалтай та нүүр тулах болно. Жишээ нь, автобусанд явж байгаад бусдын гар цүнхэнд байсан боодолтой юмыг хулгайлахад уг зүйл нь лабораторийн шинжилгээнд өгөхөөр авч явсан ялгадас /баас/ байх.⁹⁹ Үүнд ямар хариултын хувилбар танд байна вэ?

Монгол Улсын Дээд шүүхээс эрхлэн гаргасан “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” гэдэг 2010 оны хамтын бүтээлийн 111 дэх хуудсанд “жишээ нь, хүнийг алах зорилгоор хоолонд нь хор хийлээ гэж бодсон, тэр нь ердийн угаалгын нунтаг байсан” гэх мэт ашиггүй зүйлд завдах, халдсан нь бодит байдал дээр ямар нэг хор уршиг учруулдаггүй учир хууль хэрэглэх практикт Эрүүгийн хуулийн “... хэлбэрийн төдий ... үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэсэн заалтыг үндэслэж асуудлыг шийдвэрлэж байвал зохино” гэж бичжээ.

Тэгвэл “энэ нь тийм зөв практик бус бөгөөд нийтлэг журам үйлчлэх нь илүү зохимжтой. Учир нь “хүнийг алах зорилгоор хоолонд нь хор хийнэ” гэдэг аюултай үйлдэл, гэмт хэрэгт тооцохгүй бол хордож үхтэл нь уг гэмт үйлдлийг харсаар, төгс үйлдэгдэх хүртэл нь хүлээсээр байх гэж үү” гэсэн асуулт зүй ёсоор урган гарахыг бодолцох ёстой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед дараах ажиллагааг уялдаа холбоотой, харилцан шүтэлцээтэй, шат дараалалтай, логик үндэслэлтэй, нарийн нягт судлан үзэж явуулснаар тухайн эрүүгийн хэргийн талаар хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байдлыг хангасан хууль зүйн дүгнэлт /хувилбар/ гаргах нөхцөл бүрдэхийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Гэмт хэргийн шинж байгаа эсэх үндэслэлийг тогтоох буюу, ямар гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдаж буйг судална.

2. Гэм буруу, хэргийн зүйлчлэл, ял буюу эрүүгийн хариуцлага, хохирол ба гэм хор зэрэг ямар асуудлын талаар маргаантай эсэхийг тогтооно.

3. Эрүүгийн материаллаг болон процессын эрх зүйн харилцаа хэрхэн яаж үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохыг /хууль зүйн фактыг/ тодорхойлж, уг харилцаанаас үүсэх хууль зүйн эерэг ба сөрөг үр дагаврыг илрүүлнэ.

4. Эрүүгийн хэргийн үйлдэгдсэн бодит байдал хэрхэн бүрэн тогтоогдсон эсэхийг шалгана /нотлох баримтын хүрээнд/.

5. Яллах ба өмгөөлөх талуудын хэргийн онолыг тодорхойлж, талуудын зүгээс гарган илэрхийлж мэтгэлцэх үндсэн хэв маяг, агуулга, үндэслэлийн гол чиглэл ба байр суурийг тодорхой болгож тогтооно.

6. Эрүүгийн хэргийн бодит үйлдэгдсэн нөхцөл байдлын агуулгад яв цав нийцэн тохирох хуулийг нэг мөр, зөв хэрэглэх онолын ба практикийн үндэслэлийг суурь болон хавсарга судалгаанд тулгуурлаж, харьцуулан шинжилнэ.

⁹⁹ Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973., 306 дахь тал.

7. Тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэгдэх хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тухайн харилцаанд хамаарах хуулийн зүйл, заалтыг оновчтой сонгон авах буюу хэргийн зүйлчлэлийг хийнэ.

8. Сонгон авсан буюу зүйлчлэл хийсэн хуулийн зүйл, заалтад тусгалаа олсон эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээг тайлбарлана.

9. Онол, практик, хууль зүйн хамгийн зохистой гэж үзсэн хувилбарт үнэлгээгээ тухайн эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт гэж сонгон авч, хууль зүйн томъёолол ба хэлбэрт оруулж гаргана.

Жишээ нь: “М”-д холбогдох хүнийг алах гэмт хэргийн хувьд “А”хувилбар нь “гэм буруугаа хүлээх”, “Б” хувилбар нь “гэм буруу дээрээ маргах” “В” хувилбар нь “хэрэг мөрдөх ажиллагаанд буцаах” гэсэн үндсэн 3 хувилбарыг хэргийг шүүхэд шилжсэн үед өмгөөлөгч боловсруулан гаргаж болох юм.

Дүгнэлт, санал

Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлтийг онол ба практикийн үндэслэл бүхий хийх явдал нь гагцхүү судалгааны ажлын сэдэв бус энэ нь практикт хууль ёсны зарчим хэрэгжих, шударга ёс тогтох, хүний эрхийн хамгаалалт болох хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэгэн салшгүй хэсэг мөн.

Хуульч бүр Эрүүгийн хэрэн хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл ба журмын дагуу хууль зүйн дүгнэлтийг бичгээр гаргаж хэвших нь нэгдмэл практикийг тогтоож, хууль хэрэглээг бүрэн дүүрэн болгох ач холбогдолтой.

Хууль зүйн дүгнэлт нь хэргийн хувь заяаг шийдвэрлэх эцсийн алхам учраас хүний эрх, эрх чөлөөг үнэт зүйлд тооцох үндэслэлд хамаарч шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаа болно.

Ашигласан материал

- Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973.
- С.Нарангэрэл. Англи - Монгол - Орос хууль зүйн толь. УБ., 1994.
- В.Н.Махов, М.А.Пешков. Уголовные процесс США. М., 1998.
- Зууны алуурчин. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ., 2002., №01.
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. УБ., 2005.
- Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. II /Д-Л/. УБ., 2008.
- Ш.Л.Монтескье. Хуулийн амин сүнс /орч.Т.Төмөрхүлэг/. УБ., 2008.
- Г.Б.Батзориг, Ч.Н.Баясгалан. АНУ-ын эрүүгийн процесс. УБ., 2008.
- Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай /орч.Г.Эрдэнэбат/. УБ., 2009.
- С.Жанцан. МУ-ын Эрүүгийн эрх зүйн онол I. УБ., 2009.
- Үз. Volume 11., Number 1., Green Bag 2D.,
- <https://mojha.gov.mn/newmojha/?p=1300>.
- Б.Ганболд. Криминологи. УБ., 2013.
- Л.Галбаатар. Miranda v. Arizona /1963/. Шүүх эрх мэдэл. №1., 2015.
- Б.Ганболд. Эрүүгийн номлол /зураглалт толь/. УБ., 2016.
- Б.Ганболд. Хууль зүйн дүгнэлт. УБ., 2022.
- Б.Ганболд. МУ-ын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2024.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ХУУЛЬД ТОДОРХОЙ ЗААГААГҮЙ АГУУЛГА, НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, БОЛОМЖ, ЧИГ ХАНДЛАГА

METHODS AND APPROACHES FOR RESOLVING CONTENT AND CONDITIONS
NOT SPECIFIED IN THE CONSTITUTION AND LAW

Х.Одонтуяа

Шихихутуг Их сургуулийн

Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант

Товч агуулга: Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдал болох эрх зүйн тодорхойгүй байдал, хуулийн тодорхой бус байдлыг хууль тогтоомжийн орхигдол, хийдлээс ангид авч үзэн, шийдвэрлэж болох хэд хэдэн арга зам, боломж байдаг, мөн чиг хандлагыг нь тодруулах үүднээс харьцуулсан судалгааны үндсэн дээр практикт тулгуурлан авч үзэв. Тухайн эрх зүйн тодорхойгүй байдал өөрийн гэсэн үзэл баримтлал, хэлбэртэй, тодорхой байдлыг нь хэмжих хэмжигдэхүүнтэй мөн хууль эрх зүйд өөрийн гэсэн сайн, сөрөг талыг бий болгон оршин байдаг тухай эрдэмтэд санал бодлоо илэрхийлсээр ирсэн.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ч өөрийн гэсэн өвөрмөц онцлогтойгоор хөгжиж буй хэдий ч хууль тогтоомжийн тодорхой бус байдал хууль тогтоогчийн санаатай, тооцоолоогүй, санамсаргүй үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэн гардаг, тэдгээрийг эрх бүхий субъектүүд ямар арга, арга зүйг хэрэглэн шийдвэрлэдэг талаар авч үзэв.

Хууль дээдлэх ёс болон гагцхүү хуульд захирагдах зарчим хуулийн тодорхой бус байдал хэрхэн нөлөөлдөг мөн тодорхой бус байдал тодорхой бус нөхцөлд шийдвэрийн боломжит хувилбарыг таамаглах, эрсдэлийг тооцох, шийдвэр гаргахад хэцүү байдаг талаар мөн субъектийн хандлага, ур чадвар, итгэл үнэмшил хэрхэн чухал хэмжигдэхүүн болох, мөн энэхүү тодорхой бус байдал, нөхцөлийг даван туулах арга, замыг өөрийн орны хууль, эрх зүйн практикт тулгуурлан харьцуулан судалж өөрийн үзэл бодлоо судалгааныхаа хүрээнд бага ч гэсэн гаргаж ирсэн онцлогтой.

Abstract: There are several ways and possibilities to consider and resolve legal uncertainty, which is a content and situation that is not clearly specified in the Constitution and laws, and legal uncertainty, which is a situation that is not clearly specified in the Constitution and laws, and to clarify its trends, based on comparative research and practice. Scholars have expressed their opinions that legal uncertainty has its own concept, form, and a scale to measure its clarity, and that it exists in law, creating its own good and bad sides.

Although the legal system of Mongolia is also developing with its own unique characteristics, the uncertainty of legislation is manifested in the intentional, unplanned, and accidental actions and inactions of the legislator, and what methods and methodologies are used by authorized subjects to resolve them.

The rule of law and the principle of being subject only to the law are affected by legal uncertainty, and uncertainty makes it difficult to predict possible decision options, calculate risks, and make decisions in uncertain situations, and how the attitude, skills, and beliefs of the subject are important dimensions, and the ways and means of overcoming this uncertainty and conditions are compared based on the laws and legal practices of their own countries, and their own views have been expressed in their research, albeit a little.

Түлхүүр үгс: Эрх зүйн тодорхойгүй байдал, хуулийн тодорхой бус нөхцөл, хийдэл ба хуулийн цоорхой, хууль тогтоомжийн орхигдол, шаардлагатай ба зөв заалтыг дурдах, хоёрдмол байдал, тайлбарлах арга

Keywords: legal uncertainty, legal gap, legislative omission, Necessary and Proper Clause, ambiguity, interpretation method

Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлын тухай ойлголт, хэлбэр, үр дагавар

Үндсэн хууль ба хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлыг эрх зүйн тодорхойгүй байдал гэж тодорхойлдог. Яагаад Үндсэн хууль, бусад хуульд тодорхой бус заалтуудыг хууль тогтоогч ямар зорилгоор, байр сууриар эрх зүй хийдэл, алдаа, орхигдол, тодорхой бус байдал, хоёрдмол байдал гэсэн нэр томъёог ашиглан тэдгээрийг даван туулах арга замыг практикт бий болгодог нь эрх зүйн хөгжлийг урагш түлхдэг эсхүл хойш татдаг үр дагаврыг аль алиныг бий болгон оршсоор байдаг хэмээн эрдэмтэд байр сууриа илэрхийлсээр ирсэн.

Эрх зүйн тодорхойгүй байдал нэг талаар хууль дээдлэх ёсонд харшлах бөгөөд хуулийн зорилгодоо хүрэх хуулийн чадамжийг алдагдуулдаг гэж үздэг бол (Kerhuel and Raynouard)¹⁰⁰ зарим эрдэмтэд Үндсэн хууль бусад хуульд бүхий л агуулга багтах боломжгүй тэдгээрийг тухайн нөхцөл байдалд бүрэн эрх олгогдсон албан тушаалтан, шүүгч нар тодорхой бус байдлаас үүдэлтэй хуулийн хоёрдмол утгатай бичвэрийг чадварлагаар тайлбарлах үр чадвараар дамжуулан эрх зүйн хөгжилд шинэ зам мөрийг гаргаж ирдэг гэж үздэг.

Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны олон шинэ нэр томъёог судлагдахууны эргэлтэд оруулах, тэдгээрийн ялгаатай, төсөөтэй чиг үүрэг гүйцэтгэж буйг шинжлэн, уялдаатай холбоонд нь авч үзэх шаардлагатай болсон.

Үндсэн хуульд заагаагүй асуудал, нөхцөл байдал гэдгийг урьдчилан харж хэлэх боломж хомс юм. Яагаад гэвэл эрх зүйн тодорхойгүй байдлыг оновчтой тодорхойлоогүй мөн түүнийг хэмжих тодорхой хэмжүүр байхгүйгээс тэдгээрийг судалсан эмпирик дүн шинжилгээ хийсэн нь бага байдаг гэж 2017 онд дүгнэсэн байдагтай холбоотой. Харин Үндсэн хуулийн маргаан, мөн улс төрийн практик, шүүхийн шийдвэр тэр дундаа Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрээс Үндсэн хууль болон хуулийн тодорхой бус байдлыг олж харах боломжтой гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

Тиймээс эрх зүйн тодорхойгүй байдал, хуулийн тодорхой бус байдал нь ялгаатай эсэх, эрх зүйн зохицуулалтгүй үлдсэн нөхцөл байдал нь хуулийн цоорхой, эрх зүйн хийдэл, хууль тогтоомжийн орхигдсон байдал гэх мэт олон нэр

¹⁰⁰Kevin E.Davis. The concept of legal Uncertainty
file:///C:/Users/win10/Downloads/Conceptoflegaluncertainty_8232017002.pdf (Үзсэн. 2024.12.20-ний өдөр)

томьёоны утга агуулгын нийцэлд нь тайлбарлах агуулгыг уг өгүүллийн зорилго биш учраас товчхон авч үзэв.

Эрх зүйн хийдэл гэж эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдвал зохих нийгмийн зарим харилцааг зохицуулах хэм хэмжээ дутагдах тухай ойлголт юм. Эрх зүй, хууль хоёр ялгаатай гэсэн үзэл баримтлалын талаас авч үзэхэд хууль нь амьдралд хэрэгжүүлэх нэг хэлбэр учраас хууль тогтоомжоос эрх зүйн хийдлийг хайх хэрэгтэй.¹⁰¹ Эрх зүйн хийдлийн хүрээнд авч үзвэл энэхүү тодорхой бус байдал нь хийдэл бол биш гэж үзэж болно. Эрх зүйн хэм хэмжээ дутагдах ойлголтод хамаарахгүй эрх зүйн зохицуулалт нь байгаа атлаа бүрэн эрх олгогдсон эрх бүхий субъектийн дур зоргын сонголт руу хөтлөн тайлбарлаж болох хоёрдмол утгыг бий болгож байдаг.

Хууль тогтоомжийн орхигдсон байдал гэдэг нь заавал биелүүлэх хуулийн шаардлага (норматив үүрэг) байгаа хэдий ч хууль санаачлагч шаардлагатай зохицуулалтыг боловсруулаагүй эсвэл бүрэн бус, хангалтгүй зохицуулалтыг баталсан нөхцөл байдлыг (хууль тогтоогчийн зан үйл) хэлдэг.¹⁰²

“Тодорхойгүй байдал” гэдэг нь эргэлзээтэй, тодорхойгүй гэсэн үг, “Тодорхойгүй байдал” гэдэг үг нь илүү олон утгаар ойлгогдох чадвартай гэсэн үг.¹⁰³ Иймээс хуулийн хоёрдмол байдлыг бий болгоно. Тодорхойгүй байдал нь урьдчилан таамаглах боломжгүй зүйл юм.

Хоёрдмол утга хуулийн тодорхой бус байдлаас үүснэ. Хоёрдмол утгатай ойлголт нь өөрөө хоёрдмол байдлыг бий болгох бөгөөд Үндсэн хууль дээдлэх үндсэн зарчимтай зөрчилддөг.¹⁰⁴ Эдгээр нэр томьёо бүрийн утга учрыг мөн тэдгээрийн объектив, субъектив ангилалтад болгоомжтой хандан дүгнэлт хийх хэрэгтэй.

Эрх зүйн тодорхой бус байдлын объектив болон субъектив үзэл баримтлалын талаар авч үзэхгүйгээр уг ойлголтыг тодорхойлох боломжгүй юм. Өөрөөр хэлбэл объектив хэлбэр бол Х хууль нь тодорхойгүй байгааг харин субъектив хэлбэр нь хүмүүсийн тодорхой бусд хандах хандлага, итгэл үнэмшил бөгөөд эдгээр нь тодорхой бус байдлын хэлбэр мөн үзэл баримтлал болдог байна.

Объектив хүчин зүйл гэдэгт хууль дах бичвэрүүдийн тодорхой бус байдал өөр хэлбэл хуулийн тодорхой бус байдал, шийдвэр гаргагчийн нэгдмэл бус байдал, эрх зүйн тодорхойгүй байдлын үйл ажиллагаа, нөхцөл байдал зэрэг болно. Харин субъектив байдал бол тухайн тодорхой бус байдлын үйл ажиллагаанд оролцогч субъектийн хандлага, итгэл үнэмшлийн асуудал юм.

Эцэст нь хэлэхэд эдгээр объектив, субъектив хүчин зүйлүүдээс эрх зүйн тодорхой бус байдлын нийгэм, эдийн засгийн үр дүнг шууд тайлбарлахад ашиглагдах тодорхой хэмжигдэхүүнүүдийг гаргаж ирж болох юм гэсэн санааг дэвшүүлсэн байдаг байна.¹⁰⁵ Эдгээр хэмжигдэхүүнийг гаргаж ирээгүй байсан

¹⁰¹ Ч.Нямсүрэн. Эрх зүйн онол. УБ., 2009. 349 дэх тал.

¹⁰² Marian Grzybowski. Legislative Omission in practical Jurisprudence of Polish Constitutional Tribunal. https://www.confueconstco.org/reports/rep-xiv/report_Poland_en.pdf (Үзсэн. 2024.12.20-ний өдөр)

¹⁰³ Kevin E.Davis. The concept of legal Uncertainty. [Conceptoflegaluncertainty 8232017002.pdf](#) (Үзсэн. 2024.12.20-ний өдөр)

¹⁰⁴ [file:///C:/Users/hp/Downloads/SSRN-id2799840%20\(1\).pdf](file:///C:/Users/hp/Downloads/SSRN-id2799840%20(1).pdf)

¹⁰⁵ Д.Амато. АНУ-ын хууль эрх зүйн систем дэх тодорхойгүй байдлын шалтгаан үр дагаврыг судлахдаа “хуульчийн тодохойгүй байдал” ба “хуулийн санал зөрөлдөөн” хэмээх субъектив

учраас судалгааны ажил харьцангуй бага гэж үнэлэгдсэнээс хойш даруй 7 жил өнгөрчээ.

Тийм учраас эдгээр сэдвийг эмпирик дүн шинжилгээний түвшинд судлах шаардлагатай бол хангалттай материал бий болсон байгаа гэдэгт итгэлтэй байна.

Эрх зүйн тодорхойгүй байдал нь үнэ цэнэ, үр дүнтэй байдаг мөн сул тал байдаг гэдгийг аль алиныг нь бүдгэрүүлэхгүйгээр судлах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Тухайлбал, эрх зүйн тодорхойгүй байдал нь оролцогчдоо хууль зүйн үр дагаврыг мэдэгдэхгүй болгож, хууль дээдлэх ёсыг алдагдуулдаг том дутагдалтай мөн урьдчилан таамаглах боломжгүй байдлыг бий болгосноор эрсдэлийг тооцоолох боломжийг хязгаарласнаар урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нь сөрөг нөлөөлж, хэрэг шийдвэрлэгдэх процесст бас тодорхой бус байдлыг үүсгэж болно. Нөгөө талаас тайлбарлавал тодорхойгүй байдлын шалтгааныг судлах, шийдвэр гаргах боломжит зөв магадлалыг боловсруулан гаргана гэдэг хуульчаас олон талын чадварыг шаардах болно. Цаашилбал хууль хэрэглээний аналог буюу төсөөтэй хэрэглэх, тайлбарлах арга зүйгээр дамжуулан эрх зүйг хөгжүүлэх боломж гэж харж болох юм.

I. Монгол Улсын Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдал, тэдгээрийг шийдвэрлэсэн нь.

Монгол Улсын хувьд эрх зүйн тодорхой байдлын хуулийн тодорхой бус асуудал байдаг уу? байхгүй гэсэн асуултад хариу эрье.

1. Судлаач Б.Өнөрмаагийн “Хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсэж буй бэрхшээл”¹⁰⁶ нийтлэлд:

- ...хүнийг гэмт хэрэгт сэрдэж эхэлсэн үеэс, цаашилбал эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэхийн өмнө гэмт хэрэгт холбогдсон хүнээс ямар статусаар мэдүүлэг авах нь ойлгомжгүй байна.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдын эрх үүргийг хуульчилсан атлаа “сэжигтэн”-ий статус, эрх үүрийг тодорхойлоогүй нь Үндсэн хуульд харшилж байна. Гомдол мэдээллийг шалгах хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийг ямар статустай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь тодорхойгүй байна.

- Гэрчээс мэдүүлэг авах тухай зохицуулсан атлаа хохироосон талаар гомдол гаргасан хүн, хуулийн этгээдийг ямар статусаар мэдүүлэг авахыг тодорхойлоогүй тул практикт хохирсон тухай гомдол гаргасан хүн хуулийн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч байна.

- “Төрийн алба” “нийтийн алба” гэсэн 2 нэр томъёо зэрэгцэн оршиж байгаа бөгөөд “нийтийн алба” гэсэн нэр томъёог албан ёсоор тайлбарлаагүй, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуульд нийтийн алба гэж юу

хэмжигдхүүнийг авч үзсэн байдаг. Kevin E.Davis. The concept of legal Uncertainty file:///C:/Users/win10/Downloads/Conceptoflegaluncertainty_8232017002.pdf (Үзсэн. 2024.12.20-ний өдөр)

¹⁰⁶ Б.Өнөрмаагийн “Хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсч буй бэрхшээл” <https://www.mglbar.mn/a/2490> (Үзсэн. 2024.12.23-ний өдөр)

ойлгох талаар огт зохицуулаагүй бөгөөд "нийтийн алба" гэдэгт төрийн албыг бүхэлд нь хамруулан ойлгож иржээ гээд дараах санал дэвшүүлсэн байна.

1. Прокурорын даалгаврыг эс зөвшөөрч санал гаргах мөрдөгчийн эрхийг процессын хуульд тусгах;

2. ЭХХША-ны оролцогчдын статусыг тодорхой болгож зохицуулах;

3. ЭХХША-нд оролцогчдын эрхийг зохицуулсан хуулийн заалтыг боловсронгуй болгож оролцогчдын тэгш эрхийг хангах;

2. Судлаач А.Түвшинтөгс" Шүүх эрх зүйн хэм хэмжээ байхгүй эсхүл тодорхой бус үндэслэлээр хэргийг шийдвэрлэхээс татгалзаж болохгүй гэсэн зохицуулалтыг удирдлага болгон сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулсан шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ"¹⁰⁷ сэдэвт эрх зүйн шүүмждээ: ...Дээд шүүхийн үндэслэл нь хоёр шатны шүүх дээрх дүгнэлтийг хийхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 -д заасан "Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг байхгүй буюу байгаа нь тодорхой бус үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй" гэсэн журмыг зөрчсөн болохоос гадна материаллаг хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзжээ. Улсын Дээд Шүүх тогтоолынхоо хянавал хэсэгтээ:

- Сэтгэл санаад учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхыг заасан байх боловч ийм зохицуулалт байхгүй.

Иймээс шүүх Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулан гэж зааснаар гэм хорын ерөнхий зохицуулалтын агуулга, зарчмыг баримтлан шийдвэрлэх үүрэгтэй.

Эцэст нь шүүх хууль байхгүй эсхүл байгаа хууль нь тодорхой бус үндэслэлээр татгалзаж огт болохгүй учир нь тус үндэслэлээр маргааныг шийдвэрлэхээс татгалзах нь иргэний Үндсэн эрхийг зөрчих аюултай. Нөгөө талаас шүүхийн зорилгод нийцэхгүй. Тиймээс хууль тогтоогч энэхүү зохицуулалтыг иргэний процессын хуульд оруулсан. УДШ-ээс төсөөтэй хуулийг олж, хэрэглэж байгаа нь гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус гэм хорыг нөхөн гаргуулах зохицуулалт байхгүй болохыг хүлээн зөвшөөрсөн илэрхийлэл мөн хэмээн бичжээ.

Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж буй 2 гол процессын болон материаллаг хуульд дурдсан тодорхой заалтууд дахь хуулийн тодорхой бус байдлыг судлаач илрүүлэн гарч болох эрсдэл, тэдгээрийг шийдвэрлэх арга болох саналыг илэрхийлснээс харвал Монгол Улсын тодорхой хуулиудад хуулийн тодорхой бус байдал байгааг харуулж байна.

3. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан хуулийн тодорхой бус байдлаас үүдэн 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль тодорхой бус нөхцөлд явагдсан тухайд: Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2021 оны

¹⁰⁷ А.Түвшинтөгс" Шүүх эрх зүйн хэм хэмжээ байхгүй эсхүл тодорхой бус үндэслэлээр хэргийг шийдвэрлэхээс татгалзаж болохгүй гэсэн зохицуулалтыг удирдлага болгон сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулсан шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ" <https://legaldata.mn/index.php/b/2066> (Үзсэн. 2024.12.20-ний өдөр)

дөрөвдүгээр сарын 16-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн гуравдугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг¹⁰⁸ хянан хэлэлцээд Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзсэн. Ингэснээр ерөнхийлөгч Х.Баттулга дахин нэр дэвших эрхгүй болсон.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц наймдугаар сарын 15-нд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж байна гэж үзсэн тул уг заалтыг хүчингүй болгох шийдвэр гаргасан юм. Үр дүнд нь "давхар дээл"-тай нэг их олон гишүүнтэй болсон.

Монгол Улсын хувьд хуулийн тодорхой бус байдалд дараах байр суурийг баримталдаг нь харагдана. "Эрх зүйн эх сурвалжийг маргааныг хянан шийдвэрлэхдээ ашиглах арга зүйн хүрээнд ч тухайлсан зохицуулсан хуулийн тусгай зүйл заалтаас эхлээд хуулийн зорилго, зарчим руу чиглэх буюу тусгайгаас ерөнхий анги руу гэсэн бүтцийг ашигладаг бол тухайлсан хууль байхгүй тохиолдолд хууль дээдлэх зарчмаар Үндсэн хуулиас зохицуулалтыг хайх нөхцөл бүрддэг. Мөн хууль дээдлэх ёсыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгож Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан тул төрийн албан хаагчид, улс төрчид Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалаар амьсгалах зайлшгүй үүрэгтэй юм."¹⁰⁹ Тиймээс ч Үндсэн хуулийн цэцийн ихэнх шийдвэр нь Үндсэн хуулийн дээрх заалтыг удирдлага болгон тодорхой асуудлыг шийдвэрлэсэн байдаг.

Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх үүрэгтэй шүүх нь Үндсэн хуулийн шаардлагатай гэж үзсэн онол, үзэл баримтлалын үнэт зүйлд тулгуурлан тайлбар хийн шийдвэрлэх гарц байдаг. Тухайлбал, Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Монгол улсын иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх ¹¹⁰нар 2022 онд Үндсэн хуулийн цэцэд хүргүүлсэн мэдээллийг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийг дурдаж болно.

Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй асуудал, нөхцөл байдлыг урьдчилан харж, шалгуур тогтоон хянах, илрүүлэх боломж хомс юм. Харин ялангуяа Үндсэн хуулийг зөрчсөн гэх маргаан гарах тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн тухайн асуудал, нөхцөл байдлыг тодруулах үүднээс хийх тайлбарт тулгуурлан тухайн тодорхойгүй байдлыг тодруулах, тухайн маргаж буй заалтыг өргөтгөн тайлбарлан зөвтгөх, эсэргүүцэхэд ашиглаж буй хууль хэрэглэгчийн ур чадвар шаардсан хуульд хандах зарчим, арга, хэлбэр, арга барил эв дүйд тулгуурлан Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан хуулийг бодитой үнэлж, зөв тайлж, онож хэрэглэх үзэл, онол, мэдрэмжээс хамаарна.

¹⁰⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн гуравдугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207135094741>

¹⁰⁹ Б.Чимид "Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс". УБ., 2006. 60 дахь тал.

¹¹⁰ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАРИМ ЗААЛТ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941>

Дүгнэвэл, хуулийн тодорхой бус зохицуулалтаас үүдэн тодорхой бус нөхцөл байдал үүсдэг бөгөөд тэдгээрийг шүүх хянан шийдвэрлээд ямар үр дүн бий гарахыг урьдчилан таамаглах нь бас тодорхой бус байдаг талаар урьд дурдсан. Энэхүү Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн үр дүнд зарим судлаачийн хувьд таамаглаагүй, сөрөг үр дагавартай үр дүнд хүрснийг улс төрд өрнөж буй практикаас харж болох олон жишээтэй болсон билээ.

Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг авч хэлэлцэх эрхгүй гэсэн маргааны тухайд хуульд тодорхой асуудлыг заагаагүйгээс үүссэн маргааны нэг гэж өмнө нь дурдсанаа тодруулъя. Энэхүү маргааныг тайлсан Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн үндэслэл нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, бүтцийн онолын хүрээнд мөн Үндсэн хуулийн “Оршил”-ын үнэт зүйлийг удирдлага болгон шийдвэрлэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргаан 2019 оны Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Монгол Улсын иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нар 2022 онд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргажээ.¹¹¹ Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой асуудлаар Үндсэн хуулийн цэц хэргийг хянан шийдвэрлэх бүрэн эрх байхгүй буюу энэ нь тухайлсан хуулиар зохицуулагдаагүй байсан юм. Гэвч энэ тохиолдлыг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн үзэл баримтлал, бүтэц, суурь зарчимд үндэслэж хэргийн харьяаллыг тогтоож, шийдвэрлэсэн байна.

Энэ тохиолдолд цэцэд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэх эсэх талаар тухайлсан хуулийн зохицуулалт байгаагүй бөгөөд өмнө нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэхгүй гэж шийдвэрлэсэн байдаг. Харин уг тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 3/06, 2015 оны 17 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгох талаар мөн дурджээ. Энэхүү шийдвэрийн эцэст Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хянан шийдвэрлэх эрхгүй болгон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.2.1 дэх хэсэгт тус тус тусгасан.¹¹² Энэ нь тэр чигтээ Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцсэн буюу төрийн байгуулал, байгууллагуудын тогтолцоо, түүнд тавигдах хяналтын тогтолцоо алдагдаж, УИХ хууль тогтоох бүрэн эрхийн хүрээнд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж түүнийг нь цэцээр ч хянан шийдвэрлүүлэхгүй байхаар зохицуулсан нь тэр чигтээ Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь бүтцийг хөндсөн байна гэж үзэхээр байна. Мөн Үндсэн хуулийн зарчим буюу нийтлэг зарчим болох Үндсэн хуулийн ерөнхий шинж, мөн чанарыг тодорхойлж байгаа Үндсэн хуулийг дээдлэх, түүнд захирагдах үзэл болон төрийн үйл ажиллагааны зарчимд үл нийцсэн байна. Үндсэн хуулийн үндсэн бүтэц гэдэг

¹¹¹ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941>

¹¹² Заалтын өмнөх агуулга:

“1/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр,” гэж байсан бол нэмэлт, өөрчлөлтөөр:

1/Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр; болсон байна.

нь үндсэндээ Үндсэн хуулийн зарчим мөн.¹¹³ Эрдэмтэд Үндсэн хуульд нийцээгүй нэмэлт өөрчлөлтийн асуудлыг 20-р зууны дунд үеэс хөгжүүлж, нэрт хуульч Намбиар М.К. Энэтхэгийн Голакнаттай¹¹⁴ холбоотой хэргийг шийдвэрлэх явцад Профессор Дитрих Конрадын “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийн далд хязгаарлалт”¹¹⁵ сэдвээр лекц уншсаны дараа тэрээр үндсэн бүтцийн талаарх үзэл баримтлалыг тодорхойлсон гэж үздэг. Энэ үзэл баримтлалыг Энэтхэгийн дээд шүүхийн шүүгч Мудолкар Ж.Р Энэтхэгийн хуулийн системд шуугиан тарьсан Сажан Сингхийн хэргийг шийдвэрлэхдээ хүлээн зөвшөөрсөн юм.¹¹⁶ Энэхүү аргыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээр дурдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуульд үл нийцсэн эсэх маргааныг цэцийн харьяалан хянан шийдвэрлэх маргаан мөн гэдгээ бүтцийн онолд үндэслэн тайлбарлан хэрэглэсэн байдаг.

Эдгээр Үндсэн хууль, хуульд тодорхой заагаагүй асуудал, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга замын зарим нь хууль дээдлэх зарчимтай харшилдаг гэж өмнө нь дурдсан. Хууль дээдлэх зарчмын суурь нь Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс гэж болно. Энэ бол ямар нэгэн мухар сүсгийн тухай таамаглаж байгаа хэрэг огтхон ч биш билээ. Харин оршин буй улс нийгэмд бодитойгоор үйлчилж буй эрхэм дээд үзэл санаа, зарчмын тухай асуудал юм.¹¹⁷ Үндсэн хууль бол Монгол Улсын тулгуур хууль болохын хувьд төрийн бусад хууль, эрх зүйн аливаа баримт бичгийн эх сурвалж болдог үндэсний төр ёсны тунгаамал үнэт хэсэг, төрийн тухай тогтолцоо байхын нэгэн гол субьектив нөхцөл юм.¹¹⁸ Иймээс аливаа асуудалд хандахдаа пропорциональ байдлын зарчмыг баримтлах нь зүйтэй юм.

Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй асуудлыг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэн хянан шийдвэрлэснээр, зохицуулалтгүй байсан эрх зүйн орчныг илрүүлэн цаашдын тусгайлсан хуулийн зохицуулалтыг бий болгоход чухал ач холбогдолтой байна. Зайлшгүй өөрчлөхөд хүрэхийн наана тулгамдсан элдэв бичил асуудлыг зөв зохицуулах олон арга бий. Тэр бүхнийг эзэмшиж, оновчтой хэрэглүүштэй байдаг. Түүний нэг нь үндсэн хуульчилсан бусад хууль ба ердийн хууль гаргаж зохицуулах арга юм.¹¹⁹ Ийнхүү эрх зүйн зохицуулалтын аргыг бэхжүүлэх боломжтой бөгөөд энэ нь өөрөө Үндсэн хуулийн шүүх болох цэцээр хянан шийдвэрлэгдэх ба Үндсэн хуульд үл харшилдах, хууль дээдлэх ёс болон Үндсэн хуулийн тулгуур үзэл баримтлал, зарчмыг үл зөрчсөн зохицуулах механизм бүрэлдэн тогтох үндэс болж байгаа юм.

Үндсэн хуулийн цэц тухайлсан зохицуулалтгүй ийм тохиолдол үүсэхэд Үндсэн хуулийн бүтцийн¹²⁰ аргын дагуу тайлбарлан шийдвэрлэх боломжтой. Үндсэн бүтцийн тухай ойлголтын хүрээ нь маш тодорхой бөгөөд Үндсэн хуулийн аливаа өөрчлөлтөөр зөрчигдөж болохгүй заалтуудыг багтаасан байдаг.

¹¹³ МУИХ УИХТГ. “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол-практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018. Ж.Амарсанаа, Л.Төр-Од “Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал” илтгэлээс. 57 дахь тал.

¹¹⁴ Yaniv Roznai. Unconstitutional Constitutional Amendments. 2014. London. p.55

¹¹⁵ Constitutional amendment rules: a comparative perspective, 2011, <http://www.law.uchicago.edu/a>

¹¹⁶ Odbayar D, Chief justice of the Constitutional Court of Mongolia. Basic structure of the Constitution of Mongolia. “Conception on basic structure and the theoretical aspect” https://www.conscourt.gov.mn/?page_id=3241&lang=en#_ftn2

¹¹⁷ Б.Чимид “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс”. УБ., 2006. 127 дахь тал.

¹¹⁸ П.Очирбат. “Алдаж болохгүй агшин”. УБ., 1997. 363 дахь тал.

¹¹⁹ Б.Чимид. “Үндсэн хуулийн мэдлэг”. УБ., 2008. 420 дахь тал.

¹²⁰ “Structuralism” гэсэн нэр томъёо ба Үндсэн хуулийг ерөнхий бүтэц, загварт үндэслэн тайлбарлах явдал юм.

Улс төрийн практикт өрнөсөн нэгэн үйл явдал нь Үндсэн хуульд заасан асуудлыг өөрөөр хэлбэл шийдвэрлэх асуудал нь хэрхэн УИХ-д шийдвэрлэх дэгийн зохицуулалт байхгүй байхад шийдвэрлэсэн. Тухайлбал, Монголд анх удаа Ерөнхий сайд өөрийн хүсэлтээр огцрох хүсэлтээ гаргасан. Анх удаа ийм саналыг хэлэлцэж байгаа учир хэлэлцэх дэг, зохицуулалт байхгүй байв. Тиймээс УИХ-ын дэгийн тухай хуулийн 5.1-д зааснаар уг асуудлыг хэлэлцэх горимын санал гаргаж байжээ.¹²¹ Уг асуудлыг шийдэх УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд тусгайлан зохицуулсан зохицуулалт, нөхцөл байдлыг шийдэх эрх зүйн зохицуулалт байгаагүй үед олонхын саналаар асуудлыг шийдсэн байдаг. Энэ нь тухайн хуульд тодорхой заагаагүй асуудлыг тогтсон жишгээр шийдэх, мөн цаашид тухайн асуудлыг шийдэх эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг шаарддаг байна.

III. Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам, Харьцуулсан судалгаа

Үндсэн хуульд болон хуульд тодорхой заагаагүй асуудал, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам, боломж:

Хууль тогтоогч тухайн асуудал, нөхцөл байдлыг нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;

Тухайлбал, өмнө дурдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргаан 2019 оны Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Монгол улсын иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нар 2022 онд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргажээ.¹²² Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой асуудлаар Үндсэн хуулийн цэц хэргийг хянан шийдвэрлэх бүрэн эрх байхгүй буюу энэ нь тухайлсан хуулиар зохицуулагдаагүй байсан юм. Гэвч энэ тохиолдлыг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн үзэл баримтлал, бүтэц, суурь зарчимд үндэслэж хэргийн харьяаллыг тогтоож, шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэрийн дараа 2022 оны 8 дугаар сарын 24 -ний өдрийн хуулиар Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд дараах нэмэлтийг оруулсан. Үүнд, ҮХЦМХША -ны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр” нь маргааны харьяалалд нэмсэн.

- Эрдэмтэд, судлаачид олон ургалч үзлээр уг асуудал, нөхцөл байдлыг хуульд зааснаас өргөтгөн тайлбарлах замаар шийдвэрлэх;

Хүний эрхийг ханган, хамгаалах зорилгын хооронд тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд Үндсэн хууль болон хуульд заасан тодорхой бус заалтын агуулгыг өргөтгөн тайлбарлах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ.

- Үндсэн хуулийн маргаанд талуудын тайлбарт олон улсын гэрээ, конвенцын нэр томъёог, бусад улсын эрх зүйн зохицуулалт зэргийг дурдан шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхэд ашиглах болсон. Тухайлбал, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон

¹²¹ “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай”. 2021-01-21 өдрийн хуралдааны тойм. <https://www.parliament.mn/nn/13707/>

¹²² Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941>

эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.¹²³

Үүнээс гадна банк, санхүү, татвартай холбоотой хүний эрхийн заалтуудыг олон улсын баримт бичиг болон гэрээ, конвенцын заалтуудыг удиртгал болгон сүүлийн үеийн эрх зүйн чиг хандлагаар өргөтгөн тайлбарласан шийдвэр олон байдаг.

- Улс төрийн практикт өрнөх үйл явдлыг шийдэх арга замыг жишиг болгох замаар шийдэх;

Ерөнхийлөгч Х.Баттулгын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших эсэх улс төрийн маргааны сэдвийн хүрээнд эрх баригч нам, олонх хүч түрэн шийдвэрлэх хүрээн дунд шүүх шийдвэрээ гаргасан хэдий ч зарим судлаачид Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрт сэтгэл дундуур үлдсэн тайлбарыг зарим талаар зөвтгөн хардаг тал бий гэдгийг судлаачийн зүгээс боддог.

- Үндсэн хуулийн шүүх тухайн асуудлыг шаардлагатай ба зөв заалтыг дурдан¹²⁴ зарим хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэхийг зөвтгөх, эсэргүүцэх зорилгоор хууль эрх зүйн үндэслэл болгон ашиглах. Өөрөөр хэлбэл, зайлшгүй шаардлагатай ба зөв заалттай холбоотой хууль эрх зүйн үйл ажиллагаа нь ихэвчлэн Үндсэн хуулийн сорилтуудын эргэн тойронд эргэлддэг бөгөөд талууд уг заалтын үндсэн дээр тодорхой хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хамгаалж эсвэл эсэргүүцдэг.

Тухайлбал, МакКаллоч Мэрилэндийн эсрэг (*McCulloch v. Maryland*) 1819 оны хэрэг дээр Ерөнхий шүүгч Маршаллын (Marshall) сонгодог үзэл санаа нь өнөөг хүртэл цуурайтаж буй үгсийн жишгийг тогтоожээ. "Төгсгөл нь хууль ёсны байх болтугай" гэж тэр бичээд "Үндсэн хууль, түүнд тохирсон хориглоогүй, хууль ёсны үзэл баримтлалд нийцсэн бүх арга хэрэгсэл нь хууль ёсны байх болтугай" гэж бичжээ.¹²⁵ Шүүхээс шаардлагатай ба зөв заалтыг тайлбарласны үр дүнд энэ шийдвэр¹²⁶ Америкийн үндсэн хуулийн түүхэнд хамгийн нөлөө үзүүлсэн шийдвэрүүдийн нэг хэвээр байна.

Үндсэн хууль болон хуульд тодорхой заагаагүй асуудал, нөхцөл байдлыг шийдвэрлэсэн зарим улсуудын жишээг дурдвал.

№	Улс	Үндсэн хуулийн шүүхэд хэрэглэгддэг тайлбарын аргын төрөл	Үндсэн хуульд болон хууль тодорхой заагаагүй асуудал, нөхцөл байдлыг шийдвэрлэсэн кэйс, тохиолдол
---	-----	--	---

¹²³ https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123489875221&fbclid=IwAR3WGxHbTIVP2iTKpcr63tndUkxSOO9WA5wjxUtyanmhBuQMzEEcx0T0c_E

¹²⁴ Necessary and Proper Clause. <https://law.justia.com/constitution/us/article-1/60-necessary-and-proper-clause.html>

¹²⁵ Necessary and Proper Clause. <https://law.justia.com/constitution/us/article-1/60-necessary-and-proper-clause.html>

¹²⁶ U.S. Government, U.S. Judicial Branch, U.S. Supreme Court Cases. *McCulloch v Maryland* (1819). https://academy4sc.org/video/mcculloch-v-maryland-1819/?utm_campaign=&utm_medium=ppc&utm_source=adwords&utm_term=mcculloch%20v%20maryland&hsa_tgt=kwd-295971719896&hsa_mt=b&hsa_acc=2755491261&hsa_grp=137195960045&hsa_ver=3&hsa_src=q&hsa_cam=17727349663&hsa_net=adwords&hsa_kw=mcculloch%20v%20maryland&hsa_ad=609888621105&gclid=EAlaIqObChMI7snA_ty7qwMVu1cPAh34zAyQEAAAYASAAEgLSf_D_BwE

1	Америкийн Нэгдсэн Улс. (АНУ)	- <i>Оригинал буюу эх тайлбар</i> - <i>Түүхчилсэн тайлбар</i> - Текстиализм - Амьд үндсэн хуульч үзэл - Үндэсний онцлог - Ёс суртахууны тайлбар - Прагматизм - Амьд Үндсэн хууль	(<i>McCulloch v. Maryland</i>) 1819. Конгресс өөр үндэсний банк байгуулахаар шийдсэн бөгөөд Мэдисон үүнийг зөвшөөрч, 1816 онд АНУ-ын Хоёр дахь банкныг байгуулжээ. Хоёр жилийн дараа Мэрилэнд муж Мэрилэндэд бүртгэлгүй аливаа банк, тэр дундаа АНУ-ын Хоёрдугаар банкнаас татвар авахаар шийджээ. Үндэсний банкны Балтимор дахь салбарын кассчин Жеймс МакКаллох муж улсын татвараас татгалзжээ. Хариуд нь Мэрилэнд нэхэмжлэл гаргасан. Энэхүү маргааныг Үндсэн хуульд тодорхой заагаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн шаардлагатай ба зөв заалтыг дурдан шийдвэрлэсэн байдаг. /Article I, Section 8 of the Constitution/
2.	Австрали Улс.	-Үгчилсэн тайлбар - Хуулийн Зорилго буюу телологийн тайлбар - Нөхцөл байдлын тайлбар -Түүхчилсэн тайлбар - Бүтцийн тайлбар - Шаардлагатай ба зөв заалт / далд эрхийг хүлээн зөвшөөрөх/ -Олон Улсын эрх зүй ба гэрээнүүд - Нийтлэг хуулийн зарчим -Амьд Үндсэн хууль	New South Wales v Commonwealth (The Payroll Tax Case). Шинэ Өмнөд Уэльс Хамтын нөхөрлөлийн эсрэг (Цалингийн татварын хэрэг) Австралийн Дээд шүүх Австралийн Үндсэн хуулийн "худалдаа, худалдааны" эрх мэдлийг тайлбарлахтай холбоотой хэргүүдийг хянан шийдвэрлэсэн (51-р хэсэг, I хэсэг). Шүүх нь худалдаа, арилжаатай холбоотой холбооны хуулийг дагаж мөрдөхийн тулд шаардлагатай ба зөв заалттай төстэй өргөн тайлбарыг ашигласан.
3.	<i>Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.</i> (ХБНГУ)	- Текстиийн тайлбар - Түүхчилсэн тайлбар - Системчилсэн тайлбар - Телеологийн тайлбар - Норматив тайлбар - Европын болон Олон Улсын эрх зүй. - Амьд Үндсэн хууль - Эрхийн Тэнцвэрт байдал -	Germany - BVerfGE 55, 274 (Lisbon Treaty Case) (Лиссабоны гэрээний хэрэг) ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх нь Германы Үндсэн хуулийг (Grundgesetz) тайлбарлахтай холбоотой хэргүүдийг авч үзсэн. Европын интеграцлал, гэрээ хэлэлцээртэй холбоотой хэргүүдэд шүүх Үндсэн хуулийн заалтуудыг тайлбарлахдаа системтэй, зорилготой хандаж шийдвэрлэжээ. Холбогдох заалтуудад олон улсын харилцааны асуудлаар Холбооны Засгийн газарт эрх олгосон 24 дүгээр зүйл, Үндсэн хуулийн өөрчлөлтөд дасан зохицох уян хатан байдлыг тогтоосон 79 дүгээр

			зүйлийн 3-т үндэслэж шийдвэрлэв. Эдгээр тохиолдол бүрт шүүхүүд тулгамдаж буй эрх зүйн асуудлыг шийдвэрлэхийн тулд үндсэн хуулийн тодорхой заалт, зарчмуудыг тайлбарласан. Эдгээр заалтууд нь ихэвчлэн Холбооны Засгийн газарт эрх мэдлийг олгодог эсвэл Засгийн газрын янз бүрийн түвшний эрх мэдлийн хуваарилалтыг зохицуулдаг. Шүүхүүд тайлбар хийхдээ тухайн Үндсэн хуулийн эх бичвэр, түүхэн нөхцөл байдал, Үндсэн хуулийн зарчмыг удирдлага болгон хуулийн уялдаа холбоотой, зорилготой ойлголтыг хангасан.
4.	Канад Улс.	- Амьд модны арга - Нөхцөл байдлын тайлбар	(Canada - Reference Re Anti-Inflation Act) Инфляцийн эсрэг хууль. Энэ тохиолдолд Канадын Дээд шүүх инфляцийн эсрэг хуулийн Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг авч үзсэн. Шүүх Канадын Үндсэн хуулийн "Энх тайван, дэг журам, сайн засаглал" (POGG) ¹²⁷ заалтын дагуу эдийн засгийг зохицуулах холбооны Засгийн газрын эрх мэдлийг тайлбарлахын тулд өргөн бөгөөд зорилготой хандлагыг ашигласан. 1967 оны Үндсэн хуулийн 91-р хэсэгт "Энхтайван, дэг журам, сайн засаглал" (POGG) заалт байдаг бөгөөд энэ нь Үндсэн хуулийн үндсэн зарчим юм. АНУ-ын Үндсэн хуулийн шаардлагатай ба зөв заалттай төстэй.
5.	Энэтхэг Улс.	- Суурь бүтцийн онол - Олон Улсын гэрээ, конвенц - Үндсэн хуулийн Оршилд тулгуурласан тайлбар	(India - Union of India v. H.S. Dhillon) Энэтхэгийн холбоо H.S. Диллоны хэрэг нь Энэтхэгийн Дээд шүүх Энэтхэгийн Үндсэн хуулийн Төв Засгийн газарт олгосон "үлдэгдэл эрх"-ийн (residuary powers) хамрах хүрээг авч үзсэн. Шүүх нь Үндсэн хуулийн заалтуудыг тайлбарлахдаа, тэр дундаа Үндсэн хуульд тодорхой заагаагүй Төв Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах заалтуудыг тайлбарлах зорилготой хандлагыг ашигласан.

Жич: Эдгээр үндсэн хуулийн тайлбарын төрөл нь эцсийн эцэст тухайлсан зохицуулалтгүй болон тодорхойгүй байдал, хоёрдмол байдал зэргийг даван туулах хамгийн чухал арга замуудаас тайлбарын арга учраас тайлбарын төрлийг харьцууллаа.

¹²⁷ "Peace, Order, and Good Government"

Энэ олон арга зүйг эрх зүйн тогтолцооны онцлог, эрх зүйн соёл, ухамсартаа нийцүүлэн нутагшуулахад анхаарах цаг болсон гэдгийг илтгэлээрээ дамжуулан илэрхийлэв.

Дүгнэлт, санал

Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан хуульд тодорхой заагаагүй агуулга, нөхцөл байдлыг шийдвэрлэх арга зам нь хуульд хандах зарчим, арга, хэлбэр, арга барил эв дүйд тулгуурлан Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан хуулийг бодитой үнэлж, зөв тайлж, онож хэрэглэх үзэл, онол, мэдрэмжид тулгуурлах буюу дэлхийн улс орнуудын эрх зүйн хийдэл, зохицуулалтгүй орчныг шийдвэрлэхэд практикт хэрэглэж буй арга барил, онол үзэл баримтлалыг шингээсэн Үндсэн хуулийн тайлбар, түүнд үндэслэдэг билээ. Ийнхүү эрх зүйн зохицуулалтын аргыг бэхжүүлэх боломжтой бөгөөд энэ нь өөрөө Үндсэн хуулийн шүүх болох Үндсэн хуулийн Цэцээр хянан шийдвэрлэгдэх ба Үндсэн хуульд үл харшилдах, хууль дээдлэх ёс болон Үндсэн хуулийн тулгуур үзэл баримтлал, зарчмыг үл зөрчсөн зохицуулах механизм бүрэлдэн тогтох үндэс болж байна. Гүнзгий ойлгож, учрыг зөв тайлж, шударгаар хэрэглэх явдал Үндсэн хуулийг тууштай баримтлах оюун санаа, сэтгэл зүйн гол үндэс мөн. Энэ бол хүн. Хуулийн хувь заяа хүнээс л шалтгаалдаг.¹²⁸

Дараах санал дэвшүүлж байна.

1. Үндсэн хуулийг Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж хэрэглэх үүднээс сүүлийн буюу XX зуунаас эхлэн яригдах болсон эрх зүйн тодорхойгүй байдал, хуулийн тодорхой бус байдал, хууль тогтоомжийн тодорхойгүй байдал, хоёрдмол байдал, Үндсэн хууль болон хуульд тусгагдаагүй асуудал, нөхцөл байдлыг зохицуулах үүднээс судлагдахууны эргэлтэд эдгээр нэр томьёог таниулан мэдүүлэх, хэрэглэх;

2. Үндсэн хуулийн цэц тухайн зохицуулалтгүй тохиолдлыг шийдвэрлэхэд Үндсэн хуулийн оршил хэсгийг идэвхтэй тайлбарлах арга зүйдээ ашиглах, мөн шаардлагатай ба зөв заалтыг дурдан хуульд заалтад буй далд санааг илэрхийлэх, өргөтгөн тайлбарлан тодорхойгүй байдал, хоёрдмол байдал, хуульд тусгагдаагүй асуудал, нөхцөл байдлыг шийдэх тайлбарын арга зүйг дэмжих;

3. Хууль тогтоогч тухайн асуудал, нөхцөл байдлыг нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхдээ тухайн агуулгыг хэвээр өөрчлөн баталдаг Германчуудын нэрлэсэн дахин жүжиглэхийг хориглох заалтыг Үндсэн хуульд нэмэх;

4. Эрдэмтэд, судлаачид олон ургалч үзлээр уг асуудал, нөхцөл байдлыг хуульд зааснаас өргөтгөн тайлбарлах замаар шийдвэрлэх;

5. Улс төрийн практикт өрнөх үйл явдлыг шийдэх арга замыг жишиг болгох замаар шийдэхдээ Үндсэн хуулийн болон тухайн хуульд тусгагдаагүй асуудлаа хуулиудын зорилгоор болон нийтлэг зарчимд тулгуурлах;

6. Үндсэн хуулийн шүүх тухайн асуудлыг шаардлагатай ба зөв заалтыг дурдан зарим хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэхийг зөвтгөх, эсэргүүцэх зорилгоор хууль эрх зүйн үндэслэл болгон ашиглах;

7. Үндсэн хуулийн хяналт нь хууль тогтоомжийг орхигдуулсан үзэгдлүүдийг (тохиолдлуудыг) хамрах ёстой гэсэн заалтыг зохих хуульд нэмэх;

¹²⁸ Б.Чимид. “Үндсэн хуулийн мэдлэг”. УБ., 2008. 420 дахь тал.

Тайлбар: Хууль тогтоох эс үйлдэхүй (түүний дотор хууль тогтоомжийн үл тоомсорлох) нэрийн дор илэрдэг. Үндсэн хуулийн хэрэгжилт (хэрэгжилт)-д тавих хяналтын үүднээс авч үзвэл дараах элементүүдийг тодорхойлж, зааж өгөх нь чухал юм: а) үндсэн хуулийн зайлшгүй буюу заавал биелүүлэх хэм хэмжээ, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох үр дагавар; б) тэдгээрийн үйл ажиллагааны зэрэг, хамрах хүрээг "үндсэн хуулийн дэд" хууль санаачлагчийн үнэлгээ; в) Үндсэн хуульд захирагдах хүчинтэй, үндсэн хуулийн шаардлага, үүргээ биелүүлээгүй зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлох.

Ашигласан материал

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль.
3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль.
4. Улсын хурлын чуулганы дэгийн тухай хууль.

Эрх зүйн акт:

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941>

Судалгааны тайлан, эмхэтгэл:

1. МУИХ УИХТГ. "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол-практикийн асуудлууд" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018.

Ном, сурах бичиг:

1. Б.Чимид "Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс". УБ., 2006.
2. Б.Чимид. "Үндсэн хуулийн мэдлэг". УБ., 2008.
3. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал (хоёр дахь хэвлэл). УБ., 2017.
4. П.Очирбат. "Алдаж болохгүй агшин". УБ., 1997.

Гадаад эх сурвалж:

1. Tom Ginsburg, Judicial Review in New Democracies: Constitutional Courts in Asian Cases, Cambridge University Press, 2003.
2. Kesavananda Bharati case. 1973.
3. Yaniv Roznai. Unconstitutional Constitutional Amendments. 2014. London.
4. Constitutional amendment rules: a comparative perspective, 2011, <http://www.law.uchicago.edu/a>
5. "Minister of Health and Another v Treatment Action Campaign and Others" 2002.
6. U.S. Government, U.S. Judicial Branch, U.S. Supreme Court Cases. McCulloch v Maryland (1819). https://academy4sc.org/video/mcculloch-v-maryland-1819/?utm_campaign=&utm_medium=ppc&utm_source=adwords&utm_term=mcculloch%20v%20maryland&hsa_tgt=kwd-295971719896&hsa_mt=b&hsa_acc=2755491261&hsa_grp=137195960045&hsa_ver=3&hsa_src=g&hsa_cam=17727349663&hsa_net=adwords&hsa_kw=mcculloch%20v%20maryland&hsa_ad=609888621105&qclid=EAlaIqObChMI7snA_ty7gwMVu1cPAh34zAyQEAAAYASAAEgLSf_D_BwE

Интернэт эх сурвалж:

1. Kevin E.Davis. The concept of legal Uncertainty file:///C:/Users/win10/Downloads/Conceptoflegaluncertainty_8232017002.pdf

2. Marian Grzybowski. Legislative Omission in practical Jurisprudence of Polish Constitutional Tribunal. [https://www.confeuconstco.org/reports/rep-xiv/report Poland en.pdf](https://www.confeuconstco.org/reports/rep-xiv/report%20Poland%20en.pdf)
3. Б.Өнөрмаагийн “Хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсэж буй бэрхшээл” <https://www.mglbar.mn/a/2490>
4. А.Түвшинтөгс” Шүүх эрх зүйн хэм хэмжээ байхгүй эсхүл тодорхой бус үндэслэлээр хэргийг шийдвэрлэхээс татгалзаж болохгүй гэсэн зохицуулалтыг удирдлага болгон сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулсан шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” <https://legaldata.mn/index.php/b/2066>
5. Б.Чимид. “Үндсэн хууль ба Үндсэн хуульчилсан хууль гэх асуудал” лекцийн тэмдэглэл. <https://legaldata.mn/news/207>
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн гуравдугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207135094741>
7. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ЗАРИМ ЗААЛТ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941>
8. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941>
9. Odbayar D, Chief justice of the Constitutional Court of Mongolia. Basic structure of the Constitution of Mongolia. “Conception on basic structure and the theoretical aspect” https://www.conscourt.gov.mn/?page_id=3241&lang=en#_ftn2
10. <https://law.justia.com/constitution/us/article-1/60-necessary-and-proper-clause.html> “Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай”. 2021-01-21 өдрийн хуралдааны тойм. <https://www.parliament.mn/nn/13707/>

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОХИРЛЫГ ИРГЭНИЙ ЖУРМААР НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ

COMPENSATION FOR PSYCHOLOGICAL DAMAGE CAUSED BY A CRIME THROUGH CIVIL PROCEDURE

Б.Оюун-Эрдэнэ
Судлаач

Товч агуулга: Хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд тэрнээс учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь хуулиар хамгаалагдсан буюу Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрх мөн. Харин Иргэний хуульд гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол, түүнийг хэрхэн үнэлэх тухай зохицуулаагүй тул сэтгэл санааны хохирлыг судлагдахуун болгож судлах, хууль зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий болж байна.

Abstract: The right to compensation for psychological damage caused by a crime in cases where legally protected rights and interests are violated is a fundamental right of a citizen protected by law or granted by the Constitution. However, since the Civil Code does not regulate specifically psychological damage caused by a crime so there are some necessary demands for 1 compensating the damage and 2 how to assess it, as a subject and improve its legal regulation.

Түлхүүр үг: Гэм хор, хохирол, эдийн бус баялаг, сэтгэц, эдийн бус хохирол

Keywords: Guilt, harm, non-economic wealth, psychological, non-economic harm

Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлүүдийн нэг бол гэм хор учруулахаар иргэний эрх зүйн харилцаа үүсэж болдог. Уг харилцаа нь гэрээний үүрэгтэй холбоогүйгээр бусдын хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол болон эд хөрөнгөд хууль бусаар хохирол учруулсан этгээд учруулсан гэм хороо хариуцан арилгадаг зохицуулалттай. Хуулиар хамгаалагдсан эрх ашигт эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд¹²⁹, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгийг хамруулан авч үзэх ба үүнд хэн ч бай хууль бусаар халдаж болохгүй зохицуулалт нь хууль болон эрх зүйн суурь зохицуулалт юм. Салбар эрх зүй болгоноор эдгээр эрх, ашиг сонирхлыг хамгаалж байдаг.

Иргэний эрх зүйд эд хөрөнгийн хохирлыг тухайн эд хөрөнгө хэрхэн гэмтэж, эвдэрсэн, хэр хохирол учирсныг мөнгөөр үнэлж, хохирлыг арилуулах боломж байдаг. Тухайн хөрөнгийг шинээр солих, өөр ижил төрлийн шинжтэй зүйлээр орлуулах гэх мэт. Харин эдийн бус баялаг буюу сэтгэл санаа, сэтгэцэд, нэр төр, тэр бүү хэл гэмт хэргийн улмаас амь насанд учирсан хохирлыг хэрхэн тооцож, түүний хэрхэн барагдуулах нь одоог хүртэл маргаантай, асуудалтай байгаа юм.

Сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой маргаан нь бусдын буруутай, хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас үүсдэг. Ялангуяа бусдын

¹²⁹ 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан.

эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас сэтгэл санааны хохирол дагалдан гарах нь элбэг тохиолддог. Харин бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас бусад байдлаар учирсан эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэж байгаа эсэхтэй холбоотой судалгаа, мэдээлэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргадаг шүүн таслах ажиллагааны аль ч оны тайланд тусгагдаагүй байна. Энэ нь Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хор гэж зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдлыг тооцохоор хязгаарлагдмал хүрээнд зохицуулсантай холбоотой¹³⁰ гэж үзэж байна.

Хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд тэрнээс учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь хуулиар хамгаалагдсан буюу Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрх¹³¹ мөн. Харин Иргэний хуульд сэтгэл санааны хохирол, түүнийг хэрхэн үнэлэх тухай зохицуулаагүй тул сэтгэл санааны хохирлыг судлагдахуун болгож судлах, хууль зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий болж байна.

1. Иргэний эрх зүйн гэм хорын тухай

Иргэний эрх зүй харилцаа нь иргэний хуульд заасан 8 үндэслэлээр үүсэх бөгөөд тэдний дийлэнх нь хэлцэл болон гэм хор учруулахаар үүсдэг. Иймээс гэм хор гэж юу болохыг тодорхойлох нь зүйтэй байх.

Үүрэг үүсэх үндэслэл нь гэрээний ба гэрээний бус гэж ангилдаг. Гэрээний бус үүрэг нь хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа ба зөрчлийн улмаас үүсэх үүргийн харилцаа гэж хуваагдах бөгөөд гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь зөрчлийн улмаас үүсэх үүрэгт хамаардаг. Энэ нь Иргэний хуулийн хоёрдугаар дэд хэсэг, тавин хоёрдугаар бүлэгт зохицуулсан. Амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг эдийн бус гэм хорын хохирол гэж үздэг бол материаллаг шинжтэй буюу эд хөрөнгийн бодит үнэ, алдагдал, олох ёстой байсан орлого нь эд хөрөнгөд учирсан гэм хорд тооцогддог¹³² байна.

Гэм хор¹³³ гэдгийг хууль зүйн үүднээс нь “хохирогчийн эд хөрөнгийн буюу материаллаг бус баялгийг¹³⁴ багасгах, устгах, хөндөх замаар илэрхийлэгдэх, материаллаг хохирол. Гэм хор ба хохирол гэсэн нэр томъёо нь өөр хоорондоо яг нийцдэггүй ба гэм хор нь нийлээд өргөн хүрээтэй ба эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг аль алиныг нь багтаадаг.¹³⁵ Зарим судлаачид гэм хор нь иргэний эрх зүйн хариуцлага үүсэх нэг нөхцөл. Гэм хор нь тухайн харилцаанд өртөгдөж буй субъектийн амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөн явдлаар илэрдэг материаллаг ба материаллаг бус гэм хор гэж ангилдаг¹³⁶. Материаллаг гэм хорд эд хөрөнгийг эвдэлсэн, сүйтгэсэн, хорогдуулсан гэх зэрэг орох бол материаллаг бус гэм хорд хүний амь насыг хохироосон, эрүүл мэндэд

¹³⁰ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 15 дах тал.

¹³¹ Монгол Улсын Үндсэн хууль., Арванзургадугаар зүйл.

¹³² Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV, УБ., 2016, 54 дэх тал.

¹³³ Англи хэлнээ “Harm”

¹³⁴ Амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг

¹³⁵ Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, С.Нарангэрэл, УБ., 2021, 88 дах тал.

¹³⁶ Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт нийтлэл, Ш.Үнэнтөгс, 2015.

халдсан, сэтгэцийн байдлыг хэвийн биш болгосон, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг орно гэж үздэг.

Иргэний хууль тогтоомжид эдийн бус хохирол хэмээх ойлголтын тухай томъёолоогүй харин эдийн бус гэм хор гэж томъёолсон байдаг. Харин хохирлын талаар тодорхойлон тусгасан боловч хор уршиг хэмээх ойлголт, нэр томъёог¹³⁷ тусгаагүй.

Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.3-т “Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно.” гэснээс үзвэл хохирол гэдэгт хохирогчоос зөрчигдсөн эрхээ сэргээхэд буюу эрх зөрчигдөхөөс өмнөх байдалд эргүүлж оруулахад шаардагдах зардал болон эрх зөрчсөний улмаас алдсан орлогыг буюу олох ёстой байсан орлогыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-д хохирол болон хор уршиг гэсэн хоёр ойлголтыг ялгаатайгаар тодорхойлсон. Эрүүгийн хуульд гэмт хэргийн улмаас шууд учирсан үр дагаврыг хохирол; гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршиг¹³⁸ гэж тодорхойлсон.

Зарим судлаачдын зүгээс Иргэний хуульд зохицуулсан сэтгэл санааны асуудлыг сэтгэл санааны гэм хор биш харин сэтгэл санааны хохирол гэж томъёолох нь үндэслэлтэй гэж үзсэн. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд “Эдийн бус гэм хорыг арилгах” гэсэн эдийн бус баялагтай холбоотой ерөнхий зохицуулалт боловч уг зохицуулалтын агуулга нь зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг зөрчсөний улмаас үүсэн харилцааг зохицуулах заалт учир үүнд сэтгэл санааны болон сэтгэцэд учирсан хохирлыг тооцож барагдуулах нь учир дутагдалтай юм.

Дээрх зохицуулалтаас үзвэл эдийн бус гэм хорын тухай хуульд ерөнхий зохицуулалт байгаа хэдий ч үндсэн агуулга, зарчим, үзэл санаа нь эдийн бус баялгийн хохирлыг¹³⁹ бүхэлд нь хамруулж чадахгүй байгаа нь зарим эдийн бус хохирлыг хариуцан арилгах хуулийн үндэслэл дутмаг байгаа юм. Мөн Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-т “эдийн бус гэм хорыг арилгуулахаас хохирогч шаардах эрхтэй” гэж тодорхойлсон ч эдийн бус гэм хорд юуг багтааж ойлгох талаар хуульд тусгайлан заагаагүй байна.

Эдийн бус хохирол тур дундаа бусдын хууль бус үйлдлийн улмаас бусдад учирсан сэтгэл санааны буюу сэтгэцэд учирсан хохирлыг зөв тодорхойлох хэрэгтэй. Сэтгэл санааны хямрал гэдэг нь бусдын хууль бус үйлдлийн үр дүнд үүсэх сэтгэл санааны, оюуны зовлон, шаналлыг хэлэх бөгөөд үүнд уй гашуу, сэтгэл гонсойх, уур уцаар төрөх, бахархал үгүй болох, ичих, олон нийтийн доромжлолд өртөх, цөхрөл зэрэг хамаарах ба дээрх хямрал нь сэтгэл санааны хохирол болно¹⁴⁰ гэж үздэг байна.

2. Эдийн бус хохирол /сэтгэц/-д учирсан хохирлын тухай

¹³⁷ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 19 дэх тал.

¹³⁸ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1, 2 дах хэсэг

¹³⁹ Материаллаг бус бүх хохирол. Тухайлбал, бие эрхтний болон сэтгэцийн хохирол, хэвийн амьдрах боломж, хүнд эмчилгээний зовлон шаналал гэх мэт.

¹⁴⁰ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 21 дэх тал.

Эдийн бус хохирол буюу сэтгэцэд болон сэтгэл санаанд учирсан хохирлыг тодорхойлохын өмнө сэтгэц мэдрэлийн өвчин, эмгэг гэдэг юу вэ гэдгийг томьёолох шаардлага тулгарч байна.

Аливаа гэмтлийг шинжлэх ухааны үүднээс бие махбодын болон сэтгэл санааны¹⁴¹ гэж хоёр ангилдаг байна. Бие махбодын гэмтэл нь олон төрлийн шалтгаантай үүсдэг ба ихэвчлэн өөрөөс шалтгаалсан болон өөрөөс шалтгаалахгүй буюу бусдын нөлөөгөөр мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчний нөлөөгөөр үүсдэг. Тухайлбал, авто осолд орох, хүн цохисны улмаас бие эрхтэн хугарах, бяцрах, тархи толгойндоо гэмтэл авах зэрэг. Харин сэтгэл санааны гэмтлийн хувьд сэтгэл санааны хүчтэй нөлөө үзүүлдэг өөрчлөлт нь хүний амьдралын дадал үйлдэл буюу ойр дотнын хэн нэгнээ алдах, ганцаараа үлдэх гэх мэт амьдралын өөрчлөлт нь тухайн хүндээ сэтгэл санааны гэмтэл болж байдаг.

Эрүүл мэнд гэж хүн зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, сэтгэц, оюун санаа, нийгмийн сайн сайхан¹⁴² байдлын цогц бүрдлийг хэлнэ. Эндээс харахад эрүүл мэндийг биеийн болон нийгмийн, сэтгэцийн эрүүл мэнд гэж гурван бүрэлдэхүүнд хуваан авч үзэж байна.¹⁴³ Сэтгэцийн эрүүл мэнд гэсэн ойлголтыг ихэнх хүмүүс сэтгэцийн өвчин эмгэгтэй холбон ойлгодог харин сэтгэцийн эрүүл мэнд гэдэг нь маш өргөн хүрээний ойлголт юм.¹⁴⁴ Тухайн хүний сэтгэл хөдлөл, оюун санаа, бие махбод, хувь хүний хувьд ямар нэг эмгэггүй байхыг хэлдэг. Гэтэл бусдын учруулсан эдийн болон эдийн бус хохирлын улмаас сэтгэл санааны хямралтай байгаа хүнийг эрүүл хүн гэж үзэх үү эсхүл түр зуурын стресс¹⁴⁵ гэж үзэх үү гэдгийг бид анзаарах шаардлага үүснэ. Тухайн хүн ямар гэмтэл авснаас шалтгаалан сэтгэл зүйн өөрчлөлт хэр хугацаанд үргэлжлэх нь тогтоогддог.

Сэтгэл санааны хямралд өртсөн этгээдэд сэтгэлийн хөдөлгөөн сөрөг хэлбэрээр илрэх ба гашуудах, нойргүйдэх, сэтгэлээр унах, сэтгэлийн шаналал, зовлонтой байх, цөхрөх, айх, ичих, уурлах, сэтгэлийн түгшүүртэй болох, санаж, мартаж зэрэг хэв шинжээр илэрнэ¹⁴⁶. Иймд сэтгэл санааны хохирол нь бие махбодод хохирол учрахтай адил сэтгэцийн гэмтэл үүсгэдэг бөгөөд бие махбодын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд 497.1-т “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж зохицуулсан ба үүнд тусгасан эрүүл мэнд гэсэн зохицуулалт нь хүний бие махбодод учирсан хохирол юм. Сэтгэцэд гэдэг нь сэтгэл санаанд учирсан хохирлыг шаардахаар зохицуулсан байна. Шүүх гэм хорын хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэд хэдэн урьдчилсан нөхцөлийг хангасан эсэхийг шалгах ба энэ нь онолын үүднээс гэм хорын үндсэн шинж юм. Үүнд: Гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь санаатай болон болгоомжгүй байдлаар илэрдэг. 2. Хамгаалагдсан эрхийн зөрчил буюу хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол, эд хөрөнгөд халдсан байх. 3. Эдгээрийн хоорондын шалтгаант холбоо байхыг шаарддаг.

¹⁴¹ Л.Жавхлан., “Сэтгэл санааны хохирлыг тооцож чаддаггүй” Нийтлэл., УБ, 2019.

¹⁴² Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт

¹⁴³ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 22 дэх тал.

¹⁴⁴ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 22 дэх тал.

¹⁴⁵ Гэнэтийн болон санамсаргүй, аливаа тааламжгүй явдлаас болж сэтгэл санаа, бие махбод доройтон хямрахыг ойлгоно.

¹⁴⁶ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 23 дэх тал.

Хүний эрүүл мэндэд учирсан хохирлыг тооцох аргачлал байдаг. Гэхдээ үүнийг хүний бие махбодын гэмтлээр хязгаарласан байдаг.¹⁴⁷ Үүний улмаас сэтгэл санааны хохирлыг хэрхэн шаардах буюу хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд¹⁴⁸ сүүлд нэмэлт өөрчлөлт оруулан зохицуулсан. Гэмт хэргийн үйлдэл болон хууль бус үйлдлийн улмаас хүний сэтгэл санаанд тодорхой хэмжээний цочрол, айдас түгшүүрт автаж, энэ нь аажмаар зан төлөвт сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайн гэмт хэргийн улмаас алдсан үнэт зүйлсийнхээ хэмжээгээр хүний сэтгэл зүй, сэтгэц нь гэмтдэг байна. Сэтгэл санаа буюу сэтгэцийн өөрчлөлт нь хүний амьдралын дадал үйлдэл буюу сэтгэлийн гэмтэл болон үлддэг байна. Сэтгэл санааны хямрал хохирогчид учирсан эсэхийг тогтооход нэлээд хүндрэлтэй байхаас гадна үүнийг сэтгэл зүйч, мэргэжлийн сэтгэцийн эмчийн тусламжтайгаар тогтоох нь ихээхэн үр дүнтэй юм.

Сэтгэц¹⁴⁹ гэдгийг хууль зүйн үүднээс нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “Сэтгэцийн эрүүл мэнд” гэж хүн сэтгэцийн эмгэггүй байхын зэрэгцээ нийгэм болон хүрээлэн байгаа гадаад орчинтойгоо дасан зохицож хэвийн амьдрах, ажиллах, суралцах, нийгэмд зохих байр сууриа эзлэн хувь нэмрээ оруулж чадахуйц байдлыг” гэж тодорхойлсон байна. Сэтгэцийг түр зуурын¹⁵⁰ болон эмгэг¹⁵¹ гэж хоёр ангилдаг.

Сэтгэл санааны буюу сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хангах нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаажуулах үзэл баримтлал, иргэний эрх зүйн хохирол арилгахаас өмнөх байдалд эрхийг сэргээх үндсэн зарчимд тус тус нийцнэ.¹⁵² Иргэний хуулийн 228-230, 497, 511 дүгээр зүйл заалт нь гэм хорын ерөнхий болон эдийн бус гэм хорын зохицуулалт бөгөөд хохирсон этгээд нь учирсан хохирлоо шаардах эрхтэй юм.

Хохирол нь тухайн зөрчигдсөн эрхийг зөрчигдөхөөс өмнөх байдалд оруулах, нөхөн сэргээх бөгөөд өмнөх байдалд сэргээх боломжгүй үед мөнгөөр тооцож барагдуулах юм. Юун түрүүнд хохирсон этгээдийн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчсөн байх шаардлагыг хангах ба шаардах эрх үүссэнээр хохирлыг арилгах тухай яригдах ба Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.” гэж зохицуулсан байна.

Харин Иргэний хуульд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт орсноор сэтгэцэд учирсан хор уршгийг шаардаж болохоор зохицуулсан. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана” гэсэн нь сэтгэл санаанд учирсан хохирлыг гагцхүү мөнгөөр тодорхойлох шаардлага үүсэж байгаа юм.

¹⁴⁷ П.Сайнзориг., Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй, Нийтлэл., УБ, 2021.

¹⁴⁸ Энэ нэмэлт өөрчлөлт нь 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих юм.

¹⁴⁹ Монгол хэлний тайлбарт: Сэтгэн бодох явц, сэтгэн бодох чадвар

¹⁵⁰ Нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг хэлнэ.

¹⁵¹ Өвчний олон улсын ангиллын "сэтгэц, зан үйлийн эмгэгүүд" бүлэгт заасан оношилгооны хэмжүүрээр оношилж болох бүх өвчнийг ойлгоно.

¹⁵² Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 30 дах тал.

Хүний сэтгэл санааны байдлыг мөнгөөр үнэлэх нь нэг талаас учир дутагдалтай юм. Бие махбодод учирсан хохирлыг мөнгөөр үнэлж болно. Тухайлбал, гар хугарсан гэж үзвэл гарыг эдгэрэх хугацаанд шаардагдах эмчилгээний зардал, түүнээс учирсан бусад зардлуудыг тодорхойлсноор хохирлыг тооцон шаардаж болно. Харин тухайн үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан хохирлыг хэрхэн тооцож мөнгөн дүнгээр шаардах нь бас эргэлзээтэй бөгөөд дээр дурдсанчлан мэргэжлийн сэтгэл зүйч болон эмч нарын дүгнэлтийг үндэслэх нь зүй ёсных байх. Мөн энэ асуудал дээр тухайн гэм буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас хохирогч нас барсан тохиолдолд гэм хор болон хохирлыг асуудлыг тодорхойлох нь нэлээдгүй хүнд. Хүний амь насыг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй. Гэхдээ нэгэнт гэм буруутай этгээд нь учруулсан хохирлыг арилгах үүрэгтэй бөгөөд энд оршуулгын зардал зэрэг шууд учирсан хохирлыг тооцон шаардана.

Мөн Иргэний хуульд орсон сүүлийн нэмэлт өөрчлөлтүүдийн агуулгыг харвал нийгмийн дундаж наслалтыг тогтоон нас барсан этгээдийн наслалтыг тогтоож, цаашид хэдэн жил амьдрах боломжтой, амьд байх хугацаандаа хэр хэмжээний бүтээмжтэй, хэдий хэмжээний орлого олох боломжтой байсан зэрэг өргөн хүрээний асуудлыг тогтоон хохирогч этгээд шаардаж болох зохицуулалтыг оруулсан.

Сэтгэцэд учирсан хохирлыг тооцон арилгахдаа хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр үнэлж болох монгол хүний дундаж наслалтаас хохирсон этгээдийн насны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлж, зөрүү үүссэн жилээр нь тооцож үнэлэх суурь үнэлгээг¹⁵³ гаргасан байна. Энэ бол суурь доод үнэлгээ бөгөөд шүүхээс жишиг тогтоох асуудал одоог хүртэл яригдаж байгаа юм. Мөн энэхүү зохицуулалт дээр тухайн гэмт хэргийн улмаас бүтэн өнчин болсон тохиолдолд суурь үнэлгээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцон гаргах юм.

Эдийн бус хохирол буюу сэтгэл санаа, сэтгэцэд учирсан хохирлыг тооцох суурь үнэлгээ буюу хамгийн доод үнийг тогтоох нь тухайн хохирлыг барагдуулах буюу шүүхээс тооцож гаргах боломж нээгдэж буй юм. Өмнө нь амь нас хохирсон хэргийн хохирол болон бусад эдийн бус баялгийг тооцон гаргах аргачлал байхгүйгээс энэ төрлийн маргаан шийдвэрлэгдэхгүй орхигддог байсан.

Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ний өдрийн 15 дугаар тогтоолд “Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол” гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд, Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйгээр учруулсан гэм хорыг ойлгоно”, түүнчлэн “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “...эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан ба “...хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовуурь шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй” гэж тайлбарласан байдаг ба шүүх өнөөдрийг хүртэл дээрх хууль хэрэглээний зөвлөмжийн дагуу хууль хэрэглэж¹⁵⁴ ирсэн.

¹⁵³П.Сайнзориг., Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй, Нийтлэл., УБ, 2021.

¹⁵⁴ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 39 дэх тал.

Сэтгэл санааны хямрал, түүнд учирсан хохирлыг тооцох аргачлалыг Хууль зүйн дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яамнаас баталж, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгээс сэтгэл зүйд учирч буй хямралын зэргийг тогтоож зөвхөн шүүх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлно.¹⁵⁵ Сэтгэл санаанд учирч буй хор уршгийг мөнгөөр үнэлж баршгүй. Гэхдээ энэ асуудлыг орхигдуулж болохгүй.

3. Зарим гадаад орны харьцуулалт

Эдийн бус гэм хор тэр дундаа сэтгэл санааны гэм хорыг асуудлыг харьцуулан судлан авч үзэхдээ ХБНГУ, Япон болон Европын зарим орныг харьцуулан судаллаа.

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ нь манай улстай ижил эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс бөгөөд манай улс анх Иргэний хуулийн үзэл баримтлалыг боловсруулахдаа ХБНГУ-ын Иргэний хуулийн үзэл баримтлалыг жишиг боолгон боловсруулсан байдаг. Үүнд эдийн бус гэм хорын асуудал ч хамаарах юм. Тус улс нь Иргэний кодексдоо нэлээдгүй нэмэлт өөрчлөлт оруулсан ба үүний багагүй хэсэг нь эдийн бус гэм хорын асуудал багтаж байгаа юм.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 847 дугаар зүйлд бие махбодод гэмтэл учруулсны улмаас сэтгэл санаа зовж шаналсны нөхөн төлбөрийг гаргуулах талаар зохицуулж ирсэн. Гэхдээ хууль хэрэглээний хувьд хэрэв хохирогч гэм хор учруулагчийн хууль бус үйлдлийг нотолж чадахгүй тохиолдолд гэм хор учруулагчаар нөхөн төлбөр төлүүлэхгүй байх эрх зүйн үр дагавар үүсэж байсан¹⁵⁶ гэвч уг зүйл заалт нь хүчингүй болж 253 дугаар зүйлийн 2 дахь¹⁵⁷ зохицуулалтаар илүү өргөн хүрээнд зохицуулах болсон байна.

ХБНГУ-ын хувьд сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг шүүхийн практик хэрэглээний явцад жишиг байдлаар тогтоосон байдаг. Гэхдээ сэтгэл санааны хохирлыг үнэлэхдээ шүүх шууд үзэмжээр шийдэж байгаа гэсэн үг биш.¹⁵⁸ Сэтгэл санааны хохирлыг эдийн хохирол учирснаас үл хамааран гаргуулахаар тусгахдаа тодорхой хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хязгаарлаж тусгасан. Учир нь бүхий л нөхцөлд сэтгэл санааны хохирлыг шаардах боломжгүй юм. Ингэхдээ бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэг гэж тоочих зарчмын дагуу шаардах эрхийн хүрээг хязгаарласныг анхаарах шаардлагатай байна¹⁵⁹ гэж судлаачид үздэг байна.

ХБНГУ-ын дээд шүүхийн шийдвэрүүдээс үзвэл өвчин шаналал, гэмтэл учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нь хоёр зорилготой.¹⁶⁰ Нэгдүгээрт нөхөн төлбөр нь нийгмийн амьдралд оролцох, аз жаргалтай байх боломжоо өвчин шаналлаас болж алдсан хүмүүст чиглэгдэх, хоёрдугаарт тухайн гэмтэл нь аль хэсэгт байгаагаас хамаарч мөн нөхөн төлбөрийн хэмжээ ялгаатай. Тухайлбал, гар

¹⁵⁵ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 40 дэх тал.

¹⁵⁶ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 70 дах тал.

¹⁵⁷ “Бие махбодид халдсан эрүүл мэндийг хохироосон, эрх чөлөө эсвэл бэлгийн амьдралаа бие даан тодорхойлох эрхэнд халдсан шалтгаанаар хохирлыг нөхөн төлөх нөхцөлд хөрөнгийн бус хохирлыг шударгаар үнэлэн мөнгөн төлбөр ноогдуулж болно.” ХБНГУ-ын Иргэний хууль /Кодификацийн бүрэн эх/, УБ., 2017, 49 дэх тал.

¹⁵⁸ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 73 дах тал.

¹⁵⁹ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 74 дах тал.

¹⁶⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2019, 35 дах тал

хугарсан бол 1000-12500 евро, хөл хугарсан бол 2500-12500 евро, нүдээ алдсан бол 12000 ба түүнээс дээш евро, түүнчлэн сар бүрийн тэтгэмж, хоёр хөл ажиллагаагүй болсон бол 12000 ба түүнээс дээш евро гэх мэт. Мөн асрах, нөхөн сэргээх, гэмт хэргийн хохирогч тахир дутуу иргэний амьдрах боломж буурсан бол тэтгэвэр олгох, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүл, оршуулгын зардал, гэр бүлийн гишүүдэд олгох нөхөн төлбөр, хохирогчийн урьд өмнө хийж байсан ажлыг өөрчлөхөд олгох төлбөр, туслалцаа зэрэг зардлыг нөхөн олгохоор¹⁶¹ зохицуулсан.

2. Япон Улс

Японы орчин үеийн эрх зүйн тогтолцоо нь XIX зууны дунд үеэс Франц, Германы эрх зүйн тогтолцоог дуурайх байдлаар бүрэлдэн тогтож, 20 зууны дунд үед АНУ-ын шахалтаар дахин хэлбэрийн болон агуулгын хувьд зарим байдлаар өөрчлөгдсөн байдаг. Үүнээс үзвэл зарим судлаачид холимог төрлийн эрх зүйн тогтолцоотой гэж үздэг.

Иргэний эрх зүй дэх гэм хорын эрх зүйн хувьд Франц буюу эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсын үзэл баримтлалыг хүлээн авч, нутагшуулсан гэж үздэг.¹⁶² Япон Улс нь Иргэний хуулийнхаа гэм хорын эрх зүйн зохицуулалтыг анх боловсруулах явцдаа Франц, Латин Америкийн улсуудын Иргэний хуулиудыг судалж байжээ. Мөн ХБНГУ-ын гэм хорын эрх зүйн зохицуулалтууд ч нөлөөлсөн байдаг. Иргэний хуулийг боловсруулахдаа Япон улсын судлаач, эрдэмтэд эдийн бус алдагдлын хувьд гэм хорын төрлийг хөгжүүлэхээс илүү хохирлыг үнэлж, тооцоолох дээр анхаарсан байдаг.

Сэтгэл санааны хохирол түүнийг нөхөн төлүүлэх шаардах эрхийн үндэслэлийг Иргэний хуулийн 710¹⁶³, 711¹⁶⁴ дүгээр зүйлд тус тус хуульчлан зохицуулсан байдаг. Харин эдгээр зохицуулалт дээр тулгуурлан хохирлын хэмжээг хуулиараа зохицуулж өгсөн байдаг. Эдийн бус хохирлын шинж чанараас хамаараад түүний хэмжээг тооцоолох, нотлох асуудал нь нэлээдгүй ярвигтай бөгөөд сэтгэл санааны хохирол шиг яв цав нотлох боломжгүй асуудал дээр тусгайлсан зохицуулалт хэрэгтэй гэж үзэх нь бий.¹⁶⁵ Япон улсын хувьд ч энэ нөхцөл байдалтай уялдуулан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолохдоо Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйлд¹⁶⁶ зааснаар шийдвэрлэдэг¹⁶⁷ байна.

¹⁶¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2019, 39 дэх тал

¹⁶² Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 67 дах тал.

¹⁶³ Эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх нь: "Бусдын бие махбод, эрх чөлөө болон алдар хүндэд гэм хор учруулсан тохиолдол болон бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан аль ч тохиолдолд 709 дүгээр зүйлд заасны дагуу хохирлыг хариуцах үүрэгтэй этгээд нь эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй."

¹⁶⁴ Гэр бүл, дотнын хүний хохирлыг нөхөн төлүүлэх нь: "Бусдын амь насыг бусниулсан тохиолдолд хохирогчийн эцэг эх, хань ижил болон хүүхдэд эд хөрөнгийн хохирол учраагүй байсан ч бусад хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй."

¹⁶⁵ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 78 дах тал.

¹⁶⁶ Хохирлын хэмжээг тогтоох нь: "Хохирол үүссэн байдлыг тогтооход хохирлын шинж чанараас шалтгаалан түүний хэмжээг нотлоход илт хүндрэлтэй бол шүүх талуудын мэтгэлцээний бүрэн агуулга болон нотлох баримтын үнэлгээний үр дүнд үндэслэн, тохирох хохирлын хэмжээг тогтоох эрхтэй."

¹⁶⁷ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 78 дах тал.

Дээрх агуулгаар Япон Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө гэм хор учруулагчийн үйлдэлд шийтгэл байдлаар тодорхойлохыг хүлээн зөвшөөрдөггүй.¹⁶⁸ Хохирогчийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, хохирлын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх, нөхөх байдлаар хүлээн зөвшөөрөх хандлага илүү давамгайлж байна.

АНУ-ын муж бүр нь нөхөн төлбөрийн талаар өөр өөр зохицуулалттай тусгай хууль гарган хохирлын хэмжээг тодорхойлдог. Энгийн хохирлын хэмжээг 1-5 дахин ихэсгэх, зарим муж нь 300,000-5 сая ам.доллар¹⁶⁹ гэж зохицуулсан байна.

Франц¹⁷⁰ Улс нь хохирлын хэмжээг хэрхэн тооцох тухай хүснэгт гаргасан байдаг бөгөөд шүүх сэтгэл санааны хохирлын хэрэг маргааныг шийдвэрлэхдээ тэрхүү хүснэгтийг ашиглан хохирлын хэмжээг тооцон шийдвэрлэдэг байна. Тухайлбал, 25 настай эрэгтэй хүн гэмтэж, улмаар хэвийн амьдрах чадвараа 30 хувиар алдсан бол хохирлын хэмжээ нь 100 мянган евро¹⁷¹ байх зэргээр хуульчилсан байна. Үүнтэй ижил төсөөтэй шийдвэрлэдэг улс цөөнгүй байдаг байна.

Улс бүрийн өөрийн гэсэн онцлог, нийгмийн амьдралын хэв маягаас хамааран хохирлыг хэмжээ харилцан адилгүй байх ба үүнийг тооцох нийтлэг үндэслэл нь тухайн улс орны эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийнх нь орлогын дундаж үзүүлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн, хөдөлмөр эрхлэлт, дундаж наслалт зэргийг зайлшгүй харж үзэх хэрэгтэй юм.

Дүгнэлт

Гэм хорын эрх зүйд ихэнхдээ бусдын бие махбод, эрүүл мэндэд учруулсан зовлон шаналал, өвдөлт гэсэн утгаар хууль, ном сурах бичиг, судалгаанд дурдагддаг. Харин дээрх ойлголтоос тусдаа сэтгэл санаа болон сэтгэцийн хувьд зовох, шаналах, хямралд өртөх өөр шинжүүд бий болж байна. Дээрх сэтгэцэд учирсан хохирлыг шаардах нь тухайн хүнд учирсан бодит нөхцөл байдлыг тооцон гаргахаас илүү ярвигтай бөгөөд хуулийн ийм зохицуулалт өнөөг хүртэл байхгүй байгаа нь энэ төрлийн хэрэг маргаан шийдвэрлэгдэхгүй, орхигдуулж байсан нь харагдаж байна. Үүнээс улбаалан хэдэн хүн сэтгэл санаагаар хохирч үлдсэнийг тооцон гаргах хэцүү.

Олон улсын хандлагыг судалж үзвэл гэм хорын эрх зүйд хэрэглэгддэг зовлон, шаналал, өвдөлт хэмээх ойлголтоос тусдаа сэтгэл санааны хямрал, сэтгэцэд учирсан зовлон, шаналал хэмээх ойлголт нь бие даасан судлагдахуун гэж үзэх хандлагатай болсон. Сэтгэл санааны хямрал хэмээх ойлголтыг бүр тодотгон сэтгэл санаа, оюуны гэмтэл гэж тодорхойлох ба сэтгэл санааны хямрал нь энгийн стресстэй харьцуулшгүй бөгөөд сэтгэл санааны хямралд өртсөн этгээд нойрны дутагдалд орох, хоол, унд идэж уух дуршилгүй болох, оюун санаа нь төвлөрөхгүй байх, байнгын уур уцаартай байх зэрэг олон шинжүүдээр илэрдэг. Үүнээс үүдэн сэтгэц, мэдрэлд нөлөөлөх, цаашлаад сэтгэц, мэдрэлийн өвчин тусах, эмгэгтэй болох магадлал ч нэмэгддэг болохыг мэргэжлийн судлаач, шинжээчид үздэг байна.

¹⁶⁸ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 80 дах тал.

¹⁶⁹ Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт, Суурин дүн шинжилгээ, УБ., 2013., 12 дах тал.

¹⁷⁰ Харьцуулсан эрх зүй, Гарын авлага, УБ, 2013., 66 дах тал

¹⁷¹ П.Сайнзориг., Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй, Нийтлэл., УБ, 2021.

Манай улсын хувьд сэтгэцэд учирсан хохирлыг хэрхэн тооцох талаар хараахан нэгдсэн ойлголтод хүрч амжаагүй байгаа ч хуулийн нэмэлт өөрчлөлтөөрөө энэ асуудлыг анхаарч авч үзэж байгаа нь харагдаж байна. Хохирсон этгээд буюу нэхэмжлэгч этгээдийн сэтгэл санаа, сэтгэцэд учирсан хохирлоо хэрхэн тооцож, ямар баримтыг үндэслэн тодорхойлох зэрэг нь учир дутагдалтай байгаа бөгөөд үүнийг боловсронгуй болгох хуулийн зохицуулалт зайлшгүй хэрэгцээтэй байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Иргэний хууль, 2002 он
- Эрүүгийн хууль, 2015 он
- ХБНГУ-ын Иргэний хууль /Кодификацийн бүрэн эх/, 2017 он
- Япон улсын Иргэний хууль, 1896 он
- Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV. 2016 он
- С.Нарангэрэл- Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. 2021 он
- Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал 4, 2022 он
- Харьцуулсан эрх зүй гарын авлага-2013 он
- Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол. 2019 он
- Гэмт хэргийг улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт, Суурин дүн шинжилгээ. 2013 он
- Ш.Үнэнтөгс- “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт”. Нийтлэл 2015 он
- П.Сайнзориг: “Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй”. Нийтлэл 2021 он
- Л.Жавхлан- “Сэтгэл санааны хохирлыг тооцож чаддаггүй” Нийтлэл 2019 он

ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР АВЧ ҮЗЭХ НЬ

CONSIDERING EMPLOYMENT IN THE MINING SECTOR

Ё.Болормаа
Судлаач

Товч агуулга: Хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудын үүргийг тодорхойлж, Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийн талаарх зарим асуудлыг хөндөн авч үзэхэд оршино.

Abstract: The aim of this article is to determine the role of the provisions of the Labor Law and discuss some issues regarding the implementation of the relevant provisions of the law in the employment /labor/ relationship of the mining sector.

Түлхүүр үгс: Суурь хэм хэмжээ¹⁷², стандарт заалт¹⁷³, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хэм хэмжээ¹⁷⁴, уртын ээлжээр ажиллуулах¹⁷⁵, хөдөлмөрийн нөхцөл¹⁷⁶, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл¹⁷⁷, нөхөн зохицуулах, нарийвчлан зохицуулах.¹⁷⁸

Keywords: Basic norms, standard provision, mandatory and non-mandatory norm, long shift work, working condition, employment condition, compensatory regulation, detailed regulation

¹⁷²Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн зорилтоор илэрхийлэгдэх бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүхий л аж ахуй нэгж, байгууллага, иргэний хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд зайлшгүй мөрдлөг болгох шаардлагатай хэм хэмжээ буюу Хөдөлмөрийн тухай хууль юм.

¹⁷³ Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулиар дээд, доод хязгаарыг заасан заалтуудаар илэрнэ.

¹⁷⁴ Хөдөлмөрийн тухай хуулиар заавал биелүүлэх, дагаж мөрдөх нь хууль зүйн үүрэг байдлаар томъёологдсон заалтуудаар ойлгоно. Харин үүрэгжүүлээгүй заалт нь талуудад санал болгож буй заалтууд буюу харилцан тохиролцож хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулж болох боломж нь хуулиар олгогдсон гэж харж болохоор заалтууд хамаарна.

¹⁷⁵ Хөдөлмөрийн тухай хуулийн 92.1.Ажилтныг байнга оршин суугаа газраас нь өөр, алслагдсан газар байрлуулж ажил үүрэг гүйцэтгүүлэхээр уул уурхай, олборлох салбарын ажил олгогч уртын ээлжээр ажиллуулах горим хэрэглэж болно.

¹⁷⁶ Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.4."хөдөлмөрийн нөхцөл" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;

¹⁷⁷ Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.17."хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл" гэж ажлын байр, түүний байршил, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цаг зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ажилтан ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйлийг.

¹⁷⁸ Хөдөлмөрийн тухай хууль нь зохицуулагдаж буй хөдөлмөр эрхлэлтийн харилцааны онцлогтой холбоотойгоор холбогдох хуулийн заалтуудыг нарийвчилан зохицуулах, тус хуулиар зохицуулалтгүй байгаа асуудлыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ батлан гаргаж зохицуулахыг үүрэгжүүлсэн эсвэл үүрэгжүүлээгүй байдаг.

1. Хөдөлмөрийн тухай хууль дахь заалтын үүргийг тодорхойлох нь

Хөдөлмөрийн тухай хуулийн зорилт нь хөдөлмөрийн харилцааны зарчим, суурь хэм хэмжээг тогтоож¹⁷⁹, уг харилцаанд оролцогч талуудын үндсэн эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын зохистой тэнцвэрт байдлыг хангахад оршино гэж томъёологдсон.¹⁸⁰ Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагдах хөдөлмөрийн харилцааны мөн чанар, онцлог нь хууль зүйн ямар аргаар түүнийг зохицуулах нь зохистойг тодорхойлох гол хүчин зүйл болдог.¹⁸¹ Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь улсын, хувийн, холимог, иргэд хоорондын зэрэг олон салбарт, үйл ажиллагааны чиглэл, хүрээнээс хамаарч харилцан адилгүй үүсэж, өөрчлөгдөж, дуусгавар болохын зэрэгцээ зохицуулалтын нарийвчилсан төвлөрсөн бус арга¹⁸²-ыг шаарддаг онцлогтой. Зохицуулалтын арга нь тус салбарын харилцааг зохицуулах эх сурвалж болох хууль тогтоомжоор¹⁸³ илэрдэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулалтын ерөнхий аргаар зохицуулах буюу хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, хөдөлмөр эрхлэлтийн салбарт нийтээр дагаж мөрдөх шинжтэй захиргааны хэм хэмжээний акт, улсын хамтын хэлэлцээрээр зохицуулах нь ажил олгогч, ажилтан талуудын хувьд, салбар харгалзахгүйгээр тоглоомын *нийтлэг дүрэм*¹⁸⁴ гэж үзэж болох юм.

Харин байгууллагын хувьд *тусгайлсан дүрэм* байдлаар илэрдэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах хууль тогтоомж нь ерөнхийгөөс тусгай руу чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн тухай хууль¹⁸⁵, хөдөлмөрийн дотоод журам¹⁸⁶, Хамтын гэрээ¹⁸⁷, хөдөлмөрийн гэрээ¹⁸⁸...байдлаар харж болно. Мөн түүнчлэн материаллаг хэм хэмжээ ихтэй, процессын хэм хэмжээ харьцангуй багатай хуульчлагдсан. Холбогдох хууль нь хөдөлмөр эрхлэлтийн

¹⁷⁹ Суурь хэм хэмжээ нь Хөдөлмөрийн тухай хуульд стандарт заалтаар, стандарт бус заалтаар илэрдэг. Стандарт, стандарт бус заалтууд нь үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хэлбэрээр хуульчлагдсан.

¹⁸⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн зорилтын шинжилгээ нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэглээний чухал хэсэг болох нь илтгэлээс үзнэ үү. ХДЭС сэтгүүл. 2023

¹⁸¹ Б.Уранцэцэг, "Аж ахуй нэгж байгууллагад тогтоогдон үйлчлэх хэм хэмжээ /дотоод хэм хэмжээ/ түүнийг хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхдээ шүүх хэрэглэж буй практик", *Шүүх эрх мэдэл* №4 (2017), 46 дахь тал.

¹⁸² Тус байгууллагаас батлан гаргаж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг ойлгоно.

¹⁸³ Хөдөлмөрийн тухай хууль. 2.3 дахь заалт, Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.5-д зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ:

2.3.1.энэ хууль;

2.3.2.Монгол Улсын бусад хууль;

2.3.3.захиргааны хэм хэмжээний акт;

2.3.4.салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;

2.3.5.хамтын гэрээ;

2.3.6.хөдөлмөрийн гэрээ;

2.3.7.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ.

2.4.Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй.

¹⁸⁴ Ямар нэгэн тоглоомын дүрэмтэй адилтган үзэж болох юм. Нийтлэг дүрийг ХтХ гэж харж болох юм. Харин байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тусгайлсан дүрэм гэж үзэж болох юм.

¹⁸⁵ Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж буй бүхий л субъектэд хамааралтай.

¹⁸⁶ Зөвхөн тухайн байгууллагын нийт ажилтнуудад хамааралтай. /дэг журмын тогтоох/

¹⁸⁷ Зөвхөн тухайн байгууллагын нийт ажилтнуудад хамааралтай. /хөдөлмөрлөх эрх ашиг, нийгмийн баталгааг хангаж, хамгаалах/

¹⁸⁸ Зөвхөн ажил олгогч, ажилтанд хамааралтай. /2 субъект хоорондын тухайлсан харилцааг нарийвчилсан зохицуулах/

харилцааг зохицуулах суурь хэм хэмжээ болох төдийгүй материаллаг болон процессын хэм хэмжээний агуулгын илрэл нь мөн л зохицуулагдах харилцааны онцлогтой холбоотой. Өөрөөр хэлбэл, ХтХ-иар материаллаг болон процессын хэм хэмжээг нарийвчлан хуульчлах боломжгүйг тус харилцаа нь өөрөө бий болгодог. Тиймээс тухайн байгууллага хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг батлан гаргахдаа материаллаг хэм хэмжээг заахаас гадна, асуудлыг ямар процессоор шийдвэрлэхийг процессын зураглалын хамт гаргах зайлшгүй шаардлагатай. Хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудыг стандарт заалт, үүрэгжүүлсэн заалт, үүрэгжүүлээгүй заалт хэлбэрээр хуульчлагджээ гэж үзэж болно.

Энэ байдлаар холбогдох заалтуудыг түүвэрлэн байршуулж авч үзье. Үүнд, стандарт заалтууд нь тухайлбал, Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах¹⁸⁹, ажлын цагийн дээд хязгаар¹⁹⁰, хөдөлмөрийн гэрээний хэлбэр¹⁹¹, ажилтан ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрх¹⁹², өөр ажилд түр шилжүүлэх¹⁹³, урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авах¹⁹⁴, дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээ¹⁹⁵, үл өрсөлдөх үүрэг¹⁹⁶, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг

¹⁸⁹ Хөдөлмөрийн тухай хуулийн 31.3. Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг 3 жилээс илүүгүй хугацаагаар байгуулна. 31.4.Цалин хөлсний асуудлаар байгуулах хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг нэг жилээс доошгүй хугацаагаар байгуулна.

¹⁹⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.1.Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна. 84.2.Ердийн ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна. 84.3.Насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байна. 84.4.Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна.

¹⁹¹ Тус хуулийн 48.2.Хүндэтгэн үзэх шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдээгүй бол ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш ажил олгогч ажлын 10 өдрийн дотор хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулах үүрэгтэй.

¹⁹²Хөдөлмөрийн тухай хуулийн 54.1.3.ажил олгогч ажилтны цалин хөлсийг олговол зохих өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд олгоогүй.

¹⁹³ Хөдөлмөрийн тухай хуулийн 58.1.2.үйлдвэрлэлийн осол болон гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах зэрэг зайлшгүй шаардлага гарсан, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулахад хүргэсэн бөгөөд урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол 45 хүртэл хоногийн хугацаагаар;

¹⁹⁴ Хөдөлмөрийн тухай хуулийн 61.1.1.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон хүн хөдөлмөрийн чадвар сэргээгдсэн тухай эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор ажилдаа орох хүсэлтээ гаргасан; 61.1.3.ажлын байр нь хасагдсан шалтгаанаар ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосноос хойш гурван сарын дотор уг ажлын байр дахин бий болсноос хойш 30 хоногийн дотор ажилтан хүсэлт гаргасан;

¹⁹⁵ Хөдөлмөрийн тухай хуулийн 62.6.Дагалдан ажилтны үндсэн цалинг түүний гүйцэтгэх ажил үүрэг, эзэмших ажлын дадлага, ур чадвар зэргийг өөртэй нь тохиролцож тогтоох бөгөөд ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн ажилтны үндсэн цалингийн 70 хувиас доогуур байж болохгүй.

¹⁹⁶ Хөдөлмөрийн тухай хуулийн 72.4.Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш үл өрсөлдөх нэмэлт нөхцөл, эсхүл дагалдах гэрээ үйлчлэх хугацаанд ажил олгогч ажилтанд хамгийн сүүлийн сарын цалин хөлснийх нь 50-аас доошгүй хувийн олговрыг сар бүр олгоно. 79.2.Ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай ажил олгогчид бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоног өнгөрмөгч ажлын байраа орхих эрхтэй бөгөөд энэ тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсанд тооцно.

ажилтны санаачилгаар цуцлах¹⁹⁷, бөөнөөр халах үеийн зохицуулалт¹⁹⁸, ажлын бүтэн бус цаг¹⁹⁹, ээлжийн ажлын цаг²⁰⁰, дуудлагын цаг²⁰¹, уртын ээлжээр ажиллуулах²⁰², туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний онцлог²⁰³, ажил олгогчийн зардлаар суралцах ажилтны хүлээх үүрэг²⁰⁴, ээлжийн амралт, түүний хугацаа²⁰⁵, туслах малчны цалин хөлс²⁰⁶, сул зогсолтын үеийн олговор²⁰⁷, цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах²⁰⁸ гэсэн зохицуулалтуудаар илэрчээ. Төрөөс

¹⁹⁷ Хөдөлмөрийн тухай хуулийн 80.4.Ажил олгогч энэ хуулийн 65.4.2, 78.1.5, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай ажилтанд 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд ажилтанд мэдэгдэл өгсөн тухайгаа шаардлагатай тохиолдолд ажил олгогч нотлох үүрэгтэй.

¹⁹⁸ Хөдөлмөрийн тухай хуулийн 81.6.Ажил олгогч бөөнөөр халах шийдвэрээ гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

¹⁹⁹ Хөдөлмөрийн тухай хуулийн 86.1.Ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны долоо хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй байна.

²⁰⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн 87.1.Ажил олгогч ээлжийн ажлын цаг, хуваарийг ээлжийн ажил эхлэхээс 48-аас доошгүй цагийн өмнө ажилтанд мэдэгдэнэ.

²⁰¹ Хөдөлмөрийн тухай хуулийн 89.2.Ажилтан ажил олгогчийн заасан байршилд хүлээсэн бол тухайн хугацаанд ногдох үндсэн цалингийн 50-аас, бусад тохиолдолд 30-аас доошгүй хувийн олговрыг ажил олгогч ажилтанд олгоно. 89.2.Ажилтан ажил олгогчийн заасан байршилд хүлээсэн бол тухайн хугацаанд ногдох үндсэн цалингийн 50-аас, бусад тохиолдолд 30-аас доошгүй хувийн олговрыг ажил олгогч ажилтанд олгоно. 89.3.Ажил олгогч дуудлагаар ажиллуулах өдөр, цагийг ажилтанд 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх бөгөөд ажилтныг нэг сард наймаас илүү удаа дуудлагаар ажиллуулахгүй.

89.3. Хөдөлмөрийн тухай хуулийн Ажил олгогч дуудлагаар ажиллуулах өдөр, цагийг ажилтанд 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх бөгөөд ажилтныг нэг сард наймаас илүү удаа дуудлагаар ажиллуулахгүй.

²⁰² 92.3.Уртын ээлжээр ажиллах ажилтны ажлын өдрийн үргэлжлэл 12 цагаас илүүгүй байх бөгөөд энэ хуулийн 87 дугаар зүйлийг баримтлан энэ хуулийн 109.1-д заасны дагуу илүү цагийг тооцож нэмэгдэл хөлс олгоно.

92.4. Хөдөлмөрийн тухай хуулийн Уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байна.

²⁰³ Хөдөлмөрийн тухай хуулийн 71.6 олгогч нь туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтныг долоо хоногт тасралтгүй 24 цагаас дээш хугацаагаар амрах, энэ хуульд заасны дагуу ээлжийн амралт олгох үүрэгтэй.

²⁰⁴ Хөдөлмөрийн тухай хуулийн 73.3.Сургалтын дараа ажилтны тухайн аж ахуйн нэгж, байгууллагад үргэлжлүүлэн ажиллах хугацааг талууд харилцан тохиролцох бөгөөд гурван жилээс илүүгүй байна.

²⁰⁵ Хөдөлмөрийн тухай хуулийн 99.3.Хуульд өөрөөр заагаагүй бол ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр байна. 99.4.Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна. 99.8.Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна.

²⁰⁶ Хөдөлмөрийн тухай хуулийн 112.1.Туслах малчин зөвшөөрсөн бол түүний цалин хөлсний 30-аас илүүгүй хувийг мөнгөн бус хэлбэрээр олгож болно.

²⁰⁷ Хөдөлмөрийн тухай хуулийн 116.1.Ажил олгогчоос үл шалтгаалан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасан аюулт үзэгдэл, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийн улмаас, эсхүл ажилтнаас үл шалтгаалах сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол түүнд үндсэн цалингийнх нь 60-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний олговор олгох бөгөөд олговрын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.

²⁰⁸ Хөдөлмөрийн тухай хуулийн 119.2.Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгал нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан

холбогдох хуулийг батлан гаргахдаа тоон үзүүлэлтээр илэрсэн заалтуудын хэрэгжилтийн дээд, доод хязгаарыг хуульчилж өгсөн байна.

Харин үүрэгжүүлсэн байдал нь дараах байдлаар холбогдох хуулиас харагдана. Тухайлбал, ...үүрэгтэй²⁰⁹...дагаж мөрдөх үүрэгтэй²¹⁰...дагаж мөрдөнө²¹¹...бүрдүүлэх үүрэгтэй²¹², ...байршуулах үүрэгтэй²¹³, ...ажлын байраар хангах үүрэгтэй²¹⁴, ...баталж мөрдүүлнэ.²¹⁵, ...хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр

цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна.

²⁰⁹ Тус заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд 53 байна.

²¹⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн 2.4.Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй. /гэсэн заалт 1 байна/

²¹¹Хөдөлмөрийн тухай хуулийн 2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. 40.3.Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах үйл явц бүрэн дуусах хүртэлх хугацаанд хамтын гэрээг дагаж мөрдөнө. 107.5.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг салбар, салбар дундын хамтын хэлэлцээрээр энэ хуулийн 107.3-т заасан хэмжээнээс нэмэгдүүлэн тогтоосон бол түүнийг дагаж мөрдөнө.

²¹² Хөдөлмөрийн тухай хууль. 6.3.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөлийг ажил олгогч бүрдүүлэх үүрэгтэй. Мөн 7.4. Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Мөн 31.6. Ажил олгогч хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд ажил олгогчоос шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. /гэсэн заалт 3 байна./

²¹³ Хөдөлмөрийн тухай хууль. 6.6. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан гэж үзсэн хүн, ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. Гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. 7.3.Ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртсөн гэж үзвэл гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатны албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага...байршуулах үүрэгтэй. 33.5. Ажил олгогч хамтын гэрээ, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэх хамтын хэлэлцээрийг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. 45.2.Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам, түүнд оруулсан өөрчлөлтийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Мөн 122.2. Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмыг шинээр баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болон хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заана.

²¹⁴Хөдөлмөрийн тухай хууль. 43.2.3. энэ хуульд заасны дагуу хувь хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан шаардлага, стандартад нийцсэн, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байраар хангах

²¹⁵Хөдөлмөрийн тухай хууль. 103.3. Ажил олгогч хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн цалин хөлсний талаар дараах хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг баталж мөрдүүлнэ.

103.3.1.ажил мэргэжлийн жагсаалт;

103.3.2.ажлын байрны тодорхойлолт;

103.3.3.энэ хуулийн 106.3-т заасантай нийцсэн хөдөлмөрийн норм, норматив;

103.3.4.цалин хөлсний журам.

тогтооно.²¹⁶, ... хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.²¹⁷, ...тогтоон мөрдүүлнэ²¹⁸,...бодлого хэрэгжүүлнэ.²¹⁹...үйлчилнэ²²⁰...тусгана²²¹...байгуулна²²² гэсэн заалтуудаас харагдана. Үүнтэй холбоотойгоор, ажил олгогчийн зүгээс заавал батлан мөрдүүлэхээр хуулиар үүрэгжүүлсэн, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг авч үзвэл, Хөдөлмөрийн тухай хуулийн 122.1. “Хөдөлмөрийн дотоод журам”, 7.4. “Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан

122.1. Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

²¹⁶ Хөдөлмөрийн тухай хууль. 108.1. Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно. Мөн 109.6. Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.

²¹⁷ Хөдөлмөрийн тухай хууль. 100.2. Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. Мөн 139.1. Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

²¹⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 43.2.8. зайлшгүй шаардлагаар ажлын байранд хяналтын тоног төхөөрөмж ажиллуулах бол энэ тухай ажилтанд урьдчилан мэдэгдэх, ашиглах журмыг тогтоон мөрдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.15-д заасан ахуйн байранд хяналтын тоног төхөөрөмж байрлуулахгүй байх;

²¹⁹ Хөдөлмөрийн тухай хууль. 43.3. Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ. /...байгуулах замаар хэрэгжүүлнэ, ...арга хэмжээг авч хэрэгжүүлнэ, ...чиг үүргийг хэрэгжүүлнэ,... байцаагч хэрэгжүүлнэ,...хяналтыг хэрэгжүүлнэ, ажил олгогч хэрэгжүүлнэ/

²²⁰ Хөдөлмөрийн тухай хууль 2.3.Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.5-д зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ..., ... 35.2.Салбар, салбар дундын хамтын хэлэлцээр нь тухайн хэлэлцээрт оролцогчдын төлөөлж байгаа нийт ажилтан, ажил олгогчид хамаарч үйлчилнэ.... 64.5.Туршилтаар ажиллах ажилтанд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ... 66.4.Ажлын бүтэн бус цагийн ажилтан энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажлын бүтэн цагаар ажиллах ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ. Мөн 67.4.Гэрээсээ ажиллах ажилтан энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажил олгогчийн ажлын байран дээр ажиллаж байгаа үндсэн ажилтантай адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ түүнд нэгэн адил үйлчилнэ. 68.3.Зайнаас ажиллах ажилтан энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа бусад ажилтантай адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ түүнд нэгэн адил үйлчилнэ.

²²¹ Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана: 49.1.1.ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг; 49.1.2.ажил үүрэг гүйцэтгэх байршил; 49.1.3.цалин хөлсний хэмжээ; 62.2.Дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан нөхцөлөөс гадна ажилтны дагалдан ажиллах хугацаа, дагалдуулан ажиллуулах ажилтан, эзэмшвэл зохих ажлын дадлага, ур чадварын талаар тусгайлан тусгана гэх мэт /14 заалт байна./

49.1.4.хөдөлмөрийн нөхцөл.

²²² гэсэнтэй холбоотой заалт 16 байна.

зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”, 45.1. “Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам”, 43.2.8 “Хяналтын төхөөрөмж байршуулж, ашиглах журам”, 103.3. Ажил мэргэжлийн жагсаалт, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн норм, норматив, Цалин хөлсний журам, Нууцтай холбоотой журам зэрэг нь тухайн хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үйл ажиллагааны чиглэл, онцлог, ажилтнуудын тоо зэргээс шалтгаалан бие даасан байдлаар батлагдан мөрдөгдөх эсвэл хөдөлмөрийн дотоод журамд бүлэг байдлаар оруулан зохицуулагдах боломжтой. Хөдөлмөрийн тухай хууль дахь үүрэгжүүлээгүй хэм хэмжээг авч үзвэл, Тухайлбал, ...эрхтэй²²³, ...баталж мөрдүүлж болно.²²⁴, ...байгуулж болно²²⁵, ...баталж болно.²²⁶, ...тогтоож болно.²²⁷, ...олгож болно.²²⁸, ...тусгаж болно.²²⁹, ...зохицуулж болно.²³⁰, ...эвлэлдэн нэгдэх эрх²³¹, ...тохиролцож болно²³² гэсэн заалтуудаас авч үзэхэд энэхүү ...ж болно гэсэн заалтууд нь...ж болохгүй ч байж болохыг бас хуулиар зөвшөөрчээ гэж үзэж болохоор байна.. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 20.1.Хамтын хэлэлцээ хийх санаачилгыг аль ч тал гаргаж болно. Мөн 107.2. Ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцсон бол цалин хөлсийг аж ахуйн нэгж,

²²³ Тус заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд 32 байна.

²²⁴ Хөдөлмөрийн тухай хууль. 106.1. Ажил олгогч ажиллах хүчний тоог төлөвлөх, ажиллах хүчний тоог ажил, мэргэжлээр тогтоох, хийснээр цалин хөлс олгох зорилгоор хөдөлмөрийн норм, норматив баталж мөрдүүлж болно.

²²⁵ Хөдөлмөрийн тухай хууль. 49.3. Энэ хуулийн 49.1-д зааснаас гадна ажил үүргийн онцлогтой нь холбоотойгоор эд хөрөнгийн хариуцлагын, нууцын, сургалтын, үл өрсөлдөх зэрэг нэмэлт нөхцөлийг харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд тусгах, эсхүл эдгээр асуудлаар хөдөлмөрийн гэрээнд дагалдах тусгайлсан гэрээ байгуулж болно. Мөн 14.4. Нийгмийн хоёр талт түншлэлийн хүрээнд дараах баримт бичгийг байгуулж болно:

14.4.1.салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;

14.4.2.хамтын гэрээ;

14.4.3.хууль тогтоомжид заасан бусад. /...байгуулж болно гэсэн заалт-19/

²²⁶ Хөдөлмөрийн тухай хууль. 74.2. Аж ахуйн нэгж, байгууллагын нууц хадгалах, нууцтай харьцах журмыг ажил олгогч баталж болно.

²²⁷ Хөдөлмөрийн тухай хууль. 82.3. Хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр энэ хуулийн 82.1, 82.2-т заасан тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгохоор тогтоож болно. Мөн 109.9.Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно. /...тогтоож болно гэсэн заалт-6/

²²⁸ Хөдөлмөрийн тухай хууль. 100.1. Ажил олгогч ажилтны хүсэлтээр хувийн чөлөө олгож болно. 100.2.Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. /...олгож болно гэсэн заалт-8/

²²⁹ Хөдөлмөрийн тухай хууль. 37.1.Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцох бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно. /ХТХ 37.1.1-37.1.11/

²³⁰ Хөдөлмөрийн тухай хууль. 107.2. Ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцсон бол цалин хөлсийг аж ахуйн нэгж, байгууллагын болон салбар, салбар дундын түвшинд тус тус хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр зохицуулж болно. Мөн 125.4. Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан энэ хуулийн 125.1-д заасан нөхөн төлбөрийн хэмжээг индексжүүлэх асуудлыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулж болно.

²³¹ Хөдөлмөрийн тухай хууль. 9.1. Ажилтан болон ажил олгогч аливаа байгууллага, албан тушаалтнаас зөвшөөрөл авахгүйгээр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо төлөөлөн хамгаалах байгууллага байгуулах, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаагаа явуулах, дүрмээ батлах, төлөөлөгчөө сонгох эрхтэй.

²³² Хөдөлмөрийн тухай хуулийн 71.6.Ажил олгогч туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай ажил үүргийн онцлогийг харгалзан ажил, амралтын цагийг энэ хуульд зааснаас өөрөөр харилцан тохиролцож болно. /ХТХ-д 5 заалт байна.

байгууллагын болон салбар, салбар дундын түвшинд тус тус хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр зохицуулж болно. ХтХ 145.1. Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно гэх мэт. Практикт хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулахдаа илрэх хэлбэр нь Хамтын гэрээ, ...нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журам, Хувцас хэрэгсэл олгох журам, Хоол, унааны мөнгө олгох журам, Буцалтгүй тусламж олгох журам, Ур чадварын нэмэгдэл хөлс олгох журам...гэх мэт талууд харилцан тохиролцож шийдвэрлэж болох боломжийг хуулиар олгосон.

Үүрэгжүүлээгүй эрх зүйн актын цаана хөдөлмөр, нийгмийн баталгааг бий болгохтой холбоотой асуудал нарийвчилсан зохицуулалтгүй, тодорхойгүй байдлаар үлдэх магадлалтай. Практикт зарим тохиолдолд хамтын гэрээгүйгээр²³³, бусад эрх зүйн актаар нийгмийн баталгааг хангах зохицуулалт хийх нь байдаг. Гэвч энэ нь эрх зүйн үр дагаврын хувьд харилцан адилгүйг анхаарах нь зүйтэй. Байгууллагад хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журам буюу хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь материаллаг зохицуулалт нь ерөнхий бөгөөд нарийвчилсан зохицуулалт бага, хэрэгжих эсэх нь хоёрдмол утгатай, тодорхойгүй, зохицуулалтын давхардал, хийдэлтэй, хэрхэн хэрэгжүүлэх процессын зохицуулалт тодорхойгүй, агуулгын бус, хэлбэрийн зохицуулалттай байдаг нь ажиглагддаг. Ийнхүү хэлбэрдсэн хөдөлмөрийн дотоод хэмжээ буюу байгууллага бүрт үйлчлэх эрх зүйн актууд нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилтнуудын эрхийг зөрчих, ажил олгогч, ажилтан талууд үл ойлголцох, байгууллагын соёлыг бүтээхэд асуудал үүсэх, шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалт бий болох зэрэг тус салбарын зарчим агуулгаараа зөрчигдөх, хэрэгжихгүй байх нөхцөл нь болдог.

2.Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчлэл /Уул уурхайн салбарт/

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Тус заалтын хүрээнд хүрээлэн буй орчин, байгаль орчинтой холбоотой тулгамдаж буй олон асуудлыг хөндөж болох ч тухайлсан уул уурхайтай холбоотойгоор шууд болон шууд бус байдлаар сөрөг нөлөөллүүд хөдөлмөр эрхлэлтийн төдийгүй бусад харилцааны хувьд ч их байдгийг дурдах нь зүйтэй. Тухайлбал, малчдын хөдөлмөрийн нөхцөл алдагдахад хүргэдэг. Монгол Улс нь байгалийн арвин их нөөцтэй бөгөөд сүүлийн жилүүдэд түүнийгээ эрчимтэй ашиглах болсноор уул уурхайн салбар хөгжиж байна. Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой, Тавантолгой болон бусад ашигт малтмалын ордууд эдийн засгийн эргэлтэд орсноор Монгол улсын өрсөлдөх чадвар нэмэгдэн эдийн засаг нийгмийн хөгжил хурдсаж, хүн амын орлого нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.²³⁴ Нэг талаас ийм эерэг үзүүлэлт гарч буй боловч, нөгөө талаас хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр байгаль орчин доройтож, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах...эрх ноцтой зөрчигдөх боллоо.²³⁵ Монгол Улсын хэмжээнд хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зэрэг 30 гаруй

²³³ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. 101 дэх тал. /Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 60 орчим хувь нь хамтын гэрээ, хэлэлцээргүй байв. Энэ нь тэдгээр байгууллагад Үйлдвэрчний эвлэл байхгүйтэй холбоотой юм гэжээ./

²³⁴ Ашигт малтмалын эрх зүй /гарын авлага, 2 дахь хэвлэл/, /Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл 2-р шат/, European Bank, ШЕЗ, IDLO8, 2017 он., УБ.

²³⁵ Мөн тэнд

хуулиар зохицуулж байна.²³⁶ Аливаа орны эдийн засаг урт хугацаанд, тогтвортой хөгжихөд эдийн засгийн салбаруудын төрөлжилт, хоорондын уялдаа холбоо чухал нөлөөтэй байдгаас гадна улс орны эдийн засгийн онцлогоос хамаарсан тэргүүлэх салбаруудын бусад салбартаа үзүүлэх дам нөлөө чухлаар тавигддаг билээ.

Учир нь дотоодын нийт бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт, төсвийн орлого, ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн голлох үзүүлэлтэд эдийн засгийн тэргүүлэх салбарын үйлдвэрлэл, түүний хэлбэлзэл голлох нөлөөг үзүүлж байдаг.²³⁷ гэжээ. Уул уурхайн салбарт²³⁸ зэрэг хуулиуд үйлчлэхээс гадна уул уурхайн салбар дахь тусгайлсан хэм хэмжээ тогтоосон актууд, хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд мөрдлөг болговол зохих нийтлэг хэм хэмжээ тогтоосон актуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийн салбарт 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 1,124.6 мянган иргэн ажиллаж байснаас уул уурхайн салбарт 44,3 мянган иргэн, 2021 оны 3-р улирлын байдлаар нийт хөдөлмөр эрхлэгч 1,135.6 мянга байснаас 57,8 мянга нь уул уурхайн салбарт, 2021 оны 4-р улирлын байдлаар нийт 1,127.1 мянган иргэн ажиллаж байснаас 5% буюу 56,2 мянган иргэн нь уул уурхайн салбарт ажиллаж байсан статистик судалгаа байна. Ажиллах хүчний мэдээлэл улсын болон уул уурхайн салбарын хэмжээнд.²³⁹

Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүнээр	2020.10-12	2021.7-9	2021.10-12
Нийт	1,124.6	1,135.6	1,127.1
Уул уурхай	44.3	57.8	56.2

Хөдөлмөрийн тухай хуулийн стандарт заалт, үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй заалтууд нь тус харилцааны онцлогтой холбоотойгоор уул уурхайн салбарын хүрээнд ч хуульчлагдсан үүргийнхээ хүрээнд үйлчилнэ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Уул уурхайн салбартай холбоотой тусгайлсан заалт нь уртын ээлжээр ажиллуулах /ХТХ-нд ажлын өдрийн үргэлжлэл 12 цагаас илүүгүй байх, илүү цагийг тооцож нэмэгдэл хөлс олгоно. Нэг

²³⁶ “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” МУ-ын ХЭҮК-ын 2011 оны илтгэл, 62 дахь тал

²³⁷ Уул уурхайн ба уул уурхайн бус салбарын хоорондын харилцан хамаарлыг судла-х нь Монголбанк, Судалгаа, Статистикийн газар, Судалгааны хэлтэс, Ахлах эдийн засагч. Цахим хаяг: anand@mongolbank.mn

²³⁸ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгайзөвшөөрлийн тухай, Цөмийн энергийн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Агаарын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Усны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зэрэг

²³⁹ [BookLibraryDownload.ashx \(1212.mn\)](#)


ажиллах эсвэл амралтын 14 хоногоос хасах шаардлагатай болж байна. Жишээ нь: А компанийн ажилтнууд Улаанбаатар хотоос 21 цагийн галт тэргэнд сууж, маргааш өглөөний 7 цагт Дорноговь аймгийн Сайншанд хотод бууж, уурхай руугаа 2 цаг тээврийн хэрэгслээр зорчиж очдог. Уурхай тасралтгүй ажилладаг тул очсон өдрөө ажлаа хүлээж аваад, 14 хоног ажиллаад 14 дэх хоногийн оройн галт тэргээр Улаанбаатар хот руу явдаг. Тухайлбал, Уурхайд ажиллах, амрах хуваарийн жишээ

Хүснэгтэд харуулснаар ирэх, буцах хоног, ажил хүлээлцэх хоногийг ажлын 14 хоногтообагтааж оруулснаар ажилтан 14 хоног амрах боломжгүй, амрах хугацаа 10 хоног болж байна. Тиймээс энэхүү 14/14 гэдэг хуваарийг уурхайд ажилладаг,



тухайн аймаг, хотод амьдардаг ажилтнуудаас бусад аймаг, хотод амьдардаг ажилтнуудад хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзэж болохоор байна. Мөн уртын ээлжийн 14/14 хуваарьт монгол, гадаад ажилтны эрх зүйн ялгаатай зохицуулалт үгүй тул уурхайн компанид ажилладаг гадаад ажилтнууд мөн тус хуваариар ажиллана гэж харж болохоор байна. Гадаад ажилтнууд монгол ажилтнуудтай харьцуулахад нисэх онгоцоор Монгол улсад ирэх, буцахдаа монгол ажилтнуудаас илүү олон цагийг зарцуулдаг зэрэг. Манай улсад 2021 оны 4 дүгээр улирлын эцэст гадаадын 77 улсын 5.6 мянган иргэнхөдөлмөрийн гэрээгээр ажиллаж мөн сайн дурын ажил хийж байна²⁴⁰. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг ажиллаж буй салбараар харвал:

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гадаадын иргэд насны бүлгээр,



²⁴⁰ BookLibraryDownload.ashx (1212.mn), Immigration

Гадаад иргэдийн 36.1% нь уул уурхай,олборлох салбарт ажиллаж байна. Уул уурхайн салбарын гадаад ажилтнууд ихэвчлэн 4/2, 5/3 хуваариар ирж ажилладаг нь зардал нэмэгдэх шалтгаан нь болохыг үгүйсгэх боломжгүй.

Дүгнэлт

Холбогдох илтгэлийн хүрээнд судлагдаж буй сэдвийн томъёололтой холбоотойгоор Уул уурхайн талаар судлахыг төдийлөн зорилгоо болгоогүй болно. Харин хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудын үүргийг ерөнхий байдлаар тодорхойлохын зэрэгцээ, уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд тус хуулийн холбогдох заалтын хэрэгжилт ямар байгаа талаар стандарт заалтын хүрээнд авч үзлээ. Цаашид тухайн салбарт тус хуулийн мөн чанарыг ойлгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Иргэний хууль, 2002 он
- Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011 он
- Ашигт малтмалын тухай хууль, 2006 он